



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ЖИЛИЙН ТАЙЛАН 2022



МОНГОЛБАНК



ЖИЛИЙН ТАЙЛАН 2022

Монголбанкны Ерөнхийлөгч
Б.Лхагвасүрэн



Өмнөх үг

Эрхэм уншигч Танд 2022 оны Монголбанкны Жилийн тайлан хүрэх энэ өдрийн мэндийг дэвшүүлье!

2022 он Монгол Улсын эдийн засагт эерэг олон өөрчлөлт бий болсон сэргэлтийн жил байлаа. Гадаад болон дотоод эдийн засгийн орчинд эрсдэл, сорилтын дунд дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 4.8 хувь өсөж, цар тахлын өмнөх ердийн үеийн түвшиндээ хүрч өслөө. Монголбанк инфляцыг зорилтод түвшинрүү бууруулах зорилгоор мөнгөний бодлогын хүүг шат дараатай нэмэгдүүлэв. Гэхдээ зээлийн тасалдлаас сэргийлэх, аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтийн нөхцөлийг харьцангуй таатай байлгах, эдийн засгийг огцом хумихгүй байхад анхаарч, сэргэлтийг үргэлжлүүлэх үүднээс харьцангуй алсуур өсгөсөн.

Монголбанк хуулиар ногдсон зорилтын дагуу санхүүгийн системийн тогтвортой байдлыг хадгалж ажиллав. 2022 онд системийн ач холбогдолтой банкууд олон нийтэд нээлтэй хувьцаат компани болж эхэлсэн нь өмчлөл, засаглал, хяналт шалгалтын шинэчлэлт төдийгүй 2 шатлалт банкны тогтолцоотой болсноос хойш түүхэн үйл явдал юм. Төв банкнаас хэрэгжүүлж буй Банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөрийн үр дүнд банкны системийн эрсдэл даах чадварыг үргэлжлүүлэн сайжруулж, олон улсын стандарт, сайн туршлагад нийцсэн зохицуулалтын эрх зүйн орчныг бий болгохыг зорьж ажиллалаа.

Эдийн засгийн гадаад орчны эрсдэл нэмэгдэж, төлбөрийн тэнцэл дээрх дарамт өндөр сорилттой жил байсан хэдий ч Монгол Улсын гадаад валютын улсын нөөцийг 2022 оны эцэст 3,399.6 сая ам.доллар буюу валютын төлбөртэй барааны импортын 4.7 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрэв. Төв банк дотоодын зах зээлээс худалдан авсан үнэт металлын хэмжээ 22.9 тоннд хүрч, өмнөх оны үзүүлэлтээс 10.1 хувиар нэмэгдсэн нь валютын нөөц бүрдүүлэхэд чухал хувь нэмэр боллоо. Үндэсний төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, төлбөр тооцооны хөгжлийг шат ахиулах шинэчлэлүүдийг хэрэгжүүлэв. Үүний зэрэгцээ, мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, гүйлгээнээс татах, гүйлгээнд байгаа мөнгөн тэмдэгтийн зохистой бүтцийг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэв.

Монголбанк төв банкны нээлтэй, ил тод байдлыг хадгалж, олон нийттэй харилцах харилцаагаа шинэ түвшинд хүргэхэд онцгой анхаарч ажилласны зэрэгцээ төв банкны мэдээлэл, бодлого шийдвэрийг түгээх гол суваг болох www.mongolbank.mn цахим хуудсаа бүрэн шинэчлэв. Иргэдийн санхүүгийн суурь мэдлэг, боловсролыг дэмжих ажлаа идэвхжүүлж, нийслэл болон орон нутагт цахим болон танхимын сургалт, арга хэмжээнүүдийг зохион байгуулав.

Төв банкны үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү Жилийн тайлангаар дамжуулан Таны мэлмийд хүргэж байгааг хүлээн авна уу.


Монгол Улсын Төв Банк

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ

A vertical handwritten signature in black ink, reading from top to bottom: "Б.Лхагвасүрэн".

Б.ЛХАГВАСҮРЭН

МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СХЕМ



ГАРЧИГ

1. ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ	9
1.1 Бодит сектор	9
1.2 Гадаад сектор	12
1.3 Мөнгө, санхүүгийн сектор	19
1.4 Улсын төсөв	24
2. ТӨВ БАНКНЫ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА	27
2.1 Мөнгөний бодлогын зорилт, хэрэгжилт	27
2.2 Монголбанкны зах зээлийн үйл ажиллагаа	30
2.3 Санхүүгийн тогтвортой байдал	40
2.4 Гадаад валютын улсын нөөцийн удирдлага	46
2.5 Үнэт металл худалдан авах үйл ажиллагаа	48
2.6 Монгол Улсын Үндэсний төлбөрийн систем	48
2.7 Мөнгөн тэмдэгтийн үйл ажиллагаа	53
2.8 Засгийн газрын санхүүгийн зуучлал	55
2.9 Төв банкны судалгаа, статистик	56
3. ТӨВ БАНКНЫ ЗАСАГЛАЛ, БҮТЭЦ, БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА	59
3.1 Монголбанкны бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц	59
3.2 Дотоод аудит	59
3.3 Эрсдэлийн удирдлага	60
3.4 Мэдээллийн технологи	63
3.5 Төв банкны олон нийттэй харилцах харилцаа	64
3.6 Гадаад харилцаа	66
3.7 Эрдэнэсийн сан, Мөнгөн тэмдэгтийн танхим	68
3.8 Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэг боловсрол	69
3.9 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа	75
3.10 Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн үйл ажиллагаа	86
3.11 Зээлийн мэдээллийн сан	87
3.12 Банк, санхүүгийн салбарын хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлт	88
4. АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	95
5. ХАВСРАЛТ: СТАТИСТИК	228

1.1 БОДИТ СЕКТОР


Үйлдвэрлэл

Эдийн засаг 2022 онд 4.8 хувиар өссөн байна. Салбаруудаар авч үзвэл үйлчилгээ, хөдөө аж ахуй, цэвэр татвар өсөлтийг голлон бүрдүүлжээ. Уул уурхайн салбар оны сүүлийн хагаст идэвхжсэн хэдий ч жилийн дүнгээр агшив (Зураг 1.1).

Тайлант онд өрхийн хэрэглээ сэргэж, гадаад худалдааны эргэлт нэмэгдсэнээр цэвэр татвар 11.5 хувь, худалдааны салбар 8.0 хувиар, үйлчилгээний салбар 4.9 хувиар өссөн бол мал төллөлт, өвөлжилт сайн байж хөдөө аж ахуйн салбар 12.0 хувиар өслөө. Тодруулбал, оны эцсийн мал тооллогын дүнгээр 2022 онд 25 сая төл бойжиж, малын тоо 71.1 сая толгойд хүрсэн нь түүхэн дээд үзүүлэлт болов. Түүнчлэн, оны сүүлийн хагаст мах бэлтгэл, ус ундаа, барилгын материалын боловсруулах үйлдвэрлэл эрчимжиж, орон сууцны барилга угсралтын ажил нэмэгдсэнээр аж үйлдвэр, барилгын салбар жилийн дүнгээр 6.1 хувиар өслөө.

Хилийн хязгаарлалт оны дунд үеэс суларч нүүрс, газрын тос зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт, экспорт сэргэлээ. Оны сүүлийн хагас жилээр тооцвол нүүрсний экспорт өмнөх оны мөн үеэс 3.6 дахин нэмэгдэж 23.6 сая тонн, газрын тосны экспорт 67 хувиар нэмэгдэж 2.5 сая баррель хүрсэн байна. Харин жилийн дүнгээр уул уурхайн салбар 11.9 хувиар буурав.

Зураг 1.1. ДНБ-ий өсөлт, үйлдвэрлэлийн аргаар



Зураг 1.2. ДНБ-ий өсөлт, эцсийн ашиглалтын аргаар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Эрэлт талаас хөрөнгийн нийт хуримтлал өсөлтийн гол хэсгийг бүрдүүлсэн бол өрхийн хэрэглээ цар тахлын өмнөх үеийг давж сэргэлээ (Зураг 1.2). Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлсэн дүнгээр олгох, орон сууцны ипотекийн зээлийн төлөлтийг хойшлуулах арга хэмжээ 2022 онд үргэлжлэн хэрэгжиж, хөдөлмөрийн зах идэвхжэсэн нь өрхийн орлогоор дамжин эрэлтийг дэмжив. Өрхийн хэрэглээ 2022 онд 7.4 хувиар өсөж, цар тахлын өмнөх 2019 оноос 3.2 хувиар давжээ.

Инфляц

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлд Төв банк инфляцын зорилтыг 2022-2024 онд жилийн 6 хувь орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулахаар тусгасан. Олон улсад үүсээд буй геополитикийн асуудал, худалдааны түнш орнуудын өндөр инфляц, тээврийн саатал зэрэг гадаад, дотоод орчны эдийн засгийн эрсдэл, тодорхой бус байдал өндөр байлаа. Ийнхүү хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх улсын инфляц 6 дугаар сард оргил үедээ хүрч, түүнээс хойш алгуур буурсаар оны эцэст 13.2 хувьд хүрлээ (Зураг 1.3).

Оны сүүлийн хагаст шатахууны үнэ харьцангуй тогтворжиж, тээврийн саатал багасч, импортын хүнсний үнэ буурлаа. Мөн 6, 7 дугаар сард улирлын хандлагаасаа огцом давж өсөөд байсан хүнсний ногооны үнэ хямдарч, дотоодын мах, махан бүтээгдэхүүний үнэ 6 дугаар сараас эхлэн өнгөрсөн оны мөн үеэс илүү буурсан нь инфляц буурахад голлон нөлөөллөө.

Зураг 1.3. Улсын жилийн инфляц, сараар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 1.1. Жилийн инфляцын задаргаа

Бүлэг	Жилийн өсөлт	Жилийн инфляцад эзлэх хувь
	12 сар	12 сар
Импортын бараа /хүнсний бус/	12.6%	4.4%
Шатахуун	16.6%	1.0%
Импортын хүнс	13.2%	0.9%
Махнаас бусад дотоодын хүнс	30.8%	3.5%
Үйлчилгээ	9.7%	1.6%
Дотоодын бараа/хатуу түлш хассан/	19.1%	1.0%
Хатуу түлш	25.2%	0.7%
Төрийн зохицуулалттай	5.5%	0.4%
Дотоодын мах	-3.1%	-0.3%
Нийт		13.2%

Тээврийн зардал, шатахууны үнэ болон худалдааны түнш орнуудад инфляц нэмэгдсэнээр импортын барааны үнэ эрчтэй өсөж, дотоодын бараа, бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлсэн нь **оны туршид инфляц өндөр хадгалагдахад нөлөөллөө**. Тухайлбал, газрын тосны үнэ дэлхийн зах зээлд эрчтэй өссөн мөн ханш суларсан нөлөөгөөр шатахууны үнэ өндөр хадгалагдав. Мөн тээврийн гацаанаас шалтгаалан импортын барааны үнэ өссөнөөр оны турш нийт импортын барааны үнийн өсөлт инфляцын талаас илүү хувийг бүрдүүлэв. Оны эцсийн байдлаар инфляцад өндөр нөлөөлсөн хүчин зүйлсийг дэлгэрүүлбэл (Хүснэгт 1.1):


- **Хүнсний бус импортын бараа** жилийн 12.6 хувиар нэмэгдэж, инфляцын 4.4 нэгж хувийг бүрдүүллээ. Үүнд, 1) нийлүүлэлтийн сүлжээний доголдол, хүнс, түүхий эдийн үнийн өсөлт, эрчим хүчний хомсдол зэргээс шалтгаалж дэлхий нийтэд инфляц эрчимжсэн 2) ханшийн сулрал, тээврийн саатлаас үүдэлтэй зардлын өсөлт зэрэг нь үнэ өсөхөд голлон нөлөөлөв
- **Махнаас бусад дотоодын хүнсний үнийн өсөлт** инфляцын 3.5 нэгж хувийг бүрдүүлэв. Үүнд, 1) үр, бордоо, шатахууны үнийн өсөлтөөс үүдэн дотоодын улаанбуудайн үнэ нэмэгдсэнээр гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ оны сүүлийн улиралд эрчтэй өсөв 2) импортын орц, шатахууны үнэ өссөнөөр сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ өндөр өссөн нь уг бүлгийн үнэ өсөх гол шалтгаан болов.

- **Үйлчилгээний** үнэ жилийн 9.7 хувиар нэмэгдэж инфляцын 1.6 нэгж хувийг бүрдүүлэв. Хөл хорионы дэглэм бүрэн цуцлагдаж, үйлчилгээний салбар идэвхэжсэн, үйлдвэрлэлийн орц, зардлын өсөлт зэрэг нь үнэ өсөхөд голлон нөлөөлсөн.
- **Дотоодын бараа** инфляцын 1.7 нэгж хувийг бүрдүүлэхэд 1) 2021 оны 10 дугаар сараас тайлант оны 4 дүгээр сар хүртэл сайжруулсан түлшийг 50 хувийн хөнгөлөлттэй худалдаалсан суурь нөлөөгөөр сайжруулсан түлш инфляцын 0.7 нэгж хувийг бүрдүүлэв 2) бусад дотоодын барааны үнэ жилийн 19.1 хувь өсөхөд орц, үйлдвэрлэлийн зардлын өсөлт нөлөөлөв.


Ажил эрхлэлт

Хөдөлмөрийн захын үндсэн үзүүлэлтүүдийг авч үзвэл 2022 онд өмнөх оноос сайжирсан байна. Тухайлбал, ажиллах хүчний тоо өмнөх оноос 1.6 хувиар нэмэгдсэн нь бүхэлдээ ажиллагчид өссөнтэй холбоотой юм. Мөн ажилгүй иргэдийн тоо өмнөх оноос 16 хувиар буурч, ажилгүйдлийн түвшин 2010 оноос хойшхи хамгийн доод түвшин болох 6.7 хувьд хүрчээ. Харин ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо буурснаар хөдөлмөрийн насны хүн ам өмнөх оноос 29 мянгаар багассан байна. Ийнхүү ажиллах хүч нэмэгдэж, ажиллах хүчнээс гадуурх хүн ам буурсан нь ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оноос 1.7 нэгж хувиар нэмэгдэх үндэс боллоо (Зураг 1.4, Зураг 1.5).

Зураг 1.4. Ажиллах хүчний оролцооны түвшин




Зураг 1.5. Ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Улсын хэмжээнд нийт ажилчдын тоог эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар авч үзвэл 2022 онд 452 мянга (38.9 хувь) нь үйлчилгээний салбарт, 293 мянга (25.3 хувь) нь хөдөө аж ахуйн салбарт, 273 мянга (23.5 хувь) нь аж үйлдвэрийн салбарт, 143 мянга буюу 12.3 хувь нь худалдааны салбарт тус тус ажиллаж байна. Нийт ажилчдын тоо 2022 онд өмнөх оноос 3.1 хувиар нэмэгдэж, 1 сая 161 мянгад хүрсэн бөгөөд өсөлтөд аж үйлдвэрийн болон үйлчилгээний салбарт ажиллагсадын тоо нэмэгдсэн нь нөлөөллөө (Зураг 1.6). Харин худалдааны салбарт ажиллагчдын тоо өмнөх оноос 0.6 хувиар буюу 6 мянган хүнээр буурч, хөдөө аж ахуйн салбарын ажилчдын тоо өмнөх оны түвшинд тогтвортой байв.

Зураг 1.6. Ажилчдын тооны жилийн өөрчлөлт, хувиар, гол бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.2 ГАДААД СЕКТОР

Гадаад эдийн засгийн орчин

Зэс: Зэсийн үнэ 2022 оны дунджаар тонн тутамд 8796.2 ам.доллар болж, өмнөх жилийн дунджаас 5.5 хувиар бага байв. 2022 оны эцэст зэсийн үнэ эргэн нэмэгдэхэд БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлогын хязгаарлалтууд суларч, үл хөдлөх хөрөнгийн салбар дахь хөрөнгө оруулалт өсөх хүлээлт үүссэн нь нөлөөлсөн байна.

Төмрийн хүдэр: Төмрийн хүдрийн үнэ 2022 онд дунджаар 113.1 ам.доллар/тонн-д хүрч өмнөх оноос 27.7 хувиар буурлаа. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын хямралаас үүдэн төмрийн хүдрийн үнэ 2022 оны 10 дугаар сард сүүлийн 3 жилийн доод түвшиндээ хүрээд байсан бол 12 дугаар сарын эцэст 107.5 ам.долларт хүрч өмнөх сараас 11.9 хувиар нэмэгджээ. БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлогын арга хэмжээ суларч байгаа нь төмрийн хүдрийн эрэлт нэмэгдэнэ гэсэн хүлээлтийг зах зээлд үүсгээд байна.

Алт: Алтны үнэ 2022 онд унц тутамдаа дунджаар 1795.7 ам.доллар хүрч өмнөх жилээс 0.1 хувиар нэмэгдэв. АНУ-ын Холбооны нөөцийн банк 2022 оны эхэн үед бодлогын хүүгээ эрчтэй нэмэгдүүлсэн нь ам.долларын харьцангуй өгөөжийг нэмэгдүүлж, алтны үнэ буурах нөхцөлийг бүрдүүлж байв. Харин 2022 оны сүүлийн хагаст дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч, зах зээлд тодорхой бус байдал нэмэгдэж алтны үнэ өсөх нөлөөг үзүүлсэн.


Коксжих нүүрс (БНХАУ): БНХАУ-ын коксжих нүүрсний үнэ 2022 онд дунджаар 350 ам.долларт хүрч өндөр түвшинд хадгалагдлаа. Геополитикын хүндрэлээс үүдэлтэй эрчим хүчний хямрал, БНХАУ-ын Тэг-Ковид бодлого суларсан зэрэг нь нүүрсний үнийг дэмжив.

Газрын тос: Дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ 2022 онд нэг баррель нь дунджаар 116.4 ам.доллар болж жилийн өмнөхөөс 22 хувиар буурав. Оны эхний саруудад Орос-Украины асуудал, түүнээс улбаалсан хязгаарлалтууд газрын тосны үнийг огцом нэмэгдүүлээд байсан бол оны 2-р хагаст зарим улс орнууд ОХУ-с импортлох газрын тосны үнэд дээд хязгаар тогтоох шийдвэрийг хэлэлцэж, 12 дугаар сарын 2-нд нэг баррель нь 60 ам.доллараас хэтрүүлэхгүй байх шийдвэр гаргасан нь газрын тосны үнэ бууруулах нөлөөг үзүүлэв.


Төлбөрийн тэнцэл

2022 оны жилийн гүйцэтгэлээр урсгал ба хөрөнгийн данс 2,149 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 1,644 сая ам.долларын ашигтай гарснаар, төлбөрийн тэнцлийн алдагдал 727 сая ам.долларт хүрсэн. Алдаа ба орхигдуулга 222 сая ам.доллар байна.

Зураг 1.7. Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл




Зураг 1.8. Урсгал ба хөрөнгийн дансны тэнцлийн бүтэц




Эх сурвалж: Монголбанк

Урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2,149 сая ам.долларын алдагдалтай гарсан нь өнгөрсөн оноос 8 хувиар буюу 155 сая ам.доллараар өссөн дүн бөгөөд үүнд үйлчилгээний дансны алдагдал голлон нөлөөлжээ.

Зураг 1.9. Санхүүгийн дансны тэнцлийн бүтэц



Зураг 1.10. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бүтэц



Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн дансны тэнцэл 1,644 сая ам.долларын ашигтай гарч өнгөрсөн оны гүйцэтгэлээс 17 хувиар буюу 338 сая ам.доллараар буурсан үзүүлэлт байна.

Барааны гадаад худалдаа¹

Монгол Улсын барааны гадаад худалдааны тэнцэл 2022 онд 3,834 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оноос 60 хувиар буюу 1,439 сая ам.доллаароор өссөн үзүүлэлт юм. Тодруулбал, импорт 27 хувиар буюу 1,859 сая ам.доллаароор, экспорт 36 хувиар буюу 3,297 сая ам.доллаароор тус тус өсч, худалдааны нийт эргэлт өмнөх оноос 32% хувиар буюу 5,156 сая ам.доллаароор өссөн байна.

Хүснэгт 1.2. Барааны гадаад худалдаа, сая ам.доллар

Төрөл	2018	2019	2020	2021	2022	Өөрчлөлт (22'/21')	
						Дүн	Хувь
Эргэлт	12,887	13,747	12,875	16,087	21,243	5,156	32%
Экспорт	7,012	7,620	7,576	9,241	12,539	3,297	36%
Импорт	5,875	6,128	5,299	6,845	8,704	1,859	27%
Тэнцэл	1,137	1,492	2,277	2,396	3,834	1,439	60%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Экспорт: Төмрийн хүдэрийн экспорт өнгөрсөн оны түвшнээс 561 сая ам.доллаароор, зэсийн баяжмал 165 сая ам.доллаароор, мөнгөний хүдэр 36 сая ам.доллаароор, хайлуур жонш 33 сая ам.доллаароор, боловсруулаагүй нефтийн экспорт 32 сая ам.доллаароор тус тус буурсан хэдий ч чулуун нүүрсний экспорт 3,737 сая ам.доллаароор, мөнгөжөөгүй алт 123 сая ам.доллаароор, цайрын хүдэр 107 сая ам.доллаароор тус тус өссөний нөлөөгөөр уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оноос 37 хувиар буюу 3,142 сая ам.доллаароор өссөн байна.

Мөн мал аж ахуйн гаралтай экспорт 35 хувиар буюу 130 сая ам.доллаароор өссөн нь нийт экспортын өсөлтөд эергээр нөлөөлжээ.

Хүснэгт 1.3. Экспорт, голлох ангиллаар, сая ам.доллар

Төрөл	2018	2019	2020	2021	2022	Өөрчлөлт (22'/21')	
						Дүн	%
Уул уурхай	6,200	6,751	7,039	8,520	11,663	3,142	37%
Зэсийн хүдэр, баяжмал	2,012	1,796	1,778	2,900	2,735	-165	-6%
Мян.тонн	1,437	1,404	1,395	1,283	1,453	171	13%
Чулуун нүүрс	2,786	3,074	2,124	2,759	6,496	3,737	135%
Мян.тонн	35,758	36,467	28,587	15,688	31,694	16,006	102%
Төмрийн хүдэр, баяжмал	342	576	640	952	391	-561	-59%
Мян.тонн	7,449	8,449	8,202	7,106	4,732	-2,374	-33%
Мөнгөжөөгүй алт	144	418	1,788	1,005	1,127	123	12%
Кг	3,432	9,069	30,491	17,250	19,660	2,411	14%
Бусад	914	886	710	905	914	9	1%
Уул уурхайн бус	812	869	537	721	876	155	22%
Нийт дүн	7,012	7,620	7,576	9,241	12,539	3,297	36%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Экспорт 2022 онд өнгөрсөн оноос 36 хувиар буюу 3,297 сая ам.доллаароор өссөн ба тодруулбал үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 9 хувиар буурч, харин тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 91 хувиар өссөн. Тоо хэмжээний өөрчлөлтийн хувьд дийлэнх хувийг нүүрсний тоо хэмжээний өсөлт эзэлж байна.

¹ ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэсэн тоон мэдээлэл бөгөөд аргачлалын ялгаатай байдлаас шалтгаалан Төлбөрийн тэнцлийн статистикаас зөрүүтэй болно.

Импорт: 2022 онд импорт өнгөрсөн оны үзүүлэлтээс 27 хувиар буюу 1,859 сая ам.доллаар өсөхөд дараах хүчин зүйлс голлон нөлөөлөв. Үүнд:

Хэрэглээний барааны импорт өнгөрсөн оноос 502 сая ам.доллаар өссөн нь хүнс, автомашин, түүний сэлбэг хэрэгсэлийн импорт 441 сая ам.доллаар өссөнөөр тайлбарлагдана. Тэгвэл хөрөнгө оруулалтын шинж чанартай бүтээгдэхүүний импорт 20 хувиар буюу 551 сая ам.доллаар өсөхөд машин, механик тоног төхөөрөмж, эд ангийн импорт 12 хувиар, барилгын материалын импорт 38 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Нефтийн бүтээгдэхүүний импорт мөн өнгөрсөн оны гүйцэтгэлээс 592 сая ам.доллаар өссөн бөгөөд энэ нь дэлхийн зах зээл дээрх нефтийн бүтээгдэхүүний үнэ өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт 1.4. Импорт, голлох ангиллаар, сая ам.доллар


Төрөл	2018	2019	2020	2021	2022	Өөрчлөлт (22'/21')	
						Дүн	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	1,643	1,631	1,542	2,184	2,686	502	23%
Түргэн эдэлгээтэй	864	859	878	1,315	1,501	186	14%
Удаан эдэлгээтэй	779	772	664	869	1,185	316	36%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	2,396	2,661	2,290	2,757	3,308	551	20%
Машин, тоног төхөөрөмж, эд анги	1,512	1,801	1,419	1,768	1,987	219	12%
Барилгын материал	648	654	599	727	1,002	275	38%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	236	206	272	262	318	56	21%
Аж үйлдвэрлэлийн орц	717	665	634	762	966	204	27%
Нефтийн бүтээгдэхүүн	1,112	1,166	817	1,132	1,724	592	52%
Дизель түлш	577	669	432	590	960	370	63%
Мян.тонн	849	1,080	1,027	989	982	-7	-1%
АИ-92, АИ-95	264	289	222	353	535	182	52%
Мян.тонн	371	476	529	514	648	134	26%
А-80	45	38	23	38	26	-12	-32%
Мян.тонн	65	65	57	59	33	-26	-45%
Бусад нефтийн бүтээгдэхүүн	227	169	140	151	203	52	34%
Мян.тонн	292	223	250	202	170	-32	-16%
Бусад	7	5	15	11	21	10	95%
Нийт дүн	5,875	6,128	5,299	6,845	8,704	1,859	27%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк


Үйлчилгээний гадаад худалдаа

Үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 2022 онд өмнөх оноос 41%-иар өсөж 2,355 сая ам.долларт хүрсэн. Үйлчилгээний дансны алдагдал өсөхөд тээврийн үйлчилгээний алдагдал 365%-иар өсөж 763 сая ам.долларын алдагдалтай, бизнесийн бусад үйлчилгээний алдагдал 36%-иар өсөж 530 сая ам.долларт хүрсэн нь голлон нөлөөлжээ.

Зураг 1.11. Үйлчилгээний экспорт



Зураг 1.12. Үйлчилгээний импорт



Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 1.5. Үйлчилгээний гадаад худалдаа, сая ам.доллар

Үйлчилгээний гадаад худалдааны дансны нэр төрөл	2018	2019	2020	2021	2022	Өөрчлөлт (22'/21')	
						Дүн	%
1. Тээвэр	-561	-594	-212	-167	-763	-596	358%
2. Аялал жуулчлал	-415	-412	-521	-722	-745	-23	3%
3. Барилга, барилгын ажил үйлчилгээ	-165	-107	-97	-118	-60	59	-50%
4. Даатгал болон тэтгэврийн үйлчилгээ	-21	-23	-21	-24	-23	1	-5%
5. Санхүүгийн үйлчилгээ	-121	-207	-145	-151	-149	1	-1%
6. Оюуны өмч ашиглах эрхийн төлбөр	-15	-25	-23	-30	-32	-1	5%
7. Харилцаа холбоо, компьютер, мэдээллийн үйлчилгээ	-64	-55	-70	-97	-75	22	-22%
8. Бизнесийн бусад үйлчилгээ	-590	-546	-343	-363	-487	-123	34%
9. Бусад үйлчилгээ	-27	-23	-18	-4	-22	-18	514%
Нийт үйлчилгээ	-1,978	-1,992	-1,450	-1,675	-2,355	-680	41%

Эх сурвалж: Монголбанк

Гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2022 оны эцсийн гүйцэтгэлээр -41,936 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 6%-иар буюу 2,203 сая ам.доллаароор нэмэгдсэн байна.

Монгол Улсаас гадагш хийсэн нийт хөрөнгө оруулалтын дүн буюу гадаад актив 6,898 сая ам.доллар, үүний 50%-ийг гадаад валютын улсын нөөц, 30%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 13%-ийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 7%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.

Монгол Улсад оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн буюу пассив 48,834 сая ам.доллар, үүний 58%-ийг шууд хөрөнгө оруулалтын пассив, 34%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 7%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 54% буюу 15,337 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, 46% буюу 13,185 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг, санхүүжилт эзэлж байна.

Хүснэгт 1.6. Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын позиц, сая ам.доллар

А. ГАДААД АКТИВ	6,898	Б. ГАДААД ПАССИВ	48,834
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	907	1. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)	28,521
2. Багцын хөрөнгө оруулалт	505	2. Багцын хөрөнгө оруулалт	3,498
3. Санхүүгийн дериватив	1	3. Санхүүгийн дериватив	1
4. Бусад хөрөнгө оруулалт	2,085	4. Бусад хөрөнгө оруулалт	16,814
5. Нөөц актив	3,400		
		В. ПОЗИЦ	-41,936

Эх сурвалж: Монголбанк

Гадаад хөрөнгө оруулалтын позицийн жилийн өөрчлөлтийг данс бүрээр тайлбарлавал

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 2,157 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 219 сая ам.доллар тус тус өсөж, багцын хөрөнгө оруулалтын богино позиц 1,115 сая ам.доллараар, гадаад валютын албан нөөц 966 сая ам.доллараар тус тус буурсан дүнтэй байна.

Хүснэгт 1.7. Гадаад хөрөнгө оруулалтын позицын өөрчлөлт, сая ам.доллар

Үзүүлэлтүүд	2018	2019	2020	2021	2022	Өөрчлөлт (22'/21')	
						Дүн	%
Гадаадын шууд хөрөнгө оруулалтын позиц	-19,690	-21,891	-23,510	-25,457	-27,614	-2,157	8%
Багцын хөрөнгө оруулалтын позиц	-4,589	-5,146	-4,301	-4,143	-2,992	1,151	-28%
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн позиц	-1	9	4	11	0	-11	-100%
Бусад хөрөнгө оруулалтын позиц	-12,891	-13,144	-14,037	-14,510	-14,729	-219	2%
Гадаад валютын улсын нөөц	3,542	4,341	4,526	4,366	3,400	-966	-22%
Нийт позиц	-33,630	-35,831	-37,318	-39,733	-41,936	-2,203	6%

Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсад орсон шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийг хөрөнгө оруулагч улсаар нь ангилан харуулбал (урьдчилсан гүйцэтгэл): Нидерланд 40%, БНХАУ 18%, Сингапур 8%, Хонг-Конг 5%, Япон улс 5%, Люксембург 3%-ийг бүрдүүлж байна. Харин үлдэгдлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилан харуулбал, уул уурхайн салбарт нийт хөрөнгө оруулалтын 71%, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 8%, санхүү даатгалын салбарт 5%, үйлчилгээний бусад салбарт 3%, барилгын салбарт 3% нь тус тус орсон байна.

Зураг 1.13. Монгол Улсад орсон ШХО-ын үлдэгдэл улсаар, нийт дүнд эзлэх хувь




Эх сурвалж: Монголбанк

2022 оны гүйцэтгэлээр Монгол улсаас гадагш хийсэн багцын хөрөнгө оруулалтын үлдэгдэл (актив) 505 сая ам.долларт хүрсэн бол Монгол улсад оруулсан багцын хөрөнгө оруулалтын үлдэгдэл (пассив) 3,498 сая ам.доллар байна.

Багцын хөрөнгө оруулалтын активыг хөрөнгө оруулагч улсаар ангилвал (урьдчилсан гүйцэтгэл): АНУ-д 25%, Хонг-Конг улсад 23%, Сингапур 21%, Австрали болон Их Британи улсад тус тус 4%, Канад улсад 3%-ийн хөрөнгө оруулалтыг тус тус хийсэн байна. Харин пассивыг хөрөнгө оруулагч улсаар ангилбал: нийт багцын хөрөнгө оруулалтын 13% нь АНУ-аас, 4% нь Швейцарь улсаас, тус тус 3% нь Сингапур болон Их Британи улсаас, харгалзан 2% нь Герман болон Хонг-Конг улсаас тус тус орж ирсэн байна.

Зураг 1.15. Багцын хөрөнгө оруулалтын актив, нийт дүнд эзлэх хувь




Эх сурвалж: Монголбанк

Зураг 1.14. Монгол Улсад орсон ШХО-ын үлдэгдэл салбараар, нийт дүнд эзлэх хувь



Зураг 1.16. Багцын хөрөнгө оруулалтын пассив, нийт дүнд эзлэх хувь



Гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2022 оны гүйцэтгэлээр 33,345 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 1%-иар буюу 461 сая ам.доллаар буурав. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын гадаад улсаас авсан хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл, өрийн бичгийн үлдэгдэл 5%-иар буюу 442 сая ам.доллаар буурсан.
- Төв банкны гадаад өр зээлийн төлөлт болон хашийн өөрчлөлтөөс шалтгаалан 17%-иар буюу 431 сая ам.доллаар буурсан.

- Хувийн салбарын гадаад өр арилжааны зээл болон худалдааны зээлийн өсөлтөөс шалтгаалан 2%-иар буюу 412 сая ам.доллароор өссөн дүнтэй байна.

Хүснэгт 1.8. Монгол Улсын нийт гадаад өр, сая ам.доллар

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022	Өөрчлөлт (22'/21')	
						Дүн	%
НИЙТ ГАДААД ӨР	28,715	30,702	32,362	33,806	33,345	-461	-1%
Засгийн газар	7,184	7,806	8,654	8,454	8,012	-442	-5%
Засгийн газрын гадаад өр/ДНБ (%)	55%	55%	65%	55%	48%	-0.1	-14%
Төв банк	2,030	1,985	2,221	2,610	2,179	-431	-17%
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	2,230	2,138	1,651	1,627	1,533	-94.0	-5.78%
Богино хугацаат	764	610	594	361	224	-137	-38%
Урт хугацаат	1,466	1,528	1,057	1,265	1,308	43	3%
Бусад сектор	8,042	8,407	8,430	8,843	8,436	-406	-5%
Богино хугацаат	609	562	683	812	1,622	810	100%
Урт хугацаат	7,433	7,845	7,747	8,030	6,814	-1217	-15%
Хөрөнгө оруулагчаас авсан зээл	9,228	10,366	11,406	12,272	13,185	913	7%

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

Засгийн газрын гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2018-2019 онд 55% байсан бол 2020 онд 65%-д хүрч өсч, 2022 онд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, Засгийн газрын гадаад өрийн бууралтаас шалтгаалан 48%-д хүрч эргэн буурсан үзүүлэлттэй байна (олон улсын аргачлалын дагуу Хөгжлийн банкны гадаад өрийг бусад сектор хэсэгт ангилсан).

1.3 МӨНГӨ, САНХҮҮГИЙН СЕКТОР


Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд

Мөнгөний нийлүүлэлт (M2² мөнгө) 2021 онд жилийн 13.8 хувийн өсөлттэй байсан бол 2022 оны эхнээс өсөлт хурдтай саарч 8 дугаар сард -1.7 хувьд хүрэв. Харин 2022 оны сүүлийн саруудад тогтвортой өсөж эхэлсэн бөгөөд 12 дугаар сард огцом өсөж 6.5 хувьд хүрсэн байна. M2 мөнгөний жилийн өсөлтийг эх үүсвэр талаас нь задалж үзвэл гадаад валютын харилцах 9.3 нэгж хувийг, гадаад валютын хадгаламж 3.4 нэгж хувийг, төгрөгийн харилцах 2.5 нэгж хувийг, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө -0.1 нэгж хувийг, төгрөгийн хадгаламж -8.7 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл 2022 онд мөнгөний нийлүүлэлт өсөхөд гадаад валютын харилцах 2.6 их наяд төгрөгөөр, гадаад валютын хадгаламж 936.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн бол төгрөгийн хадгаламж 2.4 их наяд төгрөгөөр буурч сөрөг нөлөөг үзүүлэв. Хөрвөх чадвартай мөнгө болох M1³ мөнгө 2022 онд мөнгөний нийлүүлэлт өсөхөд 2.5 нэгж хувиар нөлөөлсөн ба төгрөгийн харилцах 710.2 тэрбум төгрөгөөр өсөж, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 16.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

² M2=M1+бусад хадгаламж

³ M1=Төгрөгийн харилцах+Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө


Зураг 1.17. Мөнгөний нийлүүлэлт, эх үүсвэр талаас
Жилийн өсөлтийн бүрэлдэхүүн



Эх сурвалж: Монголбанк

Мөнгөний нийлүүлэлтийн жилийн 6.5 хувийн өсөлтийг байршуулалт талаас нь задалбал аж ахуйн нэгжээс авах авлага 15.4 нэгж хувийг, Засгийн газрын цэвэр зээл -4.2 нэгж хувийг, гадаад цэвэр актив -4.7 нэгж хувийг эзэлж байна. Банкуудын зээлийн өсөлт 2022 оны дундаас саарч эхэлсэн ч өмнөх оны хандлагатай адил мөнгөний нийлүүлэлтэд эерэг нөлөө үзүүлж байгаа бол гадаад цэвэр актив бууруулах нөлөөтэй байв.

Зураг 1.18. Мөнгөний нийлүүлэлт, байршуулалт талаас
Жилийн өсөлтийн бүрэлдэхүүн




Эх сурвалж: Монголбанк


Банкуудын зээл 2022 оны эхнээс өсөж 4 дүгээр сард жилийн өсөлт хамгийн өндөр КОВИД-19 цар тахлын өмнөх үеийн түвшин буюу 28.9 хувьд хүрсэн боловч хагас жилээс өсөлтийн хурд саарч оны эцэст огцом буурч зээлийн өсөлт 6.5 хувь болж өмнөх оны мөн үеэс 14.8 нэгж хувиар буурч 22.0 их наяд төгрөгт хүрэв. Хэрэглээний⁴ болон хадгаламж барьцаалсан зээл оны туршид өссөн бөгөөд 2022 оны эцэст 3.1 хувиар нэмэгдэв. Уул уурхай, үл хөдлөх, худалдааны салбарын зээлийн жилийн өсөлт өмнөх онтой харьцуулахад саарсан бөгөөд оны эцсийн байдлаар худалдааны салбар 3.1 хувь, үл хөдлөх 2.3 хувиар өссөн бол боловсруулах үйлдвэрлэл 0.7 хувь, уул уурхай 3.3 хувиар буурчээ.

⁴ Хэрэглээний зээл=Цалин+Тэтгэвэр+Картын зээл+Малчны зээл+бусад хэрэглээний зээл


Бүтэц



Бүтэц



Зураг 1.19. Банкуудын зээлийн үлдэгдэл, салбарын ангиллаар



Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн үлдэгдлийн бүтцийг авч үзвэл хэрэглээний ба хадгаламж барьцаалсан зээл нийт зээлийн 27.1 хувь (өмнөх оноос +1.3 нэгж хувь), худалдааны салбарын зээл 21.6 хувь (+1.7 нэгж хувь), үл хөдлөх хөрөнгийн салбарын зээл 15.5 хувь (+1.3 нэгж хувь)-ийг тус тус эзэлж байна. Харин 2022 оны эцэст цар тахлын үед хойшлогдсон зээлийн эргэн төлөлтүүд хийгдсэнтэй холбоотойгоор уул уурхайн салбарын зээлийн нийт зээлд эзлэх хувь 2021 оноос 3.6 нэгж хувиар буурч нийт зээлийн 5.3 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын зээлийн эзлэх хувь 1.1 нэгж хувиар буурч нийт зээлийн 6.9 хувийг тус тус бүрдүүлж байна.


Санхүүгийн салбар

Монгол Улсын санхүүгийн салбарт 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 12 банк, 513 банк бус санхүүгийн байгууллага, 196 хадгаламж зээлийн хоршоо, 18 даатгалын компани, 63 даатгалын зуучлагч компани, 25 даатгалын хохирол үнэлэгч компани, 2,376 даатгалын төлөөлөгч үйл ажиллагаа явуулж байна. Банкнаас бусад санхүүгийн салбарын үйл ажиллагааны цар хүрээ жилээс жилд нэмэгдэж буй боловч нийт санхүүгийн зах зээлийн 90 гаруй хувийг банкны салбар дангаараа бүрдүүлсэн хэвээр байгаа юм.

Зураг 1.20. Санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбарын ДНБ-нд эзлэх хувь хэмжээ



Зураг 1.21. Санхүүгийн дэд салбаруудын нийт салбарт эзлэх хувь хэмжээ /2022 он, активын хэмжээгээр/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын нийт актив 2022 оны эцэст өмнөх оны мөн үеэс 30.1 хувиар өсч 3.5 их наяд төгрөгт хүрчээ. Түүнчлэн ББСБ-ын зээлийн багц өмнөх оны мөн үеэс 35.3 хувиар буюу 710.5 тэрбум төгрөгөөр өссөн нь нийт активын өсөлтийн 26.2 хувийг тайлбарлаж байна. ББСБ-ын зээлийн өрийн үлдэгдлийн 88.5 хувь нь хэвийн, 3.9 хувь нь хугацаа хэтэрсэн, 7.6 хувь нь чанаргүй зээл байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.4 нэгж хувиар, хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь 0.6 нэгж хувиар тус тус өссөн дүнтэй байна.

Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-дын нийт активын хэмжээ 2022 оны эцсийн байдлаар өмнөх онтой харьцуулахад 8.1 хувиар буурч 267.7 тэрбум төгрөгт, ХЗХ-дын нийт зээлийн үлдэгдэл 4.0 хувиар буурч 205.0 тэрбум төгрөгт тус тус хүрчээ. ХЗХ-дын нийт зээлийн багцын 3.4 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байна.

Даатгалын салбарт 2022 оны эцэст ердийн даатгалын 15, урт хугацаат даатгалын 2, давхар даатгалын 1 компани нийт 18 даатгагч үйл ажиллагаа явуулж байна. Даатгалын компаниудын нийт активын хэмжээ 474.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.6 хувиар өссөн байна. Даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 304.8 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд нийт хураамжийн орлогын 31.0 хувь буюу 94.4 тэрбум төгрөгийг даатгалын нөхөн төлбөрт олгосон байна. 2021 оны эцсийн байдлаарх ашигт ажиллагааны үзүүлэлтүүдтэй харьцуулахад активын өгөөж 1.8 нэгж хувиар, өөрийн хөрөнгийн өгөөж 3.7 нэгж хувиар тус тус буурчээ.


Үнэт цаасны арилжаа 2022 онд нийт 580.5 тэрбум төгрөгийн дүнтэй хийгдсэний 59.1 хувийг хувьцааны арилжаа, 23.1 хувийг компанийн бондын арилжаа, 17.0 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа, 0.7 хувийг хөрөнгө оруулалтын сангийн арилжаа тус тус эзэлжээ. Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 6.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 907.5 тэрбум төгрөгөөр буюу 15.2 хувиар нэмэгджээ.

Хүснэгт 1.9. Банкаас бусад санхүүгийн салбарын голлох үзүүлэлтүүд /2022 он, тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	ББСБ	ХЗХ	Даатгал
Актив	3,527.0	267.7	474.9
Өр төлбөр	1,335.4	207.9	263.8
Эзэмшигчдийн өмч	2,191.6	59.8	211.1
Зээлийн өрийн үлдэгдэл	2,722.6	205.0	-
Чанаргүй зээл	207.0	7.0	-
Тайлант үеийн ашиг	312.9	11.6	18.5
Даатгалын хураамжийн орлого	-	-	304.8
Даатгалын нөхөн төлбөр	-	-	94.4

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Зураг 1.22. Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо

Банкны салбар


Банкны салбар тайлант оны эцсийн байдлаар нийт 12 банк, 16,203 ажилтан, 1,393 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт хадгаламжийн дансны тоо 3230.8 мянга, харилцахын дансны тоо 6310.9 мянга, зээлдэгчдийн дансны тоо 1497.4 мянгад тус тус хүрлээ.

Банкны салбарын нийт актив өмнөх оноос 12.3 хувиар буюу 5.0 их наяд төгрөгөөр өсөж 46.0 их наяд төгрөгт хүрэв. Активын дийлэнх хувийг иргэд, байгууллагад олгосон зээл бүрдүүлж байна.


Банкны салбарын зээл 2022 оны эцсийн байдлаар нийт активын 47.2 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд өмнөх оноос 6.7 хувиар буюу 1.4 их наяд төгрөгөөр өсөж 21.7 их наяд төгрөгт хүрэв. Зээлийн өсөлтийг

өмнөх онтой харьцуулахад 2.5 нэгж хувиар буурсан байгаа бөгөөд иргэдийн зээлийн өсөлт эергээр нөлөөлжээ.

Зураг 1.23. Зээлийн өсөлт



Зураг 1.24. Зээлийн чанар





Эх сурвалж: Монголбанк

Тайлант оны эцсийн байдлаар нийт зээлийн 7.8 хувь нь чанаргүй, 5.2 хувь нь анхаарал хандуулах зээл байна. Банкуудын зээл олгосон голлох салбаруудаас уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарын чанаргүй зээлийн хувь 2022 оны эцэст харгалзан 31.3, 21.5, 21.3 хувь байгаа нь банкны системийн дунджаас өндөр байгаа бол үл хөдлөх хөрөнгө 3.8 хувь, худалдааны салбар 4.8 хувьтай байгаа нь бусад салбаруудтай харьцуулахад бага байна.

Банкуудын харилцах, хадгаламж 2022 оны эцсийн байдлаар пассивын 70.0 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд өмнөх оноос 6.7 хувиар өсөж 28.7 их наяд төгрөгт хүрсэн байна. Харилцах, хадгаламжийн өсөлтийг өмнөх онтой харьцуулахад 7.1 нэгж хувиар буурчээ. Тодруулбал, хадгаламж өмнөх оноос 8.0 хувиар буурч 17.4 их наяд төгрөгт хүрэв. Хадгаламжийн жилийн өсөлт өмнөх оноос 12.0 нэгж хувиар буурсан бөгөөд үүнд иргэдийн төгрөгийн хадгаламж буурсан нь нөлөөлжээ. Харин харилцах өмнөх оноос 41.4 хувиар буюу 3.3 их наяд төгрөгөөр өсөж 11.3 их наяд төгрөгт хүрсэн нь байгууллагын гадаад валютын харилцах нэмэгдсэнээр тайлбарлагдаж байна.

Зураг 1.25. Харилцах, хадгаламжийн өсөлт




Эх сурвалж: Монголбанк

Банкуудын өөрийн хөрөнгө өмнөх оноос 24.3 хувиар буюу 1.0 их наяд төгрөгөөр өсөж 5.0 их наяд төгрөгт хүрэв. Тайлант онд 2020 оноос хэрэгжиж буй банкны салбарын шинэтгэл, эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөрийн хүрээнд системийн нөлөө бүхий банкууд олон нийтэд хувьцаагаа арилжаалж, хувьцаат компани өмчлөлийн хэлбэрт шилжсэн нь нэмж төлөгдсөн хувьцааг нэмэгдүүлжээ. Банкуудын ашиг

2022 онд өмнөх оноос 0.5 их наяд төгрөгөөр өсөж 1.0 их наяд төгрөгт хүрсэн ба активын өгөөж 2.4 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 17.0 хувь хувьд хүрсэн байна.


Банкны салбарийн нийт орлогын 45 хувь нь хүүний орлого, 41 хувь нь ханшийн үнэлгээний орлого, 14 хувь нь бусад орлого байв. Хүүний орлогын 73 хувийг зээлийн хүүнээс, 18 хувийг үнэт цаасны хүүнээс олжээ. Харин банкуудын нийт зардлын 46 хувь нь ханш, үнэлгээний тэгшитгэлийн, 23 хувь нь хүүний, 31 хувь нь бусад зардал байна. Хүүний зардлыг авч үзвэл, 68 хувь нь хадгаламжинд төлсөн хүүний, 18 хувь нь зээлийн хүүнд зарцуулагджээ.

Зураг 1.26. Өөрийн хөрөнгийн бүтэц



Эх сурвалж: Монголбанк

Зураг 1.27. Орлого, зарлагын бүтэц



1.4. УЛСЫН ТӨСӨВ

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр 17'199 тэрбум төгрөг, нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 18'178 тэрбум төгрөгт хүрч, төсвийн тэнцэл 979 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.9 хувьтай тэнцүү алдагдалтай байв (Хүснэгт 1.10).

Хүснэгт 1.10. Төсвийн үндсэн үзүүлэлтүүд

их наяд төгрөг	2021		2022		2022/2021
	Гүй.	Тод.	Урьд.Гүй.	Өөрчлөлтийн хувь	
Нийт орлого	14.3	16.3	18.6	30.4	
Сангуудын орлого	1.6	0.8	1.4	-10.9	
Тэнцвэржүүлсэн орлого	12.7	15.5	17.2	35.5	
Татварын орлого	11.3	13.6	15.6	38.2	
Татварын бус орлого	1.4	1.9	1.6	14.3	
Нийт зардал	15.6	17.9	18.2	16.5	
Анхдагч зардал	14.8	17.0	17.4	17.5	
Хүүний зардал	0.8	0.9	0.8	-1.4	
Нийт тэнцэл	-1.3	-1.6	0.4	-	
ДНБ-д эзлэх хувь	-3.0	-3.1	0.8	-	
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-2.9	-2.4	-1.0	-	
ДНБ-д эзлэх хувь	-6.6	-4.5	-1.9	-	
Анхдагч тэнцэл	-2.1	-1.5	-0.2	-	
ДНБ-д эзлэх хувь	-4.7	-2.8	-0.3	-	


Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

Тэнцвэржүүлсэн орлого 2022 онд 36 хувиар өсөж 17.2 их наяд төгрөгт хүрсэн байна. Эдийн засаг, гадаад худалдаа идэвхжиж, төсвийн ихэнх дэд бүлгийн орлого төлөвлөгөөнөөс давжээ (Зураг 1.28). Гол өссөн бүлгүүдээр задалбал:

- АМНАТ-ын орлого +1.4 их наяд (347.6 хувь)⁵ төгрөг: 2022 оноос Ирээдүйн өв сангийн орлогыг АМНАТ-ын орлогын бүлэгт бүртгэж эхэлсэн нь АМНАТ-ын орлого өмнөх оноос ийнхүү өндөр өсөхөд гол нөлөөллөө. Тодруулбал, АМНАТ-ын орлого нэмэгдсэний 84 хувийг ирээдүйн өв сангийн орлого бүрдүүлэв;
- НӨАТ-ын орлого: +1.1 их наяд (38.1 хувь) төгрөг;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого +768 тэрбум (34.0 хувь) төгрөг: Эдийн засаг тэлж, 2022 оноос эхлэн НДШ-ийн хувь хэмжээ хөнгөлөлтгүй⁶ буюу 26 хувиар хэрэгжиж эхэлсэн зэрэг нь НДШ-ийн орлогод эергээр нөлөөлөв;
- ААНОАТ-ын орлого: +464 тэрбум (20.9 хувь) төгрөг;
- Импортын барааны гаалийн албан татвар: +349 тэрбум (37.0 хувь) төгрөг;
- ХХОАТ-ын орлого: +217 тэрбум (19.1 хувь) төгрөгөөр нэмэгджээ.

Зураг 1.28. Төсвийн орлогын бүтэц



Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зардал

Урьдчилсан дүнгээр 2022 онд төсвийн татаас, шилжүүлгийн зардал 33 хувь орчим өссөн бол бусад зардал нийлбэртээ 2021 оны түвшинд байв (Зураг 1.29). “Хуримтлалтай хүүхэд”, КОВИД-19 тусламж үйлчилгээ, тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, боловсролын салбарт гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоо хэрэгжүүлж, хувьсах зардлыг салбар хариуцсан яамд шийдэхээр болсон зэрэг арга хэмжээний үр дүнд **төсвийн татаас, шилжүүлгийн зардал** цар тахлын өмнөх буюу 2019 оны мөн үетэй харьцуулахад **3 дахин** нэмэгдэж, төсвийн зардлын 53⁷ хувийг дангаар эзлэв. Татаас, шилжүүлгийн зардлын дэд бүлгүүдийг өмнөх онтой харьцуулбал:

- Боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилт⁸: + 1.4 их наяд төгрөг;
- Өндөр насны тэтгэвэр: + 616 тэрбум (34.4 хувь) төгрөг;
- Ковид-19 тусламж үйлчилгээ: + 297 тэрбум төгрөг;
- Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж: + 151 тэрбум (11.3 хувь) төгрөгөөр өсжээ.


⁵ Хаалтанд тухайн бүлгийн орлого өссөн хувийг үзүүлэв.

⁶ Хөнгөлөлтийн хувь: 2020 оны 4-9 дүгээр сард 20 хувь, 2020 оны 10-12 дугаар сард 10 хувь, 2021 оны 1-6 дугаар сард 5 хувиар НДШ хөнгөлсөн.

⁷ 2010-2020 оны дундаж 32 хувь, 2021 онд 47 хувь

⁸ 2022 оноос эхлэн боловсролын салбарт мөн хэрэгжүүлж эхэллээ.

Зураг 1.29. Төсвийн зардлын бүтэц



Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн алдагдал, өр төлөхөд ашигласан эх үүсвэр

Тайлант онд гадаад зээл, үнэт цаас эргүүлэн төлөх, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд нийт 2.4 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдлаа. Үүнээс 1.7 их наяд төгрөгийг гадаад зээл, 680 тэрбум төгрөгийг дотоод үнэт цаас гарган санхүүжүүлжээ (Хүснэгт 1.11). Тухайлбал, 12 дугаар сард “Чингис” бондын сүүлийн төлбөр болох 136 сая ам.доллар буюу 520 тэрбум төгрөгийг Төрийн сангаас төлж барагдуулсан байна.

Хүснэгт 1.11. Санхүүжилтийн шаардлага болон эх үүсвэр бүрдүүлсэн байдал

Их наяд төгрөг	2021	2022	Өөрчлөлт
	Гүй.	Урьд.Гүй.	
Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2.9	1.0	-1.9
Харилцах болон хадгаламжийн данс	2.2	-0.7	-2.9
ЗГ-ийн бонд	-0.6	-0.1	0.4
Шинээр гаргах	2.8	0.7	-2.1
Үндсэн төлбөр	-3.4	-0.8	2.6
ЗГ-ийн зээл	0.6	1.1	0.5
Шинээр гаргах	1.3	1.7	0.4
Үндсэн төлбөр	-0.7	-0.6	0.1
ТС-ийн хуримтлагдсан үлдэгдэл	0.7	0.8	0.0
Өмч хувьчлал	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

2.1 МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТ, ХЭРЭГЖИЛТ


Мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлж, хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2022-2024 онд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулах зорилт тавин ажиллаж байна.

Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляц 2022 оны 12 дугаар сард улсын хэмжээнд жилийн 13.2 хувь, Улаанбаатар хотод 12.9 хувь буюу зорилтот интервал (6 хувь (+/-2))-аас өндөр байв. Эрэлтийн шалтгаантай инфляц алгуур нэмэгдэх хандлагатай байсан хэдий ч гадаад хүчин зүйлсээр өдөөгдсөн зардлын шалтгаантай үнийн өсөлтийн нөлөө тайлант оны туршид өндөр байлаа.

Гадаад хүчин зүйлсээс 1) тээвэр, логистикийн нөхцөл сайжирч байгаа ч тээврийн зардал хэвийн үеэс 2 дахин өндөр, худалдааны түнш орнуудын өндөр инфляц, ханш суларсан зэргээс импортын барааны үнэ эрчтэй нэмэгдсэн, 2) шатахууны үнэ, импортын орцын үнийн өсөлттэй холбоотойгоор дотоодын бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зардал нэмэгдэж үнэ өссөн нь инфляцад голлох нөлөөтэй байв.

Тайлант оны эхний хагаст хилийн хязгаарлалтаас үүдэн тээвэр, логистикийн зардал эрчтэй нэмэгдсэн, олон улсад үүссэн геополитикийн нөхцөл байдлаас үүдэн газрын тос, хүнсний үнэ нэмэгдсэн нь инфляц хурдацтайгаар өсөхөд голлон нөлөөлсөн. Оны сүүлийн хагаст тээврийн саатал багассан, импортын хүнсний үнийн өсөлт саарсан, шатахууны үнэ тогтворжиж, огцом өсөөд байсан хүнсний үнэ буурч, дотоодын мах махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оноос илүүтэйгээр буурсан нөлөөгөөр инфляц алгуур буурч эхэлсэн.

Зураг 2.1. Улсын жилийн инфляц, хувиар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тайлант онд цар тахалын нөхцөл байдал сайжирч өрхийн хэрэглээ сэргэж, 3-р улирлаас эхлэн хилийн хязгаарлалт суларч, экспорт нэмэгдснээр эдийн засаг сэргэж эхэлсэн. Гэвч макро эдийн засгийн эрсдэл, эмзэг байдал буураагүй, инфляц өсөж зорилтот түвшнээс давсан, төлбөрийн тэнцлийн алдагдал тэлсэн,

гадаад суурь хүү хүлээлтээс хурдан өссөн зэргээс шалтгаалан Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2022 онд ээлжит болон ээлжит бус 5 удаагийн хурлаар мөнгөний бодлогын төлөвийг чангаруулах шийдвэрийг гаргаж, хэрэгжүүлээ.

Монголбанкны МБХ 2022 оны 1 дүгээр сарын ээлжит бус хуралдаанаар коронавирусын омикрон хувилбарын тархалт нэмэгдэж, гадаад худалдааны тээврийн саатал үргэлжлэн импортын бараа, шатахууны үнээс гадна малын гоц халдварт өвчин, импортын хүнсний нийлүүлэлт доголдоноос мах, хүнсний ногооны үнэ нэмэгдэж, инфляц огцом өссөн. Иймээс нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлтийн дараа үеийн нөлөөг бууруулах, улмаар инфляцын хүлээлтийг дунд хугацаанд тогтворжуулах зорилгоор

1. Бодлогын хүүг 0.5 нэгж хувиар өсгөх;
2. Төгрөгийн татан төвлөрүүлсэн хөрөнгөд тооцох заавал байлгах нөөцийн хувийг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 8 хувьд хүргэх;
3. Уул уурхайн бус экспорт, боловсруулах аж үйлдвэрийн салбарт олгох урт хугацаат репо арилжааны санхүүжилтийн нөхцөлийг өөрчлөх; багц шийдвэрийг хэрэгжүүлсэн.

2022 оны эхний улиралд дэлхийн зах зээл дээрх газрын тос, хүнсний үнэ огцом өсөж, нийлүүлэлтийн сүлжээний доголдол үргэлжлэх, эдийн засгийн өсөлт саарах эрсдлийг олон улсын харилцаанд үүсээд байсан хурцадмал байдал бий болгож гадаад, дотоод эдийн засгийн тодорхой бус байдлыг ихээхэн нэмэгдүүлсэн. Үүний зэрэгцээ төлбөрийн тэнцлийн алдагдал тэлж, гадаад суурь хүү илүү хурдтай өсөж, төгрөгийн харьцангуй өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагыг бий болгосон. Иймээс МБХ-ны 3-р сарын хурлаар бодлогын хүүг 2.5 нэгж хувиар нэмэгдүүлж 9.0 хувьд хүргэх шийдвэрийг гаргасан.

Тайлант оны 2-р улиралд дэлхийн зах зээл дээрх газрын тос болон дотоодын шатахууны үнийн өсөлт эрчимжиж, тээвэр, логистикийн саатал үргэлжилж, үйлдвэрлэлийн орц болон тээврийн зардлыг нэмэгдүүлэн, гадаад өндөр инфляц, ханшийн сулралтаар импортын бараа, бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж, инфляц улам эрчимжсэн. Үүний зэрэгцээ хилийн хязгаарлалт, экспортын сааралт, гадаад үнийн өсөлт, импортын тэлэлттэй холбоотойгоор төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдсэн. Иймд инфляцын хүлээлтийг дунд хугацаанд тогтворжуулах, төгрөгийн өгөөжийг хадгалах зорилгоор МБХ бодлогын хүүг 1.0 нэгж хувиар өсгөсөн.

Өнгөрсөн оны 7-р сараас эхлэн хилийн хязгаарлалт тодорхой хэмжээнд суларч хэрэглээ тэлж, эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, импортын барааны үнийн өсөлт саарч, хүнсний голлох барааны үнэ улирлын хандлагаараа буурч эхэлсэн боловч инфляцын төсөөлөл зорилтот түвшнээс өндөр хэвээр байсан. Мөн гадаад зах зээлийн суурь хүү хүлээлтээс давж өсч, банкны системийн эх үүсвэрийн долларжилт нэмэгдсэн зэрэг нь төгрөгийн өгөөжийг ахин нэмэгдүүлэх шаардлагыг бий болгов. Иймд Мөнгөний бодлогын хороо 9-р сарын ээлжит хурлаараа


1. Бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 12 хувьд хүргэх;
2. Бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +2, -2 хувийн өргөнтэй болгох;
3. Банкуудын 360 хоног ба түүнээс дээш хугацаагаар гадаад зах зээлээс болон зээл хэлбэрээр татсан эх үүсвэрийг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрээс хасах

багц шийдвэрийг гаргасан. МБХ-ны ээлжит 12 дугаар сарын хуралдаанаар инфляц буурч эхэлсэн хэдий ч гадаад инфляц, хүнс болон шатахууны үнийн өсөлтийн нөлөө нэмэгдэх, төсвийн зардал, цалин өмнөх тооцооллоос өндөрөөр батлагдаж, инфляцын төсөөллийг нэмэгдүүлэхэд хүргэсэн. Эдийн засгийн төлөв сайжирсан боловч 2023 онд гадаад орчны төлөв үргэлжлэн муудахтай зэрэгцэн төсвийн зардал огцом тэлж байгаа нь импортын эрэлтийг урамшуулж дотоод, гадаад тэнцвэрт сөргөөр нөлөөлөх эрсдэлийг харгалзан бодлогын хүүг 1.0 нэгж хувиар нэмэгдүүлж 13.0 хувьд хүргэсэн.

Мөнгөний захын үйл ажиллагаа

Банкнудын зээл олгох, хадгаламж татах шийдвэр нь банк хоорондын зах дээрх санхүүгийн хэрэгслүүдийн хүүнээс хамаарч байдаг. Иймд Монголбанкнаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүний нэгдсэн бодлого болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийн тусламжтай банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүг бодлогын хүүтэй ойролцоо төвшинд хадгалахыг зорьдог билээ (Зураг 2.2).


Зураг 2.2. Мөнгөний бодлогын шилжих механизм



Эх сурвалж: Монголбанк

Коронавируст (КОВИД-19) цар тахлын улмаас эдийн засагт бий болсон сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор 2020 онд бодлогын хүүг 6.0 хувьд буюу түүхэн доод төвшинд хүргээд байсан нь 2021 оны туршид хадгалагдсан бол 2022 оны эхнээс бодлогын хүүг нийт 5 удаа шат дараалан нэмэгдүүлж тайлант оны сүүлд 13.0 хувьд хүргэсэн. Дээрх бодлогын өөрчлөлтийн үр дүнд 2022 онд банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү өмнөх онтой харьцуулахад 7.0 нэгж хувиар өссөнөөр 13.0 хувьд хүрч, банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүний бодлогын хүүнээс хазайх абсолют хазайлт 0.13 хувь болж өмнөх оноос 0.08 нэгж хувиар өсжээ (Зураг 2.3).

Зураг 2.3. Банк хоорондын захын хүү




Эх сурвалж: Монголбанк

Түүнчлэн гадаад орчны эрсдэлүүдтэй холбоотойгоор төгрөгийн харьцангуй өгөөжийг нэмэгдүүлэх, мөнгөний захыг идэвхжүүлэх зорилгоор 2022 оны 9 дүгээр сард Мөнгөний Бодлогын Хороо (МБХ)-ны ээлжит хурлаар хүүгийн коридорын өргөнийг бодлогын хүүнээс ± 2 нэгж хувь байхаар тогтоож, цар тахлын өмнөх үеийн төвшинд хүргэв. Улмаар банк хоорондын захын хүүний бодлогын хүүнээс хазайх абсолют хазайлт тайлант оны 9 дүгээр сарыг хүртэл дунджаар 0.10 хувь байсан бол 4 дүгээр улиралд 0.22 хувь болж 0.12 нэгж хувиар өсжээ.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш


Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2022 оны эцэст 3,444.60 төгрөгт хүрч, оны эхнээс 20.89 хувиар суларлаа (Зураг 2.4). Монголбанкнаас богино хугацааны валютын эрэлт, нийлүүлэлтийн зөрүү, ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад оролцдог. Тайлант хугацаанд төгрөгийн ам.доллартой харьцах ханш өдөрт дунджаар 0.077 хувиар хэлбэлзсэн бөгөөд нийт хугацааны 67 хувьд өдөрт [0.0%;0.1%] хувийн интервалд хэлбэлзжээ (Зураг 2.5). Түүнчлэн нэг өдөрт хамгийн ихдээ 0.82 хувиар буюу 24.4 төгрөгөөр суларч, 0.24 хувиар буюу 8.17 төгрөгөөр чангарсан байна.

Зураг 2.4. Төгрөгийн ам.доллартой харьцах Монголбанкнаас зарласан хаалтын ханшийн хэлбэлзэл



Эх сурвалж: Монголбанк

Зураг 2.5. Төгрөгийн ам.доллартой харьцах ханшийн өдрийн хэлбэлзлийн давтамж



2.2 МОНГОЛБАНКНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.2.1 Нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа


Төв банкны үнэт цаас

Нээлттэй захын үйл ажиллагаа буюу Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь банк хоорондын захын богино хугацаатай хүү болон нөөцийн хэлбэлзлийг удирдах замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл юм. Монголбанк 2022 онд хугацаа, хүү, арилжаалагдах хэлбэрээр ялгаатай дараах ТБҮЦ-ыг арилжааллаа. Үүнд:

- 28 хоногтой ТБҮЦ-ыг тогтмол хүүтэй, хэмжээ хязгаарлаагүй хэлбэрээр долоо хоногийн Даваа гараг бүр арилжааллаа. Энэ төрлийн үнэт цаасны хүү нь бодлогын хүү болох бөгөөд банк хоорондын захын хөтөч хүүний үүргийг гүйцэтгэж, системийн илүүдэл нөөцийг татах, банкнуудын нөөцийг удирдахад чухал үүрэгтэй байдаг.
- 84 хоногтой ТБҮЦ-ыг тогтмол хүүтэй, хэмжээ хязгаарласан хэлбэрээр 2 долоо хоног тутмын Лхагва гарагт зохион байгууллаа. Ингэхдээ банк хоорондын захын байнгын шинжтэй бүтцийн илүүдэл нөөцийг бууруулах, урт хугацаат хэлцлийн идэвхийг нэмэгдүүлэх, төгрөгийн өгөөжийн муруйн эхлэлийг бүрдүүлэх, мөнгөний бодлогын шилжих механизмын нөлөөг сайжруулах зорилгоор 84 хоногтой ТБҮЦ-ны арилжааг зогсоож, 196 хоногтой ТБҮЦ-ыг 2022 оны 3 дугаар улиралд нэвтрүүлж, урт хугацаат ТБҮЦ-ны арилжааны нөхцөлийг сайжруулсан болно. Ийнхүү 196 хоногтой ТБҮЦ-ыг тогтмол хүүтэй, хэмжээ хязгаарласан хэлбэрээр 2 долоо хоног тутмын Даваа гарагт урьдач нөхцөлийг биелүүлсэн арилжааны банкнууд оролцох боломжтой байхаар зарлан арилжаалсан.

2022 оны эцэст ТБҮЦ-ны нийт үлдэгдэл нэрлэсэн дүнгээр 5,700.81 тэрбум төгрөгтэй тэнцүү байна. Энэ нь 2021 оны эцсээс 34.01 хувиар буюу 2,944.15 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлт юм. Үүнээс 196 хоногтой ТБҮЦ 682.8 тэрбум төгрөгөөр өсөж нийт ТБҮЦ-ны 12.0 хувьд хүрсэн бол 28 хоногтой ТБҮЦ 3,071.4 тэрбум төгрөгөөр буурч, 5,573.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тус өөрчлөлтөд Монголбанкны алт худалдан авалтаар нийлүүлсэн 3,192.1 тэрбум төгрөг, Засгийн газрын ТСНД-аар нийлүүлсэн 350.6 тэрбум төгрөг, Монголбанкны гадаад валютын интервенцээр цэвэр дүнгээр 6,202.7 тэрбум төгрөгийг татсан нь гол нөлөөг үзүүлэв (Зураг 2.6).

Зураг 2.6. Төв банкны үнэт цаасны үлдэгдэл



Эх сурвалж: Монголбанк

Репо арилжаа


Төв банкны репо арилжаа нь банкны эзэмшиж буй үнэт цаасыг хугацааны эцэст урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдах нөхцөлтэй худалдан авах хэлцэл юм. Монголбанкаас Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор уул уурхайн бус экспорт, боловсруулах аж үйлдвэрийн салбарт олгох урт хугацаат репо арилжааны хугацааг 3 жил болгон сунгаж, банкнуудын эх үүсвэрийг зээл олголтод татан оролцуулахаар шийдвэрлэж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А-34 тушаалаар урт хугацаат репо арилжааны нэмэлт нөхцөлд өөрчлөлт оруулан баталлаа. Түүнчлэн нийлүүлэлтийн тасалдлаас үүсэж болзошгүй инфляцын эрсдэлийг бууруулах зорилгоор урт хугацаат репо арилжааны эх үүсвэрээр мах бэлтгэн нийлүүлэгчдэд олгох зээлийн нөхцөлийг шинэчлэн баталсан юм.

Мөнгөний бодлогын хорооноос 2022 оны 1 дүгээр улиралд урт хугацаат репо санхүүжилтийн хэмжээг 250.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр шийдвэрлэсний дагуу Монголбанк 2022 оны 1 дүгээр улиралд 81.0 тэрбум, 2 дугаар улиралд 25.3 тэрбум, 3 дугаар улиралд 74.3 тэрбум төгрөг буюу нийт 180.6 тэрбум төгрөгийн репо арилжааг банкнуудтай байгуулаад байна. Түүнчлэн Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 4 дүгээр тогтоолд урт хугацаат репо санхүүжилтийн зориулалтыг өргөтгөн шатахуун болон хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийг шаардлагатай төвшинд хүртэл бүрдүүлэхэд ашиглахаар шийдвэрлэсний дагуу 2022 онд нийт 39.9 тэрбум төгрөгийн шатахууны нөөц бүрдүүлэх санхүүжилтийг репо эх үүсвэрийн хүрээнд олгов.

Нөгөөтгээгүүр, банк шинэ зээл хэлбэрээр болон дахин санхүүжилт хэлбэрээр ашиглаагүй үлдсэн эх үүсвэр болох нийт 136.7 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг Монголбанканд тухай бүр эргэн төлсөн бол 198.7 тэрбум төгрөгийн репо арилжаа хуваарийн дагуу эргэн төлөгдсөн байна. Ийнхүү банкнуудад олгосон репо арилжааны эх үүсвэрийн үлдэгдэл 2022 оны эцсийн байдлаар 900.3 тэрбум төгрөгт хүрчээ.

Мөн тайлант онд зээлдэгчдээс 490.8 тэрбум төгрөгийн хүсэлт ирүүлснээс 483.3 тэрбум төгрөгийг 282 (180 аж ахуйн нэгж, 102 иргэн) зээлдэгчид олгосноор арилжааны банкнуудын олгосон нийт репо зээлийн дүн 1,308.8 тэрбум төгрөгт хүрээд байна. Зээл олголтын задаргааг салбараар нь авч үзвэл репо санхүүжилтийн хүрээнд бөөний болон жижиглэнгийн худалдаа¹, машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбарыг (68 хувь) голлон дэмжсэн байна. Мөн олгосон зээлийн 12 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 6 хувийг үйлчилгээний бусад салбар, 5 хувийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, ан агнуур (21.9 тэрбум төгрөг), салбарт тус тус олгожээ. Үлдсэн бусад эдийн засгийн салбаруудад 16 хувийг олгожээ.

Зураг 2.7. Урт хугацаат репо арилжааны зээл олголт, 2022 он, салбараар



Эх сурвалж: Монголбанк

Хэвийн зээлийг үнэт цаасжуулах ажлыг гүйцэтгэж буй “ҮЦСК актив нэг ТЗК” нь 40.5 тэрбум төгрөг, “ҮЦСК актив хоёр ТЗК” нь 160.4 тэрбум төгрөг, “ҮЦСК актив гурав ТЗК” нь 82.9 тэрбум төгрөг, “ҮЦСК актив дөрөв ТЗК” нь 83.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг тус тус гаргалаа. Үүний хүрээнд Монголбанкнаас анх барьцаалсан ТБҮЦ-ыг уг үнэт цаасаар солих ажлыг тухай бүр зохион байгуулж байна.

2.2.2 Төв банкны байнгын санхүүжилт

Монголбанк нь банкны системийн түр зуурын шинжтэй илүүдэл нөөцийг шингээх, шаардлагатай тохиолдолд нөөц татах, нийлүүлэх замаар банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүний хэлбэлзлийг бууруулах зорилгоор байнгын хэрэгслүүдийг ашигладаг. Байнгын хэрэгсэлд нөөцийг татах буюу овернайт хадгаламж, нөөцийг нийлүүлэх буюу репо санхүүжилтийн хэрэгсэл багтана. Түүнчлэн Монголбанк хүүний нэгдсэн бодлогын хүрээнд репо санхүүжилтийн хүү нь Төв банкны хүүний коридорын дээд хязгаар, овернайт хадгаламжийн хүү нь Төв банкны хүүний коридорын доод хязгаар болж, банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүний хэлбэлзлийг хязгаарладаг.

Тайлант онд Монголбанк нийт 729 удаагийн хэлцлээр өдөрт дунджаар 238.8 тэрбум төгрөгийн овернайт хадгаламжийг 8.7 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр банкнуудаас татсан байна. Харин нийт 133 удаагийн хэлцлээр өдөрт дунджаар 30.1 тэрбум төгрөгийн репо санхүүжилтийг 9.7 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр банкнуудад олгожээ.

¹ Бөөний болон жижиглэн худалдааны салбар нь 200-с доошгүй ажилтантай байхаар холбогдох журамд заасан.

Зураг 2.8. Байнгын санхүүжилтийн өдрийн дундаж хэмжээ болон сард хийгдсэн хэлцлийн тоо




Эх сурвалж: Монголбанк

2.2.3 Заавал байлгах нөөцийн шаардлага

Төв банкны тухай хуулийн 11.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Монголбанк төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ банкны заавал байлгах нөөцийн арга хэрэгслийг ашиглаж болохоор заасан. Үүний дагуу Төв банкны тухай хуулийн 27-3 дугаар зүйлийн 4.3-т заасны дагуу Монголбанкны Мөнгөний бодлогын хороо заавал байлгах нөөцийн хэмжээг хэлэлцэж шийдвэрлэдэг. Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар төгрөгийн татан төвлөрүүлсэн хөрөнгөд тооцох заавал байлгах нөөцийн хувийг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 8 хувьд хүргэх шийдвэрийг гаргасан. Ингэснээр 2022 оны 2 дугаар сарын 9-ний өдрөөс 2 дугаар сарын 22-ны өдрийг дуустал банкны системийн төгрөгийн ЗБН-ийн хэмжээ 1,731.8 тэрбум төгрөгөөр тогтоогдсон бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 606.6 тэрбум төгрөгөөр буюу 53.9 хувиар нэмэгдсэн үзүүлэлт байна. Валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг хамгийн сүүлд Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор 3 нэгж хувиар буюу 15 хувиас 18 хувь болгон нэмэгдүүлэх шийдвэрийг гаргасан бөгөөд тус хувь хэмжээ 2022 онд өөрчлөгдөөгүй байна.

Зураг 2.9. Төгрөгийн заавал байлгах нөөцийн шаардлага, түүний хангалт (2021/12/29-2023/01/10)



Эх сурвалж: Монголбанк

Монголбанк мөнгөний болон макро зохистой бодлогын зорилгоор тодорхой хугацаанд зарим төрлийн эх үүсвэрийг заавал байлгах нөөц тооцоход хасаж тооцдог бөгөөд 2022 оны хувьд хоёр төрлийн эх үүсвэрийг шинээр хасаж тооцох шийдвэрийг Мөнгөний бодлогын хорооноос гаргасан билээ. Тодруулбал, уул уурхайн бус экспорт, боловсруулах аж үйлдвэрийн салбарт олгох урт хугацаат репо

арилжааны санхүүжилтийн нөхцөлийг өөрчлөх хүрээнд Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар уул уурхайн бус экспорт болон боловсруулах үйлдвэрлэлийн салбарт хамтын санхүүжилт хэлбэрээр банкнаас олгосон нийт зээлийн дүнг заавал байлгах нөөцийн төгрөгийн тооцох эх үүсвэрээс хасаж тооцох шийдвэрийг гаргасан. Мөн валютын заавал байлгах нөөцийн тооцооллоос хасаж тооцдог 3 жил болон түүнээс дээш хугацаагаар гадаад зах зээлээс бонд болон зээл хэлбэрээр татсан эх үүсвэрээс гадна богино буюу 1 жилээс 3 жил хүртэлх хугацаатай гадаад валютын эх үүсвэрийг хасаж тооцохоор Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэр нь банкнуудын дунд хугацаанд санхүүжилт татах сонирхлыг нэмэгдүүлэх, жижиг банкнуудад эх үүсвэр татах хөшүүргийг бий болгох, валютын эх үүсвэрийн зардлыг бууруулах эерэг нөлөөтэй юм.

2.2.4 Бусад санхүүжилт

Өдрийн зээл

Өдрийн зээл нь төлбөр тооцооны хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Монголбанкнаас банканд олгож буй санхүүжилтийн хэрэгсэл бөгөөд тухайн өдөрт багтан эргэн төлөгдөх нөхцөлтэй, хүүгүй зээл юм. Тайлант онд Монголбанкнаас банканд өдрийн зээл олгоогүй байна.

Барьцаат зээл


Монголбанк эцсийн зээлдүүлэгчийн үүргийн хүрээнд банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор “Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн А-174 тоот тушаалаар батлагдсан “Монголбанкнаас банканд олгох барьцаат зээлийн журам”-ын дагуу банканд барьцаат зээл олгодог. Тайлант онд банкууд барьцаат зээлийн хүсэлт Монголбанканд ирүүлээгүй болно.

Ипотекийн санхүүжилт

Монголбанк Засгийн газартай хамтран 2013 оноос “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн 2 дахь хэсэг болгон “Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлсэн. Орон сууцны ипотекийн хөтөлбөрийн гол зорилго нь бага, дундаж орлоготой өрхүүдийн орон сууцны нөхцөлийг сайжруулах, агаар болон хөрсний бохирдлыг бууруулах, орон нутгийн шилжилт хөдөлгөөнийг саармагжуулахад оршдог.

Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш нийт 6.9 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийг 112 мянган өрхөд Монголбанк, Засгийн газар, банкнуудын эх үүсвэрээр олгожээ (Зураг 2.10).

Зураг 2.10. Ипотекийн зээл олголт




*2022 онд олгосон нийт зээлийн дүн (үүнээс Монголбанкнаас олгосон санхүүжилт 469.4 тэрбум төгрөг)

Эх сурвалж: Монголбанк

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоол, Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд 2024 он хүртэл нийт 2 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн хөтөлбөрийн зээлийг олгохоор тусгагдсан. Үүнээс 2021 онд нийт 1.0 их наяд төгрөгийн зээлийг 13.4 мянган өрхөд, 2022 онд 732.3 тэрбум төгрөгийн зээлийг 7.8 мянган өрхөд олгов.

Олгогдсон зээлийн эргэн төлөлтийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлуулах арга хэмжээг нийт 5 удаа авч хэрэгжүүлсэн. Үр дүнд нь ойролцоогоор нийт 63.2 мянга орчим өрхийн зээлийн төлбөрийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр нийт 33 орчим сарын турш хойшлуулсан байна. Энэ хугацаанд ойролцоогоор нийт 979 тэрбум төгрөгийн төлбөр (419 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 560 тэрбум төгрөгийн хүүний төлбөр)-өөс чөлөөлөгдсөн буюу хойшлуулжээ (Зураг 2.11).

Зураг 2.11. Ипотекийн төлбөр хойшлуулалт



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 65 дугаар тогтоолоор баталсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлд Монголбанк хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийг 2023 оны эхний хагас жилд багтаан Засгийн газарт шилжүүлэхээр тусгасан. Уг ажлын хүрээнд Монголбанк холбогдох байгууллагуудтай хамтран хөтөлбөрийг тогтвортой, урт хугацаанд хэрэгжих боломжтой схемийг боловсруулж Засгийн газарт хөтөлбөрийг шилжүүлэхээр ажиллаж байна.

Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондын санхүүжилт

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хуулийн 10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолын 2.6-д заасны дагуу НОСК ХК-ийн хэрэгжүүлж буй Түрээслээд өмчлөх орон сууцны хөтөлбөр нь цар тахлын эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчдад зориулсан онцгой нөхцөлтэй хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор НОСК ХК-иас үүсгэн байгуулсан Тусгай зориулалтын компанийн гаргасан 150 тэрбум төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондыг нэрлэсэн үнээр худалдан авах тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-417 дугаар тушаал, 2022 оны А-363 дугаар тушаалыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд баталсан. Уг тушаалын дагуу 2020 онд нийт 34.4 төгрөг, 2021 онд 65.6 тэрбум төгрөг, 2022 онд 50 тэрбум төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондыг тус тус худалдан авч, хөтөлбөрийг санхүүжүүлснээр нийт 1,772 төрийн албан хаагчийн орон сууцны хэрэгцээг хангасан байна.

Шатахууны нөөц бүрдүүлэх санхүүжилт

“Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай”, “Тол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Монголбанкнаас газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, Ковид-19 цар тахлаас шалтгаалсан шатахууны нийлүүлэлтийн тасалдлаас үүсэж болох инфляцын эрсдэлийг бууруулж, төгрөгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор 2022 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 311 дүгээр тогтоолд заасан шатахууны нөөцийг бүрдүүлэхэд шаардлагатай эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн хүрээнд 2022 онд 410.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг банканд репо арилжааны хүүтэй тэнцүү байх нөхцөлтэйгөөр олгосон.
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас ОХУ-ын Роснефть компанитай хийсэн 120 мянган тонн (2022 оны 4, 5, 6 дугаар сарын Монгол Улсын хэрэглээ) АИ-92 шатахууныг тонн тутамд 840 ам.доллаароор худалдан авах хөнгөлөлттэй нөхцөл бүхий хэлэлцээрийн урьдчилгаа төлбөр болох нийт 282.8 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийг холбогдох хуулийн дагуу банканд репо арилжааны хүүтэй тэнцүү нөхцөлтэйгөөр олгосон. Түүнчлэн тус хэлэлцээрийг 2022 он дуустал сунгасантай холбогдуулан Монголбанкнаас 2021, 2022 онд олгосон санхүүжилтийн үлдэгдэл эх үүсвэрийн эргэн төлөгдөх хугацааг 2023 оныг дуустал хугацаагаар сунгав.

Ийнхүү 2022 оны эцсийн байдлаар шатахууны нөөц бүрдүүлэх санхүүжилтийн үлдэгдэл 426.6 тэрбум төгрөг, урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийн үлдэгдэл 3.4 тэрбум төгрөг байна.


2.2.5 Монголбанкны валютын захын оролцоо

Спот захын арилжаа

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлд нийцтэй, уян хатан тогтох зарчмыг баримтлан эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүүнээс үүсэх ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцож ирлээ. Эдийн засгийн идэвхжил 2022 онд хүлээлтээс харьцангуй өндөр байж, Ковид-19 цар тахлын өмнөх төвшинг давснаар гадаад валютын эрэлт өсөж, төгрөгийн ханш сулрах дарамт нэмэгдэх хандлагатай болов. Мөн 2022 онд геополитикийн хямралаас үүдэлтэй эдийн засаг, санхүүгийн хориг арга хэмжээ, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “Тэг-Ковид” бодлогын нөлөөгөөр Манай улсын гадаад орчны таагүй нөхцөл байдал үргэлжлэх, төлбөрийн тэнцлийн алдагдалтай байхад голчлон нөлөөлж байв.

Түүнчлэн, өндөр хөгжилтэй орнууд, тэр тундаа Америкийн Нэгдсэн Улсын Холбооны нөөцийн банк бодлогын төлөвөө эрчимтэй чангаруулж байгаа нь улс орны өсөлтийн төлөв нь саарах нэг нөхцөл болж байна. Ийнхүү дэлхийн эдийн засгийн өсөлт саарч, аж үйлдвэрлэлийн салбар удааширч байгаа нь түүхий эдийн үнэд сөргөөр нөлөөлж, экспортын үнэ саарах хандлага ирэх онуудад үргэлжлэх төлөвийг бий болголоо. Улмаар Монголбанк 2022 онд төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид огцом хэлбэлзэл үүсгэхгүй байх зорилгоор спот арилжааны цэвэр дүнгээр нийт 2,359.7 сая ам.долларыг валютын захад нийлүүлжээ.


Зураг 2.12. Монголбанкны валютын захын спот арилжааны цэвэр дүн 2013-2022 он



Эх сурвалж: Монголбанк

Монголбанкнаас 2022 онд нийт 97 удаа гадаад валютын дуудлага худалдаа зохион байгуулж, дуудлага худалдаа болон цахим талбараар дамжуулан цэвэр дүнгээр 5,999.3 сая ам.доллар нийлүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 66.3 хувиар буюу 2,391.5 сая ам.доллаар өссөн үзүүлэлт юм. Үүнээс 953.5 сая ам.долларыг Монголбанкнаас нефть, нефтийн бүтээгдэхүүн, хий болон цахилгаан эрчим хүчний импортын төлбөрт зориулж холбогдох хуулийн дагуу олгосон болно. Харин Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нарын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 03/3/А-5 дугаар хамтарсан тушаалын дагуу төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдээс тайлант хугацаанд нийт 3,518.6 сая ам.доллар, бусад арилжаагаар 121.0 сая ам.долларыг тус тус худалдан авч, Төв банкны тухай хуульд заасны дагуу Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн гүйцэтгэх үүргийн хүрээнд цэвэр дүнгээр 554.3 сая ам.доллартой тэнцэх гадаад зээл, бондын үндсэн ба хүүгийн төлбөрийг хийж гүйцэтгэжээ.

Зураг 2.13. Монголбанкны валютын захын спот арилжааны задаргаа



Эх сурвалж: Монголбанк


Санхүүгийн үүсмэл хэрэгсэл

Монголбанк банкнуудын богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх, ханшийн эрсдэл, спот захын дарамтыг бууруулах, дотоодын зах зээл дэх долларжилтыг бууруулах, бодит эдийн засгийг дэмжих зорилгоор банкнуудтай богино хугацааны санхүүгийн үүсмэл хэрэгслийг 2010 оноос, урт хугацаат своп хэлцлийг 2014 оноос тус тус байгуулж эхэлсэн. Гадаад болон дотоод зах зээлийн нөхцөл байдал, банкнуудын гадаад эх үүсвэрийн өртөг зэргийг харгалзаж Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн А-237 дугаар тушаалаар урт хугацаат своп

хэлцлийн хүүний нөхцөлд өөрчлөлт оруулав. Ингэснээр банкнуудын гадаад эх үүсвэрийн зардлыг бууруулж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх хүчин зүйл болсон.

Мөн олон улсын ам.долларын хүүний шилжилттэй холбоотойгоор урт хугацаат своп хэлцлийн ам.долларын бүрэлдэхүүн хэсэг болох London Inter-Bank Offered Rate хүүг Secured Overnight Financing Rate (SOFR) хүүнд шилжүүлснээр 2022 онд бүх хэлцлийг SOFR хүүнд шилжүүлэв.

Зураг 2.14. Банкуудтай байгуулсан урт хугацаат своп хэлцлийн хэмжээ



Эх сурвалж: Монголбанк

Тайлант хугацаанд Монголбанк банкуудын төгрөгийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор холбогдох журмын дагуу 46.0 сая ам.долларын богино хугацаат своп хэлцэл хэлцэл байгуулсан бөгөөд АИ-92 шатахууны гадаад төлбөр тооцоонд шаардлагатай гадаад валютын ханшийн эрсдлийг бууруулах зорилгоор холбогдох хуулийн дагуу 132.8 сая ам.долларын дүн бүхий төгрөгийн форвард хэлцэл байгуулав. Харин урт хугацаат своп хэлцлийн хүрээнд холбогдох журмын дагуу банкнуудын нэгээс дээш жилийн хугацаатай гадаад зах зээлээс татсан эх үүсвэрээр УХСХ байгуулж байгаа бөгөөд 2022 онд нийт 430.5 сая ам.долларын дүнтэй бодит бус урт хугацаат своп хэлцлийг банкуудтай байгуулж, 567.0 сая ам.долларын хэлцлийн хугацааг сунгасан билээ. Мөн тайлант онд нийт 673.2 сая ам.долларын урт хугацаат своп хэлцлийн хугацаа дуусаж, төлбөр тооцоог гүйцэтгэсэн бөгөөд урт хугацаат своп хэлцлийн үлдэгдэл 324.4 сая ам.доллароор өсөж, 1,751.8 сая ам.долларт хүрэв.

Гадаад валютын хадгаламж

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны А-674 дүгээр тушаалаар баталсан “Дотоодын банкнаас Монголбанканд гадаад валютын хадгаламж байршуулах журам” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-297 дугаар тушаалын дагуу гадаад валютын хадгаламжийн хүүгийн хувь хэмжээ нь Олон улсын төлбөр тооцооны банк (ОУТТБ)-ны харгалзах хугацаанд санал болгож буй хугацаат хадгаламжийн өгөөжтэй тэнцүү нөхцөлтэйгөөр 7 хоногоос 3 хүртэлх сарын хугацаатай банкууд Монголбанканд гадаад валютын хадгаламж байршуулдаг. Банкнуд 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар 485.0 сая ам.долларын гадаад валютын хадгаламжийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 455.0 сая ам.доллароор өссөн үзүүлэлттэй байна (Зураг 2.15).

Зураг 2.15. Банкнудын Төв банк дахь ам.долларын хадгаламжийн үлдэгдэл, сараар




Эх сурвалж: Монголбанк

2.2.6 Банк хоорондын захын арилжаа

Монголбанкнаас банк хоорондын захын тогтвортой үйл ажиллагааг өдөр бүр хангаж ажиллаж байгаа бөгөөд тайлант онд сард дунджаар 68.7 тэрбум төгрөгийн овернайт арилжаа, 382.1 тэрбум төгрөгийн репо хэлцэл, 434.7 тэрбум төгрөгийн ТБҮЦ-ны шууд худалдан авалтыг хийсэн байна. Мөн банк хоорондын захын хэлцлийн дундаж хугацаа 12.0 хоног болж, өмнөх оноос 2.1 хоногоор нэмэгджээ (Зураг 2.16).

Зураг 2.16. Банк хоорондын төгрөгийн захын арилжаа, төрлөөр



Эх сурвалж: Монголбанк

Банк хоорондын валют арилжааны цахим талбар нь банк хооронд валют арилжаа хийх үйл явцыг хялбаршуулаад зогсохгүй мэдээллийн тэгш байдлыг бий болгосноор зах зээл дэх арилжааны спот ханш бүрэлдэх үйл явцыг сайжруулах болгох, арилжаа хийхэд тулгарч буй харилцагчийн болон төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах, өндөр дүнтэй валютын арилжаа хийх иргэн, аж ахуйн нэгжүүд уг талбараас ханшийн мэдээлэл авах зэрэг ач холбогдолтой юм. Тайлант онд банкнуд БХВАЦТ-аар дамжуулан нийт 14.4 сая ам.долларын дүн бүхий 23 удаагийн арилжаа хийсэн бол банк хоорондын шууд арилжаагаар 122.7 сая ам.долларын дүн бүхий 85 удаагийн арилжаа хийсэн байна (Зураг 2.17).

Зураг 2.17. Банк хоорондын валютын захын арилжаа, төрлөөр



Эх сурвалж: Монголбанк

2.3 САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Макро зохистой бодлого


Монголбанк нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн макро зохистой бодлогын арга хэмжээг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж байна. Тухайлбал, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 3 дугаар улирлын ээлжит хурлаар эдийн засгийн гадаад, дотоод орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзээд банкуудын гадаадын зах зээлээс бонд болон зээл хэлбэрээр 360 хоног болон түүнээс дээш хугацаагаар шинээр татсан эх үүсвэрийг заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлөх шийдвэрийг гаргалаа. Энэ арга хэмжээ нь хөрөнгийн орох урсгалын төлөв хангалтгүй, хөгжиж буй орнуудын хувьд эх үүсвэр татах санхүүгийн нөхцөл чангарч байгаа үед банкуудад гадаад валютын эх үүсвэр татах хөшүүргийг бий болгож хөрөнгийн орох урсгал, гадаад тэнцвэрт эерэг нөлөө үзүүлнэ.

КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор зээлдэгчдэд үүсэж буй дарамтыг бууруулах зорилгоор 2020 онд эхлүүлсэн орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлуулах арга хэмжээ 2022 оны эцэст дуусгавар боллоо. 2022 оны 9 дүгээр сарын байдлаар нийт 68.2 мянган зээлдэгчийн 3.9 их наяд төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах хүсэлт өгч шийдвэрлүүлсэн байснаас дийлэнх нь буюу 62.0 мянган зээлдэгчийн 3.5 их наяд төгрөгийн зээл нь орон сууцны ипотекийн хөтөлбөрийн буюу хөнгөлөлттэй хүүтэй зээл байна. Зээлийн эргэн төлөлтөө хойшлуулах хүсэлт өгч, шийдвэрлүүлсэн хэдий ч нийт 19.4 мянган зээлдэгч 995.9 тэрбум төгрөгийн зээлээ хуваарийн дагуу төлжээ. Харин эргэн төлөлтийг хойшлуулсан 48.9 мянган зээлдэгчийн 2.9 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдлийн 2.8 их наяд төгрөг нь хэвийн зээл, 51.2 тэрбум төгрөг буюу 1.8 хувь нь анхаарал хандуулах болон чанаргүй зээл байна.

Монголбанкнаас иргэдийн хэрэглээний зээлийн өсөлтийг зохистой түвшинд хадгалах, өрхийн өрийн дарамтыг бууруулах болон банкны системд эрсдэл хуримтлагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор банкнаас олгох хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцаа (ӨОХ) болон хугацааны хязгаарлалт тогтоон 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдүүлж эхэлсэн билээ. Тус арга хэмжээний үр нөлөөгөөр банкнаас иргэдэд олгосон хэрэглээний зээлийн өсөлт 2019 оноос хойш харьцангуй тогтворжиж, 2018 оны эцэст 49.6 хувьтай байсан хэрэглээний зээлийн жилийн өсөлт 2022 оны эцэст 11.4 хувьтай байна (Зураг 2.18). Гэвч энэхүү арга хэмжээг дан ганц банкны салбарт хэрэгжүүлэх нь хэрэглээний зээлийн эрэлт Банк бус санхүүгийн байгууллага руу (ББСБ) шилжиж, бодлогын үр нөлөөг бууруулах эрсдэл учруулж байна. Тодруулбал, 2022 оны эцсийн байдлаар ББСБ-ын нийт хэрэглээний

зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 33.3 хувиар буюу 367 тэрбум төгрөгөөр өсөж 1.5 их наяд төгрөгт хүрээд байна. Энэ нь банкнаас олгох хэрэглээний зээлд ӨОХ болон хугацааны хязгаарлалт тогтоохоос өмнөх үе буюу 2018 оны эцсээс 4.2 дахин нэмэгдсэн дүн юм. Иймд банкнаас олгох иргэдийн хэрэглээний зээлд тавигдаж буй дээрх хязгаарлалтын арга хэмжээг банкны бус санхүүгийн салбарт давхар мөрдүүлэх нь өрхийн өрийн дарамтыг бууруулах, банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой байна.

Зураг 2.18. Банкны салбарын хэрэглээний зээлийн үлдэгдэл



Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Хязгаарлалт бүхий бусад хэрэглээний зээлд цалингийн, малчны, автомашины, картны, өрхийн хэрэглээний болон бусад хэрэглээний зээлүүд хамаарна. Тэтгэврийн зээл 2019 болон 2020 онуудад ӨОХ-ны хязгаарлалттай байсан.

Банкны хяналт шалгалтын бодлогыг боловсронгуй болгох ажлын хүрээнд

Монголбанк банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор “Эрүүл, найдвартай, ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай, харилцагчид хүртээмжтэй, цахимжсан банкны тогтолцоог бий болгох банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр”-ийг 2020 оноос эхлүүлэн хэрэгжүүлж байна. Банкны салбарын шинэтгэлийг хэрэгжүүлснээр банкны системийн эрсдэл даах чадварыг сайжруулж, олон улсын стандарт, сайн туршлагад нийцсэн зохицуулалтын эрх зүйн орчныг бий болгож, улмаар банкны систем эдийн засгийн урт хугацааны тогтвортой, хүртээмжтэй эерэг өсөлтөд чиглэхэд чухал алхам болох юм. Энэхүү шинэтгэлийн хөтөлбөрийн томоохон нэг зорилт болох банкны хяналт, шалгалтын стандартыг сайжруулах ажлын хүрээнд Монголбанкны зүгээс гүйцэтгэл болон эрсдэлд суурилсан хяналт шалгалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлж, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэн ажиллаж байна.

Банкны системд нөлөө бүхий банкныг нээлттэй хувьцаат компани хэлбэрээр, бусад банкныг хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, банкны хувьцаа эзэмшлийн хэт төвлөрлийг бууруулж, өмчлөл-удирдлага-хяналтын тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх, улмаар банкны зохистой засаглалыг бэхжүүлэх зорилгоор Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль болон түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг 2021 онд УИХ-аас баталсан. Тус хуулийн хүрээнд банкныг хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулахтай холбогдуулан нийт 12 журмыг Монголбанк батлаад байна. Тухайлбал 1) Банкны системд нөлөө бүхий банкныг тогтоох аргачлал, 2) Хянан шалгагчдад учруулсан нөлөөллийн

мөдүүлэг хөтлөх журам, 3) Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам, 4) Банкны тогтворжуулах сангийн журам, 5) Банкнийг тогтворжуулах төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжүүлэх журам, 6) Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх, журам, 7) Банкнийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам 8) Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах, хэрэгжүүлэх журам, 9) Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журмуудыг тус тус боловсруулан баталж, банкуудын үйл ажиллагаанд мөрдүүлэн, хяналт тавин ажилласан.

Цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямрал, геополитикийн хурцадмал нөхцөл байдлын улмаас банкны систем, хөрөнгийн зах зээлд болзошгүй эрсдэлийг харгалзан 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан банкуудыг хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулагдах хугацааг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгаад байна. Тус хугацааг сунгасантай холбогдуулан, системд нөлөө бүхий банкууд хувьцаагаа нийтэд санал болгон гаргаж компанийн хэлбэрээ өөрчлөхөөс өмнө, Монголбанкны санаачилгаар банкуудын активын чанар, эрсдэлийн сан болон өөрийн хөрөнгийн хүрэлцээг үнэлэх, гадаад, дотоодын оролцогч талуудыг бодит мэдээллээр хангах зорилгоор Активын чанарын хараат бус, хөндлөнгийн үнэлгээг олон улсад нэр хүнд бүхий аудитын компаниар гүйцэтгүүлж, банкны хувьцаагаа нийтэд санал болгон анх удаагаа гаргах үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүллээ. Хараат бус үнэлгээг Бүгд найрамдах Казахстан улсын “PricewaterhouseCoopers Tax & Advisory LLP” компани 2022 оны 6 дугаар сараас 8 дугаар сарын хугацаанд гүйцэтгэж, системд нөлөө бүхий 5 банкны нийт зээлийн багцын 70 орчим хувийг хамруулан тэдгээрт харгалзах 300 барьцаа хөрөнгийн үнэлгээнд баталгаажуулалт хийсэн. Өмнө банкуудад хөндлөнгийн Активын чанарын үнэлгээг 2017 онд анх удаа хийж байсан бол ийнхүү 5 жилийн дараа банкны системд нөлөө бүхий банкуудад дахин хийсэн бөгөөд Монголбанк энэ төрлийн хөндлөнгийн үнэлгээг 5 жил тутамд хийж, үр дүнг мэдээлэх үйл ажиллагааг цаашид жишиг болгон хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

Түүнчлэн, шинэтгэлийн хөтөлбөрт тодорхойлсон банкны хяналт шалгалтын зохицуулалтыг олон улсын сайн туршлагатай нийцүүлэх зорилтын хүрээнд банкны эрсдэл даах чадварыг хамгаалах зориулалт бүхий нөөц интервалыг нэвтрүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Мөн банкны активыг ангилах, эрсдэлийн сан байгуулахтай холбоотой харилцааг гүйцэтгэлд суурилсан зарчмаас эрсдэлд суурилсан зарчимд шилжүүлэхээр Санхүүгийн тайлагналын олон улсын 9 дүгээр стандарттай холбоотой журмын төслүүдийг боловсруулсан.

Цаашид Монголбанк шинэтгэлийн хөтөлбөрийн 5 дугаар зорилтод тусгасан, үйл ажиллагааны чиглэл, бизнесийн загвар зэргээр төрөлжсөн банкны талаар хяналт шалгалтын хүрээнд баримтлах бодлогыг боловсруулах, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Банкны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт

Монголбанк 2022 онд хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх үйл ажиллагааны хүрээнд банкуудын Банкны тухай хууль, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, мөн Монголбанкнаас баталсан журам, зааврыг хэрхэн хэрэгжүүлж байгаад газар дээрх болон зайны хяналт шалгалтаар тогтмол хяналт тавин ажилласан.

Зураг 2.19. Банканд хийх хяналт шалгалтын цар хүрээ



Эх сурвалж: Монголбанк

Тайланд жилд Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамжийн дагуу газар дээрх иж бүрэн хяналт шалгалтыг 4 банканд, хэсэгчилсэн хяналт шалгалтыг тухайлсан банк бүрд нийт 8 удаа хийж гүйцэтгэсэн. Тухайн банкны эрсдэлтэй хэсэгт газар дээрх хяналт шалгалтыг төвлөрүүлж, эрсдэлтэй үйл ажиллагаатай холбоотой баримт, материалыг газар дээрх хяналт шалгалтаар тулган баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.


Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан “Ажлын байрыг дэмжих зээл”-ийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Ажлын байрыг дэмжих зээлийг Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Банк, Зээлийн батлан даалтын сан, Монголбанкууд 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр санхүүжилтийн ерөнхий гэрээ байгуулсан бөгөөд тус гэрээний дагуу арилжааны 9 банкны эх үүсвэрээр нийт 25,515 иргэн, аж ахуйн нэгжид 1,965.5 тэрбум төгрөгийн зээлийг олгосноор 109,906 ажлын байрыг дэмжсэн байна. Үүнээс, Улаанбаатар хотод 1,224.7 тэрбум төгрөгийн зээл олгож 72,901 ажлын байрыг, орон нутагт 740.8 тэрбум төгрөгийн зээл олгож 34,005 ажлын байрыг дэмжсэн байна.

Ажлын байрыг дэмжих зээлийн үлдэгдэл 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 1,088.35 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас Улаанбаатар хотод 10,160 иргэн, аж ахуйн нэгжийн 696.70 тэрбум төгрөгийн, орон нутагт 13,615 иргэн, аж ахуйн нэгжийн 391.65 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Ажлын байрыг дэмжих зээлийн мэдээллийг зураг 2.20, 2.21-т харуулав.

Зураг 2.20. Ажлын байрыг дэмжих зээл /УБ хот/



Зураг 2.21. Ажлын байрыг дэмжих зээл /Орон нутаг/



Эх сурвалж: Монголбанк

УИХ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр батлагдсан “Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шалгалт хийсэн талаарх МУЗГ, Монголбанк болон аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцаж, дүнг УИХ-д танилцуулах үүрэг бүхий ажлыг хэсэг байгуулах тухай” 20 дугаар захирамжийн дагуу ажлын хэсгийн дэд хэсэгт Хяналт шалгалтын газрын хянан шалгагчид 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс хойш ажиллаж байна. Түүнчлэн банкуудын Активын чанарын үнэлгээний хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Хяналт шалгалтын газрын хянан шалгагчид хамрагдаж Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хас банк, Төрийн банканд ажиллалаа.

Монголбанкны Хяналт шалгалтын газраас Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн арга хэмжээ

Хууль, журам, эрх зүйн орны шинэчлэлт

Банкны бизнесийн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй эрсдэл болон хяналтын тогтолцооны үнэлгээг нэгтгэн, банкуудын мөнгө угаах терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх эрсдэлийн үнэлгээг хийж, газар дээрх шалгалтын чиглэл, хамрах хүрээ, давтамжийг тодорхойлох зорилгоор олон улсын стандарт, ФАТФ-ын 40 зөвлөмжтэй уялдуулан “Банкны мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам”, “Банкны мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг тус тус шинэчлэн боловсруулж, батлуулав.

Дээрх шинэчлэлийн хүрээнд доорх ажлуудыг хийж гүйцэтгэв.

- Хяналт шалгалтын тоо, өгөгдөл, чанарын мэдээлэл цуглуулах маягтыг шинэчлэв.
- Эрсдэлийн үнэлгээний матрицыг шинэчлэв.
- Эрсдэлийн үнэлгээний тайлан, Хяналт шалгалтын стратеги гаргах маягтыг боловсруулж гаргав.
- Банканд зөвлөн туслах, банкны харилцагчдыг соён гэгээрүүлэх арга хэмжээг авах боломжийг бүрдүүлэв.
- Үндсэн хяналт шалгалтын аргачлалыг шинэчлэн боловсруулав.
- Хяналт шалгалтын аргачлалыг Европын Холбоо, АНУ-ын хяналт шалгалтын стандартад тулгуурлан шинэчилсэн.
- Хяналт шалгалтын чиглэлийг шинээр тодорхойлж, нарийвчлан гаргах, тухайлсан чиглэлээр илүү нарийвчилсан хяналт шалгалт хийх бололцоог бүрдүүлэв. Хяналт шалгалт үндсэн 20 чиглэлээр хязгаарлагдахгүй болов.

МУТС-тэй тэмцэхтэй үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалт

Монголбанкны Хяналт шалгалтын газраас 2022 онд банкуудын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан арга аргачлалын дагуу төлөвлөгөөт болон гэнэтийн сэдэвчилсэн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Газар дээрх шалгалтыг банкуудын МУТСТ бүтэц зохион байгуулалт, бодлого журам, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, гүйлгээнд хяналт тавих, мэдээлэх, эцсийн өмчлөгчийг таньж мэдэх гэх мэт чиглэлүүдийг хамруулан хийсэн бөгөөд шалгалтаар тодорхой зөрчил дутагдлууд илэрч, түүний дагуу хуульд заасан торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгах, үйл ажиллагааг нь сайжруулахад чиглэсэн зөвлөмжийг шалгалтын явцад өгч ажилласнаас гадна нийт 15 үүрэг даалгаврыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тухайн банкуудад өгч, өмнөх хяналт шалгалтаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хянаж ажиллав.

Хүснэгт 2.1. МУТС-тэй тэмцэх чиглэлээр хийсэн газар дээрх хяналт шалгалт

Үзүүлэлт	2021 он	2022 он
Банкинд хийсэн, эрсдэлд суурилсан газар дээрх хяналт, шалгалт	3	10
Сэдэвчилсэн хяналт шалгалт	22	9
Шалгалтаар тогтоосон Улсын байцаагчийн акт, мэдэгдэл	4	7
Ногдуулсан торгууль, шийтгэлийн тоо	4	1
Шалгалтаар өгсөн үүрэг даалгавар (МБЕ-ийн тушаалаар)	14	15

Эх сурвалж: Монголбанк

Түүнчлэн банкууд Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)-ийн хоригийн хэрэгжилтийг хангаж байгаа эсэхэд газар дээрх хяналт шалгалт болон зайны хяналтаар тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Сургалт, хэлэлцүүлэг

Монголбанкны Хяналт шалгалтын газраас Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөл, Тагнуулын ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн алба, Монголын банкны холбоо зэрэг байгууллагууд болон бусад байгууллагатай хамтран ФАТФ-ын зөвлөмжийн хэрэгжилт, МУТСТ хуулийн хэрэгжилт болон МУТСТ үйл ажиллагааны талаарх чиглэл бүхий 6 удаагийн танхимын сургалт, хэлэлцүүлэгт оролцож, мэдээлэл, сургалт хийлээ.

ФАТФ-ын зөвлөмжийн үнэлгээг ахиулахтай холбоотой хийсэн ажлууд

ФАТФ-ын Зөвлөмж 8-ын үнэлгээг ахиулах зорилгоор Монголбанкнаас байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хянан шалгагчид орж ажиллав. Зөвлөмж 8-ын үнэлгээг ахиулах, Ази номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (АНДМУТБ)-д хүргүүлэх тайланг боловсруулах ажлын хүрээнд банканд данс нээж, санхүүгийн үйлчилгээ авч буй ашгийн бус байгууллагаас үүсэх эрсдэл, эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ, тэдгээрийн данс гүйлгээнд хийж буй банкны хяналтын үйл ажиллагааг шалгасан. Шалгалтын үр дүнг ФАТФ-ын зөвлөмж 8-ын үнэлгээг ахиулах зорилгоор АНДМУТБ-д хүргүүллээ.

МУТС-тэй тэмцэх Үндэсний эрсдэлийн үнэлгээ, Үндэсний хөтөлбөр


Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой Үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны техник туслалцаатайгаар хийж гүйцэтгэсэн. Сангийн сайдын тушаалаар байгуулагдсан Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийн дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Хяналт шалгалтын газрын төлөөлөл оролцон ажиллаж банкуудын үнэлгээний тайланг боловсруулан ажлын хэсэгт хүргүүлсэн.

Дээрх эрсдэлийн үнэлгээний үр дүнд банкны салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээний төслийг боловсруулан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрт тусгуулахаар тайланг хүргүүлсний үр дүнд Монгол Улсын МУТСТ Үндэсний хөтөлбөрийг 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталсан бөгөөд Үндэсний хөтөлбөрт тусгагдсан банкны салбарт авч хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

2.4 ГАДААД ВАЛЮТЫН УЛСЫН НӨӨЦИЙН УДИРДЛАГА

"Төв банкны тухай хууль"-ийн 21 дүгээр зүйлд заасны дагуу Монголбанк гадаад валютын нөөцийн найдвартай байдлыг хангах, хөрвөх чадварыг алдагдуулахгүй байх, дээрх нөхцөлүүд бүрэн хангагдсан тохиолдолд үр өгөөжийг нэмэгдүүлэх гэсэн зарчмын дагуу гадаад валютын улсын нөөц(ГВУН)-ийн удирдлагыг хэрэгжүүлдэг. ГВУН-ийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт нь олон улсын жишигт нийцсэн, оролцогч талуудын эрх, үүргийг нарийвчлан тодорхойлсон давхар хяналтын тогтолцоог бий болгоход чиглэсэн байдаг.

Зураг 2.22. Төв банкнуудын бодлогын хүү (%)



Эх сурвалж: Блумберг


Монголбанк 2022 онд ГВУН-ийн бүтцийг хүлээн зөвшөөрөгдөхүйц эрсдэлийн төвшинд баталж, түүний хүрээнд нөөцийн актив, хөрөнгө оруулалтын тохиромжтой хугацаа, хэрэгслүүдийг тус тус тодорхойлон ажиллав.

Голлох эдийн засгуудын инфляцын эсрэг хийсэн тэмцэл, ОХУ-Украины дайны нөхцөл байдал, БНХАУ-ын Ковидын эсрэг авч хэрэгжүүлсэн бодлого зэрэг нь 2022 оны дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, бодлого боловсруулагчдын шийдвэрт нөлөөлсөн гол үйл явдлууд байлаа. Тэргүүлэх Төв банкнууд цар тахлын үед авч хэрэгжүүлсэн төсөв, мөнгөний зөөлөн бодлогын инфляцад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эрэлтийн гаралтай инфляцыг хязгаарлах зорилгоор 2022 онд хатуу мөнгөний бодлогыг тууштай хэрэгжүүлэн, бодлогын хүүгээ түүхэнд байгаагүй хурдаар эрчимтэй нэмэгдүүлэв (Зураг 2.22). Энэ нь ГВУН-ийн удирдлагын өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлд эергээр нөлөөлсөн хэдий ч нөгөө талаас гадаад валютын төгрөгийн эсрэг ханшийн чангаралтыг эрчимжүүлж, улмаар дотоодын валютын захад үзүүлэх дарамтыг нэмэгдүүллээ.

Монголбанкнаас валютын нөөцийг дэлхийн эдийн засагт тэргүүлэгч АНУ, Франц, Англи, Люксембург зэрэг орнуудын Төв банк, Засгийн газар, Олон улсын төлбөр тооцооны банк зэрэг зээлжих зэрэглэл өндөртэй байгууллагуудад харилцах, хадгаламж, үнэт цаас хэлбэрээр байршуулж удирдлаа. Харин нөөцийн урт хугацаат багцыг АНУ-ын Засгийн газар, олон улсын санхүүгийн корпорацын 0-3 жилийн хугацаатай үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх замаар удирдаж, олон улсын бенчмарк өгөөжийг давуулсан гүйцэтгэлтэй удирдсан.

Монголбанкны дотоодын зах зээлээс худалдан авсан алтны хэмжээ 22.9 тонн хүрч, өмнөх оны үзүүлэлтээс 10.1 хувиар нэмэгдлээ. Оны эхний 4 сард ОХУ-Украины дайны нөлөөгөөр олон улсын зах зээл дээрх алтны үнэ өндөр төвшинд хадгалагдсан бол оны дундаас ам.долларын бодлогын хүү огцом нэмэгдсэнээс шалтгаалан ам.доллар чангарч, улмаар алтны үнэ тогтмол уналттай байлаа. Харин оны сүүлийн 2 сард АНУ-ын инфляцын үзүүлэлт хүлээлтээс бага төвшинд гарсан нь ХНБ бодлогын хүүгээ 2023 оны сүүлийн хагасаас бууруулах хүлээлтийг үүсгэж, улмаар зах зээл дээрх алтны үнэ эргэн сэргэсэн үзүүлэлттэй байлаа. Дээрх зах зээлийн орчинд мөнгөжсөн алтны багцын удирдлагыг захын хандлага, статистик тоо мэдээлэл, түүний хүлээлт, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын үнийн төсөөлөл зэрэг мэдээлэлд үндэслэн бодит ашигтай удирдив.

Зураг 2.23. Гадаад валютын улсын нөөц ба импортын хэрэгцээг хангах төвшин



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын улсын нөөц (ГВУН) 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3,399.6 сая ам.долларт хүрч оны эхнээс 22.1 хувь буюу 966.5 сая ам.доллаароор буурсан байна. Энэхүү үзүүлэлт нь:

- Валютын төлбөртэй бараа болон үйлчилгээний импортын²сүүлийн 3 сарын дундаж гүйцэтгэлээр тооцоход 3.2 сар буюу 12.8 долоо хоногийн хэрэгцээг хангах төвшинд;
- Валютын төлбөртэй барааны импортын сүүлийн 3 сарын дундаж гүйцэтгэлээр тооцоход 4.7 сарын буюу 18.8 долоо хоногийн хэрэгцээг хангах төвшинд тус тус байна.

Энэ нь олон улсын жишиг доод төвшин болох импортын 3 сарын буюу 12 долоо хоногийн хэрэгцээнээс 0.2-1.7 сараар өндөр байна (Зураг 2.23). Харин Монгол Улсын Их хурлын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн үзэл баримтлалд “ГВУН нь валютын төлбөртэй импортын нэг жил буюу 52 долоо хоногийн хэрэгцээг хангах төвшнөөс багагүй байх” хэмээн зааснаас доогуур төвшинд хэвээр байна.

² Бараа, үйлчилгээний импортын хувьд 2022 оны 12 дугаар сарын статистик мэдээлэл тархах хуваарь болоогүй байгаа тул 2022 оны 11 дүгээр сарын дүн мэдээллээр тоймлож ашиглав.

2.5 ҮНЭТ МЕТАЛЛ ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолыг үндэслэн Монголбанкнаас гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, Алт-2 үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор 2020 оны 6 дугаар сараас эхлэн алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийг олгож эхэлсэн.

Тус хуулийн хэрэгжих хугацаа 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болж буй бөгөөд 2022 онд 52.0 тэрбум төгрөгийн, хууль хэрэгжсэн 3 жилийн хугацаанд нийт 505.5 төгрөгийн санхүүжилтийг арилжааны банкнуудаар дамжуулан алт олборлогчдод олгосон. Тайлант онд нийт 11 алт олборлогч аж ахуй нэгжид урьдчилгаа төлбөрийн 32.7 тэрбум төгрөг, урт хугацаат санхүүжилтийн 309.7 тэрбум төгрөг, нийт 19.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг арилжааны 4 банкаар дамжуулан олгоод байна.

Монголбанк нь Төв банкны тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хуулийн дагуу гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор дотоодын зах зээлээс худалдан авсан үнэт металлыг гадаадад цэвэршүүлэх ажлыг эрхэлдэг бөгөөд 2022 онд 22.9 тонн үнэт металл худалдан авсан нь өмнөх онтой харьцуулахад 10 хувиар өссөн үзүүлэлт боллоо. Худалдан авсан үнэт металлыг мөнгөжүүлж, гадаад валютын улсын нөөцийг 878 сая ам.доллаароор нэмэгдүүлжээ.

Зураг 2.24. Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ



Эх сурвалж: Монголбанк

2.6 МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

Үндэсний төлбөрийн системийн зөвлөлийн ээлжит хуралдааныг 2022 оны 6 дугаар сард зохион байгуулсан. Зөвлөлийн гишүүн байгууллагуудын гүйцэтгэх болон удирдах түвшний оролцогчид хүрэлцэн ирж, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн Төлбөрийн системийн шинэчлэл төслийн хүрээнд шинээр нэвтрүүлсэн систем, үндэсний төлбөрийн системд цаашид дэвшилтэд технологид суурилсан төлбөрийн шийдлийн талаар нээлттэй хэлэлцэж, санал солилцсон ач холбогдол бүхий хуралдаан болж өндөрлөсөн.

Монголбанк нь Үндэсний төлбөрийн системийг удирдан зохион байгуулах, хяналт тавих, олон нийтийг мэдээллээр хангах үндсэн чиг үүрэгтэй. Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн шийдвэрээр “Тогтвортой хөгжлийн зорилго” өдөрлөг Монгол Улс дахь НҮБ, Эдийн засаг, хөгжлийн яам, Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон бусад түнш байгууллагуудын хамтын оролцоотойгоор 2022 оны 9 дүгээр сард зохион байгуулагдсан. Төв банк өөрийн үндсэн чиг үүргийн хүрээнд тус өдөрлөгийн үеэр гадаад, дотоод төлбөр тооцоо, төлбөрийн картын хэрэглээ,

үндэсний мөнгөн тэмдэгтийн нууцлал болон бусад үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, гарын авлага, QR код ашиглан цахим товхимол түгээх болон банкны үйл ажиллагаатай холбоотой иргэдийн сонирхсон асуултад хариулж иргэд, олон нийтийг мэдээллээр хангаж ажилласан.

Дэлхийн банк нь Монгол Улсын төлбөрийн системийг хөгжүүлэх, олон улсын сайн жишигт нийцүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр 2015 оноос эхлэн техник туслалцаа үзүүлж, Монголбанктай хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд манай улсын төлбөрийн системийн хөгжлийн чиг баримжааг тодорхойлох, эрх зүйн орчныг бэхжүүлэх, төлбөрийн системийг цаашид хөгжингүй орны жишигт нийцүүлэх зорилгоор “Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх стратеги 2022-2026” баримт бичгийн төслийг хамтран боловсруулж, холбогдох санал, судалгааг хийж гүйцэтгэлээ. Стратегийг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар 2022 оны 9 дүгээр сард батласан.

Оросын холбооны улс болон Украин улсын хооронд үүссэн геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалж Монгол Улсаас ОХУ руу иргэд, аж ахуй нэгжийн гадаад шилжүүлэг хийх, бараа бүтээгдэхүүний төлбөр тооцоог гүйцэтгэхэд 2022 онд багагүй хүндрэлтэй нүүр тулсан. Энэ хүндрэлээс гарахын тулд Монголбанкны зүгээс ОХУ руу хийгдэх импортын бараа бүтээгдэхүүний төлбөр тооцоог түргэн шуурхай, саадгүй гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангах, хүндрэл үүссэн тохиолдолд тухай бүр зохицуулалт хийх зэрэг чиг үүргээр хангаж ажилласан. Энэ хүрээнд Монголбанкнаас Америкийн нэгдсэн улсын Сангийн яам болон Гадаад хөрөнгийн хяналтын газар (OFAC)-т албан захидал хүргүүлсэн. АНУ-ын Сангийн яамны дэргэдэх Гадаад хөрөнгийн хяналтын газраас 2022 оны 5 дугаар сарын 16-ны өдөр ОХУ-ын зарим санхүүгийн байгууллагад авсан хориг арга хэмжээ нь танай албан захидалд дурдсан зайлшгүй шаардлагатай импортын бүтээгдэхүүний төлбөрийг тус улсын зүгээс үндэслэлгүйгээр саатуулах ямар нэг хязгаарлалт тавиагүй бөгөөд энэ хориг арга хэмжээ нь зөвхөн ОХУ, АНУ-ын хооронд хамааралтай байна гэж мэдэгдсэн. 2022 оны гуравдугаар улирлаас эхлэн гадаад төлбөр тооцоо саадгүй дамжиж, нөхцөл байдал сайжирсан.

Монголбанк, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”-тэй хамтран “Falk” арга хэмжээг 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Үндэсний төлбөрийн системийн нийт оролцогч, Азийн хөгжлийн банкны төлөөлөгчдийн оролцоотой амжилттай зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээг төсөл хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд шинээр нэвтрүүлсэн төлбөрийн системүүд болон төсөл хэрэгжсэнээр төлбөрийн системд гарсан ололттой давуу талуудыг сурталчлан таниулах зорилготойгоор зохион байгуулагдлаа.

Монгол Улсын Их Хурал 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Зөвшөөрлийн тухай хуулийг баталсан. Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж, мөрдөхтэй холбоотойгоор төлбөрийн системийн эрх зүйн орчныг уг хуульд нийцүүлэх зорилгоор Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг тусгаж, баталсан.

Монголбанкны Ерөнхийлөгч, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Монголын Банкны холбоо болон банкуудын гүйцэтгэх болон удирдлагын түвшний албан тушаалтнуудын оролцоотой “Санхүүгийн харилцагчийг зайнаас таних шийдэл” сэдвээр хамтарсан уулзалтыг 2022 оны 11 дүгээр сард зохион байгуулж, Монголбанкнаас "Тоон гарын үсгийн үйлчилгээний тухай", Монголын банкны холбооноос “Банкны үйлчилгээнд харилцагчийн цар хүрээг нэмэгдүүлэх санал, санаачилга (eKYC, барьцаа хөрөнгийн бүртгэл, e-mongolia лавлагаа)”, Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас "Хэрэглэгчээ таних, мэдээлэлд хэрэглэгчийн зөвшөөрөлтэй хандах" гэсэн илтгэлийг тус тус танилцуулсан. Уулзалтаар банк, санхүүгийн салбарын үйлчилгээнд шинээр нэвтэрч буй QR код, eKYC ашиглан төлбөр тооцоо гүйцэтгэх зэрэг технологийн дэвшлийг ашиглахын давуу болон сул тал, мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхэд тулгамдаж байгаа асуудлуудын талаар ярилцаж, санал солилцсон.

Төлбөр тооцоонд ашиглаж ирсэн цаасан мөнгөн тэмдэгт нь улс орны эдийн засгийн чадамжаар баталгаажсан, Төв банкнаас нийлүүлэлт, нууцлал аюулгүй байдлыг нь хангаж байдаг тул хамгийн найдвартай, эрсдэл багатай төлбөрийн хэрэгсэлд тооцогдож ирсэн боловч дэлхий дахинд технологийн хөгжлийг даган олон төрлийн төлбөрийн хэрэгсэл бий болж финтек компаниуд шинэлэг шийдэл бүхий төлбөрийн хэрэгслийг нэвтрүүлж, бидний төлбөр төлөх үйл явц өөрчлөгдөж, шинэ эрсдэлүүд үүсэж байна. Түүнээс гадна зөвхөн технологид суурилсан, аль нэг улс үндэстний баялгаар баталгаажгаагүй крипто-валют гэх үзэгдэл сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдэж, түүгээр төлбөр тооцоо хийх явдал зарим улсад гарч олон улсын эдийн засаг, санхүүгийн салбарт тодорхой бус байдал үүсгэх болсон. Судалгаанаас харахад олон нийтэд зориулсан буюу тухайн улсын цаасан мөнгөн тэмдэгтийг шууд орлох нээлттэй цахим мөнгө болон зөвхөн санхүүгийн байгууллагад зориулсан банк хоорондын их дүнтэй гүйлгээ, нөөц удирдах, үнэт цаасны төлбөр тооцоо хийх гэх мэт санхүүгийн байгууллага хоорондын өндөр дүнтэй төлбөр тооцоог хийх зорилгоор ашиглах хязгаарлагдмал цахим мөнгө гэсэн 2 хэлбэрээр гаргах боломжтой байна. Хууль эрх зүй, дэд бүтэц, хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр хийгдэж буй судалгаа, шинжилгээний үр дүнг харьцуулах улмаар өөрийн орны онцлогт тохирох загвар, технологийн шийдлийг тодорхойлох зорилготой Монголбанкны дотоод ажлын хэсгийг байгуулан олон талаас нь судалж байна.

Монголбанкнаас Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр банкууд, финтек компаниуд болон төлбөрийн системийн оролцогч бүх талтай хамтран хэрэгжүүлсэн “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийн үр дүнд манай улсын төлбөр тооцооны систем олон улсын жишигт хүрч, дэлхийн санхүүгийн системтэй нэг хэлээр ярих боломж бүрдсэн билээ. Дотоодын ₮ картын хэрэглээг нэмэгдүүлэх, хилийн чандад бусад төлбөрийн картын сүлжээнд хүлээн авах гарцыг бий болгох ажлын хүрээнд Монголбанк болон БНСУ-ын КэйТи Группийн охин компани болох БиСи карт байгууллага хооронд 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа. Ингэснээр дотоодын ₮ карт БНСУ-д, БиСи байгууллагын төлбөрийн карт Монгол Улсад төлбөр тооцоо харилцан гүйцэтгэх боломж бүрдэх эхний алхамыг амжилттай хийлээ.

Төлбөрийн системийн хяналт, зөвшөөрөл

Монголбанк Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн хүрээнд Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журмын дагуу энэ онд нийт 10 зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авсан. Зөвшөөрөл авахаар ирүүлсэн баримт бичгийг судалж үзэн дараах байдлаар шийдвэрлэлээ. Үүнд:

Олгосон зөвшөөрөл:

- Төлбөрийн карт гаргах зөвшөөрлийг 2 байгууллагад; (М банк хаалттай ХК, Ардкредит ББСБ ХК)
- Төлбөрийн карт хүлээн авах зөвшөөрлийг 2 байгууллагад; (М банк хаалттай ХК, Дата бэйнк ХХК)
- Төлбөрийн хэрэгсэл – цахим мөнгө гаргах зөвшөөрлийг 1 байгууллагад; (Дата бэйнк ХХК)
- Аутсорсингийн үйлчилгээ авах зөвшөөрлийг 1 байгууллагад; (ККТТ ХХК)
- Төлбөрийн хэрэгсэл – цахим мөнгө гаргах зөвшөөрлийг хугацаагүй сунгаж 1 байгууллагад тус тус олгосон (Мобифинанс ББСБ ХХК)

Харин цахим мөнгө гаргах хүсэлт гаргасан 2, төлбөрийн карт гаргах, хүлээн авах зөвшөөрөл хүссэн 1 байгууллагад хууль, журмын шаардлага хангаагүй тул холбогдох зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэрийг хүргүүлсэн.

Монголбанк нь оператор болон оролцогчийн эрх зүйн баримт, мэдээлэл, статистик үзүүлэлтүүдийг тодорхой давтамжтайгаар цуглуулж, дүрэм, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна. Газар дээр хийсэн шалгалтын үр дүнг системийн найдвартай, үр ашигтай байдлын үнэлгээнд ашигладаг. Төлбөрийн системийн оролцогчдыг хамруулсан газар дээрх шалгалтыг 2022 онд дараах байдлаар хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Төв банкны хариуцсан төлбөрийн системийн операторын үйл ажиллагааны шалгалт (Банксүлжээ систем, ҮЦГТ-ийн бага болон картын клирингийн систем);
- Бусад төлбөрийн системийн операторын үйл ажиллагааны шалгалт (ХХБ-ны картын клирингийн систем);
- Төлбөрийн системийн оролцогчийн үйл ажиллагааны шалгалт (банкуудын иж бүрэн шалгалт);
- Цахим мөнгөний үйл ажиллагааны иж бүрэн шалгалт.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд мэдэгдэж, залруулах талаар хянан шалгагч нар өөрийн бүрэн эрхийн хүрээнд арга хэмжээ авч ажиллалаа.

Төлбөрийн системийн оролцогч хоорондын 2022 оны гүйлгээний нийт тоо, дүнг өмнөх онтой харьцуулбал гүйлгээний тоо 53 хувиар, гүйлгээний дүн 3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Төлбөрийн системийн оролцогч хоорондын 2020-2022 оны байдлаарх их, бага дүнтэй гүйлгээний тоон үзүүлэлтийг Хүснэгт 2.2, өсөлт бууралтыг Зураг 2.25-д үзүүлэв.

Хүснэгт 2.2. Банк хоорондын 2020-2022 оны гүйлгээний тоо, дүн (мянган ширхэг, их наяд төгрөг)

Он/улирал	2020 он		2021 он		2022 он		2022/2021 оны өөрчлөлт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
I улирал	17,375.00	67.40	25,791.10	109.40	39,762.98	127.12	54%	16%
1. RTP	12,599.90	3.10	19,008.10	4.30	32,286.15	7.71	70%	79%
2. АСН	4,454.90	0.20	6,402.90	0.90	7,084.39	1.09	11%	21%
3. RTGS	320.20	64.20	380.00	104.30	392.44	118.32	3%	13%
II улирал	22,014.90	84.50	35,907.20	135.00	50,395.14	137.64	40%	2%
1. RTP	15,498.30	3.70	22,949.20	5.52	42,653.86	10.20	86%	85%
2. АСН	6,113.60	0.60	12,421.10	2.44	7,243.23	1.25	-42%	-49%
3. RTGS	403.10	80.20	536.90	127.00	498.04	126.19	-7%	-1%
III улирал	24,626.80	91.30	32,633.70	125.00	52,720.96	126.83	62%	1%
1. RTP	17,435.70	4.07	25,377.50	6.10	44,397.52	10.48	75%	72%
2. АСН	6,764.70	0.61	6,664.80	0.90	7,835.79	1.11	18%	24%
3. RTGS	426.40	86.70	591.40	118.00	487.64	115.24	-18%	-2%
IV улирал	24,302.60	109.50	38,278.90	147.60	59,500.64	140.87	55%	-5%
1. RTP	17,705.50	4.12	30,815.80	7.68	50,866.26	11.76	65%	53%
2. АСН	6,171.80	0.87	6,767.90	1.07	8,096.55	1.30	20%	21%
3. RTGS	425.20	104.50	695.30	138.90	537.83	127.81	-23%	-8%
Нийт	88,319.30	352.70	132,610.90	516.90	202,379.71	532.46	53%	3%
1. RTP	63,239.40	14.90	98,150.60	23.60	170,203.79	40.16	73%	70%
эзлэх хувь	71.60%	4.20%	74.00%	4.60%	84.10%	7.54%	10%	3%
2. АСН	23,505.00	2.40	32,256.70	5.30	30,259.97	4.75	-6%	-10%
эзлэх хувь	26.60%	0.60%	24.30%	1.02%	14.95%	0.89%	-9%	0%
3. RTGS	1,574.90	335.50	2,203.60	488.10	1,915.95	487.55	-13%	0%
эзлэх хувь	1.80%	95.10%	1.70%	94.42%	0.95%	91.57%	-1%	-3%

Эх сурвалж: Монголбанк


[1] RTP – Бага дүнтэй төлбөрийн систем (бодит цагийн гүйлгээ)

[2] АСН - Бага дүнтэй төлбөрийн систем (багцын гүйлгээ)

[3] RTGS – Банксүлжээ буюу их дүнтэй төлбөрийн систем

Зураг 1-с үзэхэд гүйлгээний тоо өмнөх оны мөн үеүдтэй харьцуулахад тогтмол өссөн ба гүйлгээний дүн буурсан үзүүлэлттэй байна. Гүйлгээний тоо тогтмол өсөж байгаа нь технологийн дэвшил болон эдийн засгийн бусад нөлөөллөөс шалтгаалж бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээ өссөнтэй холбоотой юм. Тайлант оны эцэст 59.5 сая ширхэг 140.9 их наяд төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны эцэсээс 21.3 сая ширхгээр өсөж, 6,7 их наяд төгрөгөөр буурчээ.

Зураг 2.25. Банк хоорондын 2020-2022 оны гүйлгээний тоо, дүн



Эх сурвалж: Монголбанк

Төлбөрийн карт

Төлбөрийн картын хэрэглээний үзүүлэлт өсөж байгаа нь бэлэн бус төлбөрийн хэрэгслийг өдөр тутмын төлбөр тооцоонд ашиглах иргэдийн сонирхол өндөр болж байгааг харуулж байна. Банкууд ₮ карт, Виза, Мастеркарт, Юнионпэй, Американ экспресс болон Жэй Си Би гэсэн 6 төрлийн төлбөрийн картыг өөрийн оноосон нэрээр гаргаж байна. Энэ оны байдлаар нийт картын 65 хувийг үндэсний брэнд ₮ карт дангаар эзэлж, зах зээлд түлхүү ашиглагдаж байгааг Хүснэгт 2.3-аас харж болно.

Хүснэгт 2.3. Төлбөрийн картын болон төхөөрөмжийн тоо 2020-2022 он

№	Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2022/2021 өөрчлөлт (%)
1	Картын хэрэглээ (мянган ширхэг)				
1.1	Картын тоо	4,077.89	4,446.37	4,446.88	0.01%
1.2	Идэвхитэй ашиглагдаж буй картын тоо	1,863.29	2,237.52	2,243.78	0.28%
2	Картын төрөл (мянган ширхэг)				
2.1	₮ карт	2,594.60	2,600.34	2,439.00	-6.20%
2.2	Виза	519.04	661.59	863.31	30.49%
2.3	Мастеркарт	123.40	151.30	124.64	-17.62%
2.4	ЮнионПэй	762.86	1,022.33	1,012.86	-0.93%
2.5	Амекс	4.10	3.54	2.81	-20.55%
2.6	ЖейСиБи	8.73	7.27	4.26	-41.39%
3	Төхөөрөмжийн төрөл [1]				
3.1	ПОС	70,753	84,302	103,689	23.00%
3.2	МПОС	2,036	105	40	-61.90%
3.3	ПОБ	2,915	2,844	2,949	3.69%
3.4	АТМ	1,084	1,049	946	-9.82%
3.5	СДМ	42	19	18	-5.26%
3.6	СРМ	1,595	1,764	1,868	5.90%
3.7	Цахим худалдаа	1,112	5,008	8,187	63.48%
3.8	КИОСК (пос-той)	264	584	902	54.45%
3.9	Бусад	0	0	0	

[1] Төхөөрөмжийн ангиллыг 2019 оны дөрөвдүгээр улирлаас эхлэн 9 төрлөөр бүртгэж эхэлсэн.

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 2-оос үзэхэд тайлант онд төлбөрийн картын тоо 0.01 хувиар, картыг идэвхтэй ашиглагчийн тоо 0.28 хувиар тус тус өссөн байна. Төхөөрөмжийн тоон мэдээг авч үзэхэд ПОС төхөөрөмжийн тоо өмнөх оноос 23 хувиар өссөн нь бараа үйлчилгээний төлбөр тооцоог төлбөрийн картаар буюу бэлэн бусаар хийх боломж нэмэгдсэнийг харуулж байна.

Хүснэгт 2.4. Төлбөрийн картын гүйлгээний тайлан 2020-2022 он (мянган ширхэг, тэрбум төгрөг)

№	Төхөөрөмж	Утга	2020 он	2021 он	2022 он	2022/2021 өөрчлөлт	2022/2021 өөрчлөлт (%)
1	ПОС	Тоо	371,838.10	485,184.65	606,601.61	121,416.97	25.02%
		Дүн	8,641.00	12,517.27	16,340.44	3,823.17	30.54%
2	МПОС	Тоо	102.50	23.20	3.55	(19.65)	-84.69%
		Дүн	3.10	0.80	0.23	(0.57)	-70.65%
3	ПОБ	Тоо	1,390.10	1,019.90	988.35	(31.55)	-3.09%
		Дүн	331.50	258.30	230.22	(28.08)	-10.87%
4	АТМ/СRМ/СDМ	Тоо	105,566.30	81,378.50	86,701.62	5,323.12	6.54%
		Дүн	27,162.30	28,381.10	32,179.63	3,798.53	13.38%
5	Цахим худалдаа	Тоо	1,555.20	3,629.80	6,140.40	2,510.60	69.17%
		Дүн	109.10	260.10	356.60	96.50	37.10%
6	КИОСК (пос-той)	Тоо	323.20	838.80	2,554.72	1,715.92	204.57%
		Дүн	7.50	20.50	851.56	831.06	4053.96%
7	Бусад	Тоо	-	-	-	-	0.00%
		Дүн	-	-	-	-	0.00%
	Нийт (Улс)	Тоо	480,775.40	572,074.84	702,990.24	130,915.40	22.88%
		Дүн	36,254.50	41,438.07	49,958.69	8,520.62	20.56%

Эх сурвалж: Монголбанк

Гүйлгээний үзүүлэлтийн хувьд тайлант онд ПОС төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний тоо хамгийн өндөр буюу 606.6 сая ширхэг байна. Харин гүйлгээний дүнгийн хувьд АТМ, СRМ, СDМ төхөөрөмжүүдээр хийгдсэн гүйлгээний дүн хамгийн их буюу 32.2 их наяд төгрөгийн үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс хамгийн их хэрэглээ нь өссөн төхөөрөмж нь киоск байсан ба гүйлгээ тоо нь 204.6 хувиар, гүйлгээний дүн нь 4054 хувиар тус тус өссөнийг Хүснэгт 2.4-т зааснаар харж болно.

2.7 МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монголбанк нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасны дагуу Монгол Улсын мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах онцгой эрхийн хүрээнд мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргах, гүйлгээнээс татах, гүйлгээнд байгаа мөнгөн тэмдэгтийн зохистой бүтцийг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний өөрчлөлт

2022 оны эцсийн байдлаар гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээ мөнгөн дүнгээр 1.089 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад -1.5 хувь буюу 16.3 тэрбум төгрөгөөр бууржээ. Харин гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний тоо ширхэг өмнөх оноос 2.0 хувь буюу 10.8 сая ширхгээр өсөж, 537.2 сая ширхэгт хүрсэн байна.


Хүснэгт 2.5. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээ

№	Мөнгөн дэвсгэрт	Мөнгөн дүн (сая төгрөгөөр)		Тоо ширхэг (сая ширхгээр)	
		2021	2022	2021	2021
1	1 төгрөг	33.6	34.1	33.6	34.1
2	5 төгрөг	152.6	154.9	30.5	31.0
3	10 төгрөг	1,072.2	1,111.1	107.2	111.1
4	20 төгрөг	1,800.1	1,845.8	90.0	92.3
5	50 төгрөг	3,817.8	3,958.7	76.4	79.2
6	100 төгрөг	7,460.7	7,594.1	74.6	75.9
7	200 төгрөг	36.7	37.0	0.2	0.2
8	500 төгрөг	8,665.8	8,854.2	17.3	17.7
9	1000 төгрөг	20,588.0	21,790.5	20.6	21.8
10	5000 төгрөг	79,927.1	76,435.4	16.0	15.3
11	10000 төгрөг	218,555.0	205,076.0	21.9	20.5
12	20000 төгрөг	763,441.3	762,350.9	38.2	38.1
Нийт		1,105,550.9	1,089,242.7	526.4	537.2


Эх сурвалж: Монголбанк

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний бүтцийг мөнгөн дүнгээр нь авч үзвэл өндөр нэрлэсэн дүнтэй дэвсгэртүүд дийлэнх хэсгийг бүрдүүлж байна. Тодруулбал, 2022 онд 10000 болон 20000 төгрөгийн дэвсгэртүүд мөнгөн дүнгийн 88.8 хувийг, үүнээс 70 хувийг нь 20000-тын дэвсгэрт дангаараа бүрдүүлжээ. Харин бусад дэвсгэртүүдийн гүйлгээнд байгаа бэлэн мөнгөнд эзлэх хувь өмнөх оноос 0.9 нэгж хувиар буурч 11.2 хувьд хүрсэн байна. Энэ нь өндөр нэрлэсэн дүнтэй мөнгөн дэвсгэртүүдийн эрэлт жил бүр нэмэгдсээр байгаатай холбоотой юм.

Зураг 2.26. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний бүтэц, мөнгөн дүнгээр



Зураг 2.27. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний бүтэц, тоо ширхгээр



Эх сурвалж: Монголбанк

Тайлант оны эцсийн байдлаар 1-тээс 100-т хүртэлх бага нэрлэсэн дүнтэй мөнгөн дэвсгэртүүд тоо ширхгээрээ гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний 78.9 хувийг, үлдсэн дэвсгэртүүд нийлээд 21.1 хувийг бүрдүүлжээ. Энэ нь бага дүнтэй дэвсгэртүүд төлбөр тооцоонд хэрэглэгдэх нь багасаж, улмаар банкнаас гадуур иргэдийн гар дээр үлдэж, гүйлгээнээс буцан татагдахгүй байгаатай холбоотой юм.

Мөнгөн тэмдэгтийн аппликейшн

Монголбанк нь үндэсний мөнгөн дэвсгэртийг хуурамчаар үйлдэхээс сэргийлэх, иргэд олон нийт, хүүхэд залууст мөнгөн дэвсгэртийн хамгаалалтын элементүүдийн талаарх ойлголт, мэдээллийг өгөх

зорилгоор ухаалаг гар утасны аппликэйшний хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэн албан ёсоор 2023 оны 1 дүгээр улиралд албан ёсоор хэрэглээнд шинээр нэвтрүүлэв.

Мөнгөн дэвсгэргийн хамгаалалтын элементүүдийн талаарх танин мэдэхүйн сонирхолтой мэдээллүүдийг багтаасан Монгол, Англи хэлний хувилбар бүхий хэрэглэхэд хялбар тус аппликэйшнийг iOS болон Android үйлдлийн системээс татаж авах боломжтой бөгөөд сурах, бодит талбар дээр ажиллах, олсон мэдлэгээ шалгах гэсэн үндсэн 3 хэсэгтэй.


Танин мэдэхүйн энэхүү аппликэйшнийг ашиглахдаа гар утсаа тал бүр тийш хазайлгах, гэрлийн эсрэг дээш, доош хөдөлгөх зэргээр, мөн дэлгэцэн дээрх хэт ягаан туяаны гэрлийн тусламжтайгаар хамгаалалтын элементүүдийг сонирхолтой байдлаар харах, таньж мэдэх, суралцах боломжтой юм.

Монголбанк сүүлийн жилүүдэд мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдэгдэхээс сэргийлж, хамгаалалтын элементүүдийг нь технологийн өндөр түвшинд сайжруулан шинэчилсэн тул иргэд олон нийтийг энэ талын мэдээллээр хангах, мөнгөн тэмдэгтийг хуурамчаас ялгахад нь туслах зорилгоор тус аппликэйшнийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн.

2.8 ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮГИЙН ЗУУЧЛАЛ

Засгийн газрын санхүүгийн удирдлагыг сайжруулах, мөнгөний бодлогын арга хэрэгслийг нэмэгдүүлэх зорилгоор 2012 оны 10 дугаар сараас эхлэн Засгийн газар Монголбанкаар дамжуулан засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ыг анхдагч зах зээл дээр гарган, арилжаасан. ЗГҮЦ нь санхүүгийн зах зээл дэх хамгийн эрсдэл багатай хөрөнгө оруулалтын хэрэгсэл бөгөөд хүүний орлого нь албан татвараас чөлөөлөгддөг давуу талтай. Иймд ЗГҮЦ-ны тогтмол арилжаа нь эрсдэлгүй хүүний жишгийг санхүүгийн захад тогтоох буюу өгөөжийн муруйг бүрдүүлэх, богино хугацаат хүүний урт хугацаат хүүнд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлох, санхүүгийн захын идэвхийг нэмэгдүүлэх зэргээр санхүүгийн захын хөгжлийг олон талаар дэмждэг. Гэвч Сангийн яамны шийдвэрийн дагуу 2017 оны 11 дүгээр сараас хойш ЗГҮЦ-ны анхдагч захын арилжаа нээлттэй зарлагдаагүй байна.

Зураг 2.28. Монголбанкаар дамжин арилжаалагдсан ЗГҮЦ-ны үлдэгдэл



Эх сурвалж: Монголбанк

Монголбанкаар дамжин арилжаалагдсан ЗГҮЦ-ны үлдэгдэл 2022 оны эцэст 22.5 тэрбум төгрөг байна (Зураг 2.28). Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 77 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам” хүчин төгөлдөр үйлчилж байгаа хэдий ч 2022 онд ЗГҮЦ-ны хоёрдогч зах дээр арилжаа хийгдээгүй байна.

2.9 ТӨВ БАНКНЫ СУДАЛГАА, СТАТИСТИК

Судалгаа

Монголбанк нь бодлогын шийдвэрт дэмжлэг болохуйц эдийн засаг, санхүүгийн салбарын судалгааны ажлыг тогтмол гүйцэтгэдэг бөгөөд дараах үндсэн чиг үүргийг баримтлан ажиллаж байна. Үүнд:

- Монголбанкны бодлого боловсруулах, мөнгөний бодлогын оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор бодлогын суурь судалгаа болон эмпирик судалгааг хөгжүүлэх;
- Макро эдийн засаг, микро эдийн засаг, санхүүгийн зах зээл зэрэг чиглэлээр өргөн хүрээнд эмпирик судалгаа, шинжилгээний ажил болон эдийн засгийн түүвэр судалгааг гүйцэтгэх, судалгааны үр дүнд үндэслэсэн бодлогын зөвлөмжүүд боловсруулах, үр дүнг удирдлагад тайлагнах, олон нийтэд мэдээллэх;
- Зөвшөөрөгдсөн судалгааны ажлуудыг хэвлэн нийтлүүлэх, илтгэл хэлбэрээр хурал, зөвлөгөөнд танилцуулах, зөвлөмж байдлаар холбогдох байгууллагуудад хүргүүлэх;
- Макро, микро эдийн засгийн судалгаа, түүвэр судалгааны чиглэлээр гадаад, дотоодын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн хүрээнд болон Төв банкны үйл ажиллагааг дэмжих чиглэлд Монголбанкнаас доорх сэдвүүдээр эмпирик болон түүвэр судалгааны ажлуудыг боловсруулж дотоодын болон олон улсын сэтгүүлүүдэд нийтэлсэн.

- Хүртгэмжтэй өсөлт ба түүнд нөлөөлөх хүчин зүйлс;
- Farmland Rental Rates;
- Орлогын тэгш бус байдлыг бууруулахад ээлтэй татварын бодлого;
- Банкны салбарын эмзэг байдлын дохиологч индикаторууд;
- Inflation forecasting with machine learning methods: A case of Mongolia;
- Их өгөгдлийн Төв банкна дахь хэрэглээ;
- Уур амьсгалын өөрчлөлтийн нийгэм, эдийн засагт үзүүлж болох нөлөө, учирч болох эрсдэл: Монгол Улсын жишээ;
- Төв банкны бие даасан байдлын шүүмжлэл ба Монголбанкны туршлага;
- Уул уурхайн болон уул уурхайн бус салбарын хамаарлыг судлах нь;
- Сүүдрийн эдийн засгийг хэмжих нь;
- Монгол Улсын өрхийн түүвэр судалгаа;
- Орчин үеийн аж үйлдвэрийн бодлого ба ногоон эдийн засаг;
- Macroeconomic Effects of COVID-19 in a Commodity-Exporting Economy: Evidence from Mongolia;
- Socio-economic recovery from the Covid-19 pandemic: Macroeconomic impacts and policy issues in Mongolia;
- Macroeconomic modeling for optimal stabilization policy in Mongolia;
- Measuring Sudden Stops in Mongolia
- The policy-driven boom and bust in the housing market: Evidence from Mongolia;
- Non-Performing Loan Recovery: The Case of Mongolia
- The Dynamics of Business Cycle Connectedness and the Decoupling of Asia-Pacific
- Mongolia's economic outlook
- Development and Access to Finance of Small and Medium-Sized Enterprises in Mongolia
- Measuring the natural rate of interest in a commodity exporting economy: Evidence from Mongolia

- Иргэд, ААН болон шинжээчдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа;
- Банкны зээлийн төлөвийн судалгаа;
- Худалдан авалтын менежрийн индекс (PMI) тооцох түүвэр судалгаа;
- Өрхийн санхүүгийн байдал, хэрэглээний түүвэр судалгаа;
- Бизнесийн түүвэр судалгаа;
- Уул уурхайн бус экспортлогчдын түүвэр судалгаа.

Судалгааны ажлуудын дэлгэрэнгүйг Монголбанкны цахим хуудасны судалгаа хэсгээс (<https://www.mongolbank.mn/mn/research>) харна уу.

3.1 МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ

Монголбанк нь 13 газар, 1 төв, 1 хүрээлэн, 3 бие даасан алба, орон нутаг дахь 5 хэлтэс, 12 салбар, 1 төлөөлөгчийн газартайгаар мөн Төв аппаратад 542, орон нутаг дахь хэлтэс, салбарт 121, нийт 663 батлагдсан орон тоотойгоор үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Монголбанк 2022 онд дэвшүүлсэн үйл ажиллагааны шинэчлэлийн дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх, хүний нөөцийн чадавхи болон хууль, эрх зүйн орчинг сайжруулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх, дэвшилтэт технологи, арга ажиллагааг нэвтрүүлэх чиглэлээр багагүй ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Монголбанкны үйл ажиллагааг илүү тодорхой болгох, шийдвэр гаргах хэлбэр, үйл явцыг ил тод болгох, хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж байна.

2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг баталж, тус хуулийг 2022.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхлэхтэй холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А-354 дугаар тушаалаар”Монголбанкны хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан.

Хүний нөөцийн чадавхийг сайжруулах, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, өндөр мэдлэг чадвартай чадварлаг боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого баримталж, ажилтнуудаа тасралтгүй сурган хөгжүүлэх, тэдний ажиллах нөхцөл, цалин урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэн ажилласан.

Сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар Монголбанкны ажилтнуудыг цахим орчинд үр ашигтай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажлын хэрэгцээнд цуглуулсан бүх төрлийн мэдээллийг цахим хэлбэрээр хадгалах, түгээх, ашиглах, түүнд үндэслэн шинжилгээ хийхэд чиглэсэн Мэдээллийн технологийн шинэчлэлийг үе шаттайгаар хийлээ.

3.2 ДОТООД АУДИТ

Дотоод аудитын газар нь байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн хараат бус, бие даасан, бодитойгоор баталгаажуулах үндсэн зорилгын хүрээнд Монголбанкны бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд аудит, шалгалт хийх, зайны болон дараалсан хяналт тавьж, удирдлагыг мэдээллээр хангах, аудит, хяналт, шалгалтын үр дүнгээр шийдвэр гаргуулж, биелэлтийг хангуулан ажиллах замаар байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх, бууруулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дотоод аудитын газраас Монголбанкны төвийн болон орон нутаг дахь нэгжүүдэд хийх 2022 оны дотоод аудитын төлөвлөгөө, удирдамжийг үйл ажиллагаанд чиглүүлэн (process focused audit) боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгчөөр батлуулсан. Батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу Монголбанкны төвийн үйл ажиллагаанд 8, орон нутаг дахь Монголбанкны нэгжүүдийн үйл ажиллагаанд 8, нийт 16 аудитыг хийж гүйцэтгэн, үр дүнг удирдлагад танилцуулж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг батлуулан, биелэлтэд хяналт тавьж ажиллалаа.

Дотоод аудитын газар нь эрсдэлд суурилсан дотоод аудитын арга барилыг сайжруулах, хөгжүүлэх зорилгоор Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлж буй “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-д хамрагдан, зөвлөх үйлчилгээг 2019-2022 онуудад авч ажилласан.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд хөндлөнгийн чанарын үнэлгээ хийлгэж, түүнд үндэслэн Монголбанкны дотоод аудитын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх зөвлөмж бүхий “Чанарын баталгаажуулалт ба сайжруулалтын хөтөлбөр”-ийг 2023-2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулсан.

Төлөвлөгөөний хүрээнд дараах голлох ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

1. “Монголбанкны дотоод аудитын дүрэм”-ийг олон улсын стандартыг жишиг болгон Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нийцүүлэн шинэчлэн батлуулсан.
2. Аудитын тайланг CCCE (Criteria, Condition, Cause and Effect) загварыг ашиглан шинэчлэн боловсруулсан бөгөөд ингэснээр аудитын тайлан нь товч, тодорхой болж, аудитаар илэрсэн асуудал тус бүрийн нөхцөл байдал, үүссэн шалтгаан, үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж байна.
3. Аудитаар илэрсэн асуудал тус бүрд эрсдэлийн үнэлгээ хийж эрсдэлийн түвшинг тодорхойлж, аудитын тайланд тусгаж байна.
4. Эрсдэлд суурилсан аудитын арга барилыг сайжруулах ажлын хүрээнд аудитын эрсдэлийн үнэлгээ хийх бэлтгэл ажлыг хангахаар Монголбанкны аудитын хамрах хүрээг тодорхойлж, “Эрсдэлийн үнэлгээ хийх, түүнд үндэслэн төлөвлөгөө боловсруулах журам”-ын төслийг боловсруулсан.
5. “Монголбанкны мэдээллийн технологийн аудит хийх заавар”, “Дотоод чанарын давтамжит үнэлгээ хийх журам”-ын төслүүдийг боловсруулсан.
6. Дотоод аудиторуудын олон улсын институтын Монгол дахь төлөөлөгчийн газраас зохион байгуулсан сургалтуудад 5 ажилтан, “Монгол Улсын Дотоод аудиторуудын форум”-д газрын удирдлага болон ахлах ажилтнууд тус тус оролцсон.

Монголбанкны 2021 оны санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулах ажлыг зохион байгуулж, аудитын ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, аудитыг төлөвлөсөн хугацаанд дуусгасан.

Үндэсний аудитын газрын “Монголбанкнаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой авч байгаа арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн”-д хийсэн аудитын ажлын хэсгийг шаардлагатай мэдээллээр хангаж хамтран ажилласан.

Монголбанкны Хяналтын зөвлөлд улирал тутам ажлаа тайлагнаж, Хяналтын зөвлөлөөс Монголбанкинд өгсөн зөвлөмжүүдийн биелэлтийг дүгнэн Хяналтын зөвлөлийн хуралд танилцуулан хамтарч ажиллалаа.

3.3 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Монголбанк гадаад валютын улсын нөөцийн удирдлага, төв банкны зээл, санхүүжилтийн үйл ажиллагаанд учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийн удирдлагын хүрээнд гадаад валютын улсын нөөц (ГВУН)-ийн стратегийн хөрөнгө оруулалтын бүтэц, бенчмарк багц, банк, санхүүгийн байгууллагад олгох лимитийг тодорхойлох, гүйцэтгэлд нь хяналт тавих, тайлагнах, төв банкны зээл, санхүүжилтийн барьцаа хөрөнгийн шалгуурыг тодорхойлох, барьцаа хөрөнгийн жагсаалтыг гаргах, эрсдэлийн хямдруулалтын хувь хэмжээг тогтоох, санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийг тооцох аргачлалыг боловсруулах, гүйцэтгэлд нь хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа. Түүнчлэн санхүүгийн бус эрсдэлийн удирдлагын хүрээнд үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага болон үйл ажиллагааны тасралтгүй байдлын удирдлагыг хэрэгжүүлэн ажиллав.

Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Гадаад валютын улсын нөөцийн эрсдэлийн удирдлага

Тайлант онд гадаад валютын нөөцийн удирдлагын хүрээнд Монголбанкны төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн талаар баримтлах бодлого, гадаад өр төлбөрийн бүтэц, импортын барааны төлбөр тооцооны валютын бүтэц, банкуудын гадаад гүйлгээний гадагшлах урсгал болон дотоодын валютын захын бүтэцэд үндэслэн ханшийн эрсдэлийг хамгийн бага байлгах валютын бүтцийг тодорхойлж, хэрэгжилтийг ханган ажиллав. Үүний зэрэгцээ зах зээл дэх хүүний өөрчлөлтөөс шалтгаалж хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн үнэ цэнэ буурах эрсдэлийг хамгийн бага байлгах үүднээс нөөцийн дэд багц тус бүрийн хувьд үргэлжлэх хугацаа болон түүний хазайлтын оновчтой хэмжээг тогтоох замаар хүүний хэлбэлзлээс үүсч болзошгүй зах зээлийн эрсдэлийг удирдан ажиллалаа.

Олон улсад инфляцын дарамт нэмэгдэж, улс орнуудын төв банкууд бодлогын хүүгээ хурдацтай нэмэгдүүлсэн нь хөгжиж буй улс орнуудын хувьд хөрөнгийн гадагшлах урсгал ихсэх, санхүүжилтийн өртөг нэмэгдэх, дахин санхүүжилтийн эрсдэлийг нэмэгдүүлэх зэргээр гадаад зах зээлийн орчны сөрөг нөлөө тайлант онд нэмэгдсэн. Түүнчлэн дэлхий нийтэд геополитикийн эрсдэл нэмэгдсэн, томоохон эдийн засаг бүхий улс орнууд эдийн засгийн хямралтай тулгарч болзошгүй нөхцөл байдал үүссэн нь ГВУН-ийг удирдахад зайлшгүй харгалзан үзэх бодит эрсдэлүүдийг бий болгосон. Иймд тайлант онд гадаад валютын нөөцийн удирдлагын хүрээнд төлбөр тооцооны эрсдэл, зах зээлийн эрсдэл, үүний дотор хүүний түвшний эрсдэлийг харгалзан үзэж ГВУН-ийг удирдлаа. ГВУН-ийн стратегийн хөрөнгө оруулалтын бүтцийн тооцооллыг сайжруулах ажлын хүрээнд стратегийн хөрөнгө оруулалтын багцын тооцоололд алдааны шинжилгээ хийх судалгааны ажлыг гүйцэтгэж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэв. Ингэснээр ГВУН-ийн стратегийн хөрөнгө оруулалтын бүтцийг тодорхойлоход ашигласан таамаглалууд болон түүнд үндэслэн тооцоолсон багцын эрсдэл, үр өгөөжийн үзүүлэлтүүд нь бодит гүйцэтгэлээс хэр зөрүүтэй байгааг эргэн хянаж, цаашид стратегийн хөрөнгө оруулалтын бүтцийг тодорхойлоход үр дүнг нь ашиглах боломж бүрдэж байгаа юм.

Хэдийгээр 2022 онд нөөцийг байршуулдаг ихэнх хөгжингүй орнуудын эдийн засаг Ковид-19 цар тахлаас үүдсэн зогсонги байдлаас гарч сэргэж эхэлсэн ч түүхий эдийн үнэ өссөн, дэлхий нийтэд инфляцын дарамт нэмэгдэж, хүүний түвшин урт хугацаанд өндөр байх нөхцөл бүрдсэн. Хүүний түвшний өсөлт, инфляцын дарамтаас шалтгаалж олон улсад бодит секторын эрсдэл нэмэгдэж, улмаар санхүүгийн салбарт эрсдэл нэмэгдэх хандлага ажиглагдсан тул тайлант онд харилцагч банк, санхүүгийн байгууллагаас хүлээж болзошгүй зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор эрсдэл багатай төв банк, олон улсын санхүүгийн байгууллагуудад нөөцийг байршуулах, нэг харилцагчид олгох лимитийг бууруулах бодлого баримтлав. Тухайлбал, богино хугацаат багцыг олон улсын байгууллага болон төв банкуудад түлхүү тархаан байршууллаа. Түүнчлэн зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд гадаадын харилцагч банк, санхүүгийн байгууллагуудын санхүүгийн чадавхид шинжилгээ хийж, санхүүгийн гол үзүүлэлтүүд, зээлжих зэрэглэл, хувьцааны үнийн динамик, CDS спред болон тэдгээр байгууллагын талаарх онцгойлох мэдээ, мэдээллийг багтаасан танилцуулга товхимолыг улирал тутам гаргав.

Гадаад валютын нөөцийн удирдлагын хүрээнд хөрвөх чадварын эрсдэлийг удирдах зорилгоор нийт нөөцийг богино болон урт хугацаат хөрөнгө оруулалтын багцад хуваан удирдав. Нөөцийн хүрэлцээт байдлыг тодорхойлоход түгээмэл ашиглагддаг ОУВС болон бусад төв банкуудаас гаргасан аргачлалуудын дагуу хөрвөх чадвар өндөртэй богино хугацаат багцын оновчтой хэмжээг нийт гадаад өр төлбөрийн түүхэн мэдээлэл болон ирэх оны төсөөлөл, экспорт, импортын ирэх оны төсөөлөл зэрэг макро үзүүлэлтүүдэд үндэслэн тодорхойлж, үр дүнг нөөцийн удирдлагад ашигласан. Түүнчлэн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор нөөцийг харилцах, богино хугацаат хадгаламж, гадаадын засгийн газрын болон олон улсын байгууллагын богино хугацаат үнэт цаас зэрэг хөрвөх чадвар өндөртэй хэрэгслүүдэд байршуулж удирдлаа.

Түүнчлэн ГВУН-ийн хөрөнгө оруулалтын хэрэгслийн зах зээлийн үнэлгээ, эрсдэл, үр өгөөжийн гүйцэтгэл, тогтоосон бүтэц, лимитийн гүйцэтгэлийг өдөр тутам тооцож, хяналт тавин ажиллав. Түүнчлэн бусад улсын төв банк болон олон улсын санхүүгийн байгууллагын гадаад валютын нөөцийн удирдлагын тайлагналын зарчим, практикийг судалж, тэргүүн туршлагыг нөөцийн удирдлагын тайлагналд нэвтрүүлээ.

Мөнгөний бодлогын хэрэгжилттэй холбоотой эрсдэлийн удирдлага

Мөнгөний бодлого, санхүүгийн тогтвортой байдлын зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Монголбанкнаас банканд олгох зээл, санхүүжилтийн барьцаа хөрөнгийн төрлийг тодорхойлох, бодит үнэ цэнийг тооцох аргачлалыг боловсруулах, эрсдэлийн хямруулалтын хувь хэмжээг тогтоох зэрэг барьцаа хөрөнгийн бодлогоор дамжуулан төв банкны хүлээх зээлийн эрсдэлийг удирдаж ажиллалаа. Тайлант хугацаанд батлагдсан барьцаа хөрөнгийн бодлогын дагуу Монголбанкнаас банкуудад олгосон зээл, санхүүжилтийн барьцаа хөрөнгийн үнэлгээг тухай бүр хийж, барьцаа хөрөнгийн хүрэлцээг хангаж ажиллав.

Төв банкны мөнгөний бодлогын зорилт, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндсэн чиг үүргийн хүрээнд эдийн засгийн ердийн болон хямралын үед баримтлах барьцаа хөрөнгийн бодлогыг тодорхойлох, цаашид төв банкны ердийн болон хямралын үеийн барьцаа хөрөнгийн бодлогын баримт бичгийг боловсруулах, зах зээл дээр шинээр бий болж буй санхүүгийн хөрөнгүүдийг судлан барьцаа хөрөнгийн жагсаалтыг өргөжүүлэх, Монголбанкны мөнгөний бодлогын хэрэгслийн үр ашгийг нэмэгдүүлэх, төв банкны санхүүгийн эрсдэлийн удирдлагын хүрээнд авах зохистой арга хэмжээг тодорхойлох зорилгоор “Ердийн болон хямралын үеийн төв банкны барьцаа хөрөнгийн бодлого” судалгааны ажлыг гүйцэтгэв. Түүнчлэн хямралын үед Монголбанк барьцаа хөрөнгийн жагсаалтыг өргөжүүлэх шаардлага үүссэн тохиолдолд банкуудын төв банканд нэмж барьцаалах боломжит санхүүгийн хөрөнгүүдийг тодорхойлох зорилгоор банкны салбарын активын шинжилгээг улирал тутам хийв.

Сүүлийн жилүүдэд төв банкны нийт активын өсөлт, тайлан тэнцлийн бүтцийн өөрчлөлттэй уялдан төв банканд учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг тодорхойлох, удирдах асуудал чухлаар хөндөгдөх болсон. Энэ чиглэлээр Европын улсуудын төв банкууд нэлээд ач холбогдол өгч, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийх, учирч болзошгүй эрсдэлд анхаарлаа хандуулах, хэмжих арга хэрэгслүүдийг боловсронгуй болгох, эрсдэлийг бууруулах арга хэмжээг өргөжүүлсэн байдаг. Энэхүү олон улсын чиг хандлагыг даган Монголбанк Дэлхийн банкны “Sovereign balance sheet analysis” аргачлалын дагуу төв банкны санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг эрсдэлийн төрлөөр нь шинжилж, үүсч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, үнэлэх, эрсдэлийг удирдах арга хэмжээг авч ажиллалаа.

Монголбанк “Санхүүгийн тайлагналын олон улсын 9 дүгээр стандарт”-ын дагуу өөрийн эзэмшиж буй хорогдуулсан өртгөөр нь бүртгэх болон бодит үнэ цэнийг хэмжиж өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогод тайлагнах санхүүгийн хөрөнгийн хүлээж болзошгүй алдагдлыг улирал тутам тооцож, болзошгүй эрсдэлийн нөөц сангийн зохистой хэмжээг тодорхойлж, холбогдох эрсдэлийн санг байгуулсан. Ингэснээр төв банкны тайлан тэнцлийг олон нийтэд бодитой, үнэн зөв толилуулж, төв банкны олон нийтэд итгэх итгэлийг бэхжүүлэх, нөгөө талаар учирч болзошгүй эрсдэл бодитоор үүсэх үед эрсдэлийг удирдахад бэлэн байдлыг хангах ач холбогдолтой юм. Мөн тайлант онд хүлээж болзошгүй алдагдлыг тооцох аргачлалыг сайжруулах талаар судалж, үр дүнг тооцоололд тусгалаа.

Монголбанкны эзэмшиж буй зарим санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлж, үүсч болзошгүй зах зээлийн эрсдэлийг тухай бүр тайлан тэнцэлд тусган ажиллалаа. Түүнчлэн гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэх, зээлийн хүү, гадаад валютын зээлийн өсөлтийг бууруулах зорилгоор дотоодын банкуудтай байгуулсан урт хугацаат своп хэлцлийн дахин үнэлгээг долоо хоног тутам гүйцэтгэж санхүүгийн тайланд тусгав.

Түүнчлэн банк хоорондын валютын захыг идэвхжүүлэх зорилгоор валютын арилжааны системийн үндсэн дилерийг улирал тутам сонгох, банк хоорондын валютын арилжаанд оролцогчдын төлбөр

тооцооны эрсдэлийг бууруулах үүднээс тухайн оролцогчид арилжааны өдрийн лимитийг тогтоож ажиллалаа.

Санхүүгийн бус эрсдэлийн удирдлага

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Тайлант онд үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах зорилгоор онолын судалгааны ажлууд, бусад улс орны төв банкуудын тэргүүн туршлагыг судалж, улмаар эрсдэлийн засаглалын тогтолцоог бэхжүүлж, эрсдэлийг үнэлж, тодорхойлох арга хэрэгслүүдийг амжилттайгаар хэрэгжүүлэн ажиллалаа. Тухайлбал, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагад түгээмэл ашиглагддаг үнэлгээний хэрэгсэл болох “Өөрийн үнэлгээ” (Risk Control and Self-Assessment)-г бүх ажилтнуудаар хийлгэж, үр дүнд үндэслэн холбогдох арга хэмжээг авч ажиллав. Үүнээс гадна эрсдэлтэй тохиолдол гарах, үүсэх бүрт эрсдэлийн мэдээллийн санд мэдээллийг оруулж баяжуулах, үйл ажиллагааны эрсдэлийн гол үзүүлэлтүүд (KRIs)-ийн гүйцэтгэлийг тухай бүр хянаж, тайлагнав. Энэ нь үйл ажиллагааны эрсдэлийг бодит хэмжүүрээр хэмжиж, эрсдэл үүсгэж буй хүчин зүйлсийн гол шалтгааныг олж тодорхойлон, тохирсон арга хэмжээг авахад чухал хувь нэмэр оруулж байна. Түүнчлэн тайлант онд Монголбанкны гадаад валютын улсын нөөцийн удирдлагын үйл ажиллагаанд эрсдэлийн зураглалын үнэлгээг хийж, үр дүнд үндэслэн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажилласан. Түүнчлэн үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын үр өгөөжийг сайжруулах зорилгоор “Сценарь шинжилгээ хийх заавар”-ыг боловсруулан батлав.

Олон улсын туршлагад үндэслэн “Үйл ажиллагааны эрсдэлийн соёлд нөлөөлөгч хүчин зүйлс” сэдвээр судалгааны ажлыг хийж, үр дүнд нь үндэслэн Монголбанкны эрсдэлийн соёлын төлөвшлийг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллав. Эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж нь Монголбанкны бүх газар нэгжүүдийн үйл ажиллагааны эрсдэл хариуцсан ажилтнууд, шинэ ажилтнууд, орон нутгийн нэгжийн ажилтнуудад сургалт, уулзалтыг тогтмол зохион байгуулж, эрсдэлийн удирдлагын харилцан уялдааг ханган ажиллалаа. Тодруулбал, байгууллагын хэмжээнд эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг, мэдээллийг түгээж, үйл ажиллагааны эрсдэлийн соёлыг төлөвшүүлэх, нөгөө талаар нэгж тус бүр хоорондоо нягт уялдаа холбоотой хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэв. Түүнчлэн Монголбанкны хэмжээнд үйл ажиллагааны эрсдэлийн нэгдсэн ойлголттой болох үүднээс үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын нэр томъёоны толь бичгийг боловсруулан товхимол болгон хэвлүүлж нийт ажилтнуудад хүргүүлэв.

Үйл ажиллагааны тасралтгүй байдлын удирдлага

Тайлант онд Монголбанкны үйл ажиллагааны тасралтгүй байдлын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор “Монголбанкны үйл ажиллагааны тасралтгүй байдлын удирдлагын бодлогын баримт бичиг”, “Монголбанкны үйл ажиллагааны тасралтгүй байдлын ерөнхий төлөвлөгөө”-г тус тус боловсруулан баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллав. Эдгээр баримт бичигтэй уялдуулан Монголбанкны үндсэн үйл ажиллагааг хариуцсан нэгжүүдийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах тусгайлсан төлөвлөгөөг боловсруулах юм.

3.4 МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Монголбанкны Мэдээллийн технологийн газар нь 2022 онд банк хоорондын валют арилжааны цахим талбар, зээлийн мэдээллийн сан болон байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглаж буй цахим мэдээллийн системүүдийн хөгжүүлэлтийг хийж, аюулгүй, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж ажиллалаа.

Мөн одоо ашиглагдаж байгаа системүүдийг сайжруулах, боловсронгуй болгохын зэрэгцээ шинэ техник, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

- Монголбанкны Цахим оффисын гар утасны хувилбарыг Android болон iOS үйлдлийн системд зориулан хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүллээ. Уг аппликэйшнийг ашиглан Монголбанкны нийт ажилтнууд ирсэн цагаа бүртгүүлэхээс гадна цаг өдрийн чөлөө, ээлжийн амралт, амралтын өдрөөр ажиллах хүсэлтийг өөрийн гар утсыг ашиглан гаргах боломжтой болсон.
- Монголбанкны цахим хуудсыг технологи болон агуулгын хувьд бүрэн шинэчилж нэвтрүүллээ. Цахим хуудасны мэдээллийг Монголбанкны цахим оффисоос бүрэн удирдах болсон нь аюулгүй байдлыг нэмэгдүүлж, мэдээллийн урсгалыг илүү оновчтой болгосон. Мөн “Цахим хуудас эрхлэх журам”-г шинэчилж Монголбанкны газар, хэлтэс, албадууд цахим хуудасны өөрт хамааралтай хэсгийг шинэчилж, баяжуулах боломжтой болсон.
- Монголбанкны цахим архивын системийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-д нийцүүлэн, Монголбанкны цахим албан хэрэг хөтлөлтийн дэд бүтцийг боловсронгуй болгох чиг үүргийн дагуу шинээр хөгжүүлж нэвтрүүллээ.
- Орчин үеийн мэдээллийн технологийн салбарын онцлох технологи болох “Контейнер зохицуулах платформ” Kubernetes-г амжилттай нэвтрүүллээ. Уг технологи нэвтэрснээр мэдээллийн системд ашиглагдаж байгаа дотоод системүүдийн хэвийн найдвартай, тасралтгүй ажиллагаа сайжирч, эцсийн хэрэглэгч програм хэрэглэх явцад оруулж байгаа нэмэлт өөрчлөлтүүд нөлөөлөхгүй байх зэрэг олон давуу талуудтай юм.
- Лог мониторингийн системийг (Elastic) газрын үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Энэхүү системийн ашиглан Монголбанкны мэдээллийн технологийн системүүдийг бодит цагийн горимд хянах боломжтой болов.
- Сүлжээний урсгал хяналтын системийг нэвтрүүлэв. Төв болон орон нутаг дахь салбаруудын сүлжээний төхөөрөмжүүдийг холбож интернет холболтын хурд, төхөөрөмжийн хэвийн ажиллагаа зэргийг цаг алдалгүй хянах бүрэн боломжтой болсон.

3.5 ТӨВ БАНКНЫ ОЛОН НИЙТГЭЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА

Монголбанк олон улсын эдийн засагт тодорхой бус байдал өндөр энэ цаг үед макро эдийн засгийн тогтвортой байдал, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн бодлогын багц арга хэмжээг хэрэгжүүлж, бодлого шийдвэрийн үндэслэлээ олон нийтэд нээлттэй, ил тодоор тайлбарласаар ирлээ. Эдийн засагт шок ихтэй үед санхүүгийн зах зээлд савлагаа үүсэхээс сэргийлэх, үүссэн хүндрэлийг хохирол багатай даван туулж, цаашдын сэргэлтийг дэмжихэд олон нийттэй харилцаа чухал үүрэгтэй хэрэгсэл болж байна. Монголбанк олон нийттэй харилцах сувгуудаа хөгжүүлж, мэдээллийн агуулга чанарыг сайжруулан илүү оновчтой арга хэлбэрээр түгээхэд анхаарч дараах байдлаар ажиллалаа. Үүнд:

- **Бодлогын шийдвэр:** Мөнгөний бодлогын хорооны хурлын товгыг олон нийтэд урьдчилан зарлаж, хурлын шийдвэр болгоныг мөнгөний бодлогын мэдэгдэл болон хэвлэлийн хурлаар тогтмол нээлттэй танилцуулж байна.
- **Тайлан, судалгааны товхимол, статистик мэдээлэл:** Мөнгөний бодлогын шийдвэрийн үндэслэл болсон тооцоолол, эдийн засгийн шинжилгээ, төсөөллийг агуулсан Инфляцын тайлан болон Төв банкнаас нийтэлдэг бусад тайлан эмхэтгэл, судалгааны товхимол, статистик мэдээллүүдийг тогтсон хуваарийн дагуу олон нийтэд хүргэж, агуулга болон чанарыг тасралтгүй сайжруулж байна.
- **Мэдээллийн хүртээмж, зорилтот бүлгүүд:** Төв банкнаас түгээж буй мэдээллийн агуулгыг товч контент, инфографик, постер, видео шторк хэлбэрт шилжүүлэн илүү энгийн, ойлгомжтой байдлаар олон нийтэд түгээхэд анхаарч ажиллаж байна. Түүнчлэн, мэдээлэл түгээхдээ зах зээлийн

мэргэжлийн оролцогчид, төрийн шийдвэр гаргах байгууллагууд, олон улсын байгууллагууд, судалгааны байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд болон иргэд, аж ахуйн нэгжүүд тус бүрийн онцлог, хэрэгцээ шаардлагад тохирсон арга хэлбэрийг сонгож байна.

- **Төв банкны олон нийттэй харилцах сувгууд:** Монголбанк 2022 онд www.mongolbank.mn цахим хуудсаа бүрэн шинэчилж, нийгмийн цахим сүлжээ (сошиал нетворк)-ний хуудсуудыг өдөр тутам хөгжүүлж, хэвлэмэл бүтээгдэхүүнүүдийн агуулга, чанарыг сайжруулахад анхаарч ажиллалаа.
- **Олон улсын хамтын ажиллагаа:** Монголбанк төв банкны олон нийттэй харилцах харилцааны олон улсын нийтлэг сайн жишгийг судалж нэвтрүүлэх ажлыг тогтмол хийж байна. Үүний хүрээнд 2022 онд ОУВС, Английн төв банк болон Шведийн төв банкны экспертүүдээс бүрдсэн багийн зайнаас болон газар дээр хийсэн үнэлгээнд тулгуурлан боловсруулсан төв банкны олон нийттэй харилцах харилцааг сайжруулах зөвлөмжүүдийг хүлээн авч, хэрэгжүүлж эхлээд байна.

Төв банкны олон нийттэй харилцах харилцаа, түүний хөгжил

Төв банкны олон нийттэй харилцах харилцаа нь дараах мэдээллийг оролцогч талууддаа хүргэх, тайлбарлах үйл ажиллагааны цогц байдаг:

- **Зорилго:** Хуулиар төв банканд ногдуулсан зорилго;
- **Стратеги, арга хэлбэр:** Төв банк зорилгодоо ямар арга замаар хэрхэн хүрэх талаарх тайлбар;
- **Бодлогын шийдвэр, үндэслэл:** Эдийн засгийн ямар нөхцөл байдал дунд яагаад аливаа шийдвэрийг гаргасан талаарх тайлбар;
- **Эдийн засаг, төв банкны үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл**

Төв банкны олон нийттэй харилцах харилцаагаа хөгжүүлснээр зах зээл дээрх мэдээллийн тэгш бус байдлыг бууруулж, эдийн засагт оролцогчдын хүлээлтийг үр дүнтэй удирдах, эдийн засагт тогтвортой байдлыг бий болгох чухал ач холбогдолтой юм. Төв банкны оролцогч тал нь эдийн засагт оролцогч иргэд ба аж ахуйн нэгжүүд, төрийн бусад байгууллагууд, бусад төв банкууд болон олон улсын санхүүгийн байгууллагууд зэрэг өргөн цар хүрээтэй юм. Хэрэглэгчид, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид болон санхүүгийн зах зээлийн оролцогчдын хүлээлтээс макро эдийн засгийн олон үзүүлэлт, тэр дундаа инфляц ихээхэн шалтгаалдаг тул төв банкууд олон нийттэй харилцах харилцаагаа хөгжүүлэхэд анхаарч байна.

Тус хэрэгсэл нь төв банкны бодлогын үр нөлөөг дээшлүүлэх, институцын ил тод, нээлттэй байдлыг хангах, хараат бус байдлыг бэхжүүлэх зэрэг давхар олон ач холбогдолтой байдаг. Олон улсад төв банкууд 1990-ээд оноос инфляцыг онилох мөнгөний бодлогын арга хэлбэрт шилжиж эхэлснээс хойш зах зээлийн хүлээлтийг удирдах зорилгоор олон нийттэй харилцаанд чухал ач холбогдол өгч иржээ. 2008-09 оны Дэлхийн санхүүгийн хямралаас хойш олон нийттэй харилцах харилцаа нь төв банкны бодлогын чухал арга хэрэгсэл болон хөгжиж ирсэн байна. Хямралын үед ил тод, нээлттэй байдлаар хэрэгжүүлж буй бодлогоо тайлбарлах нь төв банкуудад итгэх итгэлийг дээшлүүлж, бодлогын үр дүнг сайжруулах гарц зам байв. 2020 оноос хойш дэлхийн эдийн засагт шок үүсгэсэн Ковид-19 цар тахал болон геополитикийн эрсдэл, тодорхой бус байдал дунд зах зээлийг тогтвортой байлгах, эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад төв банкуудын олон нийттэй харилцаа чухал үүрэг гүйцэтгэсээр байна.

Монголбанкны ил тод байдал, олон нийттэй харилцааны үнэлгээ

Монголбанкны олон нийттэй харилцах үйл ажиллагаанд олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэхийн зэрэгцээ цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сайжруулж ирлээ. Үүний үр дүнд Төв банкны бодлого, үйл ажиллагааны олон нийтэд танигдсан байдал харьцангуй нэмэгдсэн болох нь “Монголбанкны ил тод байдал, олон нийттэй харилцааны үнэлгээ” (ДоБиЧи Консалтинг, 2021)-ээс тодорхой байна. Хөндлөнгийн мэргэжлийн байгууллага хийж, Улаанбаатар хотын 9 дүүрэг, 158 байгууллагын төлөөлөл нийт 1056 түүврээс авсан тус түүвэр судалгаа нь дараах үр дүнг харуулж байна. Үүнд:

1) Танигдсан байдлын матрицын үнэлгээ нэмэгдсэн

Судалгаанд оролцсон нийт иргэдийн итгэл, танигдсан байдал (51 хувь, 42 хувь) нь матрицын үнэлгээ дундаж утгад ойр, мөн алслагдсан хороодын иргэдийн матрицын үнэлгээ (50 хувь, 42 хувь) нь түүврийн дундаж утгаас ялгаагүй гарсан байна. Иргэдийн түүвэртэй харьцуулахад судлаачид Монголбанкны үйл ажиллагааг илүү мэддэг, танигдсан байгаа нь харагдаж байна. Хувийн хэвшил болон төрийн байгууллагад ажиллаж буй оролцогчид илүү итгэлтэй, илүү мэдлэг, мэдээлэлтэй байдаг бол мэргэжлийн байгууллагын төлөөлөл, судлаачид болон зохицуулагч байгууллагын төлөөллүүд дундаас дээгүүр итгэлтэй байна. Энэхүү судалгааны үр дүн нь 2017 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад харьцангуй сайжирсан, дундаас дээш түвшинд ирснийг тодорхой харж болохоор байна.

2) Eijffinger and Geraats (EG) индексийн үнэлгээ сайжирсан

Олон улсад төв банкны ил тод байдлыг үнэлэхдээ EG-индексийг / Eijffinger and Geraats index (2002)/ хэрэглэдэг. EG-индекс нь 5 бүлэг дотроо 3 дэд нийт 15 асуултуудтай. Асуултууд нь 2 болон 3 сонголттой хариултуудтай. Хариултуудад 0, 0.5, 1 гэсэн оноогоор харгалзан дүгнэх бөгөөд индексийг эдгээр оноонуудын нийлбэрээр тооцно. EG-индекс хамгийн багадаа 0, хамгийн ихдээ 15 гэсэн утга авна. Индексийн утга 15 уруу тэмүүлэх тусам тухайн төв банкны ил тод байдал сайн байгааг харуулна.

Монголбанкны ил тод байдлыг EG индексийн түвшингээр нийт судлаачдын 37 хувь нь 12-15 оноо, 35 хувь нь 9-12 оноо, 20 хувь нь 6-9 оноо, 7 хувь нь 3-6 оноо, 1 хувь нь 0-3 оноо гэж үнэлсэн ба EG индекс дунджаар 10.4 оноо буюу 69.3 хувьтай байна. Монголбанкны итгэлтэй байдал дундаас дээгүүр үнэлэгдсэн бөгөөд иргэд илүү их итгэлтэй байдаг бол байгууллагуудын хувьд дунд зэргийн итгэлтэй байна. Монголбанкны олон нийттэй харилцах үйл ажиллагааг нийт түүвэр дундаас дээгүүр үнэлсэн бөгөөд байгууллагууд дундаас доогуур гэж үнэлж байна. Үүнээс харахад Монголбанкнаас танилцуулж буй мэдээ, мэдээлэл, үйл ажиллагаа нь 2016 оноос хойш олон нийтэд хүрч, сайжирсан, Монголбанкинд итгэх итгэл нэмэгдсэн, олон нийттэй харилцах үйл ажиллагаа үр дүнгээ өгч буйг харж болохоор байна.

3.6 ГАДААД ХАРИЛЦАА

Монголбанкны гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд:

- Мастеркарт байгууллагатай EMV чип технологийг үндэсний брэнд Т-картад нэвтрүүлэхэд амжилттай хамтран ажилласан туршлагад үндэслэн Төв банкнаас цахим мөнгө гаргах чиглэлээр тус байгууллагатай хамтран ажиллах боломжийн талаар санал солилцов.
- Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны “Үймээн самуунтай цаг үед сорилтуудыг давж гарах нь” сэдэвт жилийн уулзалтад Мароккогийн Хант Улсын Маракеш хотноо амжилттай оролцож санал солилцов.
- Валютын судалгааны байгууллагаас зохион байгуулсан Төв банкны төлбөрийн системийн чуулга уулзалтад амжилттай оролцож бусад Төв банкны төлөөлөгчидтэй санал солилцов.
- Монголбанк, Бүгд Найрамдах Унгар Улсын Төв банк хооронд 2022 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Улаанбаатар хотноо хоёр улсын банкны салбарын харилцааг тасралтгүй дэмжих, харилцаа холбооны сувгийг хөгжүүлэх замаар урт хугацааны хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурав.
- Монголбанк, Солонгосын хөрөнгийн удирдлагын корпораци (КАМКО)-тай 2022 оны 8 дугаар сард Бүгд найрамдах Солонгос Улсын Бусан хотноо чанаргүй хөрөнгийг үр дүнтэй бууруулах чиглэлээр туршлага солилцох, хүний нөөцийг чадавхжуулах, хөрөнгийн удирдлагын компаниудын маркетинг, үйл ажиллагааны стратегийг боловсруулах чиглэлээр хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав.

- Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 25 дахь удаагийн жилийн уулзалтад амжилттай оролцов.
- Азийн Хөгжлийн Банкны “КОВИД-19 цар тахлын дараах Уур амьсгалд тэсвэртэй ногоон эдийн засгийг дэмжих” сэдэвт жилийн уулзалтад Бүгд Найрамдах Филиппин Улсын Манила хотноо Монголбанкны Ерөнхийлөгч амжилттай оролцов.
- Олон Улсын Валютын Сан болон Дэлхийн Банкны Группийн Ерөнхийлөгч нарын Зөвлөлийн жил бүр зохион байгуулдаг уулзалтад амжилттай оролцож дэлхийн эдийн засгийн төлөв байдал, ядуурлыг бууруулах, эдийн засгийн хөгжил, тусламжийн үр дүнтэй байдлын талаар хэлэлцэж, санал солилцов.
- Монголбанк, Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын “Мэдлэгийн түншлэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд Хангүк их сургуультай хамтран “Компанийн зохистой засаглал” (Enhancing Corporate Governance)” сэдвээр хамтарсан судалгаа гаргав.
- Монгол улс, ОХУ-ын банк хоорондын дугуй ширээний Тав дугаар уулзалтыг 2022 оны 10 дугаар сард Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулав.
- Зүүн Өмнөд Азийн Төв Банкуудын холбооны 42 дахь удаагийн Төв банкны Ерөнхийлөгч нарын зөвлөлийн “Өнөөгийн дэлхийн болон Азийн эдийн засгийн нөхцөл байдал, шилжилтийн үеийн сорилтууд, уур амьсгалын санхүүжилтийн цар хүрээг нэмэгдүүлэх” сэдэвт ээлжит хуралд Камбожийн Хаант Улсын Сием Рип хотноо гишүүн Төв банкны хувьд амжилттай оролцож, өнөөгийн дэлхийн болон Азийн эдийн засгийн нөхцөл байдал, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой шилжилтийн үеийн сорилтууд болон үүний эсрэг тэмцэхэд шаардлагатай санхүүжилтийн асуудлаар санал солилцож, хэлэлцэв.
- Монгол Улсын Гадаад Харилцааны Яам болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Америкийн Нэгдсэн Улс болон Япон Улсын Элчин Сайдын яамтай хамтран Эрдэм шинжилгээний хурлыг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулав.
- Олон Улсын Валютын Сангийн “Safeguard Assessment” багийн төлөөлөгчид Монголбанканд 2022 оны 8 дугаар сараас 9 дүгээр сарын хооронд хамгаалалтын үнэлгээ хийж дүгнэлт авав.
- Төв банкны олон нийттэй харилцах харилцааг сайжруулах хүрээнд Олон Улсын Валютын Сангийн техник туслалцааны баг үнэлгээ хийж, 12 зөвлөмжийг Монголбанканд хэрэгжүүлэхээр болов.
- Олон Улсын Валютын Сангийн Дүрмийн 4-р заалтын дагуу ОУВС, Монголбанк, Сангийн яам гурван талт уулзалтыг зохион байгуулж Монголбанк-ОУВС-ийн ганцаарчилсан уулзалтаар 2023 оны Мөнгөний бодлогын үндсэн чиглэл, Төлбөрийн тэнцэл, мөнгөний статистик, гадаад өр, өрийн тогтвортой байдлын шинжилгээ, ханшийн бодлого, төсвийн шинжтэй санхүүжилт, Санхүүгийн тогтвортой байдал, Банкны салбарын шинэчлэл, IPO, AQR, AML/CFT-тэй холбоотой асуудлууд, Өрхийн өр, зээлийн мэдээллийн албаны үйл ажиллагааны талаар хэлэлцэв.
- Уул уурхайн бус экспортыг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд Олон Улсын Санхүүгийн байгууллага, АНУ-ын Элчин сайдын яам, Азийн хөгжлийн банк, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банктай хамтран ажиллав.

Мөн хамтын ажиллагааны хүрээнд:

- Бүгд Найрамдах Турк улсын Төв банктай 2011 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд тус банкны дэргэдэх Төв банкны Стамбул сургууль (Istanbul School of Central Banking) дээр хоёр талт хөтөлбөрт цахимаар оролцлоо. 2022 оны хөтөлбөрийн хүрээнд “Хөгжиж буй зах зээлийн Төв банкуудад BigData ашиглах нь” сэдвээр хамтран туршлага солилцов.

- Олон Улсын Валютын Сангийн Кавказ, Төв Ази, Монголын бүсийн сургалтын төв (ССАМТАС)-ийн Удирдах хороонд Монголбанк томилогдож, зөвлөлийн шийдвэрлэх уулзалтуудад оролцов. Төв банкны чадавхыг бэхжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө, хэрэгцээ шаардлагыг танилцуулж, Монголын банкны тогтолцооны онцлогоос хуваалцав.
- Зүүн Өмнөд Азийн Төв Банкуудын Холбоо (SEACEN) гишүүний хувьд “Мөнгөний бодлогын асуудал, сорилтууд” сэдвээр лекц, дасгал/семинар хосолсон хэлбэрээр цахим сургалтыг амжилттай зохион байгуулав.

Монголбанк 2022 онд Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Зүүн өмнөд Азийн Төв банкуудын холбооны судалгаа, сургалтын төвийн жилийн ээлжит болон удирдах зөвлөлийн хурлуудад цахимаар болон биечлэн тогтмол оролцож, тулгамдсан асуудал хэлэлцүүлэгт илтгэл тавин оролцов. Түүнчлэн Зүүн өмнөд Азийн Төв банкуудын холбооны судалгаа, сургалтын төв, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундесбанк, Швейцарын Холбооны Улсын Үндэсний Банкны Лузанны их сургууль, Бүгд Найрамдах Франц Улсын Төв банкны Олон улсын банк, санхүүгийн институт, Олон улсын төлбөр тооцооны банкны Санхүүгийн тогтвортой байдлын институт, Олон улсын валютын сангийн Сингапур Улс дахь сургалтын институт, Дэлхийн банкны Нөөцийн зөвлөгөө, удирдлагын түншлэл хөтөлбөр хийгээд бусад орны Төв банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран КОВИД-19 цар тахлын дараах хүний нөөцийн чадавхыг сайжруулах, хөгжүүлэх чиглэлээр нягт холбоотой ажиллаж, цахим болон биечлэн оролцох сургалтуудад Монголбанкны ажилтнуудыг тогтмол хамруулж ажиллав.

3.7 ЭРДЭНЭСИЙН САН, МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ТАНХИМ

Монголбанкны Эрдэнэсийн санд НТӨ (Нийтийн тооллын өмнөх) I мянганаас – XII зууны үеийн археологийн олдворууд болох Хүннүгийн үеийн ноёдын морин тэрэгний алт, мөнгө, хүрлэн чимэглэл, үлгэр домгын амьгадыг дүрсэлсэн сийлбэр, Их Монгол улсын хаадын зоосон мөнгөн тэмдэгт, Хубилай хааны үед хэвлэгдсэн анхны цаасан мөнгөн тэмдэгт, XVII-XX зууны эхэн үеийн Монголчуудын оюуны болоод эдийн соёлыг илэрхийлэх эд хэрэглэгдэхүүн, Монгол улсын хаан VIII Богд Жавзандамба хутагт болон Улсын эх дагина Дондогдулам нарын эдэлж хэрэглэж байсан эд зүйлс, Монгол улсын төрийн хаш тамга, Эрдэнийн очирт жинс, ногоон пийсүү толгойтой Чунгартаам хөөрөг, Манж чин улсаас өргөн барьсан алтан өргөмжлөл, Өндөр гэгээн Занабазарын хэрэглэж байсан Чунчигноров хөөрөг, XVII зууны үеийн Халх эхнэрийн толгойн гоёл, зүүсгэл, Дарьганга эхнэрийн гэзэгний шүрэн шигтгээтэй толгойн боолт зэрэг Монгол улсын түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт цуглуулгууд хадгалагдаж байна.

2021 онд Монголбанкны үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй болгох, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор Олон улсын төв банкуудын жишгээр Монгол Улсын төлбөрийн хэрэгслийн түүхийг харуулсан, Эрдэнэсийн сангийн дэргэдэх “Мөнгөн тэмдэгтийн танхим”-ыг нээж, үйл ажиллагааг эхлүүлсэн. Мөнгөн тэмдэгтийн танхимд Их Монгол улсын хаадын алт, мөнгө, зэс зоосон мөнгөн тэмдэгт, XVII- XX зууны эхэн үед Монгол Улсад төлбөр, тооцооны үүрэг гүйцэтгэж байсан хунзтай цай, дэнс мөнгө, олон төрөлт эмбүү, цаасан, зоосон мөнгөн тэмдэгт болон Монголбанкнаас эрхлэн гаргасан дурсгалын зоосны дээжисийг дэглэн үзүүлж байна.

Зураг 3.1. Мөнгөн гүц



2022 онд Монголбанкны Эрдэнэсийн сангийн дэргэдэх үзмэрийн танхимуудад нийт 2500 гаруй иргэд зочилсон байна.

3.8 ОЛОН НИЙГИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГ БОЛОВСРОЛ

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд иргэдийн санхүүгийн зах зээлд ухаалгаар оролцох оролцоог нэмэгдүүлэх, оновчтой шийдвэр гаргалтыг дээшлүүлэх зорилгоор холбогдох төрийн болон мэргэжлийн байгууллагуудтай иргэд, олон нийгэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг хэрэгжүүлэв.

Санхүүгийн боловсрол дээшилснээр дараах голлох үр дүнд хүрнэ. Үүнд:

- Иргэдийн санхүүгийн бүтээгдэхүүний талаарх ойлголт нэмэгдэж, илүү үр дүнтэй ашиглана;
- Иргэд өөрийн хэрэгцээнд тохирсон, зөв бүтээгдэхүүн сонгох боломжтой болно;
- Санхүүгийн залилангаас урьдчилан сэргийлж, түүнд өртөх иргэдийн тоо буурна;
- Иргэдийн хадгаламж нэмэгдэж, чанаргүй зээлийн түвшин багасна;
- Хөрөнгийн зах зээл дэх оролцоо, хөрөнгө оруулалт өснө.

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үндсэн сэдвүүд:

- Санхүүгийн талаар суурь ойлголтууд;
- Төсөв болон санхүүгийн төлөвлөлт;
- Хадгаламж;
- Зээл;

- Финтек ба Криптовалют;
- Хөрөнгө оруулалт;
- Санхүүгийн эрсдэлээс хамгаалах (Даатгал гэх мэт);
- Тэтгэврийн хуримтлал үүсгэх;
- Нийгмийн даатгал болон татварын талаар ойлголтууд;
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаар ойлголтууд.

2022 онд тус ажлын хүрээнд дараах ажлуудыг хийв. Үүнд:

Хууль эрх зүйн орчин

- Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5.1.7 буюу “банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажилласан.
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 299 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын санхүүгийн салбарыг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн зорилго 6.2 “Монгол Улсын иргэд өөрийн болон өрхийн санхүүгээ зохистой удирдах мэдлэг, чадвар болон итгэл үнэмшилтэй болгоно” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл:

2021 оны 11 дугаар сарын 18-ны өдрийн УИХ-ын “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 91-р тогтоолын зорилт 3.3 “Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дэмжинэ” хэмээн тусгагдсаныг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

- Монголбанк нь СЗХ-той хамтран Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөлд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлж байгаа санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагыг тогтоож, зохицуулагч байгууллагаас зохистой хяналт шалгалтаас гадна санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, санхүүгийн хэрэглэгчээс гаргасан санхүүгийн үйлчилгээтэй холбоотой гомдол, маргааныг түргэн шуурхай хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий санхүүгийн омбудсманыг байгуулах агуулгаар эцэслэн боловсруулж дуусав.
- “Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Нийслэлийн жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төв, Насан туршийн боловсролын үндэсний төв, Зээлийн батлан даалтын сан, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон Монголын банкны холбоо гэсэн оролцогч талуудыг багтаасан ажлын хэсгийг байгуулж, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг гүйцэтгэж эхлэв. Уг ажлын хүрээнд 2022 оны 01-р сарын 27-ны өдөр Монголбанк, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Санамж бичгийг байгуулснаар Монгол Улсын Засгийн газраас батлагдсан залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хувийн ур чадварыг хөгжүүлэх “Оролцоо” төслийн цогц сургалтын хөтөлбөрт санхүүгийн мэдлэг олгох сургалтын агуулгыг тусгаж, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний “Загвар” төвөөр дамжуулан Баталан хамгаалахын яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны хамтарсан “Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх оролцоо төсөл”-ийн 2022 оны сургалтын ерөнхий хуваарьт “хувийн санхүүгээ удирлахуй” багц модуль боловсруулж, гарын авлагын материал болон багш нарыг сургав.

Сургалт, семинар, хурал зохион байгуулах ажлын хүрээнд:

- “Бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ (БЖДҮҮ) эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар, Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих газар болон Төрийн банктай хамтран 21 аймаг, нийслэл хотын нийт 231 сургагч багшийг бэлтгэв. Тус сургалтаар сургагч багшийн заах арга зүй, банк санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээ, эдийн засгийн анхан шатны ойлголтууд, цахим худалдаа, хямралын үеийн эрсдэл болон санхүүгийн удирдлага зэрэг сэдвүүдээр мэдлэг, мэдээлэл олгов.
- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад санхүүгийн боловсрол олгох “Бизнес судлал” хичээлийг сонгон судлахаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны сайдын 2019 оны А/491 тоот “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалыг баталсан. Уг тушаалын хэрэгжилтийг хангаж Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ухааны багш нар “Бизнес судлал” хичээлийг зааж байгаа ба 2022 оны байдлаар уг хичээлийг ахлах ангийн 2020 сурагч сонгон судалсан ба Монголбанкнаас дэмжин ажилласан.
- Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиуд, орон нутаг, дүүргийн иргэд, банкны ажилчид болон УИХ-ын Тамгын газар, Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл, Батлан хамгаалах яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Рио Тинто ХХК, МҮХАҮТ, Монголын бизнесийн зөвлөл, Дэлхийн зөн олон улсын байгууллагуудын дэргэдэх ТББ зэрэг төр, хувийн хэвшлийн 32 байгууллагуудад санхүү, эдийн засгийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг 2,660 хүнд оров.
- Монголбанкнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Эрдэм шинжилгээний бага хурал” 2022 оны 05-р сарын 26-ны өдөр амжилттай болж өндөрлөлөө. Тус эрдэм шинжилгээний бага хурал нь эдийн засаг, статистик болон санхүүгийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг судлаач, эрдэмтэд болон оюутнуудыг дэмжих, бүтээлийг нь нийтэд түгээн дэлгэрүүлэх, бодлого боловсруулахад оролцох оролцоог нь нэмэгдүүлэх зорилготой. Энэ удаагийн хурал 2 үе шаттай явагдсан бөгөөд ирсэн бүтээлүүдийн тоо чанараас хамаарч хоёрдугаар шатанд оюутан, судлаачдын ангилалд тус бүр 5 бүтээл шалгаруулан хэлэлцүүлж, байр эзлүүлэв.
- Монголбанкны үндсэн зорилт болох үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангахад хүлээлтийг зөв удирдах зорилгоор төв банкны олон нийттэй харилцах харилцааны ил байдлын хүрээнд сэтгүүлчдийг мэдээллээр хангах, эдийн засгийн мэдлэг олгох сургалт уулзалтыг тогтмол хуваарийн дагуу зохион байгуулж байна. Үүнд:
 - Сэтгүүлчдэд мэдээлэл өгөх уулзалт (12 удаа)
 - Сэтгүүлчдэд эдийн засгийн мэдлэг олгох сургалт (2 удаа)
 - ТМБҮЧ-ийн зорилтыг танилцуулах уулзалт (жил бүрийн 10 дугаар сард)

Эдгээр сургалт, уулзалтад 20 орчим хэвлэл мэдээллийн хэрэгслийн давхардсан тоогоор 551 сэтгүүлч хамрагдлаа.

Нийгэмд чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд:

- "Тинк банк" хөтөлбөрийн хүрээнд 2022 оны 12-р сарын 20-ны өдөр Монголбанкны төлөөлөл МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч, МУИС-ийн Бизнесийн сургуулийн Санхүүгийн тэнхимийн эрхлэгч болон удирдсан багш нар судалгаанд хэлэлцүүлэг хийв. МУИС-аас тэтгэлэгт хамрагдсан 5 магистрант, судлаач оюутнуудын судалгааны ажлын явцтай танилцаж, МУИС- БС, Эдийн засгийн тэнхимийн удирдлагуудтай цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцов.
- Хүүхэд, залуучуудын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, түүнд олон нийтийн анхаарлыг хандуулах зорилготойгоор жил бүр олон Улсын Эдийн Засгийн Хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Санхүүгийн боловсролын олон улсын сүлжээ (OECD/INFE)-ээс зохион байгуулдаг

“Дэлхийн мөнгөний долоо хоног 2022” аяныг 10 дахь жилдээ дэлхий нийтээр тэмдэглэж “Мөнгөө ухаалгаар удирдаж, ирээдүйгээ өөрсдөө бүтээе” уриатайгаар 3 дугаар сарын 14-27-ны өдрийг дуустал орон даяар хэрэгжүүллээ. Тус аяныг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Гэр бүл, хүүхэд залуучуудын газар, БШУЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв, Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ, Монголын Банкны Холбоо, Хадгаламжийн даатгалын корпораци, ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сан, Зээлийн батлан даатлын сан, арилжааны банкууд, Рио Тинто ХХК, Юнител групп, Lemon Press компани, Мобифинанс ББСБ гэх мэт 71 байгууллага хамтран оролцсон.

Аяны хүрээнд хувь хүний санхүүгийн төлөвлөлт, ирээдүй рүү чиглэсэн хуримтлал ба хөрөнгө оруулалт хийх, мөнгөө зөв удирдсанаар ирээдүйн сайн сайхныг бүтээн бий болгож, санхүүгийн эрх чөлөөнд хүрэх гэх зэрэг агуулгын хүрээнд сургалт, уралдаан тэмцээн, нөлөөллийн арга хэмжээнүүд зохион байгуулж 2,5 сая хүүхэд, залуучуудад хүрч, 6 сая орчим хандалтыг аван, хаалтын үйл ажиллагааг 3-р сарын 26-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд бүх нийтийн гүйлтийг зохион байгуулсан бөгөөд нийт 400 гаруй хүн хамрагдав.

- Жил бүрийн 10 дугаар сарын 01-ээс 10 дугаар сарын 31-ний хооронд орон даяар зохион байгуулагддаг хуримтлалын өдрийг угтаж Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпораци, ХБНГУ-ын Шпаркассэ банкны сан, Монголын банкны холбоо хамтран “Дэлхийн хуримтлалын өдөр-2022” аяныг “Бүгдээрээ хуримтлууля” уриатайгаар Завхан, Төв, Өвөрхангай, Баянхонгор, Архангай аймгуудад тус тус нээлтийн арга хэмжээг зохион байгуулав. Энэ жилийн хувьд тус аяны нээлтийн арга хэмжээ анх удаа орон нутагт болсноороо ихээхэн онцлогтой юм. Нээлтийн арга хэмжээний үеэр арилжааны банкууд хүүхэд, багачуудад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулж, газар дээр нь хуримтлалын данс нээж ажилласны дээр хуримтлалын ач холбогдол, олон улсын туршлагыг таниулах илтгэлүүдийг оролцогчдын зүгээс танилцууллаа. Уг аяны хүрээнд хамтрагч байгууллагуудтай хамтран иргэдийн санхүүгийн боловсролыг дэмжих, хуримтлалыг хэвшил болгоход чиглэсэн хүүхэд залуучуудын дунд цахим орчин дахь уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулснаас гадна ЕБС-ийн 500 гаруй хүүхдүүдэд сургалт, уулзалтуудыг хийж, хуримтлалын ач холбогдлыг таниулж, сурталчлав. Аяны хаалтын арга хэмжээ 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Блю Скай зочид буудалд амжилттай зохион байгуулагдлаа.
- Санхүүгийн залилах гэмт хэргээс иргэд олон нийтийг сэрэмжлүүлэх зорилгоор ЦЕГ, МБХ болон бусад төрийн байгууллагуудтай хамтран жил бүр нийгэмд чиглэсэн зорилгод аяныг зохион байгуулж ирсэн бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс “UNSEND - Бүү шилжүүл” уриан дор 14 хоногийн аяныг хэрэгжүүллээ. 2022 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 33 хувь нь залилах гэмт хэрэг байсан бөгөөд 78 хувь нь цахим хэрэгсэл ашиглан үйлдэгджээ. Тус аяныг ЦЕГ-аас Монголбанк, Цахим хөгжлийн яам, Монгол банк, Монголын банкны холбоотой хамтран хамтран хэрэгжүүлэв. Энэ удаад санхүүгийн залилах гэмт хэргийг бууруулахад төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд анхаарч, тулгарч буй бэрхшээлтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэж, мэдээлэл солилцох шуурхай байдлыг хангахад анхаарч ажиллав. Тиймээс ЦЕГ-аас Монголбанкттай хамтран Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Монгол банк, Улсын Ерөнхий прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Монголын банкны холбоо, түүний гишүүн байгууллагуудыг оролцуулсан семинарыг зохион байгуулж, асуудлуудаа тодорхойлон хамтын ажиллагаагаа бэхжүүлэхээр болсон нь өмнөх жилүүдэд хэрэгжүүлж байсан аянуудаас онцлог болов. Олон нийтэд чиглэсэн ажлын хүрээнд цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргүүд ямар аргыг ашиглаж иргэдийг хохироож буйг бодит жишээнүүд дээр таниулан мэдээлсэн нь үр дүн үзүүлж, аяныг хэрэгжүүлсэн өмнөх саруудтай харьцуулахад цахимаар залилах гомдол мэдээлэл 740 буюу /39,2 хувиар/, гэмт хэрэг 517 буюу /42,6 хувиар/ тус тус буурсан. Мэдээлэл хүргэсэн агуулгыг хэмжвэл:

• Цахим орчинд нийтлэгдсэн шууд бичлэг	20
• Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлсэн	7
• Веб сайтад нийтлэгдсэн мэдээлэл	34
• Зурагт сурталчилгаа	14
• Видео сурталчилгаа	10
• Сурчилгааны самбар байршуулсан	1
• Олон дагагчтай пейжүүд түгээсэн	47

Цахим орчинд дээрх мэдээ, мэдээлэл, шууд бичлэгүүдийг давхардсан тоогоор нийт 1,630,256 хэрэглэгч үзэж, 93,377 сэтгэл хөдлөл илэрхийлж, 48,785 сэтгэгдэл бичиж, 43,006 удаа түгээгджээ.

Иргэд олон нийтэд санхүү, эдийн засгийн мэдлэг түгээх, төв банкны үйл ажиллагааг таниулах ажлын хүрээнд:

- Монголбанкнаас хэрэгжүүлсэн бодлого, шийдвэр, цаг үеийн үйл явдлын тухай мэдээ мэдээллийг төрийн эрх барих байгууллагууд, олон улсын байгууллагууд, санхүүгийн салбарынханд мэдээлж байх зорилготой хоёр сар тутамд хэвлэдэг “Монголбанкны мэдээлэл” товхимлын 7 дугаарыг эрхлэн гаргав. Эдгээр дугаарт:
 - Тогтвортын хөгжлийн төлөө Төв банкны оролцоо
 - Банкны салбарын шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлж буй бодлого
 - Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг ногоон санхүүжилтийн бодлого
 - Дэлхийн болон Монголын эдийн засгийн нөхцөл байдал, хэрэгжүүлж буй бодлого
 - Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төслийн зорилтод юу тусгав
 - Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд тусгасан зорилтууд, эдийн засгийн төлөв байдал
 - Монголбанкны 2022 оны онцлох үйл явдлын хураангуй зэрэг агуулгыг тусгав.
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээг ашиглан мэдлэг мэдээлэл олгох хүрээнд Facebook, Instagram, Tweeter хуудсуудад Санхүүгийн боловсрол хуудас, хаягийг нээж бичвэр, зурган болон дүрст мэдээ мэдээллийг тогтмол нийтэлж, мөн видео контентууд бэлтгэж байна. Үүнд: Facebook live, podcast, зочинтой ярилцлага зэргийг хийж байна. Энэ хүрээнд дараах агуулгаар мэдээллийг өгч ажиллав.
 - Орлогын зарцуулалт, төлөвлөлтийг хэрхэн хийх
 - Хувь хүн, өрхийн санхүүгийн төсвийг хөтлөх
 - Эрсдэлгүй хөрөнгө оруулалтын хэлбэрийг сонгох
 - Даатгалын тухай ойлголт
 - Санхүүгийн залилан луйвраас сэргийлэх
 - Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний сонголт
 - Ханшийн тухай ойлголт
 - Инфляцийн тухай ойлголт
 - Хүү хэрхэн тогтдог тухай ойлголт
 - Мөнгөний бодлогын зорилтын тухай ойлголт зэрэг сэдвээр цуврал мэдээллийг бэлтгэн өгч ажиллав.

Дээрх сэдвүүдийн дагуу сар бүр подкаст, долоо хоног тутамд facebook live, өдөрт 2-3 пост мэдээлэл, улиралд 1-2 видео ярилцлага зэргийг бэлтгэн түгээж мөн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр давхар нийтэлж байна. 2022 онд нийт 370 гаруй социал контентийг түгээж, Facebook пэйж хандалтын тоог 16 мянга хүргэж нэмэгдүүллээ.

- Олон нийтэд дараах хэвлэмэл бүтээгдэхүүнийг боловсруулах, хэвлэх, түгээх ажлыг хариуцан гүйцэтгэлээ. Үүнд: “Монголбанкны мэдээлэл” товхимол, Бизнесийн үйл ажиллагаа санхүүжилтийн байдал, Эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө хэрэгжилтийн үр дүн, Монголбанкны 2022 оны жилийн тайлан (англи, монгол хэлээр) Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл, Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан, “Судалгааны ажил” товхимол 17, Мөнгөө хэрхэн удирдах вэ?өрхийн төсөв, хуримтлал ба хадгаамж, Санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалт ба даатгал, Зээл, санхүүгийн хэрэглэгч танаа гэх овхимолуудыг эрхлэн гаргаж нийт 14800 хувийг хэвлүүлэн дугаар бүрийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ, ЗГ, арилжааны банкууд, Монголбанкны газар нэгжүүд, орон нутаг дахь хэлтэс салбар, аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, номын сан, сургуулиудад түгээж ажиллалаа.
- Иргэд, олон нийтээс жилийн турш давхархадсан тоогоор 21 000 орчим дуудлагад хариу өгч ажиллаа. Дийлэнх асуултууд нь Монголбанкаас гаргасан бодлогын шийдвэр, зээлийн мэдээллийн сан, ипотекийн зээл, ханш гэм мэт байлаа.

Гадаад хамтын ажиллагаа

- ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сан
Монголбанк, Монголын банкны холбоо, ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сан, Монголын Банк санхүүгийн академи хамтран “Монгол Улсын банкны салбарт ажиллахад тавигдах банкны ажилтны суурь шаардлагын жишиг”-ийг дагалдах “Шинэ банкирын онол, практик хосолсон болон мэргэшсэн банкирын сургалтын жишиг журам”, “Банкны ажилтны суурь шаардлагын жишигийг хангуулах шинэ банкирын сургалтын хөтөлбөр”-ийн хамт боловсруулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 11-р сарын 25-ны өдрийн А-313 тоот тушаалын хэрэгжитийн дагуу “Монгол Улсад банкны ажилтныг мэргэшүүлэх-онол, практик хосолсон сургалт болон Дэлхийн хуримтлалын өдрийг нэвтрүүлэх төсөл”-ийг 2017 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн хүрээнд 2022 оны байдлаар 8 банкны нийт 124 оролцогчдыг хамруулав.
- OECD/INFE Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагын Олон улсын санхүүгийн боловсролын сүлжээ
 - Олон улсын санхүүгийн боловсролын сүлжээ нь нийт 131 орны 279 байгууллагын гишүүнчлэлтэй бөгөөд орчин үеийн санхүүгийн боловсролын бодлого, хөтөлбөрийн дүн шижилгээ, ажлын хэсгүүдээс гарч буй санхүүгийн боловсрол чиглэлээр судалгаа, материал, мэдээ, мэдээллүүдийг тогтмол хүлээн авч ажиллаа.
 - Дэлхийн мөнгөний долоо хоног 2022 аяны талаарх бусад орны сайн туршлага хуваалцах онлайннар вебинарт 2022/02/03-ны өдөр Монгол Улс хэрхэн зохион байгуулах талаар мэдээлэл өгч ажиллав.
 - 2022 оны 05 дугаар сард цахим хурлаар ажлын байранд санхүүгийн мэдлэг олгох баримт бичгийг олон улсын 22 байгууллага хамтран батлав.
- Унгар Улсын Төв банк
Унгар улсын төв банктай 2022 оны 07 дугаар сард хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан "Санхүүгийн боловсрол"-ын тухайд хамтран ажиллах, страгтеги, сайн туршлага солилцох, иргэдийг мэдлэгийг дээшлүүлэх бодлогын талаар хамтрах ажлыг эхлүүлэв.
- Киргиз Улсын Төв банк
Киргизийн үндэсний банкаас 2022 оны 6-р сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулсан Евро-Азийн эдийн засгийн гишүүн улсуудын Төв банкуудын Санхүүгийн боловсролын бодлого, хөтөлбөр боловсруулах, санхүүгийн боловсролын сургагч багш бэлтгэх, техникийн туршлага солилцох арга хэмжээнд Монгол Улсын туршлагыг хуваалцаж ажиллалаа.

- Мексик Улсын төв банк

Мексик улсын төв банктай 2022 оны 08 дугаар сард "Эдийн засгийн мэдлэг"-ийн тухайд хамтран ажиллах, страгтеги, сайн туршлага солилцох, иргэдийг мэдлэгийг дээшлүүлэх бодлогын талаар туршлага солилцох цахим хурал зохион байгуулж ажиллалаа.

3.9 МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-наас Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлд тусгасан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын Үндэсний хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, ФАТФ-ын зөвлөмжийн үнэлгээг дээшлүүлэх, зөвлөмжид нийцүүлэн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээнд үндэслэн эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бий болгох, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх хүрээнд дараах шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэв.

I. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22¹ дүгээр зүйлийн 22^{1.1} дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 265 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийг батлуулсан.

Монгол Улс цаашид мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоогоо хангалттай түвшинд сайжруулж, ФАТФ-ын 40 Зөвлөмж, түүний үр дүнтэй хэрэгжилтийг илтгэх шууд хэрэгжилтийн 11 шалгуур үзүүлэлтийн шаардлагуудыг хангаж ажиллах замаар дараагийн Харилцан үнэлгээний хүрээнд гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эмзэг сул байдлыг арилгах ач холбогдолтой.

Түүнчлэн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хэмжээнд хэрэгжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь Улсын Их Хурлын 2020 оны 52 тоот тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Улсын Их Хурлын 2021 оны 106 тоот тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Улсын Их Хурлын 2020 оны 23 тоот тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын Их Хурлын 2020 оны 24 тоот тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ач холбогдолтой юм.

Иймд ФАТФ-ын Зөвлөмж 1 болон 2-т заасны дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийг үнэлж, түүний үр дүнд суурилан үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон хөтөлбөрийг төр, хувийн хэвшил, судлаачдыг хамруулан олон талын оролцоотойгоор боловсруулан батлуулсан.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хэмжээнд хэрэгжих хөтөлбөрийн дагуу 2022-2030 онд 8 стратегийн ач холбогдолтой зорилгын хүрээнд 48 дэд зорилтыг дэвшүүлэн үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын оролцоотойгоор боловсруулан 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан. Үндэсний хэмжээнд хэрэгжих Мөнгө угаах,

терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд нийт 197 ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөн үндсэн болон хамтран хэрэгжүүлэх байгууллагуудад хүргүүлээд байна. Хэрэгжүүлэгч байгууллагууд төлөвлөгөөний биелэлтийг жил бүр Үндэсний зөвлөлд тайлагнан ажиллах болно.


II. ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээг дээшлүүлэх

Монгол Улс Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргасан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт болох 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн талаар жил бүр Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт тайлагнах үүрэгтэй.

Энэ хүрээнд Монгол Улсын 2022 оны Явцын тайланг Санхүүгийн мэдээллийн албанаас Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудтай хамтран боловсруулж, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлсэн. Тус тайланд Үндэсний зөвлөлөөс баталсан төлөвлөгөөний дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон “Хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй байгаа Зөвлөмж 15-ын үнэлгээг ахиулах хүрээнд хийсэн ажлуудыг тайлагнав.

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн үнэлгээний багаас ирүүлсэн хүсэлтийн дагуу нийт 4 удаа нэмэлт мэдээлэл, тайлбарыг бэлтгэж хүргүүлснээс гадна 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр үнэлгээний багтай цахим уулзалт зохион байгуулсан. Улмаар Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн Харилцан үнэлгээний хорооны 2022 оны 6 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан хурлаар Монгол Улсын 2022 оны Явцын тайланг хэлэлцэн, Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр эрсдэлд суурилсан аргачлалыг үр дүнтэй хэрэгжүүлж байна хэмээн дүгнэсэн бөгөөд ФАТФ-ын Зөвлөмж 15-ын “Хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээг “Дийлэнхийг биелүүлсэн” болгон ахиулахаар тогтсон. Монгол Улсын Явцын тайланг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн жилийн уулзалтаар амжилттай хамгаалсан бөгөөд 2022 оны 8 дугаар сарын 02-ны өдөр тайланг цахим хуудаснаа албан ёсоор нийтэлсэн байна.

Зураг 3.2. Монгол улсын 2022 оны Явцын тайлан



Эх сурвалж: Монголбанк,
Санхүүгийн тэдээллийн алба

Монгол Улсын 2022 оны Явцын тайлангийн үр дүнд ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилт нийт 39 Зөвлөмжийн хувьд дийлэнхийг болон бүрэн биелүүлсэн гэсэн үнэлгээтэй болсон. Энэ хүрээнд Монгол Улсын гаргасан ахиц дэвшлийг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс онцлон сайшааж 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр албан захидал ирүүлсэн бөгөөд Зөвлөмж 8-ын дутагдалтай гэсэн үнэлгээг ахиулах ажилд хүчин чармайлт гаргаж ажиллахыг хүссэн. ФАТФ-ын Зөвлөмж тус бүрийн техник хэрэгжилтийн үнэлгээ дараах байдалтай байна (Хүснэгт 3.1). Үүнд:

Хүснэгт 3.1. Монгол Улсын ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийн үнэлгээ

Зөвлөмж 1	Зөвлөмж 2	Зөвлөмж 3	Зөвлөмж 4	Зөвлөмж 5	Зөвлөмж 6	Зөвлөмж 7	Зөвлөмж 8
LC	LC	LC	LC	LC	LC	LC	PC
Зөвлөмж 9	Зөвлөмж 10	Зөвлөмж 11	Зөвлөмж 12	Зөвлөмж 13	Зөвлөмж 14	Зөвлөмж 15	Зөвлөмж 16
LC	LC	C	LC	LC	C	LC	LC
Зөвлөмж 17	Зөвлөмж 18	Зөвлөмж 19	Зөвлөмж 20	Зөвлөмж 21	Зөвлөмж 22	Зөвлөмж 23	Зөвлөмж 24
LC	LC	LC	LC	C	LC	LC	LC
Зөвлөмж 25	Зөвлөмж 26	Зөвлөмж 27	Зөвлөмж 28	Зөвлөмж 29	Зөвлөмж 30	Зөвлөмж 31	Зөвлөмж 32
LC	LC	LC	LC	C	C	C	LC
Зөвлөмж 33	Зөвлөмж 34	Зөвлөмж 35	Зөвлөмж 36	Зөвлөмж 37	Зөвлөмж 38	Зөвлөмж 39	Зөвлөмж 40
LC	LC	LC	C	C	LC	LC	LC

/Бүрэн биелүүлсэн: C-compliant, Дийлэнхийг биелүүлсэн: LC-largely compliant, Хэсэгчлэн биелүүлсэн: PC-partially compliant, Биелүүлээгүй: NC-noncompliant/

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн тэдээллийн алба

Ашгийн бус байгууллагын салбартай холбоотой Зөвлөмж 8-ын шаардлагуудыг хангах хүрээнд Монголбанк, Санхүүгийн мэдээллийн албаны төлөөллийг багтаасан Хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэд Ашгийн бус байгууллагыг терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан. Уг ажлын хэсэг нь 2022 онд эрсдэлд суурилсан байдлаар ашгийн бус байгууллагуудын хяналт шалгалт хийх, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх, терроризмыг санхүүжүүлэхэд урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор соён гэгээрүүлэх, сургалтын үйл ажиллагаа явуулах, эрх бүхий байгууллагын албан тушаалтнуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч ажиллав.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Хамтын ажиллагааны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн болон Үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар Монгол Улсын 6 дахь шатны Явцын тайланг бэлтгэн хүргүүлэхээр тогтсон. Энэ хүрээнд Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/379 тоот тушаалаар ФАТФ-ын Зөвлөмж 8-ын техник хэрэгжилтийн үнэлгээг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлж, тайланг бэлтгэж хамгаалах ажлын хэсгийг байгуулсан. Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Хууль зүй, дотоод хэргийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Тагнуулын ерөнхий газар, Терроризмтой тэмцэх зөвлөл, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар зэрэг байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн тус ажлын хэсэг нь Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдөр тайланг бэлтгэн хүргүүлсэн.

III. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарын хяналт зохицуулалтын орчныг сайжруулах

Санхүүгийн мэдээллийн албанаас Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулсан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн бүртгэл, үйл ажиллагаа, эрсдэлд суурилсан хяналт шалгалттай холбоотой нийт 8 журмын төсөлд санал боловсруулан хүргүүлж, хамтран ажилласан.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь мэдээлэх үүрэгтэй этгээд болсон. Үүнтэй холбоотойгоор Санхүүгийн мэдээллийн алба, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй дотоод хэргийн яамны төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг байгуулж, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журамд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой нэмэлт өөрчлөлтийг оруулан, холбогдох талуудын саналыг тусган эцэслэв. Тус нэмэлт өөрчлөлтийн төслийг Монголбанкны

Ерөнхийлөгчийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А-26 дугаар тушаалаар батлуулан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний нэгдсэн бүртгэлийн 4221 дугаарт бүртгүүлж, нийт мэдээлэх үүрэгтэй этгээдүүд үйл ажиллагаандаа мөрдөж эхэллээ.

ФАТФ-ын Зөвлөмж 15-ын шаардлагын дагуу Монгол Улсын виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж тайлагнах үүрэг бүхий ажлын хэсгийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 4/А-5/12/А-02 тоот тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэгт Монголбанк, Санхүүгийн мэдээллийн албанаас орж ажилласан бөгөөд Дэлхийн банкны аргачлалын дагуу шаардлагатай мэдээллийг асуулга хэлбэрээр цуглуулж, олон улсын зөвлөхүүдтэй хамтран 2022 оны 2 дугаар улирлын туршид нийт 10 гаруй удаа сургалт, уулзалтыг зохион байгуулж, виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл, эмзэг байдал болон эрсдэлийг бууруулах чиглэлээр авах арга хэмжээний талаар хэлэлцүүлэг өрнүүлэн, тайлангийн төслийг боловсруулж, эцэслэсэн. Улмаар Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит хурлаар виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний тайланг танилцууллаа.

IV. Дотоод, гадаад хамтын ажиллагаа

а. Дотоод хамтын ажиллагаа

Зураг 3.3. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн ба Хатмын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд



Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн тэдээллийн алба

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд олон улсын болон дотоодын төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа өндөр ач холбогдолтой. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь Монгол Улсын мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэдэг. Зөвлөлийн нийт төрийн 17 байгууллагын төлөөллүүд нь мөнгө угаахтай тэмцэх тогтолцоог бэхжүүлэхээр тогтмол хамтран ажиллав.

Үндэсний зөвлөл

- Хууль зүй, дотоод хэргийн сайд (Зөвлөлийг даргална)
- Тагнуулын ерөнхий газрын дарга (Орлогч дарга)
- Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны дарга (Нарийн бичгийн дарга)
- Улсын ерөнхий прокурорын орлогч
- Авлигатай тэмцэх газрын дэд дарга
- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга
- Сангийн дэд сайд
- Гадаад харилцааны дэд сайд
- Монголбанкны Дэд Ерөнхийлөгч
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга
- Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга
- Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тэргүүн дэд дарга
- Гаалийн ерөнхий газрын дэд дарга
- Татварын ерөнхий газрын дэд дарга
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд дарга

Хамтын ажиллагааны зөвлөл

- Монголбанк
- Санхүүгийн мэдээллийн алба
- Тагнуулын ерөнхий газар
- Сангийн яам
- Хууль зүй, дотоод хэргийн яам
- Санхүүгийн зохицуулах хороо
- Улсын дээд шүүх
- Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх
- Шүүхийн ерөнхий зөвлөл
- Улсын ерөнхий прокурорын газар
- Гадаад харилцааны яам
- Терроризмтой тэмцэх зөвлөл
- Авлигатай тэмцэх газар
- Цагдаагийн ерөнхий газар
- Улсын бүртгэлийн ерөнхий газар
- Татварын ерөнхий газар
- Гаалийн ерөнхий газар

Зураг 3.4. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн ба Хамтын ажиллагааны зөвлөлийн хуралдсан байдал



Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн тэдээллийн алба

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл 2022 онд нийт 2 удаа, Хамтын ажиллагааны зөвлөл 4 удаа хуралдаж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэв.

Тухайлбал Санхүүгийн мэдээллийн албанаас 2022 оноос 2030 оны хугацаанд хэрэгжих мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын хамт эцэслэн, зөвлөлийн хурлаар танилцуулж, арга хэмжээг авч хэрэгжүүлэх байгууллагуудын дунд 3 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж ажиллав. Мөн ФАТФ-ын Зөвлөмж 15-ын техник хэрэгжилтийн үнэлгээг ахиулах хүрээнд зөвлөл нь виртуал хөрөнгийн салбарын хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, тус салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн тухай 5 дахь шатны Явцын тайланг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлж Зөвлөмж 15-ын “Хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээг “Дийлэнхийг биелүүлсэн” болгож ахиуллаа. Түүнчлэн Хамтын ажиллагааны зөвлөлийн даргын баталсан ажлын хэсэг нь Өршөөл үзүүлэх тухай хуулийг тайлагнах шаардлагын тухай судалж ажлын хэсгийн дүгнэлтийг Үндэсний зөвлөлд хүргүүлэв.

б. Гадаад хамтын ажиллагаа

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх чиглэлээр Санхүүгийн мэдээллийн алба болон АНУ-ын Сангийн яамны техник туслалцааны алба хооронд 2018 онд байгуулсан гэрээний дагуу Санхүүгийн мэдээллийн албанд АНУ-ын Сангийн яамны зөвлөх ажиллаж байна. Техник туслалцааны хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагаанд зориулан боловсруулсан програм худалдан авахад санхүүгийн тусламж үзүүлэх, мөнгө угаахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх сайн туршлагыг нэвтрүүлэх, тус алба болон хууль сахиулах байгууллагуудын мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх болон мөнгө угаахтай тэмцэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллалаа.

Дэлхийн банкны Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн санхүүжилтээр Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын холбогдох албан тушаалтнууд Монгол Улсыг төлөөлж Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Эгмонт бүлгээс зохион байгуулсан хурал, уулзалтуудад идэвхтэй оролцов.

Энэхүү уулзалтуудад оролцсоноор Монгол Улсыг төлөөлж олон улсын хэмжээнд байр сууриа илэрхийлэх, холбогдох тайланг хамгаалах, тайлбар, мэдээлэл өгөх, олон улсын нөхцөл байдал, чиг хандлагад үндэслэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр дэлхийн хэмжээнд гаргаж буй шинэ зохицуулалт, зөвлөмж, стандартын талаарх мэдээллийг цаг алдалгүй авах ач холбогдолтой юм. Үүнээс гадна мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гадаад хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, мэдээлэл солилцоог сайжруулах, улс орнуудын туршлагыг судлах боломжийг бүрдүүлдэг.

Мөн ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Эгмонт бүлэг зэрэг олон улсын байгууллагуудад холбогдох судалгаа, мэдээллийг хүргүүлж ажилласнаас гадна цахим сургалт семинаруудыг 2022 онд идэвхтэй зохион байгуулав. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс нийт 10 гаруй олон улсын хэмжээний семинар, сургалт, хуралд Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөл болон хувийн хэвшлийн давхардсан тоогоор 350 орчим төлөөллийг хамруулав.

V. Хяналт шалгалт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас хяналт шалгалтын зохицуулагч байгууллагууд болох Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон мэргэжлийн холбоодтой тогтмол хамтран ажиллав.

Тухайлбал, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд мэргэжлийн холбооноос хийж буй хяналт шалгалтын ажиллагааг журамлах, журмын дагуу хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах хүрээнд “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын төсөл, хяналт шалгалт хийхэд зориулсан үйл ажиллагааны горим, гарын авлагыг боловсруулж, мэргэжлийн холбоодод хүргүүлэв. Мэргэжлийн холбоод өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан эдгээр баримт бичигт холбогдох өөрчлөлт оруулан, баталж, хяналт шалгалтын үйл ажиллагаандаа ашиглах юм.

Түүнчлэн мэргэжлийн холбоодын хяналт шалгалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2022 онд Монголын Хуульчдын Холбоо, Монголын Нотариатчдын танхим, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран эрсдэл өндөртэй гэж үнэлэгдсэн хуульч, нотариатч, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалт хийлээ.

Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд зохицуулагч байгууллагуудын хянан шалгагчдыг эрсдэлд суурилсан хяналт шалгалт, хамтын ажиллагаа, мэдээлэл солилцооны талаарх олон улсын байгууллагуудын цахим сургалт, семинарт хамруулснаас гадна мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд зориулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргийг таниулах, эрсдэлийг ойлгуулах сургалтуудыг зохион байгуулав.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д зааснаар Санхүүгийн мэдээллийн алба нь тус хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын талаар нэгдсэн статистик гаргах чиг үүрэгтэй байдаг. Нийт мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийсэн хяналт шалгалт болон авсан арга хэмжээний мэдээллийг Хүснэгт 3.2-т харуулав.

Хүснэгт 3.2. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн хяналт шалгалтын үйл ажиллагаа

	2021		2022	
	Зайн хяналт	Газар дээрх хяналт шалгалт	Зайн хяналт	Газар дээрх хяналт шалгалт
Банканд хийсэн хяналт шалгалт	3	24	13	34
Банкнаас бусад санхүүгийн байгууллагад хийсэн хяналт шалгалт	35	3380	37	3297
СББМҮҮ-д хийсэн хяналт шалгалт	249	2744	28	1615
ВХҮҮ, НФТ-д хийсэн хяналт шалгалт	17	-	9	22
Хугацаатай үүрэг даалгавар		269		427
Банк болон банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавигдсан актын тоо		39		266
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил		4		6

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн тэдээллийн алба

VI. Мэдээлэл хүлээн авах болон дүн шинжилгээ хийх

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдээс 20 сая төгрөг, түүнээс дээш дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээ, гадаад төлбөр тооцооны гүйлгээ, виртуал хөрөнгийн гүйлгээ болон сэжигтэй гүйлгээг хүлээн авдаг бөгөөд 2022 оны хувьд мэдээлэх үүрэгтэй этгээдээс дараах байдлаар гүйлгээ мэдээлсэн байна (Хүснэгт 3.3).

Хүснэгт 3.3. Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн гүйлгээний тоо /2020-2022/

Үзүүлэлт	2020	2021	2022
Бэлэн мөнгөний гүйлгээний тоо	402,496	336,518	349,126
Сэжигтэй гүйлгээний тоо	3,014	1,801	2,626
Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тоо	143,191	211,176	230,402

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн тэдээллийн алба

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдаж, Монгол Улсад виртуал хөрөнгийн салбарын хууль эрх зүйн орчин бүрдсэн билээ. Энэ хүрээнд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуульд нэмэлт өөрчлөлт орж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь мэдээлэх үүрэгтэй этгээд болов. Ингэснээр виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь 20 сая төгрөг, түүнээс дээш мөнгөн дүнтэй тэнцэх виртуал хөрөнгийн гүйлгээ болон сэжигтэй гүйлгээг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэг хүлээв. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөн эхэлж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид нь Санхүүгийн мэдээллийн албанд 2022 оны туршид

1,783 ширхэг 20 сая төгрөг, түүнээс дээш дүнтэй виртуал хөрөнгийн гүйлгээ мэдээлсэн байна.

Санхүүгийн мэдээллийн алба нь ГоАМЛ програмыг 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаандаа албан ёсоор нэвтрүүлсэнтэй холбоотойгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А-171 тоот тушаалаар “Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл ирүүлэх журам”-ыг шинэчлэн батлууллаа. Тус журмын дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдүүд хуульд заасан гүйлгээний мэдээллийг ГоАМЛ програмаар дамжуулан мэдээлж эхлэв. ГоАМЛ програмыг албан ёсоор нэвтрүүлснээр бүх мэдээлэх үүрэгтэй этгээд энэхүү програмаар гүйлгээ мэдээлж, мэдээлэх үйл ажиллагаа илүү хялбар, үр дүнтэй болсон. Түүнчлэн Санхүүгийн мэдээллийн албанаас 2022 онд мэдээлэх үүрэгтэй этгээдийг ГоАМЛ програмд бүртгүүлэх ажлыг нэн тэргүүнд тавьж ажилласан бөгөөд оны сүүлийн байдлаар нийтдээ 478 мэдээлэх үүрэгтэй этгээд ГоАМЛ програмд бүртгүүлжээ.

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлсэн 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгөний гаалийн мэдүүлгийг гаалийн байгууллагаас сар бүр хүлээн авч ажилладаг (Хүснэгт 3.4).

Хүснэгт 3.4. Гаалийн мэдүүлгийн тоо /2020-2022/

Үзүүлэлт	2020	2021	2022
Гаалийн мэдүүлгийн тоо	5,520	2,660	30,151

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн тэдээллийн алба

Энэ оны хувьд Ковид-19 цар тахлаас үүдэлтэй хил, гаалийн хөдөлгөөний хязгаарлалт цуцлагдаж, улсын хилээр нэвтэрсэн иргэдийн тоо өссөнтэй холбоотойгоор гаалийн мэдүүлгийн тоо мөн өсжээ.

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18.1.1 дэх хэсэгт заасны дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн, түүнчлэн эрх бүхий төрийн болон гадаад улсын ижил төстэй байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг хүлээн авах, цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх үндсэн чиг үүргийнхээ хүрээнд 2022 онд дараах байдлаар сэжигтэй гүйлгээний тайланд дүн шинжилгээ хийв (Хүснэгт 1.5).

Хүснэгт 3.5. Сэжигтэй гүйлгээний тоо болон дүн шинжилгээ хийгдсэн, хийгдэж буй сэжигтэй гүйлгээний тоо /2020-2022/

Үзүүлэлт	2020	2021	2022
Сэжигтэй гүйлгээний тоо	3,014	1,801	2,626
Дүн шинжилгээ хийгдсэн болон хийгдэж буй сэжигтэй гүйлгээний тоо	509	551	354

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн тэдээллийн алба

VII. Мэдээлэл солилцох

а. Дотоодын байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах

Санхүүгийн мэдээллийн албанаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр дотоодын эрх бүхий хууль сахиулах байгууллагатай мэдээлэл солилцон хамтран ажиллаж, гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлж ажилладаг. Энэ хүрээнд 2022 онд дараах байдлаар мэдээлэл солилцож ажиллав (Хүснэгт 3.6).

Хүснэгт 3.6. Санхүүгийн мэдээллийн албаны дотоодын эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцсон байдал /2020-2022/

Үзүүлэлт	2020	2021	2022
<i>СМА-наас дотоодын хууль сахиулах байгууллагуудад шалгуулахаар шилжүүлсэн сэжигтэй гүйлгээний тоо</i>	505	539	324
<i>Мэдээлэл авах зорилгоор дотоодын эрх бүхий байгууллагуудаас СМА-д ирүүлсэн хүсэлт /этгээдийн тоогоор/</i>	3,336	3,665	7,148
<i>Дотоодын эрх бүхий байгууллагуудаас СМА-д ирүүлсэн хүсэлтийн дагуу явуулсан хариу /этгээдийн тоогоор/</i>	3,310	3,834	6,749

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн тэдээллийн алба

Санхүүгийн мэдээллийн алба нь цаг үеийн үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор дотоодын эрх бүхий хууль сахиулах байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилладаг. Энэ хүрээнд дотоодын эрх бүхий байгууллагуудаас 2022 онд Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн хүсэлт болон хүсэлтийн дагуу явуулсан хариуны тоо өмнөх онтой харьцуулахад 2 дахин өссөн байна.

Санхүүгийн мэдээллийн алба нь хууль сахиулах байгууллагатай мэдээлэл солилцож хамтран ажиллахаас гадна бусад эрх бүхий байгууллагууд болох Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хил хамгаалан ерөнхий газруудтай мэдээлэл солилцдог.

б. Гадаадын эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцох

ФАТФ-ын Зөвлөмж 29-т зааснаар Санхүүгийн мэдээллийн алба нь Эгмонт бүлэг болон бусад улсын Санхүүгийн мэдээллийн албатай мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйлдэлтэй холбоотой мэдээлэл солилцон хамтран ажилладаг бөгөөд энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь сүүлийн жилүүдэд дараах байдлаар Эгмонт сүлжээгээр мэдээлэл солилцон, хамтран ажиллав (Хүснэгт 3.7).

Хүснэгт 3.7. Эгмонт сүлжээгээр мэдээлэл солилцсон байдал /2020-2022/

Үзүүлэлт	2020	2021	2022
<i>СМА-аас гадаадын СМА-д явуулсан хүсэлтийн тоо</i>	353	140	170
<i>Гадаадын СМА-д явуулсан хүсэлтийн дагуу ирүүлсэн хариуны тоо</i>	247	165	138
<i>Гадаадын СМА-аас мэдээлэл авах чиглэлээр СМА-д ирүүлсэн хүсэлтийн тоо</i>	123	149	148
<i>Гадаадын СМА-аас мэдээлэл авах чиглэлээр СМА-д ирүүлсэн хүсэлтийн дагуу явуулсан хариуны тоо</i>	112	129	99
<i>Гадаадын СМА-аас шилжүүлсэн мэдээллийн тоо</i>	-	17	21

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн тэдээллийн алба

Эгмонт бүлгийн 28 дахь удаагийн жилийн уулзалт 2022 оны 7 дугаар сарын 10-ны өдрөөс 7 дугаар сарын 15-ны өдрүүдийн хооронд Латви улсад зохион байгуулагдсан бөгөөд энэ уулзалтад Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөл оролцов. Энэ жилийн уулзалтаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд Санхүүгийн мэдээллийн албадын үүрэг оролцоог сайжруулах, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, мэдээлэл солилцоог дэмжих асуудлуудыг хэлэлцэв.

Түүнчлэн 2022 онд Санхүүгийн мэдээллийн алба нь Бүгд Найрамдах Ардчилсан Зүүн Тимор Улс болон Камбожийн Хаант улсын Санхүүгийн мэдээллийн албатай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, мэдээлэл солилцон, хамтран ажиллахаар боллоо.

Санхүүгийн мэдээллийн албанаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мэдээлэл солилцох хамтын ажиллагааг цахимжуулж, үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор эрх бүхий байгууллагуудтай ГоАМЛ програмаар буюу цахимаар мэдээлэл солилцоход дотоодын хууль эрх зүйн орчинд нийцэж байгаа эсэхийг судлахаас гадна гадаад улсын шилдэг туршлагуудыг судлав.

Түүнчлэн цахимаар мэдээлэл солилцох хамтын ажиллагаатай холбоотойгоор ФАТФ-аас гаргасан Мэдээлэл солилцох гарын авлагыг орчуулан, цахим хуудсанд байршууллаа.

VIII. Сургалт, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа

Санхүүгийн мэдээллийн албанаас 2022 онд мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд зориулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр соён гэгээрүүлэх ажлын хүрээнд дараах бичиг баримтуудыг боловсруулж, олон нийтэд түгээсэн байна. Тухайлбал:

- Мэдээлэх үүрэгтэй этгээд болон эрх бүхий байгууллагуудад зориулан 2021 оны Стратегийн дүн шинжилгээний тайланг боловсруулж, хүргүүлэв;
- Санхүүгийн мэдээллийн албанаас НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газраас боловсруулсан ГоАМЛ програмыг үйл ажиллагаандаа 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдөр албан ёсоор нэвтрүүлсэнтэй холбоотойгоор мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулан ГоАМЛ програмд бүртгүүлэх, тайлан бөглөх, хэрэглэгчийн эрхийн удирдлага, нэмэлт мэдээлэл файл тайлан бөглөх 5 төрлийн гарын авлагыг боловсруулж, ГоАМЛ програмд байршуулав;
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу мэдээлэх үүрэгтэй этгээд болсонтой холбоотойгоор виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулан сэжигтэй гүйлгээний тайлан мэдээлэх гарын авлагыг салбарын онцлогт нийцүүлэн шинээр боловсруулан, түгээв;
- “Эцсийн өмчлөгчийн тухай гарын авлага”-ыг шинэчлэн боловсруулав;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны мэдээлэл солилцооны үр дүнтэй байдлыг дээшлүүлэх чиглэлээр ФАТФ-ын “Хувийн хэвшлийн мэдээлэл солилцоо”-ны гарын авлагыг орчуулан гаргав.
- Корреспондент банкны

Дээрх гарын авлага, заавар зөвлөмжүүдийг Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудас (www.mongolbank.mn) дээр байршуулсан болно.

Мөн Монголын банкуудын холбоо, Азийн сантай хамтран Ковид-19 цартахлын улмаас 2 жил зохиогдоогүй байсан Комплаенсын Форумыг зохион байгуулж мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд оролцоотой төр, хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөлд Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүн, корреспондент банкын харилцаанд тулгамдаж буй асуудал, шийдэл болон ОХУ-ын Украйнд явуулж буй цэргийн тусгай ажиллагааны улмаас гадаад төлбөр тооцоо хийхэд учирч буй хүндрэл, ОХУ-ын эсрэг тавигдсан хориг арга хэмжээний тухай илтгэл, хэлэлцүүлэгт СМА-ны дарга, ажилтнууд илтгэгч, панелистаар оролцлоо.

Түүнчлэн Хамтын ажиллагааны зөвлөлийн Хууль сахиулах болон Хууль эрх зүйн орчныг сайжруулах ажлын хэсгийн ажлын төлөвлөгөөний хүрээнд Цагдаагийн ерөнхий газраас 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан “Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэл, тулгамдаж буй асуудал, цаашдын чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг Монголбанк, Санхүүгийн мэдээллийн албанаас хамтран зохион байгуулж, илтгэл тавьж оролцлоо.

Зураг 3.5. Санхүүгийн мэдээллийн албаны нэрэмжит “Эрдэм шинжилгээний анхдугаар бага хурал”



Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн тэдээллийн алба

Санхүүгийн мэдээллийн албанаас судлаач, оюутнуудыг соён гэгээрүүлэх чиглэлээр энэ онд хийсэн голлох ажил бол мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн эрдэм шинжилгээний хурлыг анх удаа зохион байгуулсан явдал байлаа. Тус ажлыг Хамтын ажиллагааны зөвлөлийн Судалгаа дүн шинжилгээний ажлын хэсгийн ажлын төлөвлөгөөний хүрээнд хийж гүйцэтгэсэн бөгөөд 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдөр амжилттай зохион байгуулсан юм. Уг эрдэм шинжилгээний хурал нь судлаач, оюутнуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл туурвихад нь уриалж сэдэлжүүлэх, бүтээлийг нь олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, бодлогын шийдвэр гаргалтад оролцох оролцоог нэмэгдүүлэх өндөр ач холбогдол бүхий ажил бөгөөд цаашид энэхүү хурлыг Санхүүгийн мэдээллийн албанаас жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар төлөвлөж байна.

IX. Чадавхыг бэхжүүлэх, нөөц бололцоог сайжруулах

Санхүүгийн мэдээллийн алба нь шинжээчдийн чадавхыг бэхжүүлэх, сүүлийн үеийн чиг хандлагын талаар мэдлэг боловсролоо дээшлүүлэх чиглэлээр АНУ-ын Сангийн яамны техник туслалцааны хөтөлбөрт үргэлжлүүлэн хамрагдлаа. Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнууд гадаад, дотоод хамтын ажиллагааны хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мэргэжлийн сургалт, семинарт тогтмол хамрагдсан байна.

Үүнээс гадна Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэгтэй төр, хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөллийг 2022 оны туршид дотоодын болон олон улсын сургалт, семинарт тогтмол хамруулан ажиллав. Тухайлбал, Санхүүгийн мэдээллийн албанаас дангаар болон бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулсан сургалтад нийт 2045 албан тушаалтнууд оролцсон бол ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудын цахим сургалтад давхардсан тоогоор төр, хувийн хэвшлийн 240 гаруй албан тушаалтнууд хамрагдав (Хүснэгт 3.8).

Хүснэгт 3.8. Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулсан болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинар болон оролцогчдын тоо

Үзүүлэлт	2020	2021	2022
СМА-аас зохион байгуулсан сургалт, семинарын тоо	4	3	17
СМА-аас зохион байгуулсан сургалт, семинарт оролцогчдын тоо	136	120	732
Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинарын тоо	20	29	30
Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинарт оролцогчдын тоо	886	2,204	1,313

Эх сурвалж: Монголбанк, Санхүүгийн тэдээллийн алба

3.10 ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Судалгааны ажил

ЭЗССХ нь 2022 онд эдийн засгийн болон санхүүгийн хүрээний бодлогын шийдвэрт дэмжлэг болох чиг үүргийн хүрээнд дараах судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

Төлөвлөгөөт ажил

- Орчин үеийн аж үйлдвэржилтийн бодлого ба ногоон эдийн засаг
- Хүртгээмжтэй эдийн засгийн өсөлтийн бодлогын асуудлууд
- Уул уурхайн бус экспортыг дэмжих, санхүүжүүлэх тогтолцооны олон улсын туршлага, арга хэрэгслүүд
- Үндэсний тооцооны данснууд ба хөрөнгийн урсгалын матриц
- Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зээлийн хүүний дээд хязгаар тогтоох, мөнгө хүүлэлтийн эсрэг зохицуулалтын талаарх олон улсын жишээнүүд, Монгол Улсын хувьд баримтлах бодлого, эрх зүйн хандлага
- Инфляцын хүлээлтийн аргамжаа, түүнийг тодорхойлох нь судалгааны ажилд үндэслэн санал боловсруулах
- Ханшийн хүлээлтийн түүвэр судалгааны асуулгыг бэлтгэх

Төлөвлөгөөт бус ажил

- Валютын захын таксоном бүтэц, ГВУН-ийн 2006-2021 оны дүн шинжилгээ, хандлага
- Доллар төгрөгийн ханш, NEER/REER индексийн хөдөлгөөний түүхэн дүн шинжилгээ
- 2022 оны эдийн засгийн тойм, 2023-2024 оны төлөв байдал

Сургалт

Санхүүгийн салбарын мэргэжилтнүүд болон Монголбанкны ажилтнуудад холбогдох газар, нэгжүүдтэй хамтран дараах сургалт, арга хэмжээг зохион байгуулав.

Монголбанкны 80 гаруй шинэ ажилтанд зориулан Шинэ ажилтныг чиглүүлэх сургалтыг 2 удаа, Монголбанкны 35 хэлтсийн захирал, 17 орон нутгийн салбар, хэлтсийн захирлуудад зориулан Удирдах ажилтны семинарыг 2 удаа тус тус зохион байгуулав.

Арилжааны банкны ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулахаар тэдгээрээс сэдвийн санал авч “Банкны ажилтны семинар”-ыг 2022 оны 08 дугаар сараас 2022 оны 10 дугаар сарын хооронд нийт 8 удаа цахимаар зохион байгуулав. Тус сургалтад нийт 11 арилжааны банкны давхардсан тоогоор 1652 ажилтан хамрагдсан. Сургалтуудыг Монголбанкны газар, нэгжүүдтэй хамтран банкны хяналт шалгалт,

бэлэн мөнгө ялгах үндсэн стандарт, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, мөн ТоС холбоотой хамтран тогтвортой санхүүжилт зэрэг сэдвүүдийн хүрээнд зохион байгуулав.

Хэвлэн нийтлэл, хурал семинар

“Экспортлогч Үндэстэн – Шинэ сэргэлтийн бодлого” чуулган

Монгол Улсын экспортын бүтцийг өөрчлөх, бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, валютын дотогшлох урсгалыг нэмэгдүүлэх, экспортлогч ААН-үүдийг дэмжих зорилгоор Засгийн газар, МҮХАҮТ, МБГ, НУСЗЗГ, ББӨБГ-тай хамтран 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр МҮХАҮТ-ын “Их танхим”-д Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор “Экспортлогч Үндэстэн – Шинэ сэргэлтийн бодлого” чуулганыг зохион байгуулсан. Чуулганд 250 экспортлогч ААН-үүд, төрийн болон олон улсын байгууллагууд, арилжааны банкуудын төлөөллүүд оролцсон. Чуулганд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах, уул уурхайн бус экспортын нэгдсэн бодлого боловсруулах, шийдлийг хамтран хэлэлцэх талаар оролцогчид санал хүсэлтээ илэрхийлж, чуулганаас гарсан үр дүн болон ЭЗССХ-ээс хийгдсэн судалгааны ажилд үндэслэн “Уул уурхайн бус экспортыг дэмжих хөгжүүлэх төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж, холбогдох газруудад хүргүүлэв.

“Эдийн засгийг энгийнээр” сэтгүүл

Эдийн засгийн энгийнээр сэтгүүлийн дугаарт дараах сэдвүүдийн хүрээнд нийтлэлүүд бэлтгэсэн:

- Эдийн засгийн түүхийг энгийнээр
- Сөрөг хүүг тайлбарлах нь
- Бонд ба түүний төрлүүд
- Инфляцад нөлөөлөгч хүчин зүйлс
- Хөрөнгийн урсгалын матриц ба үндэсний тооцооны данс
- Гадаад валютын улсын нөөцийн тухай

Инфляцын болон валютын ханшийн календарь

Инфляцын болон валютын ханшийн календарийг гаргаж, Монголбанкны цахим хуудаст байршуулж олон нийттэй харилцах үйл ажиллагаанд ашиглав.

3.11 ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН

Зээлийн мэдээллийн сангийн зорилго нь санхүүгийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудын зээлийн эрсдэл, хуримтлагдсан чанаргүй зээл, өр, авлагын хэмжээг бууруулах, зээлдэгчийн санхүүгийн сахилга батыг сайжруулах замаар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад оршдог.

Энэхүү зорилгын хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 1997 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Монголбанк нь зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг эрхэлсээр ирсэн. Энэ хугацаанд Зээлийн мэдээллийн тухай хуульд заасан төрийн болон хувийн хэвшлийн нийт 600 орчим хэрэглэгч байгууллагууд зээлийн мэдээллийн санд холбогдсоноор давхардсан тоогоор нийт 2.8 сая орчим зээлийн мэдээлэл бүртгэгдсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Зээлийн хүү бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд зээлийн мэдээллийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн тушаалаар “Бүрэн Скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй Зээлийн мэдээллийн сан” ХХК-д олгосон бөгөөд тайлант хугацаанд тусгай зөвшөөрөл бүхий этгээдийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах, зээлийн мэдээллийн үйл ажиллагааны талаарх бодлого, үйл

ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг эхлүүлсэн.

Зээлийн мэдээллийн үйлчилгээг хувийн хэвшилд шилжүүлснээр зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэж хөгжүүлэх, зээлийн оноо /credit scoring/ буюу зээлжих зэрэглэл тооцох, зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгох, улмаар зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах ач холбогдолтой юм.

3.12 БАНК САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛТ

Тайлант оны туршид Монголбанкнаас Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасан үндсэн зорилт, эрхлэх үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн суурь нөхцөл болсон банк санхүү, эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх чиглэлээр хууль тогтоомжийг шинэчлэлийг үргэлжлүүлэв.

Монголбанкны эрхэлж байгаа Монгол Улсын Эрдэнэсийн сангийн эрх зүйн байдал, эрдэнэсийн төрөл, зүйлийг хөгжлийн өнөөгийн түвшин, цаашдын чиг хандлагатай уялдуулан өргөжүүлэх, эрдэнэсийн сангийн бүртгэлийг сайжруулж, хариуцлагын тогтолцоог бүрэн бүрдүүлэх агуулга бүхий Эрдэнэсийн сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар батлав.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, мөнгөн зээлийн үйл ажиллагааг байнга, ашиг олох зорилгоор эрхлэх иргэн, мөнгөн зээлийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх, хяналт тавих, тэдгээрээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох, зээлийн хүүг төлөх болон мөнгөн зээлийн үйл ажиллагаа дахь санхүүгийн хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр “Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль”-ийн төслийг Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит нэгдсэн чуулганы хуралдаанаар баталсан бөгөөд Монголбанкнаас тус хуулийн төсөлд өндөр ач холбогдол өгч хууль санаачлагч болон хууль тогтоогчтой нягт хамтран ажиллаа.

Улсын Их Хурлын 2021 оны 91 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэл”-д “Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд гэрээний маргаан шийдвэрлэх үйл явцыг хялбаршуулах, зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх”-ээр заасан билээ.

Энэ хүрээнд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хурдан шуурхай, үр нөлөөтэй хэрэгжүүлдэг байх, шүүх болон бусад оролцогчдод учирдаг хүндрэлийг арилгах зорилгоор шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг бий болгох, маргаан багатай, бага үнийн дүнтэй болон банк, эрх бүхий этгээдийн олгосон зээл, түүний үүргийн гүйцэтгэлийг хангахтай холбоотой хэргийг бусад иргэний хэргээс ялгамжтай авч үзэн, уг төрлийн онцлогт нийцсэн хялбаршуулсан журмыг бий болгох, шүүгч нэхэмжлэлийн хувийг хариуцагчид гардуулах ажиллагааны хүрээнд хариуцагчийн тогтоох, эрэн сурвалжлах үйл ажиллагааг цагдаагийн байгууллагаар байгууллагаас ангид байдлаар мэргэжлийн албаар гүйцэтгүүлдэг байх, хэргийн онцлогтой холбоотойгоор өмгөөлөгчгүй орох боломжтой хэргийг тодорхойлох, гадаад улсаас нотлох баримт бүрдүүлэх үйл ажиллагааг тусгах, шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах, шүүхийн шийдвэрийн үр дүнтэй байдлыг хангах зорилгоор шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх суурь зарчим, зохицуулалтыг нарийвчлан тусгах, мөн түүнчлэн үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотойгоор төлбөр гаргуулах эд хөрөнгийг нарийвчлан заах, үнэлгээг тогтоох процессыг тусгах зэрэг саналыг дэвшүүлсэн.

Түүнчлэн Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн 2.2 дахь хэсэгт заасан санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах үндсэн зорилтын хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А-6 дугаар тушаалаар “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн зүгээс Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Азийн хөгжлийн банк (АХБ)-тай хамтарсан “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах салбарын хөгжлийг дэмжих, мэдлэг олгох техникийн туслалцаа”-ны төслийн хүрээнд “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийн саналыг гадаад мэргэжилтэн зөвлөхөөс өгсөн санал, зөвлөмжийг үндэслэн санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлж байгаа санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагыг тогтоож, зохицуулагч байгууллагаас зохистой хяналт шалгалтаас гадна санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх агуулгаар боловсруулсан болно.

Хуулийн төсөл нь “санхүүгийн хэрэглэгч” буюу санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ авахаар сонирхож байгаа, эсхүл авсан хувь хүн болон Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад заасан бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн болно. Харин санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид зохицуулагч байгууллага болох Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрөл, бүртгэлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийг хамааруулсан. Өөрөөр хэлбэл тус хууль нь банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, үнэт цаас, даатгалын компаниуд, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч зэрэг этгээдүүдэд хамаарна. Хуулийн төслийг санаачлуулахаар 2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчид хүргүүлээ.

Мөн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн судалгааг хийж, тайланг боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд хуулийн төслийг Улсын Их хурлаас 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр баталсан байна. Хууль батлагдсанаар Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулагдсан банк 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор холбогдох хуулийн дагуу компанийн хэлбэрээ өөрчилсөн байх зохицуулалттай болсон болно.

МОНГОЛБАНКНААС 2022 ОНД БАТАЛСАН ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ХУРААНГУЙ

Д/д	Эрх зүйн баримт бичгийн нэр	Огноо	Дугаар	Тайлбар
1	QR кодын мессежний бүтэц, заавар	2022.01.03	A-1	Үндэсний төлбөр тооцоонд ашиглагдах “QR кодын мессежний бүтэц, зааврыг баталсан бөгөөд QR код ашиглан хийж буй бүх төрлийн худалдан авалтын гүйлгээнд харилцагчаас шимтгэл авахыг хориглосон.
2	Сценарь шинжилгээ хийх заавар	2022.03.15	A-54	Монголбанкны нэгжийг үйл ажиллагааны эрсдэлийн сценарь шинжилгээг гүйцэтгэх аргачлалаар хангах зорилготой.
3	Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авах, хэрэгжүүлэх журам	2022.03.15	A-56	Тус журмыг нь Банкны тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан үндэслэлээр Монголбанкнаас банкны системд нөлөө бүхий банканд бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ авахаар шийдвэрлэх, тусгай төлөөлөгчийг томилох, бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ хэрэгжүүлэх, дуусгавар болгохтой холбоотой харилцаанд мөрдөнө.
4	Монголбанкны албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт	2022.03.16	A-66	Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хуулийг үндэслэн шинэчлэн баталсан.
5	Монголбанкны Дата төвийн үйл ажиллагааны дүрэм	2022.03.29	A-100	Тус дүрэм нь Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийн дата төвүүдийн үйл ажиллагааг зохицуулах, тасралтгүй ажиллагааг хангах, ажилтнуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлох зорилготой юм.
6	Монголбанкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм	2022.05.02	A-135	Тус дүрэм нь Монголбанкны төлбөрийн картын клирингийн системээр дамжин төлбөрийн картаар хийгдэж буй мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн даалгаврыг дамжуулах, тохируулах, баталгаажуулах, оролцогчдын төлбөр тооцооны үр дүнг тооцоолох, клирингийн системд үүсч болох эрсдэлийг удирдах болон эдгээр үйл ажиллагааг Монголбанкны клирингийн төвөөс эрхлэхтэй холбогдох харилцааг зохицуулах зорилготой болно.

7	Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам	2022.05.09	А-143	Тус журмаар Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Монголбанкнаас банкны удирдлага (Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/, Гүйцэтгэх удирдлага)-ын бүрэн эрх, үйл ажиллагаа нь Банкны тухай хууль тогтоомж, Компанийн хуульд заасан удирдлагын тавигдах шаардлага, шалгууртай нийцэж байгаа эсэхийг тогтоож, Банкны тухай хуулийн 43.6-д заасны дагуу банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх харилцааг зохицуулна.
8	Монголбанкны шилэн данс хөтлөх журам	2022.05.23	А-155	Тус журам нь Монголбанкнаас Шилэн дансны тухай хуульд заасан нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх мэдээллийн хүрээ, төрлийг тодорхойлж, тэдгээрийг бэлтгэх, байршуулах, тайлагнах зэрэг үйл ажиллагааг хариуцсан нэгжийн чиг үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилготой.
9	Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл ирүүлэх журам	2022.06.03	А-171	Тус журмыг Мэдээлэх үүрэгтэй этгээдээс Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7, 9 дүгээр зүйлд заасан гүйлгээний талаарх мэдээлэл, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлд заасан мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагаанд мөрдөнө.

10	Үндэсний цахим гүйлгээний төвийн үйл ажиллагааны дүрэм	2022.06.30	A-193	Тус дүрмийн зорилго нь Монголбанкны Төлбөр тооцооны газрын Үндэсний цахим гүйлгээний төвийн үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдлыг хангах, болзошгүй гэмтэл саатлаас урьдчилан сэргийлэх, гэмтэл саатал гарсан тохиолдолд мэдээллийн системийг богино хугацаанд нөөцлөх, хадгалах, сэргээх, өөрчлөлт хийх ажилтнуудын үүрэг хариуцлагыг тодорхойлоход оршино.
11	Мэдээлэх үүрэгтэй этгээдээс эрх бүхий хууль сахиулах болон терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад мэдээлэл өгөх журам, Банкнаас дансны хуулга авах загвар, Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдээс гүйлгээний тухай мэдээлэл авах загвар /МБЕ, ХЗДХЯ-ны сайдын хамтарсан тушаал/	2022.06.23	A-185/A/176	Энэхүү журмыг эрх бүхий хууль сахиулах болон терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагаас мөнгө угаах, түүний суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг шалгахад хамаарах Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-т заасан мэдээлэх үүрэгтэй этгээд мөн хуулийн 7 дугаар зүйлд заасан тодорхой гүйлгээ, түүнд оролцогч талуудын мэдээллийг авах хүсэлт гаргах, мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээллийг өгөх, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагаанд мөрдөнө.
12	Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам /МБЕ, Сангийн сайдын хамтарсан тушаал/	2022.06.07	A122/A-172	Тус журмын зорилго нь Засгийн газар болон төсвийн байгууллагын Төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур нээсэн банк дах дансны удирдлагыг хэрэгжүүлэхэд тавигдах шаардлага, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
13	Монголбанкны дотоод аудитын дүрэм	2022.08.15	A-214	Монголбанкны дотоод аудитын дүрмийн зорилго нь Монголбанкны дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлэгч нэгжийн зорилго, үйл ажиллагааны цар хүрээ, эрх, үүрэг, Монголбанкны бүтцийн бусад нэгжтэй харилцах зарчим, хариуцлагын талаарх харилцааг зохицуулахад оршино.
14	Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны журам	2022.09.15	A-235	Энэхүү журмын зорилго нь Эрдэнэсийн сангийн тухай хуульд заасан үйл ажиллагаатай холбогдсон Монголбанкны харилцааг зохицуулахад оршино.
15	Монголбанкны албан томилолтын журам	2022.09.23	A-253	Монголбанкны хэмжээнд албан томилолттой холбогдох харилцааг зохицуулсан.

16	Банкны зээл олгох үйл ажиллагааны журам	2022.11.09	А-311	Энэ журмын зорилго нь банкны зээлийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ болон зээлийн бодлогыг тодорхойлох, зээлийн үйл ажиллагаа, зээлийн үйл ажиллагаанд тавих хяналт, зээлийн үйл ажиллагааг зохицуулахад баримтлах зарчмыг тодорхойлоход оршино.
17	Мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх банкны үйл ажиллагаанд Монголбанк зайнаас хяналт тавих журам	2022.12.01	А-335	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, тэдгээрт нийцүүлэн Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан дүрэм, журам, удирдамж, зөвлөмжийг банк өөрийн бүтэц зохион байгуулалт, бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр болон үйл ажиллагаатай уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэхэд зайнаас хяналт тавихад энэхүү журмыг мөрдлөг болгоно.
18	Мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх банкны үйл ажиллагаанд Монголбанк газар дээрх хяналт шалгалт хийх журам	2022.12.01	А-335	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, бусад хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанкнаас гаргасан заавар, дүрэм, журам, удирдамж, зөвлөмжийг банк өөрийн бүтэц зохион байгуулалт, бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр болон үйл ажиллагааны цар хүрээтэй уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих, үүрэг даалгавар өгөх, арга хэмжээ авах мөн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан газар дээрх хяналт шалгалт хийх, дүгнэлт гаргахад энэ журмыг мөрдлөг болгоно.

МОНГОЛБАНК

**АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БА
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

2022 ОНЫ 12 САРЫН 31

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

АГУУЛГА

ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	97
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН	98
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД	100
Санхүүгийн байдлын тайлан	100
Орлогын үр дүнгийн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайлан	103
Өмчийн өөрчлөлтийн тайлан	104
Мөнгөн гүйлгээний тайлан	105
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	
1 Танилцуулга болон үйл ажиллагааны орчин	107
2 Санхүүгийн тайлагналын тогтолцоо, тайлан бэлтгэх үндэслэл болон толилуулга	109
3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого	110
4 Нягтлан бодох бүртгэлд ашигласан ач холбогдол бүхий таамаглал болон үндэслэлийн талаар тайлангийн тодруулга	125
5 Шинэ буюу өөрчлөлт орсон стандартуудын тайлбар, хэрэгжилт	133
6 Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан мэдэгдэл	135
7 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	136
8 Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	138
9 Дотоодын банкуудад олгосон зээл	140
10 Буцаан худалдан авах хэлцлийн авлага	147
11 Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	148
12 Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	154
13 Урвуу буцаан худалдан авах хэлцэл	155
14 Алт ба үнэт метал	158
15 Эрдэнэсийн сан	159
16 Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	160
17 Засгийн газрын үнэт цаас	161
18 Засгийн газраас авах авлага	163
19 Бусад хөрөнгө	164
20 Үндсэн ба биет бус хөрөнгө	169
21 Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	171
22 Төв банкны үнэт цаас	171
23 Засгийн газрын хөрөнгө	172
24 Дотоодын банкуудын хөрөнгө	173
25 Гадаад өр төлбөр	174
26 Буцаан худалдан авах хэлцэл	176
27 Бусад өр төлбөр	176
28 Дүрмийн сан болон бусад нөөц сан	177
29 Хүүгийн орлого ба зардал	178
30 Алт, үнэт металын арилжааны ашиг/алдагдал	179
31 Үйл ажиллагааны бусад орлого	179
32 Захиргааны ба үйл ажиллагааны бусад зардал	180
33 Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага	181
34 Холбоотой талуудын ажил гүйлгээ	183
35 Санхүүгийн эрсдэлийн удирдлага	189
36 Бодит үнэ цэнийн тодруулга	212
37 Санхүүгийн хэрэгслийн хэмжилтийн ангиллаарх тодруулга	224
38 Капиталын удирдлага	227
39 Тайлагналын үеийн дараах үйл явдал	227
40 Монгол хэл дээрх орчуулга	227

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Санхүүгийн тайланг бэлтгэх нь Монголбанкны Захирлуудын зөвлөлийн үүрэг байна.

Монголбанк (цаашид "Банк" гэх)-ны санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн болно. Банкны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг санхүүгийн тайланд үнэн зөв бодитой илэрхийлэгдсэнийг Захирлуудын зөвлөл баталгаажуулах үүрэгтэй.

Захирлуудын зөвлөл нь нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв, зохистой хөтөлж явуулахыг хариуцах ба энэ нь Тодруулга 3-т тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу Банкны санхүүгийн байдлыг үнэн зөв тайлагнах үүргийг биелүүлэх боломжийг олгодог.

Банкны хөрөнгийг хамгаалах, залилах, бусад зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг өөрийн эрх мэдлийн хүрээнд авч үзэж, хэрэгжүүлэх нь Захирлуудын зөвлөлийн үндсэн үүрэг болно.

Захирлуудын зөвлөл нь (1-105 дүгээр хуудсанд тодруулсан) санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогыг тууштай баримталж, үндэслэлтэй ба оновчтой үнэлэлт, тооцооллыг ашиглаж, нягтлан бодох бүртгэлийн холбогдох бүх стандартуудыг дагаж мөрдсөн гэж үзэж байна.

Захирлуудын зөвлөлийг төлөөлөн гарын үсэг зурсан:


Б.ЛХАГВАСҮРЭН
Монголбанкны Ерөнхийлөгч



Хараат бус аудиторын тайлан

Монголбанкны Захирлуудын Зөвлөлд

Хязгаарлалттай дүгнэлт

Бидний дүгнэлтээр, хараат бус аудиторын тайлангийн Хязгаарлалттай дүгнэлт гаргах үндэслэл хэсэгт дурдагдсан зүйлсийн эдгээр санхүүгийн тайлангуудад нөлөөлж болзошгүй байдлыг эс тооцвол, Монголбанк ("Банк" гэх)-ны санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд мөн тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

Бид юунд аудит хийсэн талаар

Дараах бүрэлдэхүүн бүхий Банкны санхүүгийн тайлангуудад бид аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн орлого үр дүнгийн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн өмчийн өөрчлөлтийн тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн мөнгөн гүйлгээний тайлан; болон
- нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд болон бусад тайлбар мэдээллээс бүрдсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд.

Хязгаарлалттай дүгнэлт гаргах үндэслэл

Санхүүгийн тайлангуудын тодруулга 4 болон 15-т тусгагдсан Эрдэнэсийн сан нь түүх, соёлын болоод өв уламжлалын хосгүй үнэт зүйлс болон зоос зэрэг үнэт зүйлсээс бүрдэх ба НББОУС 16, Үндсэн хөрөнгө-ийн дагуу дахин үнэлгээний аргачлалыг ашиглан хэмжигддэг. Эрдэнэсийн санд банкны эрх залгамжлагч Монголбанкны 1925 онд гүйлгээнд гаргасны дараа Монголын мөнгөн болон зэс зооснууд ("Зооснууд") хадгалагдаж байгаа бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 908,476 сая төгрөг (2021: 908,476 сая төгрөг)-ийн дансны үнэтэй байна. Эдгээр зоосыг дахин үнэлэх болсон үндсэн зорилго нь тэдгээрийн бодит үнэ цэнийг тусгах явдал бөгөөд энэ нь зоосны мөнгөн болон зэс үнэт металын орцын үнэ цэнээс илт давуу байна гэж үзсэн.

Санхүүгийн тайлангуудын тодруулга 3-т тусгагдсан Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу Банкнаас зоос болон мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах үед нэрлэсэн өртгөөр өр төлбөр хэсэгт бүртгэх бөгөөд гүйлгээнээс татсан зоос болон мөнгөн тэмдэгтийг хөрөнгөөр хүлээн зөвшөөрдөггүй. Санхүүгийн тайлангуудын тодруулга 4-т тодруулсанчилан Банк нь Монголбанкны хууль ёсны эрх залгамжлагчийн хувьд Зоосуудыг гүйлгээнд гаргасан хэдий ч Банкны удирдлага эдгээр Зоосыг Засгийн газраас Эрдэнэсийн санд хандивласан учир тэдгээрийг хөрөнгөөр хүлээн зөвшөөрч болно гэж дүгнэсэн.

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК, Сэнтрал Тауэр, 6 давхар, 601 тоот,
Сүхбаатарын талбай, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Улаанбаатар хот 14200, Монгол Улс
Утас: +976 70009089, www.pwc.com/mn

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Хязгаарлалттай дүгнэлт гаргах үндэслэл (үргэлжлэл)

1938 оноос хойш зоосыг хууль ёсны төлбөрийн хэрэгсэл байхаа болиход тэдгээрийг гуравдагч тал өмнө нь эзэмшиж байсан бөгөөд СТОУС 3-ын дагуу гуравдагч тал Эрдэнэсийн санд Зоосыг хөрөнгө байдлаар шилжүүлэн, СТОУС-д шилжих үед Банкны хөрөнгөөр хүлээн зөвшөөрөхөд шаардлагатай хууль ёсны нотолгоог Банкны удирдлага бидэнд өгч чадаагүй. Түүнчлэн Банк зоосыг тэдгээрийн үнэлгээнд тодорхойлогдсон үнээр нь худалдан борлуулах боломжтой гэдгийг нотлох баримтыг бид олж авч чадаагүй. Үүний үр дүнд, Зоос нь СТОУС-ын дагуу санхүүгийн байдлын тайланд үнэн зөв хүлээн зөвшөөрөгдсөн эсэхэд холбогдох итгэл үнэмшлийг бид олж чадаагүй бөгөөд мөн хэрэв тэдгээр нь үнэн зөв хүлээн зөвшөөрөгдсөн байсан ч бид санхүүгийн байдлын тайланд тусгагдсан Зоосны үнэлгээнд холбогдох итгэл үнэмшлийг олж чадаагүй. Иймд, Зоосны бодит үнэ цэнийн дахин үнэлгээний дүн болох 906,788 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг 2022 оны 12 дугаар сарын 31, 2021 оны 12 дугаар сарын 31 болон 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаарх Банкны Өөрийн хөрөнгөнд дахин үнэлгээний нөөц сан дансанд хүлээн зөвшөөрөгдөх эсэхэд хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бид олж авч чадаагүй бөгөөд хэрвээ түүнийг хүлээн зөвшөөрөх ёстой бол дүн нь үнэн зөв байх хэрэгтэй.

Бид Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу аудитын ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар тус тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тусгасан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

Хараат бус байдал

Нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн стандартын зөвлөл (НБОУЁСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (МНБЁЗД)-ийн (Хараат бус байдлын олон улсын стандартыг оруулан) дагуу Банкнаас бид хараат бус болно. Бид НБОУЁСЗ-ийн МНБЁЗД-ийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэлд 2022 оны Банкны Жилийн тайланг (гэхдээ санхүүгийн тайлангууд болон түүнтэй холбоотой аудиторын тайланг оруулаагүй) багтаасан бөгөөд энэхүү аудиторын тайлангийн өдрөөс хойш бэлэн болохоор хүлээгдэж байгаа болно.

Санхүүгийн тайлангуудын талаарх аудитын дүгнэлтэд бусад мэдээлэл хамрагдаагүй бөгөөд бид түүнтэй холбоотой аудитын аливаа төрлийн баталгаа дүгнэлтийг илэрхийлэхгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбогдуулан бидний хүлээх үүрэг бол дээр дурдсан бусад мэдээллийг бэлэн болсон үед нь уншиж танилцах бөгөөд ингэхдээ бусад мэдээлэл нь аудитын явцад бидний олж авсан мэдлэгтэй эсвэл санхүүгийн тайлангуудтай материаллаг хэмжээгээр нийцэхгүй, өөрөөр хэлбэл материаллаг алдаатай илэрхийлэгдсэн байгаа эсэхийг бид авч үздэг. 2022 оны Жилийн тайланг уншиж танилцах үед хэрэв бид энэхүү бусад мэдээлэлд материаллаг алдаа байна гэж дүгнэвэл засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд энэ тухай мэдэгдэх үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор засаглал хариуцсан эрх бүхий этгээд болон удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, бодитойгоор тайлагнах болон залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлангууд бэлтгэхэд шаардлагатай гэж удирдлага тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага байна.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад удирдлага Банкны үйл ажиллагааг цаашид тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжийг үнэлэх, тухайн чадамжид нөлөөлөх нөхцөл байдлын талаар зохистой үед тодруулах болон Банкны үйл ажиллагааг татан буулгах, үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл зогсоохоос өөр сонголтгүй болсноос бусад тохиолдлуудад нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

Банкны засаглал хариуцсан эрх бүхий этгээд нь санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл байх тохиолдол бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх боломжтой ба энэ нь санхүүгийн тайланг хэрэглэгчдийн эдгээр тайланд үндэслэн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц байвал материаллаг буруу илэрхийлэл болно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандах, мэргэжлийн холбогдох итгэл үнэмшил бүхий үнэлэлтүүдийг хийдэг. Мөн бид:

- Залилан болон алдааны улмаас санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг илрүүлэн үнэлэх, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг тодорхойлон гүйцэтгэх, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Залилан нь нууцаар үгсэн тохирох, хуурамч бичиг баримт үйлдэх, санаатайгаар орхигдуулах, хуурамч батламж гаргах эсвэл эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотойгоор үүсдэг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас шалтгаалж үүсэх материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэлээс илүү өндөр байдаг.
- Банкны дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг тодорхойлох зорилгын хүрээнд дотоод хяналтын тогтолцооны ойлголтуудыг аудитын явцад олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцоолуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Банк үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадварт томоохон хэмжээний эргэлзээ үүсч болох нөхцөл байдал, тухайн үйл явдлуудтай холбоотойгоор материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэх болон удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр хангахад зөв зохистой нягтлан бодох бүртгэлийн суурийг сонгосон эсэхийг аудитын туршид бүрдүүлсэн нотолгоонд үндэслэн дүгнэдэг. Хэрэв үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжид материаллаг тодорхойгүй байдал оршин байгаа гэж үзсэн тохиолдолд санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгыг аудиторын тайланд тусгах, анхааруулах мөн эдгээр

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

тодруулгууд хангалтгүй гэж үзсэн тохиолдолд дүгнэлтээ өөрчилдөг. Бид дүгнэлтээ аудиторын тайланг гаргах өдрийг хүртэл олж авсан аудитын нотолгоонуудад үндэслэн гаргадаг боловч ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлуудаас шалтгаалан Банкны үйл ажиллагаа зогсох нөхцөл байдал үүсч болно.

- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд багтдаг.

Гарын үсэг зурсан:





Баталсан:

Шаукат Тапиа
Партнер
Прайсуотерхаускуперс Аудит ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот
2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

сая төгрөгөөр	Тодруулга	2022	2021
ХӨРӨНГӨ			
	7	166,906	177,591
Бэлэн мөнгө			
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	8	3,988,528	4,473,789
Дотоодын банкуудад олгосон зээл	9	1,927,086	1,487,308
Буцаан худалдан авах хэлцлийн авлага	10	94,864	-
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	11	6,034,122	6,393,822
Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	12	6,533	6,533
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	13	5,220,845	4,522,220
Алт ба үнэт метал	14	1,706,031	1,685,633
Эрдэнэсийн сан	15	1,091,554	1,115,085
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	16	114,739	77,103
Засгийн газрын үнэт цаас	17	38,646	231,778
Засгийн газраас авах авлага	18	514,942	-
Бусад хөрөнгө	19	150,240	319,721
Үндсэн ба биет бус хөрөнгө	20	114,612	116,024
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө		35,004	6,097
НИЙТ ХӨРӨНГӨ		21,204,652	20,612,704
ӨР ТӨЛБӨР			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	21	1,089,243	1,105,589
Төв банкны үнэт цаас	22	5,641,303	8,622,184
Засгийн газрын хөрөнгө	23	3,160,938	1,734,116
Дотоод банкуудын хөрөнгө	24	8,135,634	4,471,877
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	16	940,851	469,758
Гадаад өр төлбөр	25	6,874,737	6,914,005
Буцаан худалдан авах хэлцэл	26	95,857	-
Бусад өр төлбөр	27	396,201	667,231
НИЙТ ӨР ТӨЛБӨР		26,334,764	23,984,760
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Дүрмийн сан	28	60,000	60,000
Хуримтлагдсан алдагдал	28	(7,087,754)	(5,359,185)
Бусад нөөц	28	1,897,642	1,927,129
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		(5,130,112)	(3,372,056)
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		21,204,652	20,612,704
Захирлуудын зөвлөлийг төлөөлж энэхүү тайланг 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр нийтлэхийг хүлээн зөвшөөрөв.			
			
Б.Лхагвасүрэн Монголбанкны Ерөнхийлөгч		Ц.Гарьд Санхүү бүртгэлийн газрын захирал	

МОНГОЛБАНК

ОРЛОГЫН ҮР ДҮНГИЙН БОЛОН БУСАД ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Сая төгрөгөөр	Тодруулга	2022	2021
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого	29	400,577	286,227
Бусад адилтгах орлого	29	10,535	22,165
Хүүгийн зардал	29	(930,354)	(886,262)
Хүүгийн цэвэр зардал		(519,242)	(577,870)
Эрсдэлийн алдагдлын сангийн зардал		(114,970)	(95,118)
Эрсдэлийн алдагдлын сангийн зардлын дараах хүүгийн цэвэр зардал		(634,212)	(672,988)
Алт, үнэт металын арилжааны ашиг/ (алдагдал)	30	62,067	(68,539)
Алт, үнэт металын ханшийн тэгшитгэлийн ашиг/ (алдагдал)		145,321	(12,432)
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн дахин үнэлгээний алдагдал		(787,547)	(219,426)
Гадаад валютын арилжааны ашиг/(алдагдал)		12,539	(4,017)
Гадаад валютын хөрвүүлгийн алдагдал		(272,686)	(88,878)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгддэг өрийн хэрэгслийг данснаас хассаны ашиг/ (алдагдал)		64,153	(1,335)
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалалтын арилжааны ашиг		7,045	554
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар илэрхийлэгддэг санхүүгийн хөрөнгийн (алдагдал)/ ашиг		(3,152)	59,638
Үйл ажиллагааны бусад орлого	31	39,105	29,368
Захиргааны ба үйл ажиллагааны бусад зардал	32	(73,065)	(66,017)
Засгийн газраас авах авлагын анхны хүлээн зөвшөөрөлтийн алдагдал	4	(133,482)	-
Засгийн газраас авах авлагын үнэ цэнийн бууралтын гарз	4	(9,334)	-
ТАЙЛАНТ ЖИЛИЙН АЛДАГДАЛ		(1,583,248)	(1,044,072)
Бусад дэлгэрэнгүй (алдагдал)/орлого:			
Орлого зарлагад дахин ангилагдаж болзошгүй зүйлс:			
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгддэг өрийн хэрэгсэл:			
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн (гарз)	28	(110,655)	(20,036)
- Борлуулах үед орлогын тайланд шилжүүлсэн (гарз)/олз	28	(64,153)	1,335
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй алдагдал		(174,808)	(18,701)
ТАЙЛАНТ ЖИЛИЙН НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ АЛДАГДАЛ		(1,758,056)	(1,062,773)

МОНГОЛБАНК

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Сая төгрөгөөр	Тодруулга	Дүрмийн сан	Бусад нөөц	Хуримтлагдсан алдагдал	Нийт өөрийн хөрөнгө
2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн үлдэгдэл	28	60,000	1,958,262	(4,327,545)	(2,309,283)
Тайлант жилийн алдагдал		-	-	(1,044,072)	(1,044,072)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	(18,701)	-	(18,701)
2021 оны нийт дэлгэрэнгүй алдагдал		-	(18,701)	(1,044,072)	(1,062,773)
Бусад нөөц сангаас хуримтлагдсан алдагдал руу шилжүүлсэн	28	-	(12,432)	12,432	-
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл		60,000	1,927,129	(5,359,185)	(3,372,056)
Тайлант жилийн алдагдал		-	-	(1,583,248)	(1,583,248)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	(174,808)	-	(174,808)
2022 оны нийт дэлгэрэнгүй алдагдал		-	(174,808)	(1,583,248)	(1,758,056)
Хуримтлагдсан алдагдлаас бусад нөөцөд шилжүүлсэн	28	-	145,321	(145,321)	-
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл		60,000	1,897,642	(7,087,754)	(5,130,112)

2022 онд хуримтлагдсан алдагдлаас бусад нөөц санд шилжүүлсэн дүн нь (2021: бусад нөөц сангаас хуримтлагдсан алдагдал руу шилжүүлсэн) алт болон үнэт металын ханшийн тэгшитгэлийн бодит бүс ашиг, алдагдлын зөрүүг шилжүүлсэнтэй холбоотой.

МОНГОЛБАНК

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Сая төгрөгөөр	Тодруулга	2022	2021
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн алдагдал		(1,583,248)	(1,044,072)
<i>Тохируулга:</i>			
Эрсдэлийн алдагдлын сан		114,970	95,118
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгддэг өрийн хэрэгслийг данснаас хассаны (ашиг)/алдагдал		(64,153)	1,335
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын арилжааны ашиг		(7,045)	(554)
Алт ба үнэт металын ханшийн тэгшитгэлийн (ашиг)/алдагдал		(145,321)	12,432
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн дахин үнэлгээний алдагдал		787,547	219,426
Гадаад валютын хөрвүүлгийн алдагдал		809,880	94,437
Засгийн газраас авах авлагын анхны хүлээн зөвшөөрөлтийн алдагдал		133,482	-
Засгийн газраас авах авлагад тооцсон үнэ цэнийн бууралтын гарз		9,334	-
Үндсэн болон биет бус хөрөнгийн элэгдэл	32, 20	8,443	7,568
Данснаас хассан үндсэн хөрөнгө		1	3
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар илэрхийлэгддэг санхүүгийн хөрөнгийн алдагдал/ (ашиг)		3,152	(59,638)
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого	29	(400,577)	(286,228)
Бусад адилтгах орлого	29	(10,535)	(22,165)
Хүүгийн зардал	29	930,539	886,262
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		586,469	(96,076)
<i>Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт:</i>			
Алт, үнэт металын цэвэр бууралт		149,259	87,792
Урвуу буцаан худалдан авах хэлцлийн цэвэр (өсөлт)		(661,323)	337,273
Буцаан худалдан авах хэлцлийн авлагын цэвэр (өсөлт)		(95,597)	-
Дотоодын банкуудад олгосон зээлийн (өсөлт)		(437,589)	(1,038,737)
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгийн цэвэр (өсөлт)/бууралт		(4,879)	2,070
Засгийн газраас авах авлагын (өсөлт)		(657,758)	-
Бусад хөрөнгийн цэвэр бууралт		925,864	397,144
Төв банкны үнэт цаасны цэвэр (бууралт)/өсөлт		(2,999,536)	676,302
Засгийн газрын хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)		1,129,563	(370,287)
Дотоодын банкуудын хөрөнгийн цэвэр өсөлт		3,161,487	620,756
Бусад өр төлбөрийн цэвэр (бууралт)/өсөлт		(1,059,676)	9,950
Үйл ажиллагаанаас олсон хүүгийн өмнөх цэвэр мөнгөн гүйлгээ		36,284	626,187
<i>Хүлээн авсан хүү</i>			
Хүлээн авсан хүү		258,298	270,056
Төлсөн хүү		(912,055)	(891,510)
Үйл ажиллагаанаас олсон нийт цэвэр мөнгөн гүйлгээ		(617,473)	4,733

МОНГОЛБАНК

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ҮРГЭЛЖЛЭЛ

Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ

Үндсэн хөрөнгийн худалдан авалт		(43,388)	(14,078)
Үндсэн хөрөнгийн борлуулсны орлого		7,449	5,868
Эрдэнэсийн сангийн худалдан авалт	15	(805)	(43,420)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгддэг өрийн хэрэгслийн худалдан авалт		(4,478,974)	(4,986,979)
Хорогдуулсан өртгөөр хэмжих өрийн хэрэгслийн худалдан авалт		(803,268)	(763,232)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгддэг өрийн хэрэгслийн борлуулалт		5,732,930	4,262,051
Хорогдуулсан өртгөөр хэмжих өрийн хэрэгслийн борлуулалт		247,914	343,677

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ **661,858** **(1,196,113)**

Сая төгрөгөөр **Тодруулга** **2022** **2021**

Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөний (бууралт)/өсөлт	21	(16,346)	114,119
Гадаад өр төлбөрийн өсөлт	25	1,519,584	2,237,184
Гадаад өр төлбөрийн эргэн төлөлт	25	(2,500,693)	(1,231,344)
Буцаан худалдан авах хэлцлийн худалдан авалт	26	241,092	-
Буцаан худалдан авах хэлцийн эргэн төлөлт	26	(145,277)	-

Санхүүгийн үйл ажиллагаанаас олсон цэвэр мөнгөн гүйлгээ **(901,640)** **1,119,959**

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө **361,270** **(27,962)**

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт) **(495,985)** **(99,383)**

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл **7** **4,651,190** **4,750,573**

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл **7** **4,155,205** **4,651,190**

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1. ТАНИЛЦУУЛГА БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧИН

Танилцуулга. Монголбанк нь Монгол Улсын Төв банк бөгөөд Үндсэн хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Монгол Улсын Засгийн газрын 1924 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн тогтоолоор анх байгуулагдсан.

Монголбанк нь үйл ажиллагаагаа Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулдаг. Монголбанк нь орон нутагт нийт 17 хэлтэс, салбартай бөгөөд Их Британийн Лондон хотод нэг төлөөлөгчийн газартай.

Хуульд зааснаар Монголбанкны үндсэн зорилго нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээл болон банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн хөгжилд тэнцвэртэй дэмжлэг үзүүлэх юм.

Монголбанк нь ашгийн бус байгууллага бөгөөд төрөөс үүсгэн байгуулсан тусгай хуулийн этгээдийн хувьд Монголбанкны үйл ажиллагааны санхүүгийн үр дүн болон хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүтэц нь Монголбанкны үйл ажиллагаагаар тодорхойлогддог.

Монголбанк нь Төв банкны тухай хуулийн дагуу дараах үндсэн үйл ажиллагааг явуулдаг. Үүнд:

- Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах;
- Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах замаар мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэх (“Засгийн газар” эсвэл “Төрийн”);
- Банкны үйл ажиллагаанд хяналт тавих;
- Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах;
- Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах;
- Эцсийн зээлдүүлэгчийн үүргийг гүйцэтгэх болон дахин санхүүжилтийн системийг зохион байгуулах;
- Бусад хамтын ажиллагаа бүхий төв банкууд, олон улсын банк болон санхүүгийн байгууллагуудад Монгол Улсыг төлөөлөх;
- Санхүү, зээлтэй холбоотой бусад чиг үүргүүдийг хуульд тодорхойлсон хэм хэмжээний дагуу гүйцэтгэх.

Хуульд заасны дагуу төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор банкуудад зээл олгох, хоёрдогч зах зээл дээр үнэт цаас худалдах, худалдан авах, гадаад валют, үнэт метал худалдах, худалдан авах, дотоодын ба гадаадын зах зээл дээр үнэт метал болон энгийн металаар хийсэн дурсгалын зоосыг худалдах, Засгийн газрын үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах, Засгийн газар болон Сангийн яам (Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага) гэх мэт бусад төрийн байгууллагууд, Олон улсын байгууллагуудын дансыг Монголбанкинд байршуулах болон өөрийн үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай бусад үйл ажиллагааг явуулдаг.

Монголбанкны дүрмийн санг Монгол Улсын төр бүрэн эзэмшдэг. Төв банкны тухай хуульд заасны дагуу Захирлуудын зөвлөлийн үндсэн үүрэг нь мөнгөний бодлогын зарчмыг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавих юм. Түүнчлэн, ирэх оны жилийн төсвийг батлах, түүний биелэлт гүйцэтгэлийн талаар олон нийтэд тайлагнах, тайлант жилийн ашгийн хуваарилалтыг хийх зэрэг Монгол Улсын хууль тогтоомжид заасан эрх мэдлийн хүрээнд бусад чиг үүргийг Захирлуудын зөвлөл гүйцэтгэдэг.

Бүртгэгдсэн хаяг ба үйл ажиллагаа явуулж буй байршил. Монголбанкны албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар 46, Бага Тойруу 3, 15160.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1. ТАНИЛЦУУЛГА БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧИН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банкны үйл ажиллагааны орчин. Цар тахлын үр дагавар бүрэн арилаагүй байхтай зэрэгцээд, 2022 оны эхээр Украинд эхэлсэн Орос-Украины дайны нөлөөгөөр эдийн засаг төдийгүй бодлого боловсруулагчдын хувьд хүнд хэцүү жил байлаа. Дайны үр дагавараар олон улсад түүхий эдийн үнэ дээд цэгтээ хүрч, дэлхийн хэмжээнд өндөр инфляцтай нүүр тулсан боловч Банкны хувьд Орос, Украины нөхцөл байдал шууд нөлөөлөлгүй. Ялангуяа АНУ болон Европын орнуудад шатахууны хомсдолоос болж инфляци сүүлийн 40 жилд байгаагүй өндөр түвшинд хүрчээ. Дэлхийн олон оронд инфляци өндөр байсны уршгаар эцсийн бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж, импортын бараагаар дамжиж Монголд Улсад ч нөлөөлсөн.

Хятадын “Тэг Ковид” бодлогоос үүдсэн геополитикийн байдал, улс хоорондын хил, тээвэр ложистикийн асуудлууд нь Монгол Улсын инфляцийн түвшин 15%-д хүрэхэд нөлөөлсөн.

Өндөр инфляцийг бууруулахын тулд төв банкууд бодлогын хүүгээ өсгөх замаар мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж эхэлсэн. Тухайлбал, Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ 2022 оны эхээр 0-0.25-аас 2022 оны эцэст 4.25-4.5 хувь болгож, долоон удаа нэмэгдүүлсэн. Холбооны нөөцийн банкны бодлогын хүү өссөн нь бусад мөнгөн тэмдэгтийн эсрэг ам долларын ханш өсөхөд нөлөөлсөн. Монгол Улсын хувьд 2022 оны эхээс төгрөгийн ам.доллартай харьцах ханш 20 гаруй хувиар суларсан.

Инфляцийг бууруулах, төгрөгийн тогтвортой байдлын хангахын тулд Монголбанк бодлогын хүүг оны эцэст нэмсээр 13 хувьд хүргэсэн. Мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр мөнгөний нийлүүлэлтийн өсөлт харьцангуй тогтворжиж оны эцэст 29,651 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Бүрэлдэхүүнээр нь авч үзвэл төгрөгийн хадгаламж 16.2 хувиар буурч, гадаад валютын хадгаламж 23.6 хувиар, гадаад валютын гүйлгээ өмнөх оны мөн үеэс хоёр дахин өссөн байна. Ийнхүү иргэдийн төгрөгт итгэх итгэл буурч, долларжих үзэгдэл ажиглагдсан.

Хятадын “Тэг Ковид” бодлогын нөлөөлөллөөр Хятад улсын хил хаагдсан нь 2022 оны эхний хагаст уул уурхайн салбарыг уналтад оруулсан. Харин хөдөө аж ахуй, харилцаа холбоо, дэд бүтэц, худалдааны салбарууд КОВИД-ын өмнөх үеийн түвшинд хүрч, сэргэж чадсан нь эдийн засгийн өсөлтөд 1.9 хувийн эерэг нөлөө үзүүлсэн. 2022 оны сүүлийн хагаст хилийн хязгаарлалт суларч, сүүлийн 4 сарын нүүрсний экспортын хэмжээ сард 4 сая гаруй тоннд хүрч, уул уурхайн салбар сэргэж байна. Энэхүү өсөлтөд үндэслэн Банк нь 2023 оны эцэст эдийн засгийн өсөлт 4 хувьд хүрнэ гэж таамаглаж байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

**2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ТОГТОЛЦОО, ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ
БОЛОН ТОЛИЛУУЛГА**

Тайлан бэлтгэх үндэслэл. Санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу санхүүгийн хэрэгслийг анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх болон үндсэн хөрөнгө, Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээ, санхүүгийн хэрэгслийн дахин үнэлгээг тайлант үеийн орлого, зарлагад бодит үнэ цэнийн дагуу бүртгэх, бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийн дагуу бүртгэхээс бусад тохиолдолд түүхэн өртгийн зарчмын дагуу бэлтгэж тайлагнасан болно. Санхүүгийн тайланг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмуудыг Тодруулга 3-т тодруулсан. Өөрөөр дурдаагүй бол, дээрх бодлогуудыг толилуулсан бүх тайлагналын хугацаанд ашигласан.

Тайлагналын мөнгөн нэгж. Энэхүү санхүүгийн тайлан нь Банкны үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн анхдагч орчны мөнгөн тэмдэгт Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох “төгрөг”-өөр илэрхийлэгдсэн болно. Бүх дүнг Сая төгрөгөөр нарийвчилсан болно.

Санхүүгийн тайланг баталгаажуулсны дараа өөрчлөлт хийх тухай Монголбанкны удирдлага нь санхүүгийн тайланг баталгаажуулсан өдрөөс хойш эдгээр санхүүгийн тайлангуудад өөрчлөлт хийх эрхтэй болно.

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО

Санхүүгийн хэрэгсэл – гол хэмжилтийн нэр томъёо. Бодит үнэ цэнэ нь мэдээлэл бүхий холбоогүй талууд сайн дураараа хоорондоо хөрөнгө солилцох эсвэл өр төлбөр барагдуулахад бэлэн байгаа үнийг хэлнэ. Бодит үнэ цэнэ нь санхүүгийн хөрөнгийн хувьд идэвхитэй зах зээл дээр зарласан өнөөгийн худалдан авах үнэ, санхүүгийн өр төлбөрийн хувьд өнөөгийн худалдах үнэ болно. Идэвхитэй зах зээл гэдэг нь хөрөнгө ба өр төлбөртэй холбоотой гүйлгээ хангалттай их хэмжээгээр тогтмол гардаг, тэдгээрийн үнийн мэдээллийг хэдийд ч авах боломжтой байхыг хэлнэ. Санхүүгийн хэрэгслийн санал болгож байгаа үнэ нь хөрөнгийн зах зээл эсвэл бусад санхүүгийн байгууллагаас тогтмол нийтэд зарладаг буюу мэдээлэл нь нээлттэй олох боломжтой ба эдгээр үнийн дагуу зах зээл дээр холбоогүй этгээдийн хооронд байнгын тогтмол гүйлгээ хийгддэг тохиолдолд санхүүгийн хэрэгслийг идэвхитэй зах зээл дээр санал болгосон гэж үздэг.

Идэвхитэй зах зээл дээр арилжаалагддаггүй санхүүгийн үүсмэл хэрэгсэл эсвэл бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн багцыг бодит үнэ цэнээр нь буюу хэмжилт хийх өдөр тодорхой эрсдэлийн

түвшинд урт позицыг (жишээ нь хөрөнгийн хувьд) арилжаалж болох цэвэр үнийн дүн эсхүл тодорхой эрсдэлийн түвшинд богино позицыг (жишээ нь өр төлбөрийн хувьд) хаахад гарах цэвэр дүнг зах зээлд оролцогчдын хооронд хийгдэж буй гүйлгээнд үндэслэн үнэлнэ. Энэхүү аргачлалыг бодит үнэ цэнээр үнэлэгдэх хөрөнгийн хувьд ашиглах бөгөөд (а) тус санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг удирдахдаа байгууллагын өртөх магадлалтай зах зээлийн тодорхой эрсдэлд эсхүл тодорхой харилцагч талын эрсдэлд үндэслэдэг нь байгууллагын дотоод эрсдэлийн удирдлагын баримт бичиг болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд дурдагдсан байна; (б) санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийн багцын удирдлагын талаар байгууллагын түлхүүр удирдлагад мэдээллийг хүргэх чадамжтай байх бөгөөд (в) зэх зээлийн эрсдэл болон тодорхой зах зээлийн эрсдэлд өртөх хугацаа нь санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн хувьд ижил байна.

Удирдлагын зүгээс үнэлгээний аргачлал нь санхүүгийн үүсмэл хэрэгслийн үнэ цэнийг илүү нарийн тооцно гэж үзэж байна. Үнэлгээний аргачлалд ашигласан гол мэдээллийг Тодруулга 36-с харна уу.

Гадаад зах зээлийн мэдээлэл авах боломжгүй тохиолдолд санхүүгийн тодорхой хэрэгслийн бодит үнэ цэнийг тооцоходоо хорогдуулсан мөнгөн гүйлгээний загвар, сүүлийн үеийн сунгасан гарын зарчмын дагуу хийгдсэн хэлцэлд ашигласан загвар болон санхүүжигч талын санхүүгийн тайлан мэдээ зэрэг үнэлгээний аргачлалыг ашиглана. Бодит үнэ цэнийг бодит үнэ цэнийн ангилал тус бүрд үнэлэх ба эдгээр түвшин нь (i) Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхитэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан 1-р түвшинд тодорхойлно. (ii) Хөрөнгө болон өр төлбөрийн хувьд материаллаг боломжит өгөгдлийг ашиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) үнэлгээний аргачлалыг 2-р түвшинд хэрэгжүүлнэ (iii) 3-р түвшинд зах зээлийн ашиглаж болох өгөгдөлд тулгуурлахгүйгээр (зах зээлээс шууд ашиглах боломжгүй өгөгдлийг шаарддаг) үнэлгээг тодорхойлно. Бодит үнэ цэнийн ангилал дахь түвшингийн хоорондын шилжүүлгийг тайлант хугацааны эцэст хийгдсэн гэж үзнэ. Дэлгэрэнгүйг Тодруулга 36-с харна уу.

Гүйлгээний зардлууд нь санхүүгийн хэрэгслийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал нь гүйлгээг хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх зардлыг хэлнэ. Гүйлгээний зардалд зуучлагч, борлуулагч (борлуулалтын үүрэг гүйцэтгэж буй ажилтнуудын цалин), зөвлөх, брокер, дилерт төлсөн хураамж шимтгэл, зохицуулах агентлаг, хөрөнгийн биржийн ногдуулсан хураамж төлбөр, мөн шилжүүлгэд ногдуулсан татвар хураамж хамаарна. Гүйлгээний зардалд өрийн хямдруулалт болон урамшуулал, санхүүгийн зардлууд, дотоодын захиргааны буюу хадгалалтын зардлууд орохгүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хорогдуулсан өртөг (ХӨ) гэдэг нь санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүг анх хүлээн зөвшөөрөх үед хойшлогдсон гүйлгээний зардал, мөн нэрлэсэн үнээс аливаа урамшууллын эсвэл хямдруулалтын дүнг үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалт багтана. Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, хуримтлагдсан купон болон үнийн хорогдуулсан урамшуулал ба хямдруулалтыг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй ба тэдгээрийг санхүүгийн байдлын тайлангийн холбогдох хэсэгт дансны үнээр тусгасан болно.

Үр ашигт хүүгийн арга нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны турш дансны үнээс тооцогдох хүүгийн түвшинг тогтмол байлгах аргаар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн түвшин нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын орлого, эсвэл гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэгслийн хүлээгдэж буй хугацаа эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны турш хямдруулж санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн дансны үнийг гаргаж авах хүүгийн түвшин юм.

Үр ашигт хүүг хувьсах хүүтэй хэрэгслийн мөнгөн урсгалын хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл хямдруулах боловч уг хэрэгсэлд тусгагдсан хувьсах хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн урамшуулал болон хямдруулалтыг, мөн зах зээлийн түвшинд тохируулагдахгүй бусад хувьсах хүчин зүйлүүдээс үл хамаарна. Эдгээр урамшуулал болон хямдруулалтыг тухайн хэрэгслийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хорогдуулан тооцно. Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд

гэрээний талуудын хооронд төлөх эсвэл хүлээн авах бүх хураамжийг оруулах бөгөөд тэдгээр нь үр ашигт хүүгийн нэг бүрэлдэхүүн хэсэг болно. Худалдаж авсан эсвэл үүсгэсэн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө хөрөнгийн үнэ цэнэ буурсан бол үр ашигт хүүг ч мөн үнэ цэнийн бууралтад тохируулан бүртгэнэ. Жишээ нь: гэрээнд заасан эргэн төлөлтийн оронд анх хүлээн зөвшөөрсөн ирээдүйн мөнгөн урсгалд тулгуурлан тооцоолно.

Санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрөх. Тайлант жилийн ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдэх санхүүгийн хэрэгслийг анхлан бодит үнэ цэнээр бүртгэнэ. Бусад бүх санхүүгийн хэрэгслийг бодит үнэ цэнэ дээр гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр бүртгэдэг. Анх бүртгэх бодит үнэ цэнэ нь гүйлгээ хийгдсэн үнээр баталгаажсан байдаг. Анх бүртгэх үед үүсэх олз эсвэл гарзыг бодит үнэ цэнэ болон гүйлгээний үнийн хооронд зөрүү гарсан бөгөөд үүнийг зөвхөн ижил төстэй хэрэгслийг сүүлийн үед арилжсан талаарх зах зээлийн нээлттэй мэдээллээр баталгаажуулсан эсвэл зөвхөн нээлттэй зах зээлээс авсан мэдээлэлд үндэслэж хийсэн үнэлгээний аргачлалаар тооцсон тохиолдолд хүлээн зөвшөөрнө. Анх хүлээн зөвшөөрсний дараа хорогдуулсан өртөгөөр бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр бүртгэгдэх өрийн хэрэгслээрх хөрөнгөд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын (“ХБЭА”) санг хүлээн зөвшөөрөх ба энэ нь нягтлан бодох бүртгэлийн алдагдал болно.

Зохицуулах байгууллагаас тогтоосон эсвэл зах зээлийн жишгээр тогтсон (“хэвийн” худалдаа болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан нийлүүлэх шаардлагатай санхүүгийн хөрөнгийн бүхий л борлуулалт болон худалдан авалтыг арилжаа хийсэн өдөр буюу тухайн санхүүгийн хөрөнгийг нийлүүлэх үүрэг хүлээсэн үед бүртгэнэ. Бусад бүх худалдан авалтыг санхүүгийн хэрэгслийн гэрээний нэг тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Идэвхитэй зах зээлд арилжаалагдаагүй урт хугацаат гадаад валютын хүүгийн своп хэлцлийн бодит үнэ цэнийг тодорхойлоходоо хямдруулсан мөнгөн урсгалын үнэлгээний аргачлалыг ашигладаг. 3-р түвшний дахин үнэлгээний аргаарх анхны хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнэ болон дараа үед тодорхойлсон дүнгийн хооронд зөрүү үүсч болно. Зөрүүг хөрөнгө эсвэл өр төлбөрөөр анх хүлээн зөвшөөрч урт хугацаат гадаад валютын хүүгийн своп хэлцлийн хугацаа дуусах хүртэл шулуун шугамын аргаар хорогдуулна. Хэрэв 2-р түвшний дахин үнэлгээний аргыг ашигладаг бол зөрүүг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - хэмжилтийн төрөл. Санхүүгийн хөрөнгийг дараах төрлөөр ангилна: Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаарх (“ААБҮЦ”), Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоорх (“БДОБҮЦ”) болон Хорогдуулсан өртөг (“ХӨ”). Санхүүгийн өрийн хэрэгслийн ангилал болон дараа үеийн хэмжилт нь (i) хөрөнгийг удирдах бизнес модел (ii) хөрөнгийн мөнгөн урсгалын онцлогоос хамаарна.

Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - бизнес загвар. Бизнес загвар нь хөрөнгийг мөнгөн урсгал бий болгох зорилгоор хэрхэн удирдаж байгаагаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлвэл зорилго нь (i) зөвхөн хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах эсвэл (ii) хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авахаас болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авахын аль нь вэ гэдгээс хамаарах бөгөөд хэрэв (i) ба (ii)-ын аль ч тохиолдол биш бол санхүүгийн хөрөнгийг нь “бусад” гэсэн бизнес загварт хамааруулан ангилах ба бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжинэ.

Бизнес загварыг үнэлгээний өдөр боломжит багцад зориулан тогтоосон зорилтондоо хүрэхийн тулд хийж буй үйл ажиллагааны талаарх бүх нотолгоонд үндэслэн хөрөнгийг (багцын түвшинд) тодорхойлно. Бизнесийн загварыг тодорхойлоход авч үздэг хүчин зүйлс нь багцын зорилго ба бүрэлдэхүүн, тухайн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хэрхэн цуглуулсан, эрсдэлийг хэрхэн үнэлж, удирдаж байсан, хөрөнгийн гүйцэтгэлийг яаж үнэлсэн, цалин хөлс, урамшууллын системд хэрхэн тусгагдсан талаар өнгөрсөн туршлагад үндэслэдэг. Санхүүгийн хөрөнгийн бизнес загварыг тодорхойлоход ашигласан үнэлгээг Тодруулга 4-өөс харна уу.

Санхүүгийн хөрөнгө - ангилал болон дараа үеийн хэмжилт - мөнгөн урсгалын онцлог. Бизнес загвар нь хөрөнгийн мөнгөн урсгалыг цуглуулж авах эсвэл хөрөнгийн мөнгөн урсгалыг цуглуулах болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авах зорилготой үед мөнгөн урсгал

нь зөвхөн хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй (ЗХҮТ) эсэхэд үнэлгээ өгнө. Гэрээний мөнгөн урсгал нь ЗХҮТ-ийн онцлогтой нийцсэн эсэхийг тодорхойлоход нуугдмал деривативыг агуулсан санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь авч үзнэ. Энэ үнэлгээг хийхдээ гэрээний мөнгөн урсгал нь зээлийн гэрээний үндсэн тохиролцоонд тогтвортой эсэх, ялангуяа хүү нь эрсдэл, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон бусад эрсдэл, ашгийн түвшинг багтаасан эсэхэд үнэлгээ өгнө. Гэрээний нөхцлүүд нь эрсдэлтэй эсвэл үндсэн нөхцөлтэй үл нийцэх хэлбэлзлийг харуулж байвал санхүүгийн хөрөнгө нь Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар хэмжигдэнэ.

ЗХҮТ үнэлгээ нь хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед хийгдэх бөгөөд дараа үед дахин хийгдэхгүй. Санхүүгийн хөрөнгөд ЗХҮТ шалгалт хийхэд ашигласан үнэлгээг тодруулга 4-өөс үзнэ үү.

Санхүүгийн хөрөнгө – дахин ангилал. Багцыг удирдаж байгаа бизнес загвар бүхэлдээ өөрчлөгдсөн бол санхүүгийн хэрэгслийг дахин ангилна. Дахин ангилал нь ирээдүйд нөлөө үзүүлэх бөгөөд бизнес загвар өөрчлөгдсөний дараах хамгийн эхний тайлагналын үеэс хэрэгжинэ. Өмнөх болон тайлант хугацаанд бизнес загвараа өөрчлөөгүй болон дахин ангилахгүй болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт – Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал. Хорогдуулсан өртөг болон бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр бүртгэгдэх санхүүгийн өрийн хэрэгсэл болон зээл, баталгаатай холбоотой хүлээгдэж буй зээлийн алдагдлыг ирээдүйн төсөөлсөн нөхцөл байдалд суурилан үнэлдэг. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (“ХБЭА”)–г хэмжиж, алдагдлын хасагдуулгыг тайлант хугацаа бүрт хүлээн зөвшөөрдөг. Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилт нь (i) олон янзын боломжит үр дүнг үнэлсэний үр дүнд тодорхойлсон зохистой, магадлалаар жигнэсэн дүнг; (ii) мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ; (iii) өнгөрсөн үйл явдал, одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдлын талаарх хэт их өртөг, хүчин чармайлтгүйгээр олдох боломжтой үндэслэл бүхий бэлэн мэдээллүүд дээр үндэслэнэ.

Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэгслийг Санхүүгийн байдлын тайланд ХБЭА-ын хасагдуулгыг хассан дүнгээр тайлагнана. Зээл болон баталгааны хувьд ХБЭА-ыг санхүүгийн байдлын тайланд өр төлбөр гэж тусад нь тайлагнана. БДОБҮЦ-ээрх өрийн хэрэгслийн хорогдуулсан өртгийг хассан дүнг нь орлого зарлагаар хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод БДОБҮЦ-ээрх өрийн хэрэгслийн алдагдлыг хассан дүнгээр тайлагнагдана.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа эрсдэлийн чанарт үндэслэсэн үнэ цэнийн бууралтад “3 шатлал” бүхий дараах загварыг ашиглана. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш ямар нэг үнэ цэнийн бууралтгүй хөрөнгө нь «1-р шатлал»-д ангилагдана. 1-р шатлалын хөрөнгийн ХБЭА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдлын тайлант өдрөөс хойш 12 сарын дотор эсвэл хэрэв үүнээс богино бол гэрээний хугацаа дуусах хүртэл (12 сарын ХБЭА) үүсч болох санхүүгийн хэрэгслийн дефолтоос үүдэн гарах хүлээгдэж буй алдагдлын хэсгийн хэмжээтэй ижил дүнгээр хэмжигдэнэ. Хэрэв анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн гэдгийг тогтоовол хөрөнгийг «2-р шатлал»-д ангилах бөгөөд ХБЭА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэх ба энэ нь гэрээ дуусах хүртэл боловч хэрэв байгаа бол хүлээгдэж буй эргэн төлөлтийг авч үзнэ (Нийт хугацааны туршид дахь ХБЭА). Хэрэв санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үзвэл хөрөнгийг «3-р шатлал» руу шилжүүлэх ба ХБЭА нь ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй алдагдалд үндэслэн хэмжигдэнэ. Үнэ цэнэ буурсан хөрөнгийн болон дефолтын тодорхойлолтыг Тодруулга 35-д тайлбарласан. Худалдан авсан, шинээр гаргасан хөрөнгийн зээлжих чадамжаас үүдэлтэй үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд ХБЭА нь үргэлж хөрөнгийн ашиглалтын хугацааны турш ХБЭА-тай ижил хэмжигдэнэ. ХБЭА-ын загварыг хэмжихэд ашигласан мэдээлэл, таамаглал болон тооцооллын аргыг Тодруулга 35-аас харна уу.

Санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасах. Санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасна: (а) хөрөнгийн төлбөрийг авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусдад шилжүүлэн

өгсөн эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн дамжуулан өгөх хэлцэлд оролцож (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлсэн, эсвэл (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлээгүй ч, өөртөө авч үлдээгүй буюу хяналтын эрхийг хадгалж үлдээгүй. Холбогдох тал хөрөнгийн борлуулалтад нэмэлт хязгаарлалт хийхгүйгээр холбоогүй гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах боломжгүй тохиолдолд хяналтын эрхийг хадгалж үлдсэн гэж үзнэ.

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хөрөнгө - өөрчлөлт. Санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлийг өөрчлөх буюу дахин тохиролцох тохиолдол гардаг. Гэрээний мөнгөн урсгалын өөрчлөлт нь мэдэгдэхүйц эсэхийг дараах зүйлсийг харгалзан үзэж үнэлнэ; хөрөнгийн эрсдэлийн үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхээр гэрээний шинэ зүйл заалт байгаа эсэх, (ялангуяа ашгийн хуваарилалт эсвэл өмчийн өгөөж), хүүгийн түвшний мэдэгдэхүйц өөрчлөлт, нэрлэсэн валютын өөрчлөлт, шинэ барьцаа эсвэл хөрөнгөтэй холбоотой хөрөнгийн эрсдэлд мэдэгдэхүйц нөлөөлөх өсөлт, мөн зээлдэгчийн санхүүгийн хүндрэлд ороогүй байх үе дэх сунгалт гэх мэт.

Хэрэв өөрчлөгдсөн нөхцөлүүд нь анхны нөхцөлөөс мэдэгдэхүйц зөрүүтэй бол анхны хөрөнгийн мөнгөн урсгалыг хүчингүй болгож анхны санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч бодит үнэ цэнээр нь шинэ хөрөнгөд хүлээн зөвшөөрнө. Дахин тохиролцоо хийсэн өдөр нь дараах үеийн үнэ цэнийн бууралтыг тооцоолох зорилгоор анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр болно. Мөн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт байгаа эсэхийг харгалзан үзнэ. Мөн шинэ хөрөнгө буюу өрийн хэрэгсэл нь үндсэн төлбөр болон зээлийн хүүгийн шалгуурт нийцэж байгаа эсэхийг үнэлж үзнэ. Үл хүлээн зөвшөөрөгдсөн анхны хөрөнгийн дүн болон мэдэгдэхүйц өөрчлөлт орсон шинэ хөрөнгийн бодит үнэ цэнийн зөрүү нь өмчлөгчтэй хийсэн хөрөнгийн гүйлгээтэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Дахин тохиролцоо нь хамтрагчийн санхүүгийн хүндрэлтэй байдал болон анхны тохиролцсон төлбөрөө төлөх боломжгүй болсон үед хийгдэж байгаа нөхцөлд хөрөнгийн одоогийн шинэчлэгдсэн мөнгөн гүйлгээ болон анхны мөнгөн гүйлгээг харьцуулж гэрээний өөрчлөлтөөс үүдэлтэй мэдэгдэхүйц өөрчлөгдсөн хөрөнгөд эрсдэл болон ашиг байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв эрсдэл болон ашиг өөрчлөгдөөгүй бол өөрчилсөн хөрөнгө нь анхны хөрөнгөөс мэдэгдэхүйц өөрчлөлтгүй гэх ба өөрчлөлтөөс шалтгаалж үл хүлээн зөвшөөрөхгүй. Анхны үр ашигт хүүгийн түвшин (эсвэл худалдан авсан, шинээр гаргасан хөрөнгийн зээлжих чадамжаас үүдэлтэй үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд тохируулгатай үр ашигт хүүгийн түвшин)-г ашиглан өөрчлөгдсөн гэрээний мөнгөн урсгалыг хорогдуулах замаар нийт дүнг дахин тооцоолж, өөрчлөлтийг ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөр - хэмжилтийн ангилал. Санхүүгийн өр төлбөрийг дараахаас бусад тохиолдолд дараа үеийн хорогдуулсан өртгөөрх ангилалд ангилна, үүнд (1) бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар бүртгэгдсэн санхүүгийн өр төлбөр: энэхүү ангилал нь дериватив, борлуулахаар эзэмшиж буй санхүүгийн өр төлбөр (үүнд богино хугацаат үнэт цаас), бизнесийн нэгдэл дэх нэгтгэгчийн хүлээн зөвшөөрсөн болзошгүй зүйлс болон анхны хүлээн зөвшөөрөлтөөрөө илэрхийлэгдсэн санхүүгийн өр төлбөр, (2) мөн санхүүгийн баталгааны гэрээ болон зээлийн амлалт хамаарна.

Санхүүгийн өр төлбөр - үл хүлээн зөвшөөрөлт. Санхүүгийн өр төлбөр нь төлж барагдуулснаар үл хүлээн зөвшөөрнө. (мөн гэрээгээр хүлээсэн үүрэг нь хүчингүй болсон цуцлагдсан үед үл хүлээн зөвшөөрөгдөнө.)

Банк болон түүний анхны зээлдэгчийн мэдэгдэхүйц өөр нөхцөл бүхий өрийн хэрэгсэл болон одоогийн санхүүгийн өр төлбөрийн нөхцөл, хугацааны томоохон өөрчлөлт нь анхны санхүүгийн өр төлбөрийг данснаас хасч, шинэ санхүүгийн өр төлбөр бүртгэх үндэслэл болдог. Шинэ нөхцлөөрх мөнгөн гүйлгээний төлсөн төлбөр хураамж болон хүлээн авсан төлбөр хураамжийн дансны дүнд багтаасан хорогдуулсан өнөөгийн үнэ цэнэ нь анхны санхүүгийн өр төлбөрийн үлдэх хугацааны мөнгөн урсгалын хорогдуулсан өнөөгийн үнэ цэнээс хамгийн багадаа 10 хувийн зөрүүтэй бол мэдэгдэхүйц өөр нөхцөлтэй байна гэж үзнэ. Өрийн хэрэгслийн нөхцөл хугацаа өөрчлөгдсөнөөр өрийн хэрэгсэл үгүй болсон гэж үзвэл төлсөн төлбөр хураамж болон аливаа зардал нь өрийн хэрэгслийг үл хүлээн зөвшөөрөгдсөнөөс үүссэн ашиг алдагдал болно. Харин эсрэг тохиолдолд төлсөн төлбөр хураамж зардал нь өр төлбөрийн дансны дүнд нэмэгдэх бөгөөд өөрчлөгдсөн өр төлбөрийн үлдэх хугацаанд ногдуулан хорогдуулж тооцно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дансны өртгийн эдийн засгийн шинж чанар нь хөрөнгийн гүйлгээний шинжтэй болсоноос бусад тохиолдолд өрийн хэрэгсэл үл хүлээн зөвшөөрнө гэж үзээгүй өрийн өөрчлөлтийг орлого зарлагаар бүртгэсэн олз, гарзтай нь хамт хуримтлагдсан өөрчлөлтийн аргаар тооцооллын өөрчлөлт гэж бүртгэнэ.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө. Гадаад болон дотоод хөрвөх чадварын өөрчлөлтийг мөнгөн гүйлгээний тайланд тусгах зорилгоор тодорхой хэмжээний мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл багатай зүйлсийг багтаадаг. Мөнгө ба

түүнтэй адилтгах хөрөнгөд бэлэн мөнгө болон богино хугацаанд зарцуулж болох гурван сараас бага хугацаатайгаар байршуулсан хугацаатай ба хугацаагүй хадгаламж орно. Тодруулга 7-г харна уу. Зарцуулалтад хязгаарлалт хийсэн эсвэл хөрвөх чадвар муутайгаас шууд хөрвөдөггүй санхүүгийн хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд оруулаагүй болно. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь (1) гэрээний мөнгөн урсгалыг цуглуулснаас үүссэн бөгөөд эдгээр нь Үр ашигт хүүгийн аргыг ашиглан үндсэн төлбөр болон хүүгийн төлөлтийг багтаасан (2) бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлаар илэрхийлэхээр заагдаагүй тул хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдсэн.

Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө. Харилцагч банк руу мөнгө шилжүүлснээр бусад банкуудад байршуулсан хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Бусад банкуудад байршуулсан хөрөнгийг дараах тохиолдолд хорогдуулсан өртгөөр нь бүртгэнэ: (1) гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах зорилготой байршуулсан бөгөөд эдгээр мөнгөн урсгал нь хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй, (2) Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр тодорхойлогдоогүй.

Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт. Бизнес загвар болон мөнгөн урсгалын онцлогт үндэслэн өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртгөөрх эсвэл Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоорх гэж ангилна. Хэрэв өрийн үнэт цаас нь гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах зорилготой байршуулсан бөгөөд мөнгөн урсгал нь хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж байвал нягтлан бодох бүртгэлийн зөрүүг ихээхэн багасгахын тулд ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр тодорхойлогдоогүй бол хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Хэрэв өрийн үнэт цаасыг гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах, зарах зорилготой байршуулсан бөгөөд эдгээр мөнгөн урсгал нь хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж байвал ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдэхгүй бол өрийн үнэт цаасыг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр бүртгэнэ. Эдгээр хөрөнгийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргаар тооцоолж ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Хүлээгдэж буй зээлийн алдагдлын загвараар тооцоолсон эрсдэлийн алдагдлын хорогдуулгыг тухайн жилийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Дансны дүнгийн бусад өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө. Өрийн үнэт цаасыг данснаас хасах үед бусад дэлгэрэнгүй орлогод өмнө нь хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогоос ашиг алдагдалд шилжүүлж, дахин ангилна.

Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт. Хувьцаа гаргагчийн хувьд өмчийн тодорхойлолтод нийцэх санхүүгийн хөрөнгийг Монголбанкнаас гаргасан өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт гэж үзнэ, жишээ нь бэлэн мөнгө төлөх гэрээний үүрэг хариуцлагыг агуулаагүй хэрэгсэл мөн хувьцаа гаргагчийн цэвэр хөрөнгөд ашиг сонирхол нь байгаа гэдгийг нотлох хэрэгсэл. Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалтыг Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжинэ, учир нь эдгээр хөрөнгө оруулалт нь зөвхөн хөрөнгө оруулалтын үр ашгийг хүртэх гэхээсээ илүү стратегийн зорилготой байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бодит үнэ цэнийн олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх ба борлуулах үед ч ашиг алдагдалд дахин ангилахгүй. Хэрэв үнэ цэнийн бууралтын гарз үүсвэл үнэ цэнийн бусад өөрчлөлтөөс тусад нь хэмжихгүй. Төлбөр хүлээн авах эрхтэй болох үед ногдол ашгийг хөрөнгө оруулалтын өгөөж гэхээс илүү хөрөнгө оруулалтын буцаан төлөлт байдлаар авахаас бусад тохиолдолд ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Банкуудад олгосон зээл. Арилжаалах зорилгогүй, харилцагчаас хөрөнгийн зах зээл дээр бүртгэгдээгүй, үүсмэл бус авлагыг тусгайлан заасан буюу тодорхойлох боломжтой хугацаанд эргүүлэн төлөгдөх мөнгө шилжүүлсэн үед зээлдэгч нарт олгосон зээлийг хүлээн зөвшөөрнө.

Ашиг алдагдлаар хэмжигдэх бодит үнэ цэнээр тодорхойлогдоогүй тохиолдолд эдгээр зээлийг бизнес загварт нь үндэслэн хорогдуулсан өртгөөр ангилах бөгөөд мөнгөн урсгалын онцлог гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах зорилготой байршуулсан бөгөөд эдгээр мөнгөн урсгал нь ЗХҮТ-ээс бүрдэж буй юм.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдалыг ирээдүйн төсөөллийн мэдээллийг харгалзан хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын загвараар тооцоолно. Тодруулга 35-аас үзнэ үү.

Банкуудад олгосон зээлтэй холбоотой гүйлгээ нь үндсэн үйл ажиллагаа болох үндэсний мөнгөн тэмдэгт болон эдийн засгийн тогтвортой байдалтай (мөнгөний бодлогын үйл ажиллагаа, инфляцийн тогтворжилт, эдийн засгийн өсөлт, банкны системийн тогтвортой байдал, гэх мэт) хамааралтай тул СТОУС 13-т заасан үндсэн зах зээлийн тодорхойлолтод нийцнэ. Дээрхтэй холбоотой удирдлагын гаргасан дүгнэлтийг Тодруулга 4-аас харна уу.

Зээлдүүлсэн үнэт цаас ба буцаан худалдан авах хэлцэл. Харилцагч этгээдэд зээлдэгч буцаан төлөхөөр олгогддог буцаан худалдан авах хэлцлийг (“репо хэлцэл”) баталгаажсан санхүүгийн гүйлгээ гэж үздэг. “Репо хэлцэл”-ийн худалдсан үнэт цаасыг санхүүгийн бүртгэлээс хасахгүй. Харин хөрөнгө хүлээн авагч гэрээний дагуу хөрөнгийг борлуулах болон дахин барьцаанд тавих эрхтэй үед тус хөрөнгийг “Буцаан худалдан авах авлага” гэж ангилахаас бусад тохиолдолд үнэт цаасыг санхүүгийн байдлын тайланд дахин ангилахгүй.

Зээлдэгчээс эргэн төлөхөөр олгосон буцаан худалдах хэлцлийн (“урвуу репо хэлцэл”) дагуу худалдан авсан үнэт цаасыг гадаадын байгууллагаас авах авлага эсвэл дотоодын банкинд олгосон зээлийн аль тохиромжтойгоор нь бүртгэнэ. Буцаан худалдан авах болон худалдах үнийн зөрүүг хүүгийн орлого гэж хүлээн зөвшөөрөх ба үр ашигт хүүгийн түвшингээр “репо” хэлцлийн хугацааны турш хуримтлуулна. Буцаан худалдан авах болон худалдах гэрээгээр зарсан үнэт цаасны ангилалд үндэслэн буцаан худалдан авах хэлцлийг хорогдуулсан өртгөөр ангилна.

Алт ба үнэт метал. Олон улсын стандартын дагуу алт, үнэт металыг гадаадын банкинд биет болон биет бус хэлбэрээр хадгалдаг. Байршуулсан алт нь гадаад валютын нөөцийн нэг хэсгийг илэрхийлнэ. Эдгээр металлууд нь трой унцаар хэмжигдэх ба Монголбанкны албан ханшийн дагуу төгрөгөөр илэрхийлэгдэнэ. Алтны арилжааны албан ханш нь Лондонгийн Алтны Захын Холбооноос зарласан үнэт металын ам.долларын ханшийг Монголбанкнаас зарласан ам.долларын харьцах төгрөгийн ханшаар хөрвүүлснээр илэрхийлэгддэг болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Олон улсын жишигт хүрсэн алт болон мөнгөн гулдмайг бодит үнэ цэнээр санхүүгийн байдлын тайланд бүртгэдэг бөгөөд өдөр бүр дахин үнэлдэг. Бодит үнэ цэнийг тогтоохдоо алт ба мөнгөний зах зээлийн үнийг харгалзан үздэг. Ханшийн тэгшитгэлийн бодит бус ашиг, алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрөх ба энэхүү бодит бус ашиг, алдагдлыг жилийн эцэст өөрийн хөрөнгийн “Үнэт металын дахин үнэлгээний сан”-д хаадаг (Тодруулга 28).

Алт, үнэт металаас гадна алт олборлогч аж ахуйн нэгж, компани, иргэдээс цэвэршүүлээгүй алт, мөнгө худалдан авдаг (Тодруулга 14-ийг харна уу). Бусад үнэт метал болох дурсгалын зоос болон цэвэршүүлээгүй алт, мөнгө зэргийг бараа материалаар бүртгэж өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь бүртгэдэг.

Эрдэнэсийн сан. Эрдэнэсийн сангийн тухай хууль нь анх 1994 онд анх батлагдаж, 2022 оны 4 дүгээр сарын 22-нд шинэчлэн батлагдсан бөгөөд тус хуульд “эрдэнэс” гэдэг нь “түүхий эд, хайлш, химийн нэгдэл, бүтээгдэхүүн, түүх, соёлын дурсгалт зүйл зэрэг ямар ч байдалд байгаа үнэт метал, эрдэнийн чулууг хэлнэ” гэж заасан байдаг. Эрдэнэсийн санг үндсэн болон гүйлгээ сан гэж ангилдаг.

Үндсэн сан нь байнгын болон байнгын бус хэсгээс бүрддэг.

Байнгын хэсэгт Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу “Түүх соёлын хосгүй үнэт, дурсгалт зүйл”-д багтсан эрдэнэсийн санд шилжүүлсэн олон улсын жишигт хүргэж цэвэршүүлсэн үнэт метал, засаж өнгөлсөн эрдэнийн чулуу, түүх, соёлын хосгүй үнэт, дурсгалт зүйл, үнэт металаар хийж нөөцөд авсан зоос орно. Байнгын бус хэсэгт олон улсын жишигт нийцүүлэн, өнгөлсөн эрдэнийн чулуу, түүх соёлын дурсгалт зүйлс, үнэт металаар хийсэн зоос багтдаг.

Гүйлгээ санд үнэт метал боловсруулах аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн, мөн эрдэм шинжилгээний ажил, дурсгалын зориулалтаар ашиглах үнэт метал зэрэг зүйлсээс гадна “Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан тушаалын дагуу бүртгэгдсэн зүйлс багтана.

Эрдэнэсийн санг НББОУС 16 стандартын дагуу дахин үнэлгээний аргачлалыг ашиглан үнэлдэг бөгөөд Олон улсын үнэлгээний стандартыг хэрэгжүүлдэг. Тайлагналын үе бүрийн төгсгөлд бодит үнэ цэнэ нь дансны үнээс материаллаг хэмжээнд зөрүүтэй эсэхэд үнэлгээ хийж Эрдэнэсийн санг тогтмол давтамжтайгаар дахин үнэлдэг. Дансны үнийн нэмэгдэл нь бусад дэлгэрэнгүй орлогын дансны кредит талд бүртгэгддэг бөгөөд өмчийн дахин үнэлгээний санг нэмэгдүүлдэг. Өмнө нь бүртгэгдсэн нэмэгдлийг бууруулж байвал бусад дэлгэрэнгүй орлогыг бууруулж, өмнө нь нэмэгдүүлсэн байсан санг бууруулдаг бол бусад бүх дансны үнийн бууралтыг тайлант жилийн ашиг алдагдалд тайлагнадаг. Хөрөнгийг данснаас хасах үед бодит болсон нэмэгдлийг дахин үнэлгээний сангаас хуримтлагдсан ашиг, алдагдал руу шилжүүлэн бүртгэдэг.

Гадаад валютын хөрвүүлэлт. Үйл ажиллагааны бүртгэлийн мөнгөн тэмдэгт нь үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үндэсний мөнгөн тэмдэгт байна. Үйл ажиллагааны бүртгэлийн болон тайлагналын мөнгөн тэмдэгт нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох “монгол төгрөг” юм.

Мөнгөөр илэрхийлэгдэх хөрөнгө ба өр төлбөрийг тайлант үеийн эцэст төгрөгийн албан ханшаар үйл ажиллагааны бүртгэлийн мөнгөн тэмдэгтэд хөрвүүлж бүртгэнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Төлбөр тооцоо хийх болон жилийн эцсийн төгрөгийн албан ханшид мөнгөн хөрөнгө ба өр төлбөрийг үйл ажиллагааны бүртгэлийн мөнгөн тэмдэгтэд хөрвүүлэхэд үүсэх ханшийн олз, гарзыг орлогын тайланд (гадаад валютын хөрвүүлэлтийн ашиг, алдагдлаар) хүлээн зөвшөөрдөг. Түүхэн өртгөөр бүртгэдэг мөнгөн бус зүйлсийг тайлант жилийн хаалтын ханшаар хөрвүүлж бүртгэхгүй. Харин өмчийн хөрөнгө оруулалт зэрэг бодит үнэ цэнэ нь гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгийг бодит өртгийг тодорхойлсон өдрийн ханшаар хөрвүүлж бүртгэнэ.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх гадаад валют бүхий дүнг хөрвүүлэхэд ашигласан ханш:

	2022 оны 12 дугаар сарын 31 (Төгрөг)	2021 оны 12 дугаар сарын 31 (Төгрөг)
Ам.доллар	3,444.60	2,848.80
Зээлжих тусгай эрх	4,584.22	3,987.16
Евро	3,669.02	3,222.99
Юань	495.40	447.15
Иен	26.07	24.74

Санхүүгийн үүсмэл хэрэгсэл. Санхүүгийн үүсмэл хэрэгсэлд дотоодын банкуудтай хийсэн урт болон богино хугацаат гадаад валютын, хүүгийн своп хэлцлүүд багтана. Үүсмэл санхүүгийн хэрэгсэл нь ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хэрэгслийг төлөөлөх ба бодит үнэ цэнээр бүртгэдэг. Санхүүгийн бүх үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнэ нь эерэг бол хөрөнгөөр, сөрөг бол өр төлбөрөөр тусгана. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн тайлант жилийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Монголбанк нь хейджийн бүртгэлийг хэрэглэдэггүй.

Засгийн газраас авах авлага. Энэхүү авлага Банкны төлбөр тооцооны үндсэн дээр бүртгэсэн санхүүгийн бус хөрөнгийг илэрхийлнэ. Хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртөг буюу тухайн үед мэдэгдэж байсан мэдээлэлд тулгуурлан хорогдуулсан мөнгөн урсгалын аргаар үнэлсэн бодит үнэ цэнээр бүртгэсэн.

Хугацаа бүрийн эцэст удирдлага нь авлагын үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлж, мөн тайлант үеийн бодит үнэ цэнийг үндэслэн нөхөгдөх дүнг тооцдог. Бүртгэх дүнг нөхөх боломжтой хэмжээнд хүртэл бууруулж, үнэ цэнийн бууралтын алдагдлыг тухайн жилийн ашиг, алдагдалд бүртгэнэ.

Бусад хөрөнгө. Бусад хөрөнгө нь авлага болон урьдчилж төлсөн төлбөрөөс бүрдэнэ. Өрийн бичгийн авлагаас бусад авлага нь аккруэл суурийн дагуу хорогдуулсан өртгөөр бүртгэгдэнэ. Авлагыг гэрээний дагуу эрх үүссэн үед хүлээн зөвшөөрнө.

Урьдчилж төлсөн зардлыг төлбөр хийгдсэн үед хүлээн зөвшөөрч тухайн ажил үйлчилгээ нь хийгдсэний дараа дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ. Авлагын ХБЭА-ыг ирээдүйн төсөөлсөн нөхцөл байдлыг харсан загвараар тодорхойлно. ХБЭА-ын загварыг хэмжихэд ашигласан мэдээлэл, таамаглал, тооцооллын аргуудыг Тодруулга 35-аас үзнэ үү.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Өрийн бичгийн авлага нь бизнес загвар болон мөнгөн урсгалын онцлогоос хамааран ашиг алдагдлаарх бодит үнэ цэнэ эсвэл Хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Банк өрийн бичгийг дараах байдлаар ангилдаг: (i) Хэрэв өрийн бичгийн авлага нь гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах зорилготой байршуулсан бөгөөд эдгээр мөнгөн урсгал нь хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж байгаа бол нягтлан бодох бүртгэлийн зөрүүг ихээхэн багасгахын тулд ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдэхгүй бол хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. (ii) Өрийн бичиг нь ЗХҮТ шалгуурт нийцээгүй эсвэл ХӨ болон БДОБҮЦ-ээр бүртгэх шалгуурыг хангаагүй бол ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэнэ.

Өрийн бичгийн авлага нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдалд бүртгэгдэнэ. Бодит үнэ цэнийн дараа үеийн хэмжилтийг хийхдээ тайлант үеийн зах зээлийн хүүгээр мөнгөн урсгалын хямдруулалтын аргыг ашиглана. Өрийн бичгийн хувьд зах зээлийн хүү нь мөнгөний бодлогын хүү дээр нэмэх нь зээлийн эрсдэл байна. Тодруулга 36-аас үзнэ үү.

Өрийн бичгийн авлага нь ХӨ-өөр бүртгэж, үнэ цэнийн бууралтын үнэлгээг хийх бөгөөд үүнийг ирээдүйн төсөөлсөн ХБЭА-ын загварт үндэслэн тодорхойлно. Тодруулга 35-с үзнэ үү.

Барилга болон бусад үндсэн хөрөнгө. Барилгыг дор дурдсанчлан дахин үнэлэгдсэн өртгөөс хуримтлагдсан элэгдлийг, шаардлагатай бол үнэ цэнийн бууралтын зардлыг хассан дүнгээр тусгадаг.

Банкны эзэмшиж буй барилгыг анхны өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Барилга байгууламжийн дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү байгаа эсэхийг тайлант хугацааны эцэст дахин үнэлж баталгаажуулдаг.

Дансны үнэ дахин үнэлгээгээр нэмэгдсэн тохиолдолд нэмэгдсэн дүнгээр бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгийн холбогдох дахин үнэлгээний санг нэмэгдүүлнэ. Тухайн хөрөнгийн өмнө үүссэн нэмэгдлийг хааж буй дахин үнэлгээний хорогдлыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгөд өмнө хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний сангаас бууруулна; харин бусад бүх хорогдлыг тухайн жилийн орлого зарлагад хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлгээгээр нэмэгдсэн дүн бодитоор хэрэгжих үед барилга байгууламжийн дахин үнэлгээний санг хуримтлагдсан ашиг, алдагдлаар шууд хаана.

Эзэмшиж буй тоног төхөөрөмжийг өртгөөс үнэ цэнийн бууралт болон элэгдлийг хассан дүнгээр бүртгэнэ. Урсгал засварын зардлыг гарсан тухай бүрт нь бүртгэнэ. Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн аль нэг бүрэлдэхүүн хэсгийг сольсон томоохон зардлыг капиталжуулж, сольсон хэсгийг ашиглалтаас хасна.

Үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг удирдлага тайлант хугацааны эцэст үнэлдэг. Ийм шинж тэмдэг илэрсэн тохиолдолд удирдлага хөрөнгийн бодит үнэ цэнээс тухайн хөрөнгийг борлуулах зардлыг хассан дүн эсвэл түүний ашиглалтын үнэ цэнийн дүнгийн аль ихээр нь нөхөх өртгийг тооцож, дансны үнийг нөхөх өртөг хүртэл бууруулж, гарзыг тухайн жилийн орлого, зарлагад бүртгэдэг (хэрэв тухайн өөрийн хөрөнгө дэх дахин үнэлгээний сангийн дүнгээс давсан тохиолдолд). Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ, бодит үнэ цэнэ эсвэл борлуулах өртгийн тооцоололд өөрчлөлт орсон бол өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах бичилт хийдэг.

Олз, гарзыг тодорхойлохдоо борлуулалтаас олсон орлогыг бүртгэлийн дүнтэй харьцуулдаг ба олз, гарзыг тухайн жилийн орлого, зарлагад (бусад үйл ажиллагааны орлого, зардлын хэсэгт) бүртгэнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Элэгдэл. Дуусаагүй барилгыг элэгдүүлэхгүй. Харин, үндсэн хөрөнгийн бусад зүйлсийн хувьд тэдгээрийн өртгийг дор тооцоолсон ашиглалтын хугацааны турш шулуун шугамын аргаар үлдэх өртөг хүртэл нь элэгдүүлнэ:

	<u>Ашиглалтын хугацаа, жилээр</u>
Барилга, байгууламж	6 – 60 жил
Оффис, конторын тавилга болон компьютер, тоног төхөөрөмж	3 – 20 жил

Ашиглаглалтын хугацаа нь дуусч байгаа хөрөнгийн үлдэх өртгийг тооцохдоо тухайн үед борлуулалтаас олох боломжтой үнээс борлуулалтын зардлыг хассан дүнг авдаг. Хөрөнгийн үлдэгдэл өртөг, ашиглалтын хугацааг тайлант хугацааны эцэст дахин үнэлж, шаардлагатай гэж үзвэл тохируулга хийнэ.

Биет бус хөрөнгө. Биет бус хөрөнгө нь тодорхой ашиглалтын хугацаатай ба капиталжуулсан програм хангамжууд багтсан байна. Худалдаж авсан програм хангамжийг ашиглахад бэлэн болгоход гарсан зардлаар бүртгэлд тусгана. Биет бус хөрөнгийг 4 жилийн хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулна.

Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа эргэлтийн бус хөрөнгө. Эргэлтийн бус хөрөнгө болон зарж борлуулах хөрөнгө (эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө багтаж болно) санхүүгийн тайлагналын зорилгоор санхүүгийн байдлын тайланд ирэх 12 сард борлуулж дансны үнийн ихэнх хэсгийг нөхөн авах боломжтой гэж үзэж байгаа бол Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа эргэлтийн бус ангилалд толилуулдаг. Дараах бүх шаардлагуудыг хангасан тохиолдолд хөрөнгийг дахин ангилна. Үүнд: (а) хөрөнгө нь одоогийн байгаа нөхцөл байдал нь борлуулахад бэлэн; (б) удирдлага нь худалдан авагч олох идэвхитэй хөтөлбөртэй; (в) боломжийн үнээр борлуулах тухай идэвхитэй сурталчилдаг, (г) ирэх жилийн дотор борлуулна гэж төлөвлөж байгаа, (д) борлуулах төлөвлөгөөнд өөрчлөлт орох эсхүл түдгэлзүүлэх магадлал тун бага байна. Эдгээр хөрөнгийг тайлант хугацааны эцсийн ангиллыг тусгахын тулд санхүүгийн байдлын харьцуулсан тайланд дахин ангилдаггүй. Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгийг элэгдүүлэхгүй. Дахин ангилсан эргэлтийн бус санхүүгийн хэрэгслийг дансны үнэ ба бодит үнэ цэнийг борлуулах зардлын аль багаар бүртгэх шаардлагагүй.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө нь Монголбанкнаас 1993 оны 9 дүгээр сард гүйлгээнд гаргасан цаасан болон зоосон мөнгөн тэмдэгт бөгөөд тэдгээрийг нэрлэсэн үнээр нь өр төлбөрт бүртгэдэг. Бусад банкууд болон харилцагчид бэлэн мөнгө олгох үед гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө ба зоосыг нэрлэсэн үнийн дагуу өр төлбөрт бүртгэдэг. Бэлтгэл сан болон гүйлгээ касет байгаа төгрөгийг гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөд оруулж тооцдоггүй.

Төв банкны үнэт цаас. Монголбанкнаас гаргасан үнэт цаас нь бодит үнэ цэнээрээ анх бүртгэгдэх ба түүнээс хойш хугацаанд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо эдгээрийг гаргах эсвэл үүсэх үеийн хөнгөлөлт эсвэл урамшуулал, үр ашигт хүүг бүрдүүлж буй зардлуудыг авч үзнэ.

Засгийн газрын хөрөнгө. Засгийн газар болон бусад төрийн байгууллагын данс нь Засгийн газар болон бусад харилцагчдад төлөх үүсмэл бус өр төлбөр ба үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Засгийн газрын хөрөнгийн дийлэнх нь Олон Улсын Валютын Сан (ОУВС), Герман Улсын Засгийн газар (КФВ), Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны санхүүжилттэй хөтөлбөрийн хүрээнд Сангийн яамнаас авсан урт хугацаат зээлтэй холбоотой (Тодруулга 23).

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дотоодын банкуудын хөрөнгө. Монголбанкинд харилцагч банкуудаас мөнгө шилжин орж ирэхэд дотоодын банкуудын хадгаламжийг хүлээн зөвшөөрдөг. Үүсмэл бус өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ (Тодруулга 24).

Гадаад өр төлбөр. Гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өр төлбөр нь анх бодит үнэ цэнээр бүртгэгдэх ба түүнээс хойш үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр бүртгэгдэнэ. Гадаад өр төлбөрийн дийлэнх хэсгийг Хятадын Ардын Банк (Хятадын Төв банк), Эм Ю Эф Жи Банк, ОУТТБанк, Каргилл ОУСБ -аас авсан зээл хамаарна (Тодруулга 25).

Эрсдэлийн алдагдлын сан. Энэ нь өр төлбөрийн төлөгдөх цаг хугацаа болон дүн нь тодорхойгүй санхүүгийн бус өр төлбөр юм. Монголбанкинд өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу, эсвэл хууль эрх зүйн дагуу үүрэг хариуцлага хүлээх болсон, мөн уг үүрэг хариуцлагыг шийдвэрлэх явцад эдийн засгийн өгөөж агуулсан зарлагын урсгал гарах өндөр магадлалтай, энэхүү үүргийг хүлээх нь найдвартай тооцоологдож, мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжтой болсон тохиолдолд энэхүү санг тооцож бүртгэнэ.

Олон Улсын Валютын Сантай холбоотой үйл ажиллагаа. Монгол Улс болон Олон Улсын Валютын Сангийн (ОУВС) хооронд үндсэн үүргээс шалтгаалж ОУВС-тай хамтран ажилладаг. СТОУС-ын дагуу хөрөнгө болон өр төлбөрийн тодорхойлолтын нөхцөлийг хангасан ОУВС-ийн хөтөлбөртэй холбоотой тооцоог хүлээн зөвшөөрсөн байдаг.

Банк СТОУС-ын хүрээнд хөрөнгө болон өр төлбөрийн тодорхойлолтод нийцэхгүй ОУВС-д хамаарал бүхий тооцоог санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй.

ОУВС-тай холбоотой хөрөнгө ба өр төлбөр. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн ОУВС-тай холбоотой хөрөнгөд Зээлжих Тусгай Эрх (ЗТЭ)-ээр илэрхийлэгдсэн хөрөнгө багтана (Тодруулга 8). ОУВС-д төлөх өр төлбөрт ЗТЭ-ийн хуваарилалт бүхий өр төлбөр багтана (Тодруулга 25).

ЗТЭ-ээр бүртгэгдсэн хөрөнгө, өр төлбөрийг тайлант өдрийн ЗТЭ-ийн төгрөгтэй харьцах албан ханшаар хөрвүүлсэн. Төгрөг, ЗТЭ-ийн албан ханшийг ОУВС-гийн тогтоосон ЗТЭ, ам.долларын ханшийн мэдээлэл болон тайлант хугацааны ам.доллар болон төгрөгийн Монголбанкны албан ханшид үндэслэн тооцсон.

Монгол Улсын Засгийн газрын ОУВС-тай холбоотой хөрөнгө. ОУВС-гаас худалдан авалттай холбоотой гэрээт эрх, үүрэг Монголбанкинд байхгүй тул ОУВС-тай холбоотой хөрөнгүүд СТОУС-д заасан хөрөнгө ба өр төлбөрийн тодорхойлолтод нийцдэггүй. Эдгээр хөрөнгөд ОУВС-д хувь нийлүүлсэн хөрөнгө болон ОУВС-аас Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрийн хүрээнд авсан зээл багтана. Монголбанк нь Монгол Улсын Засгийн газарт ОУВС-тай харилцахад санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг. Сангийн яам нь Монгол Улсын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг. Иймд, Монгол Улсын ОУВС-аас авах авлага болон (ОУВС-д нийлүүлсэн хувь хөрөнгө зэрэг) ОУВС-д төлөх өр төлбөр нь Сангийн яамны хөрөнгө, өр төлбөр болох учир санхүүгийн тайланд тусгаагүй.

ОУВС-д нийлүүлсэн хувь хөрөнгө. Энэхүү хувь хөрөнгөд тулгуурлан Монгол Улс нь ОУВС-гийн гишүүн орны хувьд зээлж авч болох тусгай төрлийн хөрөнгийн хуваарилалтын дүн болно. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь улс орон тус бүрийн хувьд өөр байдаг бөгөөд эдийн засгийн хэмжээ, цар хүрээнд тулгуурлан ОУВС-гийн Удирдах Зөвлөлөөс тогтоодог. Гишүүн байгууллагын саналын эрх, тусгай сангаас хүртэх санхүүгийн нөөцийн хязгаар болон зээлжих тусгай эрх (оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн)-д үндэслэн квот ногдох оролцогчийн хувь хүртэх хувь хязгаарыг тодорхойлдог.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Монгол Улсын хувь нийлүүлсэн хөрөнгийн дийлэнх хэсэг нь Сангийн яамны зүгээс баталгаажуулсан үнэт цааснаас бүрдэх ба энэхүү үнэт цаас нь хүүгүй. Мөн үлдэх хэсэг нь ОУВС-д өгөх төлбөрөөс бүрдэх ба данс №1, №2-ын талаар тодруулсан. Зээлжих тусгай эрхийн хуваарилалтын хувьд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 72.3 сая ЗТЭ (2021: 72.3 сая ЗТЭ) байна. Сангийн яам нь өрийн бичиг гаргаж энэхүү квотын төлбөрийг хийдэг тул Сангийн яамны хөрөнгөд бүртгэгдэнэ.

ОУВС-д гаргасан үнэт цаас. Энэхүү үнэт цаас нь ОУВС-гийн зүгээс Монгол Улсын үндэсний валютад хуваарилагдах хувийг төлөөлөх ба дээр дурдсан хувь нийлүүлсэн хөрөнгийн тооцоонд үндэслэн баталгаажуулсан өрийн бичиг юм. Сангийн яам нь ОУВС-тай зээлийн эрхийн ашиглалтын талаар гэрээ хийсэн байгуулсан тохиолдолд өрийн бичгээр баталгаажуулдаг.

ОУВС-ийн данс №1 болон №2. ОУВСангийн худалдан авалт, дахин худалдан авалт болон хувь нийлүүлсэн хөрөнгийн ажил гүйлгээ гүйцэтгэхэд данс №1-г ашигладаг. Монгол төгрөгөөр гүйцэтгэх ажил гүйлгээнд данс №2-г ашигладаг. Данс №1 болон №2 нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 762 сая төгрөг (2021: 752 сая төгрөг)-ийн үлдэгдэлтэй байна.

Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөр (ӨСХ). 2017 оны 5 дугаар сарын 24-нд ОУВС-гийн Удирдах Зөвлөл Монгол Улсын эдийн засгийн реформыг дэмжих зорилгоор Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөр (ӨСХ)-ийн хүрээнд гурван жилийн хугацаатай 314.5 сая ЗТЭ-ийн дүн бүхий санхүүжилтийг баталсан. Энэхүү санхүүжилт нь ОУВС-гаас Монгол Улсад олгосон жилийн 1.53-1.59 хувийн хүүтэй зээл юм. Санхүүжилтийг 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Монголбанк болон Сангийн яамны хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичигт үндэслэн Монголбанкинд шилжүүлсэн.

Зээл болон түүний эргэн төлөлт нь ЗТЭ-ээр илэрхийлэгдсэн бөгөөд Монголбанк нь Сангийн яамны өмнөөс ОУВС-д хуваарийн дагуу эргэн төлөлтийг 2026 онд багтаан хийнэ. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ӨСХ-ийн хүрээнд Сангийн яамд төлөх өр төлбөрийн хэмжээ 138.2 сая ЗТЭ буюу 633,613 сая төгрөг (2021: 155.2 сая ЗТЭ буюу 618,751 сая төгрөг) байна. (Тодруулга 23-ыг харна уу).

Дүрмийн сан. Дүрмийн сан нь өөрийн хөрөнгөд багтдаг (Тодруулга 28-ыг харна уу).

Ерөнхий нөөцийн сан. Төв банкны тухай хуулиар жилийн цэвэр орлогын хамгийн багадаа 40 хувийг Ерөнхий нөөцийн санд хуваарилах ба үлдэх хэсгийг (хамгийн ихдээ 60 хүртэлх хувийг) Улсын Төсөвт шилжүүлж болно. Ерөнхий нөөцийн санд зөвхөн тодорхой хугацааны туршид хуримтлуулсан ба Монголбанк өөрөө захиран зарцуулах бүрэн эрхтэй цэвэр ашгийг бүртгэдэг.

Энэ санд Улсын төсөвт хуваарилсан болон цаашид хуваарилах дүнг оруулдаггүй. Учир нь Засгийн газарт тухайн тайлант жилд шилжүүлдэг. Банк 2022 болон 2021 онд алдагдалтай ажилласан тул шилжүүлэг хийгдээгүй.

Бусад нөөц. Бусад нөөцөд БДОБҮЦ-ээрх хөрөнгө оруулалтын үнэт цаасны нөөц сан, гадаад валют, мөнгөжсөн алт, оффисын барилга болон эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний санг оруулдаг (Тодруулга 28). Төв банкны тухай хуулийн дагуу өмнө нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн гадаад валют, мөнгөжсөн алт болон үнэт металын ханшийн тэгшитгэлийн олз, гарзыг жил бүрийн эцэст бусад нөөц сангийн дансанд шилжүүлдэг. Мөнгөжсөн алт болон гадаад валютын ханшийн тэгшитгэлийн гарзын хувьд дахин үнэлгээний нөөц санд бүртгэлтэй байгаа зээлийн үлдэгдлийн хэмжээгээр нөөц санг бууруулдаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зээлтэй холбоотой үүрэг хариуцлага. Банкинд зээлтэй холбоотой үүрэг хариуцлага байдаг ба үүнд аккредитив болон Хятадын Ардын банк (БНХАУ-ын Төв Банк, цаашид “ХАБ” гэх)–тай байгуулсан хэлэлцээр орно. Хэлэлцээр нь ХАБ-аас юаниар олгосон санхүүжилт болон ХАБ-д төгрөгөөр олгосон санхүүжилт юм (Тодруулга 33).

Тайлант жилийн эцэст төлбөр төлөх үүрэг нь 1) анхны хүлээн зөвшөөрөлтийн хорогдуулалтыг тооцоогүй төлбөрийн үлдэгдэл дээр нэмээд 2) хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын загвараар тодорхойлсон эрсдэлийн алдагдлын дүнгээр хэмжигддэг. Хэрэв дуусгавар болгоогүй төлбөрийн дүнд хураамж авдаг бол энэ нь тухайн үүргийн хүчинтэй хугацаанд орлого гэж хүлээн зөвшөөрдөг.

Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт. Хүүгийн орлого, зардлыг ашиг алдагдлаар хэмжигдэх бодит үнэ цэнээр бүртгэгдэхээс бусад өрийн хэрэгслийн аккруэл суурь дээр үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ арга нь талуудын хооронд гэрээний дагуу төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлого эсвэл зардал болгон бүртгэдэг. Ашиг алдагдлаар хэмжигдэх бодит үнэ цэнээр бүртгэгдэх өрийн хэрэгслийн (өрийн бичиг) хүүгийн орлогыг нэрлэсэн хүүгээр тооцоолж тайлант жилийн ашиг алдагдлын тайланд “Бусад адилтгах орлого” хэсэгт тусган бүртгэдэг.

Худалдан авах эсхүл үүсэх үедээ эрсдэлийн алдагдалтай байсан санхүүгийн хөрөнгийн хувьд үр ашигт хүү нь ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцох хямдруулалтын хувь болох бөгөөд (ирээдүйн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын урсгалыг мөн адил) уг хямдруулсан дүн нь анх хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнэ болно. Ингэснээр үр ашигт хүүд эрсдэлийн алдагдлын тохируулга хийгдэнэ.

Хүүгийн орлогыг санхүүгийн хөрөнгийн нийт дүнгээс үр ашигт хүүг ашиглан тооцож гаргах бөгөөд харин (i) чанар муутай зээлийн хувьд (Шатлал 3) хүүгийн орлогыг хорогдуулсан өртгөөс (ХБЭА-ыг оруулаад) үр ашигт хүүгийн хувиар тооцдог бөгөөд (ii) худалдан авах эсвэл үүсэх үедээ чанаргүй байсан санхүүгийн хөрөнгийн хувьд анхны эрсдэлийн алдагдлаар тохируулсан үр ашигт хүүг хорогдуулсан өртгөөр үржүүлэн тооцно.

Шатлал 3-т ангилсан байсан санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн алдагдал нь багагүй буурч, чанаргүй зээл гэж ангилахааргүй болсон тохиолдолд (мөн энэ үйл явдал нь тус ангилалд орсны дараа болсон тохиолдолд) хөрөнгийг Шатлал 3-аас гарган дахин ангилах бөгөөд хүүгийн орлогыг нийт дансны үнээс үр ашигт хүүгээр үржүүлэн тооцно.

Нэмэлт хүүгийн орлого нь хөрөнгө өмнө нь шатлал 3-д ангилагдсанаас болж ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөгдөөгүй байсан бол хөрөнгийн чанар сайжирснаас хойш ХБЭА-ын буцаалт гэж бүртгэгдэнэ.

Хураамж, шимтгэлийн орлогыг Банк гүйцэтгэлийн үүргээ биелүүлэх үед буюу үндсэн ажил гүйлгээг гүйцэтгэх тухайн үед нь хүлээн зөвшөөрдөг. Хүлээн авсан хураамж, шимтгэл, авлагын дүн нь гүйцэтгэлийн тодорхой үүрэг гэж тодорхойлсон үйлчилгээний гүйлгээний үнийг илэрхийлдэг. Ийм орлогод төлбөрийн гүйлгээний хураамж, бэлэн мөнгөний шимтгэл орно.

Бусад бүх шимтгэл, хураамж болон бусад орлого, зардлыг аккруэл суурьд үндэслэн тухайн ажил гүйлгээний гүйцэтгэлтэй уялдуулан хүлээн зөвшөөрөх бөгөөд гүйцэтгэлийг нийт тохирсон үйлчилгээнээс бодитоор үзүүлсэн үйлчилгээний хувь хэмжээгээр тооцдог.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бэлэн мөнгө хэвлэхтэй холбогдож гарсан зардал. Банк нь Монгол Улсын цаасан мөнгөн дэвсгэрт болон зоосон мөнгийг гүйлгээнд гаргадаг. Цаасан мөнгөн дэвсгэрт болон зоосыг хэвлүүлэхтэй холбоотой урьдчилж гарсан зардал нь “Бусад хөрөнгө” хэсэгт бүртгэгдэх ба тэдгээрийг үйлдвэрлэлээс бэлтгэл санд шилжих үед “Захиргааны болон үйл ажиллагааны бусад зардал”-д тусган зардлаар хүлээн зөвшөөрдөг.

Ажилчдын зардал болон холбогдох шимтгэлүүд. Цалин хөлс болон түүнтэй холбоотой бусад зардлуудыг (ээлжийн амралт, өвчтэй байх үеийн нөхөн олговор, урамшуулал болон мөнгөн бус тэтгэмж гэх мэт) ажилтнуудын холбогдох ажил үйлчилгээ үзүүлсэн жилд харгалзуулан зардал гэж хүлээн зөвшөөрдөг. Ээлжийн амралтын мөнгө, нөхөн олговортой бусад богино хугацаат чөлөө авалтыг, ажилтнуудад ирээдүйд нөхөн олговортой чөлөө авах эрхийг үүсгэх үйлчилгээг үзүүлсэн үед, харин өвчний улмаас чөлөө авах гэх мэт нөхөн олговортой богино хугацаат чөлөө авалтыг чөлөө авсан тухайн үед хүлээн зөвшөөрнө.

Ажилтнуудын тэтгэмж. Дотоод журамд үндэслэн Банк ажилтнуудын ажлын нөхцөл байдлыг сайжруулах, нийгмийн халамжийн асуудлыг шийдэх үүднээс тодорхой хөрөнгийг нийгмийн хөгжлийн санд хуваарилж, хуримтлуулдаг. Эдгээр сангийн мөнгийг тэтгэмж, нөхөн олговор, нийгмийн халамжийн хүрээнд бусад хэрэгцээг хангах зэрэгт ашигладаг.

Удирдлага нь 2022 оны 12 дугаар сарын 31 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Нийгмийн хөгжлийн сангийн дүн нь эдгээр богино болон урт хугацаат төлбөрийг төлөх бүрэн боломжтой, мөн хүлээн зөвшөөрсөн тусламж, тэтгэмжийн өр төлбөр нь тухайн тайлант өдрөөр тусламж тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнээс материаллаг хэмжээгээр зөрөхгүй гэж үзэж байна.

Орлогын албан татвар. Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу Монголбанк нь орлогын албан татвараас чөлөөлөгддөг.

Цэвэр дүнгээр бүртгэх. Нягтлан бодох бүртгэлд санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг цэвэр дүнгээр бүртгэх хууль, эрх зүйн үндэслэл байгаа үед болон цэвэр дүнгээр төлбөр тооцоог барагдуулах төлөвтэй байгаа үед эсхүл санхүүгийн өр төлбөр болон хөрөнгийг нэгэн зэрэг барагдуулах төлөвтэй үед цэвэр дүнгээр бүртгэж болно. Дээр дурдсан эрх нь (а) ирээдүйд бий болох үйл явдалд тулгуурлаагүй байх, (б) дараах бүх тохиолдолд хэрэгжих боломжтой байна: (i) үйл ажиллагаа явуулах энгийн явцад, (ii) үүргээ биелүүлээгүй тохиолдолд, болон (iii) төлбөрийн чадваргүй болсон эсхүл дампуурсан тохиолдолд хэрэгжинэ.

Санхүүгийн байдлын тайланг хөрвөх чадварын байдлаар тодруулах нь. Үйл ажиллагааны тодорхой мөчлөггүй тул санхүүгийн байдлын тайланд эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөрийг тусад нь тайлагнадаггүй болно. Харин хөрөнгө, өр төлбөрийг тэдгээрийн хөрвөх чадварын дарааллаар нь тусгасан.

Санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрөөс гадна эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөрийг Тодруулга 35-д харуулав. Санхүүгийн бус хөрөнгө болон өр төлбөрт үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж, биет бус хөрөнгө болон эрдэнэсийн сангийн эд зүйлс ордог бөгөөд тэдгээр нь тайлант хугацааны эцсээс 12 сараас дээш хугацаанд төлөгддөг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТООЦООЛОЛ БА ҮНДЭСЛЭЛ

Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүн нь дараагийн санхүүгийн жилд хөрөнгө, өр төлбөрийн хувьд хэрхэн нөлөө үзүүлэх талаар ач холбогдол бүхий таамаглал, тооцоолол, үнэлгээг хийдэг. Удирдлага нь өөрсдийн туршлага болон ирээдүйн үйл явдлын талаарх нөхцөл байдалд зохистой гэж үзсэн үнэлэлт, таамаглал зэрэг бусад хүчин зүйлсд суурилан тооцооллыг тогтмол хянадаг болно. Мөн удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх явцад ач холбогдол бүхий тооцооллуудаас гадна тодорхой үнэлгээг хийдэг. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үнэлэлт болон дараагийн санхүүгийн жилд хөрөнгө, өр төлбөрийн тайлагнасан дүнгүүдэд томоохон (мэдэгдэхүйц) хэмжээний тохируулга хийх шаардлага үүсч болох ба үүнд дараах зүйлс хамаарна:

Тасралтгүй байх зарчим. Удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн. 2022 оны 12 дугаар сарын 31 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар цэвэр өр төлбөр болон өөрийн хөрөнгө сөрөг утгатай гарсан. Банк нь тодруулга 35-д заасны дагуу санхүүгийн эрсдэл тухайлбал хөрвөх чадварын эрсдэл байгаа эсэхийг хянаж үзээд ирээдүйд үйл ажиллагаа тасалдахгүй, тасралтгүй байх зарчим алдагдахгүй гэж удирдлага үзэж байна. Төлбөрийн чадварын эрсдэлийн үнэлгээний гол эрсдэл нь Хятадын Ардын Банкнаас авсан зээлийн хугацаа дуусч 2023 оны 7 сард төлөхтэй холбоотой байна. Засгийн газрын туслалцаатай энэхүү зээлийн хугацааг дахин 3 жилээр сунгахаар удирдлагын зүгээс идэвхтэй хэлэлцээ хийж байгаа бөгөөд 2023 оны дунд үед хэлэлцээрийг амжилттай дуусгахаар төлөвлөж байна. Энэхүү санхүүжилтийг өмнө нь гурван удаа сунгаж байсан.

Түүнчлэн, шаардлагатай тохиолдолд Төв банкны тухай хуулийн 38 дугаар зүйлд зааснаар Банк нь Улсын Их хуралд Банкны хуримтлагдсан алдагдлыг Засгийн газар үнэт цаас гаргах замаар нөхөж үндсэн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжоор хангах хүсэлт гаргаж болно. Иймд, Банк нь өөрийн онцгой эрхийн хүрээнд ирээдүйн үйл ажиллагааны тасралтгүй байдалд эрсдэл учрахгүй гэж удирдлага үзэж байна.

Төв банкны тухай хуулийн 38 дугаар зүйлд Банкны пассив нь актив хөрөнгөөс хэтэрсэн тохиолдолд Засгийн газар үнэт цаас гаргах замаар уг зөрүүг нөхөх асуудлыг Улсын Их хурал шийдвэрлэнэ гэж заасан байдаг. Засгийн газар нь Төв банкны алдагдлыг нөхөх үүрэг хүлээгээгүй ч Банкны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх шаардлагатай гэж үзвэл дээр дурдсан байдлаар Улсын Их хурлаас шийдвэр гаргах боломжтой юм.

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын хэмжилт. ХБЭА-ын хэмжилт нь арга зүй, загвар, мэдээллийн өгөгдлүүдийг тодорхойлох зэргийг багтаасан чухал тооцоолол байна. ХБЭА-ын хэмжилтын арга зүйн дэлгэрэнгүйг Тодруулга 35-аас харна уу. Эрсдэлийн алдагдлын санд дараах бүрэлдэхүүн хэсгүүд чухал нөлөөтэй. Үүнд:

- дефолтын тодорхойлолт
- эрсдэлийн томоохон өсөлт байгаа эсэхийг дүгнэх шалгуур үзүүлэлтүүд;
- дотооддоо ашиглах зээлийн эрсдэлийн үнэлгээ тогтолцоог боловсруулан ашглаж зээлийн эрсдэлийн түвшин бүр магадлалыг тодорхойлно;
- дефолт болох магадлал;
- дефолт болсон тохиолдолд хүлээх алдагдлын хэмжээ;
- макро эдийн засгийн хэтийн төлөвийг сонгох, тэдгээрийн магадлалыг жинлэх.

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТООЦООЛОЛ БА ҮНДЭСЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эрсдэлийн алдагдлын тооцоолол болон бодит эрсдэлийн алдагдлын хоорондын зөрүүг багасгах загвар, түүнд ашиглах өгөгдлүүдийг байнга хянаж үздэг. Банк ХБЭА-ын хэмжилтийн хувьд ирээдүйг таамагласан мэдээлэлд сууриладаг бөгөөд өөрсдийн макро эдийн засгийн хэтийн төлөвийн загварыг ашигладаг. Дэлгэрэнгүйг Тодруулга 35-аас харна уу.

Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт. Хөрөнгийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн эсэхийг тодорхойлохын тулд тайлант үеийн эцэст санхүүгийн хэрэгслийн бүх хугацаан дахь дефолт болох эрсдэл болон анх хүлээн зөвшөөрөх үеийн дефолт болох эрсдэлийг харьцуулна. Үнэлгээгээр тайлант үеийн эцэст тодорхой нэг хөрөнгийн эрсдэлийн түвшинд хүрэх гэхээсээ илүү хөрөнгийн эрсдэлийн харьцангуй өсөлтийг нь авч үздэг. Бүхий л боломжит ашиглаж болохуйц бэлэн байгаа ирээдүйг харсан мэдээлийг хэт их зардал, хүчин чармайлт гаргалгүйгээр авч үздэг. Тодруулга 35-ийг харна уу.

Бизнес загварын үнэлгээ. Бизнес загвараас үндэслэн санхүүгийн хөрөнгийг ангилна. Удирдлага

бизнес загварын үнэлгээг хийхдээ санхүүгийн хэрэгслийн багц болон ижил байдлын түвшинг тодорхойлдог. Борлуулалтын гүйлгээг үнэлэхдээ түүхэн давтамж, цаг хугацаа болон үнэ цэнэ, борлуулалтын зорилго, ирээдүйн борлуулалтын үйл ажиллагааны хүлээлт зэргийг авч үздэг. Зээл чанаргүйдсэнээс үүдэн гарах боломжит алдагдлыг багасгах зорилготой борлуулалтын гүйлгээ нь “гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах” бизнесийн загвартай таарч байна. Эрсдэлийн алдагдлыг удирдлагын үйл ажиллагаанд хамааралгүй бусад хугацаанаас өмнөх борлуулалт ч мөн дангаараа болон бүлгээрээ олон давтамжтай биш эсвэл үнийн дүнгийн хувьд их биш гэдгийг харгалзан “гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах” бизнесийн загвартай таарч байна. Мөн түүнчлэн зөвхөн стрессийн тохиолдлын үед эсвэл хяналтаас гадуур нэг удаагийн үйл явдлын үр дүнд хийгдэж болох санхүүгийн хөрөнгийн борлуулалт нь байнга давтагддаггүй, таамаглах боломжгүй ба бизнесийн загварын зорилгын хувьд тохиолдлын гэж үзэх учир тухайн санхүүгийн хөрөнгийн ангилалд нөлөөлөхгүй.

4 Нягтлан бодох бүртгэлд ашигласан ач холбогдол бүхий тооцоолол ба үндэслэл (үргэлжлэл)

“Гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах ба зарах” бизнес загвар нь гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах болон тухайн хөрөнгийг борлуулснаас үүссэн мөнгөн урсгалыг цуглуулах нь энэхүү бизнес загварын зорилгыг биелүүлэхэд чухал. Үүнд хөрвөх чадвартай байдлаа удирдахын тулд, тодорхой нэг өгөөжид хүрэхийн тулд, эсвэл тухайн хөрөнгийг санхүүжүүлэхэд ашигласан өр төлбөрийн хугацааг санхүүгийн хөрөнгийн хугацаатай нь тохируулах гэх мэт.

Үлдсэн ангиллын гол зорилго нь худалдан борлуулснаас үүсэх мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор удирдаж байгаа санхүүгийн хөрөнгийн багцууд багтах бөгөөд жишээ нь өмнө нь худалдан борлуулсан төлөв байх ёстой. Гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах нь энэ бизнес загварын хувьд заримдаа тохиолддог.

Мөнгөн урсгал нь хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй эсэх үнэлгээ. Санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлөлтөөс (“ЗХҮТ”) бүрдэж буй эсэхийг тодорхойлоход үнэлгээ өгөх шаардлагатай.

- Мөнгөн урсгалын дүн болон хугацаанд гарч болзошгүй үйл явдал,
- Хөшүүргийн онцлогууд;
- Урьдчилсан төлбөр болон сунгах нөхцөл;
- Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэд өөрчлөлт оруулах шинж чанарууд (жишээ нь, хүүгийн хэмжээг давтамжтай шинэчлэх);

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТООЦООЛОЛ БА ҮНДЭСЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Мөнгөний үнэ цэнийн элемент нь хувирах магадлалтай, жишээ нь гэрээний хүүгийн түвшин давтамжтайгаар өөрчлөгддөг боловч тэр давтамж нь өрийн хэрэгслийн суурь хүүгийн түвшний чиглэлтэй таарахгүй, зээлийн хүүд банк хоорондын 3 сарын хүүг ашигладаг боловч хүү нь сар бүр өөрчлөгддөг. Хувиргасан мөнгөний үнэ цэнийн нөлөөг тодорхой хэрэгслийн мөнгөн урсгалыг ЗХҮТ мөнгөн урсгалтай жишиг өрийн хэрэгсэлтэй харьцуулалт хийх байдлаар үнэлэх бөгөөд үүнийг тайлант хугацаа бүрт болон хэрэгслийн хугацааны туршид хуримтлуулан хийнэ. Үнэлгээг хамгийн боломжит бүх тохиолдолд хийсэн бөгөөд санхүүгийн зах зээлд тохиолдож болох санхүүгийн стрессийн боломжит нөхцөл байдалд хийнэ. Мөнгөн урсгал нь жишиг үзүүлэлтээс ихээхэн зөрүүтэй байх тохиолдолд үнэлгээ хийгдсэн хэрэгслийн мөнгөн урсгалыг ЗХҮТ гэж үзэхгүй бөгөөд тухайн хэрэгслийг ашиг алдагдлаар хэмжигдэх бодит үнэ цэнээр бүртгэнэ. ЗХҮТ шалгуурыг даваагүй хэрэгслийг ашиг алдагдлаар хэмжигдэх бодит үнэ цэнээр бүртгэдэг.

Банк гэрээний мөнгөн урсгалын хугацаа болон дүнд өөрчлөлт оруулж болзошгүй гэрээний нөхцөлийг тодорхойлсон. Зээлийг хугацаанаас өмнө төлөх тохиолдолд тухайн дүн нь үндсэн болон хүүгийн дүнг илэрхийлж байх мөн гэрээг хугацаанаас нь өмнө төлсний хангалттай хэмжээний нөхөн олговор төлж байвал ЗХҮТ-ийн шалгуурыг хангана гэж үзсэн. Хөрөнгийн дансны үнэ нь анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн бодит үнэ цэнээс дараагийн тайлант хугацаанд төлсөн эргэн төлөлт болон үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн төлбөрийг хассан дүн юм. Урьдчилан төлөх онцлогтой санхүүгийн хэрэгслүүд нь ЗХҮТ шалгуурыг хангахын тулд дараах нөхцлүүдийг биелүүлсэн байхаар стандартад тусгасан. Үүнд: i) хөрөнгө нь хөнгөлөлт, урамшуулалтай ii) урьдчилан төлөх дүн нь гэрээний нэрлэсэн үнэ дээр хүүгийн дүн болон гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсны нөхөн олговрын дүнгийн нийлбэр байна. Түүнчлэн урьдчилан төлөх төлбөрийн бодит үнэ цэнэ цэнийн анхны хүлээн зөвшөөрөх дүн материаллаг бус байна.

Сангийн яамнаас авсан зээлийн анхны хүлээн зөвшөөрөлт. Монголбанк нь Сангийн яамнаас дамжуулан 50,696 сая төгрөг (2021: 35,661 сая төгрөг)-ийн зээлийг авсан (Тодруулга 23) ба энэ зээл нь Азийн хөгжлийн банк (АХБ), Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)-аас улс хоорондын төслийн санхүүжилтээр Монгол Улсын Засгийн газрын өмнөөс Сангийн яамны авсан зээлтэй холбоотой. Энэ эх үүсвэр нь жилийн 1.0-2.5 хувийн хүүтэй, сонгогдсон эдийн засгийн секторууд болон бусад бага хүү шаардлагатай өөр бусад тусгай зорилтуудыг хангах зорилгоор зээлдүүлэх нөхцөлтэй.

Удирдлага нь энэхүү зээлийг анхны хүлээн зөвшөөрөлт болон эхэлж бүртгэхдээ ашиг бүртгэх шаардлагатай эсэхийг харгалзан үзсэн. Ингэхдээ эдгээр зээлийг харилцан тохиролцсон төсөлд заасан тусгай зорилготой зах зээлд зориулсан буюу нийтийн ашиг сонирхолд үйлчлэх хүүгүй эсвэл маш бага хүүтэй зээлийн хэрэгсэл хэмээн удирдлага үзсэн. Энэхүү зээлийн эх үүсвэрийг ашиглан тодорхой шалгуур хангасан арилжааны банкуудад бага хүүгээр санхүүжилт хийх буюу зээл олгох боломжтой байна. Иймд эдгээр зээлийн анхны хүлээн зөвшөөрөлтийн олзыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй.

4 Нягтлан бодох бүртгэлд ашигласан ач холбогдол бүхий тооцоолол ба үндэслэл (үргэлжлэл)

Санхүүжилтийн үр дүнд шаардлага хангасан банкуудад хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох боломжтой. Удирдлага нь дээрх хэрэгслийг анх хүлээн зөвшөөрөх үед алдагдал хүлээн зөвшөөрөх шаардлагатай эсэхийг авч үзээд холбоогүй талуудад олгосон зээл учир зах зээлийн хүүгээр олгосон гэх бөгөөд анх хүлээн зөвшөөрөлтийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзсэн. Дээрх үнэлгээнд эдгээр хэрэгсэл нь анхдагч зах зээлд олгогдсон гэдгийг авч үзсэн болно.

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТООЦООЛОЛ БА ҮНДЭСЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнэ. Гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэх, хүүгийн өсөлт, гадаад валютын зээлийн хэмжээг бууруулах, валютын ханшийн эрсдэлийг бууруулах орчныг бүрдүүлэх зорилгоор дотоодын банкуудтай үүсмэл хэрэгслийн хэлцлийг тогтмол хийдэг. Эдгээр үүсмэл хэрэгслийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөх бодит үнэ цэнээр бүртгэдэг.

Монголбанк нь 2016 оны 12 дугаар сараас хойш дотоодын банкуудтай урт хугацаат хүүгийн своп хэлцлийг хийж эхэлсэн. Энэ хэлцэл нь 1-8 жилийн хугацаатай, зөвшөөрөгдсөн хүүгийн хувь хэмжээнд үндэслэсэн төгрөг-ам.долларын своп хэлцэл юм. Ийм урт хугацааны хэрэгслийн үнийн талаарх зах зээлийн мэдээлэл одоогоор алга байна. Банк нь 2022 оноос эконометрик загвар ашиглан тооцоолохын оронд форвард ханшийг хүүгийн түвшний паритын онолд үндэслэн тооцож эхэлсэн.

Удирдлага эконометрик загвараас илүү хүүгийн паритын онолд үндэслэн тооцох хандлага нь илүү оновчтой гэж үзсэн. Дээрх урт хугацаат хэрэгслийн үнийн талаар зах зээлийн мэдээлэл байхгүй. Ажиглагдахуйц зах зээлийн мэдээлэлд суурилагагүй төсөөлөл ашиглан үнэлсэн хэрэгслийн талаарх мэдээллийг Тодруулга 36-аас үзнэ үү.

Удирдлага дээрх санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрөхөд олз, гарз үүсэх эсэхийг харгалзан үзсэн ба хэлцэлд оролцогчдын хувьд сайн дурын үндсэн дээр явагдсан тул олз гарз үүсэхгүй гэж үзсэн. Мөн тус үнэлэмж, дүгнэлтийг хийхэд үндсэн зах зээлийн хэрэгслийг илэрхийлж байна гэж үзсэн болно.

Дотоодын банкуудад олгосон орон сууцны зээлийн анхны хүлээн зөвшөөрөлт. Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд төгрөгийн зээлийг дотоодын банкуудад олгож эхэлсэн. Банк, Засгийн газар, Монголын ипотекийн корпораци нарын хамтран байгуулсан “Ипотекийн зээлийг санхүүжүүлэх гэрээ”-нд тусгасан нөхцлийн дагуу эдгээр зээлийг олгодог бөгөөд Банк болон дотоодын банкууд зээлийн нөхцлийг тодорхойлоход ямар нэгэн эрхгүй байсан болно. “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн гэрээ”-ний дагуу дотоодын банкуудад Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүжилтийн төлбөрийн дүнд давуу эрхтэй ИЗББ авсан. Үүний үр дүнд дотоодын банкуудад олгосон зээлийн хүүгийн түвшин нь жилийн 1 хувь, 2 хувь, болон 4% хувь байх боломжийг Засгийн газар бүрдүүлсэн. Эдгээр зээлийн хүүг зах зээлийн хүүтэй адилтган үзэж, анх хүлээн зөвшөөрөх үед аливаа ашиг, алдагдал хүлээн зөвшөөрөх шаардлагатай эсэхийг үнэлж үзсэн. Энэхүү зээл нь Төв банкны үндсэн үүрэг болох мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, инфляцыг тогтворжуулах зорилгын хүрээнд зах зээлд мөнгөний нийлүүлэлтийг хийсэн бөгөөд зээлүүд тусдаа зах зээлийн сегментийн гүйлгээ (жишээ нь үндсэн зах зээл) мөн болохыг харгалзаж үзсэн. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд дотоодын банкуудад олгосон зээлийн үлдэгдэл нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 881,212 сая төгрөг (2021: 852,376 сая төгрөг) байна. Дотоодын банкуудад олгосон зээлийн талаар Тодруулга 9, холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар Тодруулга 3-аас харна уу.

Зах зээлийн түвшингөөс доогуур олгосон бусад санхүүгийн хэрэгслийн анхны хүлээн зөвшөөрөлт. СТОУС 9-д санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрөх дүн нь түүний бодит үнэ цэнэ байна гэж заасан. Санхүүгийн хэрэгсэл нь идэвхтэй зах зээлд арилжаалагддаггүй эсвэл зах зээлийн бус хүүгээр олгогдсон тохиолдолд бодит үнэ цэнийг холбогдох үнэлгээний аргуудыг ашиглаж тодорхойлно. Тус үнэлгээг хийхдээ холбоогүй талуудын хооронд хийгдсэн ижил төстэй ажил гүйлгээ болон үр ашигт хүүгийн аргыг ашиглана.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТООЦООЛОЛ БА ҮНДЭСЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банк Сайн” хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор 2016 онд 453,712 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 1-3 хувийн хүүтэй Засгийн газрын үнэт цаасыг худалдан авсан. Удирдлага анхны хүлээн зөвшөөрөлтийн алдагдлыг хүлээн зөвшөөрч бүртгэхийн тулд Засгийн газрын зээлийн эрсдэлийг үнэлэн, Банкны бодлогын хүү нь төгрөгөөр олгох санхүүжилтийн зах зээлийн хүүг бодитоор илэрхийлнэ гэж үзсэн.

Удирдлага нь эдгээрийг 123,668 сая төгрөгийн бодит үнэ цэнэ бүхий санхүүгийн хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн ба анхны хүлээн зөвшөөрөлтийн гарз нь 330,044 сая төгрөг байсан. Энэ гарзыг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн алдагдлаар хүлээн зөвшөөрсөн. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар “Сайн” хөтөлбөртэй холбоотой Засгийн газрын үнэт цаасны үлдэгдэл 38,646 сая төгрөг (2021: 231,778 сая төгрөг) байна. Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлогыг Тодруулга 3-аас, бусад дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 17-аас харна уу.

Өрийн бичгийн бодит үнэ цэнэ. Монголбанк нь 2014 онд аж ахуй нэгжээс өрийн бичиг худалдан авах замаар зээл олгосон бөгөөд нийтдээ 2014 онд 350,000 сая төгрөг, 2016 онд 465,000 сая төгрөгийн зээлийг жилийн 21 хувийн хүүтэй, тодорхой нөхцөлийг хангасан тохиолдолд хүүгийн хэмжээ жилийн 7-8 хувь хүртэл буурах нөхцөлтэй олгосон. Эдгээр авлагыг СТОУС 9-д шаардсаны дагуу ЗХҮТ-ийн шалгуурыг хангаагүй тул ААБҮЦ-ийн ангилалд шилжүүлсэн. Иймээс холбогдох авлагын бодит үнэ цэнийг шилжилтийн өдрийн байдлаар тооцсон.

Өрийн бичгийн бодит үнэ цэнийг хорогдуулсан мөнгөн урсгалын загварыг ашиглан тооцох замаар гаргадаг. Бодит үнэ цэнийн тооцооллод, дараах ойлголтыг мэдэгдэж байгаа мэдээлэлд ашигласан. Үүнд:

- Ирээдүйн мөнгөн гүйлгээний магадлал: Удирдлага харилцагч талуудын санхүүгийн түүхэн мэдээлэлд үндэслэн ирээдүйн мөнгөн гүйлгээний магадлалыг үнэлж, зарим өрийн бичгүүдийн эргэн төлөлтийг хугацаанд нь бүрэн авах боломжтой гэж үзэж байна.
- Хямдруулалтын хувь: Мөнгөний бодлогын хүү нь харилцагч талын эрсдэлээс хамаарч өссөн. Харилцагч талын эрсдэлийг хүүгийн нөхцлөөс татсан зээлийн зэрэглэлд үндэслэн тодорхойлно. Эдгээр аж ахуйн нэгжтэй холбоотой эрсдэлийн алдагдал үүссэн тохиолдолд төгрөгийн эх үүсвэрийн зах зээлийн ханшийг боломжийн хэмжээнд тооцож байна гэж удирдлага үзэж байна.

Олж авах боломжтой зах зээлийн мэдээлэлд үндэслээгүй таамаглалыг ашиглан эдгээр өрийн бичгийн бодит үнэ цэнийн талаарх мэдээллийг Тодруулга 36-аас харна уу.

Засгийн газраас авах авлагын анхны хүлээн зөвшөөрөлт. УИХ-ын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Монголын зэс корпораци” ХХК-аас “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмент” ХХК-ийн 49 хувийг худалдан авахыг Засгийн газарт даалгасан. УИХ-ын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 258 дугаар тогтоол, 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 315 дугаар тогтоолыг тус тус баталсан. Эдгээр тогтоолуудад Эрдэнэт үйлдвэр ХХК, “Монголросцветмент” ХХК-ийн 49 хувийг худалдан авах төлбөрт Банкны Худалдаа хөгжлийн банк (ХХБ)-аас авах өрийн бичгийн авлага болон зээлийн үлдэгдлийг дүйцүүлэн хаах тухай тусгасан. Засгийн газрын тогтоолын дагуу 2022 оны 6 дугаар сарын 30, 2022 оны 8 дугаар сарын 31-ний өдрүүдэд Засгийн газар, Монголбанк, “Монголын зэс корпораци” ХХК, ХХБ хооронд харилцан төлбөр барагдуулах тухай актууд үйлдсэн. Харилцан төлбөр барагдуулах акт 18 дугаар тэмдэглэлд тусгагдсаны дагуу тухайн өдрийн байдлаар тус тусын хөрөнгийн дансны үнэ 491,291 сая төгрөг, 166,467 сая төгрөг байсан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТООЦООЛОЛ БА ҮНДЭСЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дээрх тогтоол болон дөрвөн талын акт байгуулсаны үр дүнд Банк нь Монгол Улсын Засгийн газраас 657,758 сая төгрөг нэхэмжлэх эрхтэй болсон бөгөөд тус дүнгээр Засгийн газраас авах авлагыг хүлээн зөвшөөрсөн. “Монголын зэс корпораци” ХХК-д төлөх үлдэгдэл төлбөрийг Засгийн газар бүрэн төлж барагдуулсны дараа Засгийн газар, Банкны хооронд байгуулсан гэрээний хэлэлцээрийг эцэслэн шийдвэрлэх юм. 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн Сангийн сайдаас ирүүлсэн албан бичгийн дагуу гэрээний нөхцөл, болзлыг хангана гэж удирдлага үзэж байна. Удирдлагын зүгээс Засгийн газартай 2025 оны эцэст авлага барагдуулах гэрээ байгуулах боломжтой гэж үзэж байна. Мөн авлага нь гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 10 жилийн хугацаатай бодлогын хүүтэй тэнцүү хүүтэй байна. Тодруулга 3-т заасан нягтлан бодох бүртгэлийн холбогдох бодлогын дагуу авлагын дансны дүн нь хүлээн зөвшөөрөх өдөр 514,942 сая төгрөг байсан бөгөөд “Засгийн газраас анх хүлээн зөвшөөрөх үеийн авлагын гарз” 133,482 сая төгрөг, “Засгийн газраас авах авлагын үнэ цэнийн бууралтын гарз” 9,334 сая төгрөгийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн.

Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК)-д тавих хяналт. Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК)-д хяналтын эрхтэй эсэх болон улмаар Монголбанкны санхүүгийн тайланд түүнийг нэгтгэх хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Банк болон ХДК-ийн хоорондын харилцааны бодит байдлын талаар үнэлгээг хийсэн. Уг үнэлгээг хийхдээ дараах байдлыг харгалзан үзсэн. Үүнд:

- ХДК-ийн эрх мэдэл,
- ХДК-ийн үйл ажиллагаа дахь оролцооноос өгөөж хүртэх нөхцөл байдал, ХДК дахь өөрийн эрх мэдлээ ашиглан Монголбанкны хүртэх ашгийн хэмжээнд нөлөөлөх чадвар.

ХДК-ийн үйл ажиллагаанд шууд оролцож чаддаг бол Монголбанк ХДК-д эрх мэдэлтэй гэж үзнэ. ХДК-ийн дүрмийн дагуу Үндэсний хороо нь 7 гишүүнээс бүрдэх бөгөөд Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч Үндэсний хорооны гишүүн бөгөөд дарга нь байна. Үндэсний хорооны бусад зургаан гишүүд нь:

- Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга;
- Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга;
- ХДК-ийн Гүйцэтгэх захирал;
- Гурван гишүүнийг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд болон Банкуудын холбооноос нэр дэвшүүлнэ, харин Монголбанкны Ерөнхийлөгч болон Сангийн сайдын хамтарсан тушаалаар томилно. (Банкуудын холбоо нь банкуудаас бүрдэх бөгөөд Монголбанк ордоггүй байна.)

ХДК-тай холбоотой бүх шийдвэр нь Үндэсний хорооны 7 гишүүний саналаар батлагдах ба аль нэг гишүүн нь ХДК-ийн үйл ажиллагааг удирдах давуу эрхгүй байна. Тэргүүн Дэд Ерөнхийлөгч нь Үндэсний хороог даргалах боловч ХДК-ийн үйл ажиллагааг дангаар удирдах эрхгүй. Мөн Монголбанкнаас бусад гурван гишүүдийг томилох хязгаарлагдмал эрхтэй байгаа нь ХДК-д хяналт болон нөлөөгүй гэдгийг илэрхийлж байна. Иймд удирдлага ХДК-ийн үйл ажиллагааг санхүүгийн тайландаа нэгтгэх шаардлагагүй гэж үзсэн болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТООЦООЛОЛ
БА ҮНДЭСЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эрх хүлээн авагч томилогдсон банкуудад тавих хяналт. Эрх хүлээн авагч томилсон банкуудад хяналтын эрхтэй эсэх болон тэдгээрийг санхүүгийн тайланд нэгтгэх шаардлагатай эсэхийг тодорхойлохдоо Монголбанк болон тухайн банкуудын хоорондын харилцааны бодит байдлын талаар үнэлэлт хийсэн. Уг үнэлгээг хийхдээ дараах байдлыг харгалзан үзсэн:

- Монголбанк нь хуулийн шаардлагын дагуу Эрх хүлээн авагч томилсон;
- Эрх хүлээн авагч нь зөвхөн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн байр сууринаас хандаж банкыг татан буулгах тодорхой зорилготой ба тухайн банкны ямар нэгэн стратегийн шийдвэрийг гаргадаггүй;
- Эрх хүлээн авагч нь хуулиар тодорхойлсон хүрээнд ажиллах ба өр барагдуулах дарааллыг мөн хуулиар тодорхойлсон. Иймд, Эрх хүлээн авагч нь Монголбанкны үр өгөөжид нөлөөлөх зорилгоор тодорхой шийдвэр гаргах эрхгүй болно;
- Эрх хүлээн авагчийн үйл ажиллагаанаас авсан үр өгөөж бага байна.

Дээрх зүйлсэд үндэслэн хэдийгээр Монголбанк нь эрх хүлээн авсан банкуудын үйл ажиллагааг удирдах эрхтэй боловч өөрийн эрхээ үр ашигт нөлөөлөх зорилгоор ашиглаж болохгүй ба тэдгээр үр ашиг нь эрх хүлээн авсан банкны гүйцэтгэлээс хамаардаггүй болно. Иймд удирдлага эдгээр банкуудыг санхүүгийн тайланд нэгтгэх шаардлага байхгүй гэж үзэж байна.

Барилгын дахин үнэлгээ. Барилга байгууламжийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад орлогод дахин үнэлсэн дүнгээр бүртгэдэг. Монголбанк 2018 онд барилгын бодит үнэ цэнийг үнэлүүлэхээр хараат бус үнэлгээний байгууллагатай гэрээ байгуулсан. Барилгуудыг тухайн хөрөнгийн шинж чанар, байршил, нөхцөл байдал гэх мэт зах зээлийн бусад хүчин зүйлүүдэд тохируулан үнийг харьцуулах замаар зах зээлийн үнэлгээний сууриар үнэлсэн. 2022 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар удирдлага нь барилгын дүнд материаллаг хэмжээний өөрчлөлт ороогүй гэж үзсэн. Энэ шийдвэр нь удирдлагын туршлагад үндэслэсэн бөгөөд Тодруулга 20-д тайлбарласан ойлголттой хамааралтай. Бодит үнэ цэнийн талаарх мэдээлэл нь зах зээлийн үнийн мэдээлэл болон мэдрэмтгий байдлын шинжилгээнд үндэслээгүй таамаглалыг ашиглан үнэлсэн бодит үнэ цэнийн талаарх мэдээллийн дэлггэрэнгүйг Тодруулга 36-аас үзнэ үү.

Эрдэнэсийн сан

Хүлээн зөвшөөрөлт. Банк нь Монгол Улсын Эрдэнэсийн сангийн тухай хуулийн дагуу Эрдэнэсийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулах цорын ганц байгууллага юм. Эрдэнэсийн сан нь түүх, соёлын болон өв уламжлагдсан үнэт зүйлс, 1925 онд гаргасан зоос зэргээс бүрдэнэ. Эдгээр зүйлсийг музейд олон нийтэд үзүүлдэг бөгөөд музейн тасалбараас олсон орлогыг ашиг, алдагдлын тайланд бусад үйл ажиллагааны орлогоор бүртгэдэг. Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар Эрдэнэсийн сангийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээ, харуул хамгаалалтын удирдлагыг хариуцдаг. Тиймээс, удирдлага Эрдэнэсийн сангийн эдийн засгийн үр өгөөж нь Монголбанкинд орж байгаа бөгөөд Эрдэнэсийн санг Монгол Улсын Эрдэнэсийн сангийн хуулиар хянадаг учир Эрдэнэсийн санг санхүүгийн байдлын тайланд хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх ёстой гэж үзэж байна. 1925 онд гаргасан зоосыг 1938 онд гүйлгээнээс татсан. Эдгээр зооснуудыг Монголбанкны өмнөх буюу эрх залгамжлагч банк гаргасан ба Засгийн газраас Эрдэнэсийн санд хандивласан гэж удирдлага үзэж байгаа учир хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх нь зөв гэж үзэж байна. Банк анх 1925 онд зэс болон мөнгөн зооснуудыг гаргасан бөгөөд дансны үнэ нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 908,476 сая төгрөг (2021: 908,476 сая төгрөг) байсан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД АШИГЛАСАН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ТООЦООЛОЛ БА ҮНДЭСЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зоос нь дараах хүчин зүйлст үндэслэн хүлээн зөвшөөрөх шалгууруудыг хангасан гэж удирдлага үзэж байна:

- 1925 онд гаргасан Монгол Улсын мөнгөн зооснуудыг Монгол Улсын Сангийн яамны шийдвэрээр 1938 онд гүйлгээнээс татсан. Эдгээр зооснуудын оронд шинэ мөнгөн тэмдэгтийг гаргасан.
- Эрдэнэсийн санг байгуулах Засгийн газрын шийдвэрийн дараа засгийн газраас эдгээр зооснуудыг Эрдэнэсийн санд хандивласан бөгөөд Монголбанк нь Эрдэнэсийн санг удирдах үүрэг хариуцлагын хүрээнд зооснуудыг хянах, хамгаалах үүрэг хүлээсэн.
- Засгийн газраас эдгээр зоосыг зарах, шилжүүлэх зөвшөөрлийг авсаны дагуу гуравдагч талд зоосийг худалдан борлуулсан, шилжүүлсэнээс үүссэн олз, гарзыг хуримтлуулах эрхтэй.
- Монголын соёлын өвийн төвөөс 1925 оны зоос нь БНМАУ байгуулагдсаны дараа гүйлгээнд гарсан анхны зоос, үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр тогтсоныг нотлох баримт, Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг төлөөлж буй чухал зүйл тул “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасны дагуу “соёлын өв”-д хамаарна гэсэн тодорхойлолтыг гаргаж өгсөн.

Хэмжилт. Эрдэнэсийн санг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний компанийн бэлтгэсэн тайланд үндэслэн бодит үнэ цэнээр хэмжин бүртгэсэн бөгөөд нэмэгдлийг үнэлгээний олон улсын стандартын дагуу бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Эрдэнэсийн сангийн үлдэгдэл дүн 1,091,554 сая төгрөг (2021: 1,115,085 сая төгрөг) байна.

Бодит үнэ цэнийн үнэлгээний шатлалаар Эрдэнэсийн сангийн зүйлс нь 3-р шатлалд ангилагддаг бөгөөд зах зээлээс шууд олж авах боломжтой мэдээлэлд үндэслээгүй таамаглалыг ашиглан үнэлсэн зүйлсийн бодит үнэ цэнийн талаар мэдээллийг Тодруулга 36-аас харна уу.

Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт. Банк 2022 онд илүү бодитой аргыг нэвтрүүлэхийн тулд санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнийг үнэлэх нягтлан бодох бүртгэлийн тооцоололдоо өөрчлөлт оруулсан. Удирдлага энэхүү үнэлгээний арга нь санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнийн талаар илүү оновчтой мэдээллийг өгнө гэж үзсэн. Гол өөрчлөлт нь өмнөх жилүүдэд үнэлгээний аргачлыг эконометриксийн арга барилд суурилдаг байсан бол одоо хүүгийн түвшний паритын онолыг ашиглаж эхэлсэн. Өөрчлөлт нь 2022 оны эхнээс үйлчилж эхэлсэн бөгөөд өмнөх тайлант хугацаануудыг тооцоололд өөрчлөлт оруулахгүй. Хэрэв энэ аргачлал 2021 оны эцсээс үйлчилж эхэлсэн бол санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнэ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 82,321 Сая төгрөгөөр буурч, хуримтлагдсан алдагдал мөн 82,321 Сая төгрөгөөр буурах байсан. Дэлгэрэнгүй мэдээллийг тодруулга 16-аас харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. ШИНЭ БОЛОН ӨӨРЧЛӨЛТ ОРСОН СТАНДАРТУУДЫН ТАЙЛБАР, ХЭРЭГЖИЛТ

Дараах нэмэлт, өөрчлөлт оруулсан стандартууд 2022 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно:

Зориулалтын дагуу ашиглахын өмнөх орлого, алдагдалтай гэрээ-гэрээ гүйцэтгэлийн өртөг, үзэл баримтлалын хамрах хүрээний тайлбар - НББОУС 16, НББОУС 37 болон СТОУС 3-т орсон хязгаарлагдмал хүрээний өөрчлөлтүүд, 2018-2020 оны жил бүр хийгддэг СТОУС-уудын сайжруулалтууд - СТОУС 1, СТОУС 9, СТОУС 16 болон НББОУС 41-д орсон нэмэлт өөрчлөлтүүд (2020 оны 5 сарын 14-ний өдөр батлагдан гарсан бөгөөд 2022 оны 1 сарын 1-ний өдөр эсвэл түүнээс хойших тайлант жилийн хугацаанд хүчин төгөлдөр болно).

- НББОУС 16-д оруулсан нэмэлт өөрчлөлт нь тухайн аж ахуйн нэгж хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахаар бэлтгэж байх үед үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтаас олсон орлогыг үндсэн хөрөнгийн өртөгөөс хасахыг хориглодог байсан. Харин одоо эдгээр бүтээгдэхүүний борлуулалтаас олсон орлогыг тэдгээрийг үйлдвэрлэлийн өртөгийн хамт ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Байгууллага эдгээр зүйлийн өртгийг хэмжихдээ НББОУС 2-ыг ашиглана. Өртөгт туршилтын үеийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал орохгүй бөгөөд учир нь хөрөнгө зориулалтын дагуу ашиглахад хараахан бэлэн болоогүй байдаг. НББОУС 16-д оруулсан нэмэлт өөрчлөлтөөр тухайн байгууллага хөрөнгийн техникийн болон биет гүйцэтгэлийг үнэлэхдээ “хөрөнгийн ажиллагаа хэвийн эсэхийг шалгадаг” гэдгийг тодруулж өгсөн. Хөрөнгийн санхүүгийн гүйцэтгэл нь энэ үнэлгээнд хамаарахгүй. Тоног төхөөрөмж нь удирдлагын зүгээс үйл ажиллагааны заасан түвшинд хүрэхээс өмнө зориулалтын дагуу хэвийн ажиллагааг хангаж болох бөгөөд, элэгдэл байгуулах боломжтой.
- НББОУС 37-ын өөрчлөлтөөр “гэрээ гүйцэтгэлийн өртөг”-ийн тодорхойлолтыг тодорхой болгосон. Нэмэлт өөрчлөлтөөр гэрээний биелэлттэй шууд холбоотой гарсан зардлууд, бусад холбоотой зардлуудын хувиарлалтыг тодорхой болгосон. Түүнчлэн гэрээнд сан байгуулахаас өмнө гэрээнд зориулагдсан хөрөнгө биш, гэрээг биелүүлэхэд ашигласан хөрөнгөд гарсан аливаа үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрөхөөр тодотгож өгсөн.
- Бизнесийн нэгдэлд хөрөнгө, өр төлбөрийн бүрэлдэхүүнийг тодорхойлохын тулд буюу СТОУС 3-т нэмэлт өөрчлөлт орсон нь 2018 оны “Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал”-д тусгагдсан. СТОУС 3-т нэмэлт өөрчлөлт оруулахаас өмнө 2001 оны “Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал”-д тусгасан. Түүнчлэн, СТОУС 3-ыг мөрдөж буй байгууллага 2018 оны “Онолын үзэл баримтлал”-аас илүү НББОУС 37 эсвэл СТОУС 21-ийг дагаж мөрдөх ёстойг тусгасан. Энэхүү шинэ үл хамаарах зүйлсийг тодотгосон өөрчлөлтүүгээр НББОУС 37 дагуу хүлээн зөвшөөрөхгүй байсан зарим өрт төлбөрийг бизнесийн нэгдлээр хүлээн зөвшөөрөх байсан. Тиймээс, бизнесийн нэгдлээр аж ахуйн нэгжийг өөртөө нэгтгэснээр эдгээр өр төлбөрүүдийг үл хүлээн зөвшөөрч эдийн засгийн ашиггүй олзыг хүлээн зөвшөөрөх шаардлагатай байсан. Бизнесийг худалдаж авсан өдөр, НББОУС 37-д зааснаар болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх шаардлаггүй болохыг тодорхой болгож өгсөн.
- СТОУС 9-д орсон нэмэлт өөрчлөлт нь санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх 10%-ын шалгуурт ямар хураамж багтах ёстойг тусгаж өгсөн. Төлбөр, хураамж нь гуравдагч талд эсвэл түрээслэгчид төлөхөөр байж болно. Нэмэлт өөрчлөлтөөр гуравдагч талд төлж буй төлбөр, хураамж нь 10%-ын шалгуурт багтахгүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. ШИНЭ БОЛОН ӨӨРЧЛӨЛТ ОРСОН СТАНДАРТУУДЫН ТАЙЛБАР, ХЭРЭГЖИЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

- СТОУС 16-г дагалдан гарсан жишээ, тайлбар №13-т түрээслүүлэгчийн зүгээс хийсэн аливаа түрээсийн сайжруулалтын төлбөртэй холбоотой тодруулагыг хассан. Нэмэлт өөрчлөлт оруулсан шалтгаан нь түрээсийн хөнгөлөлт, урамшуулалтай холбоотой аливаа төөрөгдөлийг арилгах явдал юм.
- СТОУС 1-т охин компани нь СТОУС-ыг толгой компаниасаа хожуу нэвтрүүлсэн тохиолдолд уг хугацаан дахь стандартыг дагаж мөрдөхөөс чөлөөлсөн. Охин компаныг худалдан авч нэгтгэсэнтэй холбоотой толгой компани аливаа тохируулага хийгээгүй тохиолдолд, охин компани нь нэгтгэгдсэн санхүүгийн тайланд тусгагдах хөрөнгө, өр төлбөрийг нэрлэсэн үнээр хүлээн зөвшөөрч болно. СТОУС 1-ийг нэвтрүүлж эхэлсэн хугацаанд үндэслэн толгой компанийн тайлагнасан дүнгээр хуримтлагдсан хөрвүүлэгийн зөрүүг бүртгэхийг зөвшөөрнө. СТОУС 1-д оруулсан нэмэлт өөрчлөлт нь анх удаа нэвтрүүлж буй хүмүүсийн зардлыг бууруулах зорилгоор дээрх хөнгөлөлтийг хуримтлагдсан хөрвүүлэлтийн зөрүүтэй холбоотой ойлголтоор өргөтгөсөн. СТОУС 1-ийн үл хүлээн зөвшөөрөлттэй холбоотой өөрчлөлтийг нэвтрүүлсэн хараат болон хамтарсан үйлдвэрүүдэд мөн дээрх өөрчлөлт хамаарна.
- НББОУС 41-ийн дагуу зах зээлийн үнээр үнэлэхэд аж ахуйн нэгжийг татварын зорилгоорх мөнгөн урсгалыг багтаахгүй байх шалгуурыг байхгүй болгосон. Энэ өөрчлөлт нь татварын дараах байдлаар мөнгөн урсгалыг хөнгөлөлт тооцоход чиглэгдсэн.

Нэмэлт өөрчлөлтүүдийг хэрэгжүүлсэн нь Банкны санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөөг үзүүлээгүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

6. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ШИНЭЭР БАТЛАГДСАН МЭДЭГДЭЛ

2023 оны 01 сарын 01-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд заавал мөрдөх стандартууд ба тайлбарууд шинээр батлагдаж, хэвлэн нийтлэгдсэн ба эдгээрийг Банк хугацаанаас нь өмнө хэрэгжүүлж эхлээгүй.

Шинэ стандарт, нэмэлт өөрчлөлтүүд	Дагаж мөрдөх хугацаа
СТОУС 10 болон НББОУС 28-д орсон нэмэлт өөрчлөлтүүд – Хөрөнгө оруулагч, түүний хараат компани болон хамтарсан үйлдвэрийн хооронд хөрөнгө борлуулах болон хөрөнгө оруулах (2014 оны 9 сарын 11-нд батлагдсан ба НББОУС-ын зөвлөлөөс заасан хугацаанаас хойших тайлант хугацаануудад дагаж мөрдөнө).	НББОУС3-өөс хүчин төгөлдөр хэрэгжих хугацааг тодорхойлоно.
“СТОУС 16 Түрээс”-ийн нэмэлт өөрчлөлт: Борлуулалт болон буцаан түрээслэлт дахь түрээсийн өр төлбөр (2022 оны 9 дүгээр сарын 22-нд батлагдсан, 2024 оны 1 дүгээр сарын 1-нээс хойших тайлант хугацаанд хүчин төгөлдөр болно.)	2024 оны 1 дүгээр сарын 1
СТОУС 17 “Даатгалын гэрээнүүд” (2017 оны 5 дугаар сарын 18-нд анх батлагдсан 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө.)	2023 оны 1 дүгээр сарын 1
СТОУС 17 болон СТОУС 4-г орсон нэмэлт өөрчлөлтүүд (2020 оны 6 сарын 25-ны өдөр батлагдан гарсан бөгөөд 2023 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө)	2023 оны 1 дүгээр сарын 1
СТОУС 17-д орсон нэмэлт өөрчлөлтүүд – СТОУС 17-г хэрэгжүүлэх даатгагчид зориулсан шилжилтийн сонголт (2021 оны 12 сарын 9-ний өдөр батлагдан гарсан бөгөөд 2023 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө)	2023 оны 1 дүгээр сарын 1
Нэг гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөртэй холбоотой хойшлогдсон татвар – (2021 оны 5 сарын 7-ны өдөр батлагдсан ба 2023 оны 1 сарын 1-ний өдрөөс хойших тайлант хугацаанд хүчин төгөлдөр болно).	2023 оны 1 дүгээр сарын 1
Өр төлбөрийг урт болон богино хугацаатайгаар нь ангилах, дагаж мөрдөх хугацааг хойшлуулах - НББОУС 1-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд (2020 оны 7 сарын 15-ны өдөр батлагдсан ба 2024 оны 1 сарын 1-ний өдөр болон түүнээс хойших тайлант хугацаанд дагаж мөрдөнө).	2023 оны 1 дүгээр сарын 1, НББОУС 1-д оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл хойшлуулсан
НББОУС 8 Нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг тодорхойлох тухай нэмэлт өөрчлөлт: (2021 оны 2 сарын 12-ний өдөр батлагдсан ба 2023 оны 1 сарын 1-ний өдрөөс хойших тайлант хугацаанд хүчин төгөлдөр болно).	2023 оны 1 дүгээр сарын 1
НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт болон бодит туршлагын мэдэгдэл 2: НББ-ийн бодлогын тодруулга (2021 оны 2 дугаар сарын 12-нд анх батлагдсан, 2023 оны 1 дүгээр сарын 1-ээс хойших тайлант хугацаанд хүчин төгөлдөр болно.)	2023 оны 1 дүгээр сарын 1

Дээр өөрөөр дурдаагүй бол шинэ стандартууд болон тайлбарууд санхүүгийн тайланд мэдэгдэхүйц их хэмжээний нөлөө үзүүлэхээргүй байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

7. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Сая төгрөгөөр	Тодруулга	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Бэлэн мөнгө		166,906	177,591
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө:			
- Гадаад валютын богино хугацаат хадгаламж	8	1,996,138	3,297,154
- Хугацаагүй хадгаламж	8	1,575,203	789,202
- Зээлжих тусгай эрх	8	417,069	387,299
Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан		(111)	(56)
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		4,155,205	4,651,190

Дээрх хүснэгтэд Мөнгөн Гүйлгээний Тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дүнг харуулав. Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилтын аргыг Тодруулга 35-аас үзнэ үү. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд тооцогдох санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн чанарыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доорх хүснэгтэд харуулав. Эрсдэлийн үнэлгээний системийн тайлбарыг Тодруулга 35-оос үзнэ үү.

Сая төгрөгөөр	Гадаад валютын богино хугацаат хадгаламж	Хугацаагүй хадгаламж	Зээлжих тусгай эрх	Нийт дүн
Онц сайн	1,996,138	1,575,203	417,069	3,988,410
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд багтах гадаадын байгууллагуудад байршуулсан хөрөнгө, бэлэн мөнгийг оруулахгүйгээр	1,996,138	1,575,203	417,069	3,988,410
Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан	(3)	(108)	0	(111)
Дансны үнэ	1,996,135	1,575,095	417,069	3,988,299

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

7. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд тооцогдох санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн чанарыг 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доорх хүснэгтэд харуулав.

<i>Сая төгрөгөөр</i>	Гадаад валютын богино хугацаат хадгаламж	Хугацаагүй хадгаламж	Зээлжих тусгай эрх	Нийт дүн
- Онц сайн	3,297,154	789,202	387,299	4,473,655
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд багтах гадаадын байгууллагуудад байршуулсан хөрөнгө, бэлэн мөнгийг оруулахгүйгээр	3,297,154	789,202	387,299	4,473,655
Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан	(1)	(55)	-	(56)
Дансны үнэ	3,297,153	789,147	387,299	4,473,599

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хүлээгдэж буй зээлийн алдагдал нь 1-р шатлалд багтсан. Харилцагч тал нь Төв банк эсвэл олон улсын санхүүгийн байгууллага (жишээ нь Английн Төв Банк) бол үнэлгээ хийхгүй ба тухайн улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг авсан. Бэлэн мөнгө болон зээлжих тусгай эрх нь эрсдэлийн алдагдал учруулахгүй. Тодруулга 35-аас хүлээгдэж буй зээлийн алдагдлын үнэлгээний дэлгэрэнгүйг харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

8. ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Гадаад валютын богино хугацаат хадгаламж	1,996,138	3,297,154
Хугацаагүй хадгаламж	1,575,203	789,202
Зээлжих тусгай эрх	417,069	387,299
Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	216	179
Бусад хувь хөрөнгө	13	12
Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан	(111)	(57)
Нийт гадаадын байгууллагуудад байршуулсан хөрөнгө	3,988,528	4,473,789

Богино хугацаат хадгаламж. Гадаадын төв банкууд болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан 66 хүртэлх хоног (2021: 65 хоног)-ийн хугацаатай ам.доллар, евро, английн фунт стерлинг болон юанийн богино хугацаат хадгаламж болно.

Хугацаагүй хадгаламж. Гадаадын төв банкууд болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах дансдын үлдэгдлийг илэрхийлнэ.

Зээлжих тусгай эрх (ЗТЭ). ОУВС-д Монгол Улсаас төлөх хувь хэмжээтэй холбоотой нөөцийн хөрөнгийг нөхөх зээлжих тусгай эрхийн хадгаламжийг илэрхийлнэ. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 91 сая ЗТЭ (2021 онд 97.1 сая ЗТЭ) байсан бөгөөд жилийн 2.92%-ийн хүү (2021 онд: 0.08%) тооцогддог.

Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө. Энэ нь Дэлхийн банкны гишүүнчлэлийн нөхцлийн дагуу байршуулсан хадгаламж болон түүнд оруулсан хувь хөрөнгө юм. Энэ дүн нь харгалзах өр төлбөрийн дүнтэй таарч байгаа ба хүү тооцдоггүй (Тодруулга 25). Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын Төв банк болон бусад нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудад байршуулсан тул энэ хөрөнгөд үнэ цэнийн бууралт үүсэхгүй.

Бусад хувь хөрөнгө. Энэ үлдэгдэл нь Монгол Улс олон улсын гадаад төлбөр тооцооны СВИФТ системд нэгдэн орж гишүүн улс болох үед төлсөн хураамжтай холбоотой.

Доорх хүснэгтэд ХЗА-г хэмжих зорилгоор 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх гадаадын банкуудад байршуулсан хөрөнгийн үлдэгдлийн эрсдэлийн чанарыг үнэлгээгээр харуулав. Энэ нь эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын Төв банкууд болон бусад нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудад байршуулсан байгаа тул 1-р шатлалд багтсан. Эрсдэлийн чанарыг харуулах системийн тайлбарын талаар болон ХЗА-ын хэмжилтын аргыг гадаадын банкуудад байршуулсан хөрөнгийн үлдэгдэлд хамаарах дефолтын тодорхойлолт болон эрсдэлийн томоохон өсөлтийн тодорхойлолтыг Тодруулга 35-аас үзнэ үү.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

8. ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ
(ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгтэд 2022 оны 12-р сарын 31-ний өдөр ба 2021 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн дүн болон эдгээр хөрөнгийн эрсдэлд өртөх дээд хэмжээг харуулав.

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Шатлал 1 (12 сарын ХБЭА)
Онц сайн	3,988,639	4,473,846
Нийт дансны дүн	3,988,639	4,473,846
Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан	(111)	(57)
Дансны дүн	3,988,528	4,473,789

ОУВС хувь хөрөнгө болох зээлжих тусгай эрх, Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө, бусад хувь хөрөнгүүд нь эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэгт харъяалагддаг нэр хүнд бүхий олон улсын байгууллагууд тул зээлийн эрсдэл учруулахгүй.

Эдгээр хөрөнгүүд барьцаа хөрөнгөгүй. Гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн ангилал тус бүр дэх тооцоолсон зах зээлийн үнэлгээ болон хүүгийн түвшний шинжилгээг Тодруулга 36-аас харна уу. Гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн хүүгийн түвшний шинжилгээг Тодруулга 35-аас харна уу.

Дараах хүснэгтэд эрсдэлийн алдагдлын санг тайлант хугацааны эхний болон эцсийн байдлаар харьцуулж харуулав.

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл	57	1,698
Эрсдэлийн сангийн алдагдал/(буцаалт)	54	(1,641)
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	111	

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Орон сууцны үнийг тогтворжуулах хөтөлбөр	881,212	852,376
Шатахууны үнийг тогтворжуулах хөтөлбөр	446,541	297,005
Барьцаат зээл	386,898	14,318
Алт-2 хөтөлбөр	44,892	347,640
Бусад зээл	6,080	10,840
Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан	(32,426)	(34,871)
Хорогдуулсан өртгөөрх дотоодын банкуудад олгосон зээл	1,733,197	1,487,308
ААБҮЦ-рх дотоодын банкуудад олгосон зээл	193,889	-
Нийт банкуудад олгосон зээл	1,927,086	1,487,308

Доорх хүснэгтэд 2022 оны 12 дугаар сарын 31 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр хорогдуулсан өртгөөр бүртгэх дотоодын банкуудад олгосон зээлийн үлдэгдэлд байгуулсан Эрсдэлийн алдагдлын санг харуулав.

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31			2021 оны 12 дугаар сарын 31		
	Нийт дансны дүн	Эрсдэлийн алдагдлын сан	Дансны дүн	Нийт дансны дүн	Эрсдэлийн алдагдлын сан	Дансны дүн
Орон сууцны үнийг тогтворжуулах хөтөлбөр	881,212	(22,149)	859,063	852,376	(27,310)	825,066
Шатахууны үнийг тогтворжуулах хөтөлбөр	446,541	(8,061)	438,480	297,007	(5,036)	291,971
Барьцаат зээл	386,898	(2,026)	384,872	14,316	(1,943)	12,373
Алт-2 хөтөлбөр	44,892	-	44,892	347,640	(415)	347,225
Бусад зээл	6,080	(190)	5,890	10,840	(167)	10,673
ХӨ-өөр бүртгэсэн нийт зээлийн дүн	1,765,623	(32,426)	1,733,197	1,522,179	(34,871)	1,487,308

Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл

Орон сууцны үнийг тогтворжуулах хөтөлбөр. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд дэх дотоодын банкуудад олгосон төгрөгийн зээлийн үлдэгдлийг харуулна. Банк, Засгийн газар, Монголын ипотекийн корпораци нарын хамтран байгуулсан “Ипотекийн зээлийг санхүүжүүлэх гэрээ”-нд тусгасан нөхцлийн дагуу эдгээр зээлийг олгодог бөгөөд Банк болон дотоодын банкууд зээлийн нөхцлийг тодорхойлоход ямар нэгэн эрхгүй байсан болно. “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн гэрээ”-ний дагуу дотоодын банкуудад Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүжилтийн төлбөрийн дүнд давуу эрхтэй ИЗББ авдаг. Эдгээр зээлийн хүүгийн түвшин нь жилийн 1 хувь, 2 хувь, болон 4 хувь, хугацаа нь 1-6 жил байна. Удирдлага үнэ тогтворжуулах хөтөлбөртэй холбоотой зээлийг анх хүлээн зөвшөөрөх үед ямар нэгэн алдагдлыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж дүгнэсэн. Тодруулга 4 болон 3-т удирдлагын зүгээс хийсэн холбогдох дүгнэлт болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

9. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

“Ковид-19” цар тахлын нөлөөллийн эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2020 онд батлагдсан “Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн хүрээнд зээлдэгчдийн санхүүгийн дарамтыг бууруулах зорилгоор ипотекийн зээлийн эргэн төлөлт болон хүүг 2020 оны 11 сарын 25-ны өдрөөс 2021 оны 7 сарын 1, үргэлжлүүлэн 2022 оны 12 сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд зогсоосон. Үүнийг зээлийн гэрээний өөрчлөлт гэж тооцох ба удирдлага холбогдох зээлийн төлбөр зогсоосон хугацаанд хүлээх алдагдлыг тооцоолж, санхүүгийн тайланд материаллаг нөлөөгүй гэж үзсэн. Тиймээс, зээлийн дүнд тохируулга хийгээгүй болно.

Шатахууны үнийг тогтворжуулах хөтөлбөр. “Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль батлагдсантай холбогдуулан Банк нь 2021 оны 12 дугаар сараас эхлэн шатахууны үнийг тогтворжуулах зорилгын хүрээнд банкуудад зээлийг олгож эхэлсэн. Зээлийн хүү нь бодлогын хүүтэй тэнцүү бөгөөд 1-2 жилийн хугацаатай. Санхүүжилтийн гэрээний дагуу зээлийн төлөх хугацаа болмогц тухайн дотоодын банкны Монголбанкин дахь данснаас хөрөнгийг шууд татах эрхтэй.

Барьцаат зээлүүд. “Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн хүрээнд Монгол Улсын хөгжлийн банкны японы иенээр гаргасан Самурай бондын гадаад валютын ханшийн эрсдлийг бууруулах зорилгоор 2022 оны 12 дугаар сарын 1-нд Хөгжлийн банкинд олгосон зээл багтдаг. Энэхүү зээлийн барьцаа хөрөнгө нь Засгийн газрын үнэт цаас бөгөөд жилийн 12 хувийн хүүтэй, 1 жилийн хугацаатай.

Алт - 2 хөтөлбөр. УИХ-ын 2020 оны 4-р сарын 29-ний өдрийн 32 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 5-р сарын 6-ны өдрийн 167 дугаар тогтоолоор “Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хүрээнд гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор дотоодын алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд арилжааны банкуудаар дамжуулан санхүүжүүлж олгож эхэлсэн. Зээл нь жилийн 9%-13% (2021: 6% ба 9%) хүүтэй, 2-3 жилийн хугацаатай (2021: 2-3 жил). Санхүүжилтийн гэрээнд заасны дагуу Монголбанк дахь банкуудын харилцах данснаас эргэн төлөлтийг төлөвлөсөн хугацаанд татан авах эрхтэй.

Бусад зээл

Капитал банкны эрх хүлээн авагчаас авах авлага-д Клирингийн авлага 5,215 сая төгрөг (2021: 5,215 сая төгрөг), Заавал байлгах нөөцийн торгууль 4,602 сая төгрөг (2021: 4,602 сая төгрөг), ХДК-тай холбоотой авлага 44,663 сая төгрөг (2021: 44,663 сая төгрөг), Банкны эзэмшиж байгаа өрийн бичгийн торгуулийн хүүгийн авлагын 791 сая төгрөг (2021: 791 сая төгрөг) тус тус бүртгэгдсэн. Банкны эзэмшиж байгаа өрийн бичигт тооцсон торгуулийн хүү болох 791 сая төгрөгийг 2021 онд тэнцлээс хассан. 2022 онд Капитал банкинд олгосон орон сууцны ипотекийн зээлийн 12,891 сая төгрөгийн үлдэгдлийг дотоодын банкинд олгосон зээлээс бусад хөрөнгөд дахин ангилсан. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Капитал банкны эрх хүлээн авагчаас авах авлагад 100% сан байгуулсан (2021: 100% сан байгуулсан).

Капитал банкны эрх хүлээн авагчаас авах өрийн бичгийн авлага. Капитал банкны эрх хүлээн авагчаас гаргасан ААБҮЦ-ээр бүртгэгдэх өрийн бичгийг Банк 2020 оны 6 дугаар сард доор дурдсан дотоодын компаниудын нэгээс хэсэгчилсэн төлбөрт суутган авсан. 2022 болон 2021 онуудад 13,131 сая төгрөг болон 4,901 сая төгрөг тус тус эргэн төлөгдсөн. Өрийн бичгийн үлдэгдэл 2022 онд 26,909 сая төгрөг (2021: 40,040 сая төгрөг) эргэн төлөгдсөний дараа СТОУС 9-ийн дагуу Шатлал 3-д ангилан үнэлсэн бөгөөд дефолт/төлбөр төлөгдөхгүй болох магадлал 100% болон алдагдал хүлээх магадлал нь 75% байна.

Гадаадын санхүүгийн байгууллагаас авах авлага. Eastern Gates буюу гадаадын санхүүгийн байгууллага нь үйл ажиллагаагаа зогсоосон учир авлага эргэн төлөгдөхгүй гэж үзэн Банк үлдсэн авлагын дүнд ЭАС-г 100% байгуулсан. 2022 оны 12 дугаар сарын 31-ний болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банк эдгээр хөрөнгийг Шатлал 3-д ангилан үнэлсэн бөгөөд дефолт/төлбөр төлөгдөхгүй болох магадлал болон алдагдал хүлээх магадлал нь 100% байна.

Өрийн бичгийн авлага. Өрийн бичгийн авлага нь хорогдуулсан өртгийн ангиллын зөвхөн хүү болон үндсэн төлөлт (“ЗХҮТ”)-ийн шалгуурыг хангахгүй байсан тул ААБҮЦ-ээр бүртгэгдсэн. Тодруулга 4-ийг харна уу. Өрийн бичгийн авлага дотоодын компаниудаас гаргасан доорх өрийн бичгүүдийг илэрхийлэх бөгөөд Банк 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 46,875 сая төгрөг (2021: 255,500 сая төгрөг)-ийн нэрлэсэн үнэ бүхий дотоодын нэг компани (2021: дотоодын хоёр компани)-ийн гаргасан өрийн бичгүүдийг эзэмшиж байна.

Эдгээр өрийн бичгүүд нь 9 жил (2021: 5 жил болон 9 жил)-ийн хугацаатай бөгөөд холбогдох гэрээнд тодорхойлж заасан хүүгийн хувь хэмжээгээр тооцож хүүгийн орлогыг олдог. Өрийн бичгийн хугацааг нэг жилээр 2021 болон 2022 онд тус тус сунгасан.

ХХБ-ны гаргасан 166,467 сая төгрөгийн өрийн бичгийн хугацаа 2022 оны 6 дугаар сард дууссан. УИХ-ын 2017 оны тогтоолыг үндэслэн Засгийн газрын 2022 оны тогтоолын дагуу Эрдэнэт үйлдвэр ХХК болон Монголросцветмент ХХК-ийн 49%-ийн хувьцааны төлбөрийг барагдуулах зорилгоор ХХБ-ны өрийн бичгийг суутган тооцсон.

Өрийн бичгийн ихэнх гэрээнүүд нь тодорхой нөхцөл хангагдсан тохиолдолд хүүгийн түвшин буурах нөхцөлтэйгээр баталгаажсан, тухайлбал гэрээний анхны хүүгийн түвшин өндөр байхаар заасан боловч тодорхой нөхцөл байдал хангагдсан тохиолдолд зээлийн хүүг зах зээлийн хүүгээс доогуур түвшин хүртэл бууруулах боломжтой. Банкны удирдлага болон хууль эрх зүйн газар эдгээр гүйлгээнүүд нь Төв банкны болон Монгол Улсын бусад холбогдох хуулийн заалтуудыг зөрчөөгүй гэж үзсэн.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

19. БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал. Доорх хүснэгтэд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн үнэлгээг харууллаа.

Сая төгрөгөөр	Шатлал 1 (12-сарын ХБЭА)	Шатлал 3 (үнэ цэнэ буурсан бол хугацааны туршид дахь ХБЭА)	Нийт дүн
Бусад санхүүгийн хөрөнгө			
-Хангалттай	1,777	-	1,777
-Тусгайлан хянах	-	6,274	6,274
-Дефолт	-	416,923	416,923
Хорогдуулсан өртгөөрх нийт дүн	1,777	423,197	424,974
Хасах нь: Эрсдэлийн алдагдлын сан	(213)	(352,202)	(352,415)
Хорогдуулсан өртгөөрх нийт дансны дүн	1,564	70,995	72,559

Доорх хүснэгтэд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн үнэлгээг харууллаа.

Сая төгрөгөөр	Шатлал 1 (12 сарын ХБЭА)	Шатлал 2 (хугацааны туршид дахь ХБЭА, ЗЭМӨ)	Шатлал 3 (хугацааны туршид дахь ХБЭА, үнэ цэнэ буурсан)	Нийт дүн
Бусад санхүүгийн хөрөнгө				
Хангалттай	-	4,231	-	4,231
Тусгайлан хянах	909	-	-	909
Дефолт	-	-	387,264	387,264
Хорогдуулсан өртгөөрх нийт дүн	909	4,231	387,264	392,404
Эрсдэлийн алдагдлын сан	(281)	(1,454)	(317,128)	(318,863)
Хорогдуулсан өртгөөрх нийт дансны дүн	628	2,777	70,136	73,541

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

19. БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бусад санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгөнд байгуулсан үнэ цэнийн бууралтын сангийн 2022 оны өөрчлөлт, хөдөлгөөнийг доорх хүснэгтэд харууллаа:

	Шатлал 1		Шатлал 2		Шатлал 3			Нийт дүн			
	Бусад санхүүгийн хөрөнгө (Шатлал 1)	Бусад ААН-ээс авах авлага (Шатлал 1)	Бусад санхүүгийн хөрөнгө (Шатлал 2)	Анод банкнаас авах авлага (Шатлал 3)	Бусад санхүүгийн хөрөнгө (Шатлал 3)	Капитал банкны ЭХА-аас авах өрийн бичгийн авлага (Шатлал 3)	ХДК-аас авах авлага (Шатлал 3)		Капитал банкны ЭХА-аас авах авлага (Шатлал 3)	Санхүүгийн бус байгууллагаас авах авлага (Шатлал 3)	Бусад ААН-ээс авах авлага (Шатлал 3)
<i>Сая төгрөгөөр</i>											
Нийт дансны үнэ											
2022 оны 1 дүгээр сарын 1	909	-	4,231	58,534	-	40,040	148,958	54,480	24,906	60,346	392,404
<i>Эрсдэлийн алдагдлын сангийн хөдөлгөөн:</i>											
<i>Шилжилт:</i>											
- Үнэ цэнийн бууралт (Шатлал 1, Шатлал 2-оос Шатлал 3-руу)	-	-	(4,231)	-	4,231	-	-	-	-	-	-
Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	84	1,002	-	-	17,110	-	-	12,840	-	-	31,036
Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(167)	-	-	(273)	-	(13,131)	(1,665)	-	-	-	(15,236)
Эрсдэлийн алдагдлын сангийн нийт өөрчлөлт	(83)	1,002	(4,231)	(273)	21,341	(13,131)	(1,665)	12,840	-	-	15,800
<i>Эрсдэлийн алдагдлын сангаас бусад хөдөлгөөн:</i>											
Валютын ханшийн болон бусад хөдөлгөөн:	-	-	-	-	-	-	-	-	5,208	11,562	16,770
2022 оны 12 дугаар сарын 31	826	1,002	-	58,261	21,341	26,909	147,293	67,320	30,114	71,908	424,974
<i>Эрсдэлийн алдагдлын сан</i>											
2022 оны 1 дүгээр сарын 1	281	-	1,454	58,534	-	27,480	91,382	54,480	24,906	60,346	318,863
<i>Эрсдэлийн алдагдлын сангийн хөдөлгөөн:</i>											
<i>Шилжилт:</i>											
- 12 сарын ХЗА (Шатлал 2, Шатлал 3-аас Шатлал 1-рүү)	-	-	(1,454)	-	1,454	-	-	-	-	-	-
Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	52	64	-	-	14,181	-	-	12,840	-	-	27,137
Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	(10)	-	-	(273)	-	(8,860)	(1,089)	-	-	-	(10,232)
ХБЭА-ын хэмжилтийн загварт орсон өөрчлөлт	(123)	-	-	-	-	-	-	-	-	-	(123)
Эрсдэлийн алдагдлын сангийн нийт өөрчлөлт	(81)	64	(1,454)	(273)	15,635	(8,860)	(1,089)	12,840	-	-	16,782
<i>Тайлант хугацаан дахь эрсдэлийн алдагдлын сангаас бусад хөдөлгөөн:</i>											
Гадаад валютын ханшийн болон бусад хөдөлгөөн	-	-	-	-	-	-	-	-	5,208	11,562	16,770
2022 оны 12 дугаар сарын 31	200	64	-	58,261	15,635	18,620	90,293	67,320	30,114	71,908	352,415

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

19. БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бусад санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгөнд байгуулсан үнэ цэнийн бууралтын сангийн 2021 оны өөрчлөлт, хөдөлгөөнийг доорх хүснэгтэд харууллаа:

	Шатлал 1		Шатлал 2		Шатлал 3			Нийт дүн	
	Бусад санхүүгийн хөрөнгө (Шатлал 1)	Бусад санхүүгийн хөрөнгө (Шатлал 2)	Анод банкнаас авах авлага (Шатлал 3)	Капитал банкны ЭХА-аас авах өрийн бичгийн авлага (Шатлал 3)	ХДК-аас авах авлага (шатлал 3)	Капитал банкны ЭХА-аас авах авлага (шатлал 3)	Гадаадын санхүүгийн байгууллагаас авах авлага (Шатлал 3)		Бусад ААН-ээс авах авлага (Шатлал 3)
<i>Сая төгрөгөөр</i>									
Нийт дансны үнэ									
2021 оны 1 дүгээр сарын 1	-	-	58,839	47,732	148,958	55,271	24,912	60,360	396,072
<i>Эрсдэлийн алдагдлын сангийн хөдөлгөөн:</i>									
Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	-	-	(305)	(547)	-	-	-	-	(852)
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	909	4,231	-	-	-	-	-	-	5,140
Бусад хөдөлгөөн	-	-	-	(4,354)	-	-	-	-	(4,354)
Эрсдэлийн алдагдлын сангийн нийт өөрчлөлт	909	4,231	(305)	(4,901)	-	-	-	-	(66)
<i>Эрсдэлийн алдагдлын сангаас бусад хөдөлгөөн:</i>									
Валютын ханшийн болон бусад хөдөлгөөн	-	-	-	-	-	-	(6)	(14)	(20)
Данснаас хассан	-	-	-	(2,791)	-	(791)	-	-	(3,582)
2021 оны 12 дугаар сарын 31	909	4,231	58,534	40,040	148,958	54,480	24,906	60,346	392,404
Эрсдэлийн алдагдлын сан									
2021 оны 1 дүгээр сарын 1	-	-	58,839	29,474	94,728	36,814	24,912	60,360	305,127
<i>Эрсдэлийн алдагдлын сангийн хөдөлгөөн:</i>									
Шинээр бүртгэсэн болон худалдан авсан	281	1,454	-	-	-	-	-	-	1,735
ХБЭА-ын хэмжилтийн загварт орсон өөрчлөлт	-	-	-	-	-	18,457	-	-	18,457
Тайлант хугацаанд бүртгэлээс хассан	-	-	(305)	(547)	(3,346)	-	-	-	(4,198)
Хуримтлагдсан хүүгийн өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-	-
Эрсдэлийн алдагдлын сангийн нийт өөрчлөлт	281	1,454	(305)	(547)	(3,346)	18,457	-	-	15,994
<i>Эрсдэлийн алдагдлын сангаас бусад хөдөлгөөн:</i>									
Валютын ханшийн болон бусад хөдөлгөөн	-	-	-	-	-	-	-	-	-
Данснаас хассан	-	-	-	(1,447)	-	(791)	(6)	(14)	(2,258)
2021 оны 12 дугаар сарын 31	281	1,454	58,534	27,480	91,382	54,480	24,906	60,346	318,863

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

20. ҮНДСЭН БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ

<i>Сая төгрөгөөр</i>	Барилга байгууламж	Дуусаагүй барилга	Тавилга, компьютер төхөөрөмж	Нийт биет хөрөнгө	Биет бус хөрөнгө	Нийт дүн
Өртөг /2021.01.01/ Хуримтлагдсан элэгдэл/ хорогдуулалт	134,908 (45,163)	2,348 -	25,291 (7,945)	162,547 (53,108)	7,587 (1,824)	170,134 (54,932)
2021 оны 1 сарын 1-нээрх дансны дүн	89,745	2,348	17,346	109,439	5,763	115,202
Нэмэгдсэн Хасагдсан -өртгөөр Акталсан -өртгөөр Элэгдэл/хорогдуулалт Хасагдсан -хуримтлагдсан элэгдэл Акталсан -хуримтлагдсан элэгдэл	2,525 (930) - (2,380) 110 -	4,020 (4,849) - - -	6,202 (1,513) (29) (4,231) 1,498 26	12,747 (7,292) (29) (6,611) 1,608 26	1,330 (17) - (955) 15 -	14,077 (7,309) (29) (7,566) 1,623 26
2021 оны 12 сарын 31 байдлаарх өртөг эсвэл үнэлгээ Хуримтлагдсан элэгдэл/ хорогдуулалт	136,503 (47,433)	1,519 -	29,951 (10,652)	167,973 (58,085)	8,900 (2,764)	176,873 (60,849)
2021 оны 12 сарын 31-нээрх дансны дүн	89,070	1,519	19,299	109,888	6,136	116,024
Нэмэгдсэн Хасагдсан -өртгөөр Шүлжүүлсэн Акталсан -өртгөөр Элэгдэл/хорогдуулалт Хасагдсан -хуримтлагдсан элэгдэл Акталсан -хуримтлагдсан элэгдэл	9,946 (7,449) - - (2,415) - -	1,750 - (1,698) - -	1,349 (3,241) 1,698 (7) (4,668) 3,241 6	13,045 (10,690) - (7) (7,083) 3,241 6	1,435 (2) - - (1,360) 2 -	14,480 (10,692) - (7) (8,443) 3,243 6
2022 оны 12 сарын 31 байдлаарх өртөг эсвэл үнэлгээ Хуримтлагдсан элэгдэл/ хорогдуулалт	139,000 (49,848)	1,571 -	29,750 (12,073)	170,321 (61,921)	10,334 (4,122)	180,655 (66,043)
2022 оны 12 сарын 31-нээрх дансны дүн	89,152	1,571	17,677	108,400	6,212	114,612

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

20. ҮНДСЭН БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банк барилга, байгууламжаа 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн бодит үнэ цэнээр дахин үнэлүүлсэн. Үнэлгээг хараат бус, үнэлгээний байгууллага болох “Гроут Финанс Аудит” ХХК-аар үнэлүүлсэн бөгөөд үнэлгээчид нь ижил байршилд ижил ангиллын хөрөнгийг үнэлсэн туршлагатай, мэргэшсэн үнэлгээчний тусгай зөвшөөрөлтэй байсан. Үнэлгээнд ашигласан үнэлгээний суурь нь зах зээлийн үнэ, орлуулалтын өртөг болон орлогын хандлагын арга байсан. Бодит үнэ цэнийг тохирсон үнэлгээний аргыг ашиглан тооцоолсон ба дараах таамаглалуудыг ашигласан: Ихэнх барилга, байгууламжийн хувьд зах зээл дээр харьцуулж болох хөрөнгийн мэдээлэл хангалттай байсан учир зах зээлийн хандлагын арга илүү тохиромжтой байсан.

Орон нутгийн хоёр салбарын хувьд тухайн байршилд ижил төрлийн болон харьцуулж болох хөрөнгийн мэдээлэл хангалттай байгаагүй бөгөөд байгаа мэдээлэл нь их зөрүүтэй байсан учир өртгийн хандлагын арга болон орлогын хандлагын аргыг ашигласан. Зах зээлийн олж авах боломжтой мэдээлэл болон мэдрэмжийн шинжилгээнд үндэслэгдээгүй таамаглалыг ашиглан үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн талаарх мэдээллийг Тодруулга 36-д тусгасан болно.

Өнөөгийн эдийн засгийн нөхцөлийн дагуу Банкны барилгын үнэ ерөнхийдөө буурах хандлага ажиглагдахгүй байгаа бөгөөд барилга байгууламжийн боломжит үнийн өсөлт нь (үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж, биет бус хөрөнгө болон өөрийн хөрөнгө өсгөхөд хүргэх) санхүүгийн мэдээлэл хэрэглэгчдийн санхүүгийн тайлангийн шийдвэр гаргалтад материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж удирдлагын зүгээс үзэж байна.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар барилга байгууламжийн дансны дүн нь 58,821 сая төгрөг (2021: 58,739 сая төгрөг) байна. Барилга, байгууламжийн дансны үнийг доор харууллаа:

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Санхүүгийн байдлын тайланд барилга, байгууламжийн дахин үнэлэгдсэн дүн	89,152	89,070
Өмчийн тайлан дахь дахин үнэлгээний нөөц	(30,331)	(30,331)
Барилгын өртгөөс хасах нь хуримтлагдсан элэгдлийн дүн	58,821	58,739

2022 оны 12 дугаар сарын 31 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлийн барьцаанд тавьсан үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгө байхгүй байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

21. ГҮЙЛГЭЭНД ГАРГАСАН БЭЛЭН МӨНГӨ

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Гүйлгээнд гаргасан цаасан тэмдэгт	1,119,484	1,116,970
Тоолж шалгаагүй цаасан тэмдэгт	(30,264)	(11,403)
Гүйлгээнд гаргасан зоосон тэмдэгт	23	22
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	1,089,243	1,105,589

2022 оны 12 дугаар сарын 31 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө:

<i>Сая төгрөгөөр</i>	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Гүйлгээнд гаргасан цаасан тэмдэгт	1,116,970	1,341,093	(1,338,579)	1,119,484
Гүйлгээнд гаргасан зоосон тэмдэгт	22	1	-	23
Тоолж шалгаагүй мөнгөн тэмдэгт	(11,403)	(1,352,563)	1,333,702	(30,264)
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	1,105,589	(11,469)	(4,877)	1,089,243

Тоолж шалгаагүй цаасан мөнгөн тэмдэгт нь Банк хадгалж хамгаалах зорилгоор дотоодын банкуудаас шилжүүлсэн илүүдэл цаасан мөнгөн тэмдэгтүүд ба банкуудын хүсэлтээр буцааж шилжүүлнэ.

22. ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААС

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Төв банкны үнэт цаас	5,641,303	8,622,184
Нийт төв банкны үнэт цаас	5,641,303	8,622,184

Энэхүү үлдэгдэл нь дотоодын банкуудад гаргасан үнэт цаасыг илэрхийлнэ. Эдгээр үнэт цаасны дуусах хугацаа нь 28-196 хоног (2021: 28 хоног) бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар жилийн 12 хувь ба 13 хувь (2021: жилийн 6 хувь)-ийн хүүтэй байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

23. ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨРӨНГӨ

Сая төгрөгөөр	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Сангийн яамны харилцах данс	2,476,629	1,079,704
Сангийн яаманд төлөх зээлийн өр төлбөр:		
- Олон Улсын Валютын Сан (ОУВС)	633,613	618,751
- Азийн Хөгжлийн Банк (АХБ)	47,781	32,267
- Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)	2,915	3,394
Нийт засгийн газрын хөрөнгө	3,160,938	1,734,116

Сангийн яамны харилцах дансууд. Эдгээр харилцах дансууд нь Монголбанкинд байршуулсан Сангийн яамны харилцах дансууд юм. Нэг данснаас бусад нь хүүгүй бөгөөд тус харилцах дансны үлдэгдэл болох 463,398 сая төгрөг (2021: 363,217 сая төгрөг)-т овернайт хадгаламжийн жилийн хүүгийн 50 хувийн хувьсах (2021: овернайт хадгаламжийн жилийн хүүгийн 50 хувь) хүүг тооцон олгож байна.

Олон улсын байгууллагуудаас авсан зээлтэй холбоотой Сангийн яаманд төлөх өр төлбөр. Эдгээр өр төлбөрүүд нь Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Валютын Сан (ОУВС), Азийн Хөгжлийн Банктай (АХБ) болон Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)-тай байгуулсан зээлийн гэрээтэй холбоотой. Энэхүү зээлд Монгол Улсын Сангийн яам санхүүгийн зуучлагчаар, Монголбанк нь энэ төслийг хэрэгжүүлэгчээр ажиллаж байна.

Олон Улсын Валютын Сан (ОУВС). ОУВС-гийн Удирдах Зөвлөл Монгол Улсын эдийн засгийн реформыг дэмжих зорилгоор Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөр (ӨСХ)-ийн хүрээнд 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр гурван жилийн хугацаатай 314.5 сая ЗТЭ-ийн дүн бүхий өргөтгөсөн санхүүжилтийг баталсан. ӨСХ нь ОУВС-гаас Монгол Улсад ӨСХ-ийн хүрээнд олгосон жилийн 1.53-1.59 хувийн хүүтэй зээл юм.

Санхүүжилтийг 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Монголбанк болон Сангийн яамны хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичигт үндэслэн Банкны холбогдох харилцах дансыг нээж түүнд шилжүүлсэн. Эдгээр зээл нь Сангийн яамны өр төлбөр болно. Сангийн яам нь Монгол Улсын санхүүгийн зуучлагч болохын хувьд ОУВС-гийн ӨСХ-ийн хүрээнд олгосон зээлийн эргэн төлөлттэй холбоотой өрийн бичгийг гаргасан бөгөөд дээрх зээлийн эргэн төлөлтийн үүргийг ОУВС-гийн өмнө хүлээнэ.

Зээл болон түүний эргэн төлөлт нь Зээлжих Тусгай Эрх (“ЗТЭ”)-ээр илэрхийлэгдсэн бөгөөд Банк нь Сангийн яамны өмнөөс ОУВС-д хуваарийн дагуу эргэн төлөлтийг 2026 оны дотор төлнө. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ӨСХ-ийн хүрээнд Сангийн яаманд төлөх өр төлбөр нь 138.2 сая ЗТЭ буюу 633,613 сая төгрөг (2021: 155.2 сая ЗТЭ буюу 618,751 сая төгрөг) байсан.

Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны зээл нь Төлбөрийн системийн шинэчлэл төслийн хүрээнд авсан бөгөөд жилийн 1 хувь болон 2,5 хувийн хүүтэй, 16 жилийн хугацаатай болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

23. ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Сангийн яам нь Засгийн газрын төлөөлөн хэрэгжүүлэгч агентын үүрэг гүйцэтгэдэг учир Банк нь ОУВС болон АХБ-ны төлбөр тооцоонд шууд хариуцлага хүлээхгүй. Сангийн яам ба Банк хоорондын гэрээний дагуу Банк нь Сангийн яамнаас ОУВС, болон АХБ-ны гэрээний ижил нөхцөлтэйгээр эдгээр зээлүүдийг авсан байна. Банк нь эдгээр зээлийн хөрөнгийг өөрийн дансанд байршуулж буйн хувьд, ОУВС, АХБ болон Сангийн яамны хоорондын төлбөр тооцоог зохицуулах үүрэгтэй. Эдгээр сангаас дотоодын банкуудад олгосон зээлийг Тодруулга 9-д тусгасан болно. Сангийн яаманд төлөх эдгээр өр төлбөрүүд болон дотоодын банкуудад олгосон зээлтэй холбоотой удирдлагын дүгнэлтийг Тодруулга 4-өөс харна уу.

Олон улсын хөгжлийн ассоциациас Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн яамны авсан зээл нь хувийн хэвшлийг дэмжих төсөл болон санхүүгийн чадавхыг дээшлүүлэх төслүүдэд зориулагдсан бөгөөд Сангийн яамнаас жилийн 1-3 хувийн хүүтэй, 14-15 жилийн хугацаатай зээлүүд болно.

2022 оны 12 дугаар сарын 31 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тусгай нөхцөлийн (ковенант) зөрчил байхгүй болно.

24. ДОТООДЫН БАНКУУДЫН ХӨРӨНГӨ

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Харилцах дансууд:		
- валютаар	3,325,275	2,148,313
- төгрөгөөр	2,369,872	1,817,495
Гадаад валютын хадгаламж	1,674,025	-
Төгрөгийн овернайт хадгаламж	766,462	506,069
Нийт дотоодын банкуудын хөрөнгө	8,135,634	4,471,877

Корреспондент дансууд. Корреспондент дансууд нь дотоодын банкуудаас заавал байлгах нөөц болон бусад төрлийн хадгаламжаас бүрдэх бөгөөд заавал байлгах нөөцийг банкуудын хадгаламж эзэмшигчиддээ төлөх өр төлбөрийн тодорхой хувиар тооцогддог. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар корреспондент дансууд дахь заавал байлгах нөөцийн үлдэгдэл нь 2,327,260 сая төгрөг (2021: 1,558,226 сая төгрөг) байна.

Гадаад валютын хадгаламж. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх дотоодын банкуудын валютын хадгаламж нь 486 сая ам.доллар (2021: 0 ам.доллар)-ын үлдэгдэлтэй бөгөөд жилийн 4-5 хувийн хүүтэй, 7 хоногоос 91 хоногийн хугацаатай хадгаламж болно.

Овернайт хадгаламж. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх төгрөгийн овернайт хадгаламж нь дотоодын банкуудын байршуулсан жилийн 11 хувийн хүүтэй, 3 хоногийн хугацаатай (2021: жилийн 5 хувийн хүүтэй 4 хоногийн хугацаатай) хадгаламж болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

25. ГАДААД ӨР ТӨЛБӨР

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
ХАБ-тай байгуулсан хэлэлцээр	6,035,307	5,463,574
ОУВС-гийн ЗТЭ-ийн хуваарилалт	541,183	470,698
ОУТТБанкны санхүүжилт	148,186	122,512
Эм Ю ЭФ Жи банкнаас авсан зээл	147,665	284,905
Дэлхийн банкны харилцах данс	2,080	1,620
Дэлхийн банкинд оруулсан хөрөнгө	216	179
АХБ-ны харилцах данс	61	61
ОУХА-д оруулсан хувь хөрөнгө	39	39
Каргилл ОУСБ-аас авсан зээл	-	570,417
Нийт гадаад өр төлбөр	6,874,737	6,914,005

Доорх хүснэгтэд гадаад өр төлбөрийн хөдөлгөөнийг 2022 он болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар харууллаа:

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
1 сарын 1-нээрх санхүүжилтийн үйл ажиллагаатай холбоотой өр төлбөр	6,914,005	5,789,508
<i>Мөнгөн гүйлгээ:</i>		
Мөнгөн гүйлгээний орох урсгал	1,519,584	2,237,184
Мөнгөн гүйлгээний гарах урсгал	(2,500,693)	(1,231,344)
Төлсөн хүү	(296,459)	(263,496)
<i>Мөнгөн бус гүйлгээ:</i>		
Хуримтлуулсан хүү	90,614	98,471
Ханшийн тэгшитгэл	1,147,686	283,682
12 сарын 31-нээрх санхүүжилтийн үйл ажиллагаатай холбоотой өр төлбөр	6,874,737	6,914,005

Хятадын Ардын банктай байгуулсан своп хэлцэл. Энэхүү данс нь Хятадын ардын банктай хийсэн своп хэлцлийн дагуу авсан 12 сарын (2021: 7-8 сар) хугацаатай юанийн санхүүжилт бөгөөд Банк дотоодын банкуудыг юаниар санхүүжүүлэхэд ашигладаг. Хүү нь Шанхай-Интер банкны санал болгосон хүүгийн түвшин дээр 200 суурь нэгж нэмсэнтэй тэнцүү хүүтэй.

Каргилл ОУСБ-аас авсан зээл. Дотоодоос худалдан авах алтны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, ААН-ийн үйл ажиллагааг дэмжих, ГВУН-ыг нэмэгдүүлэх зорилгоор АНУ-ын Каргилл ОУСБ-тай 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр 200 сая ам долларын экспортын санхүүжилтийн гэрээг байгуулсан. Тус хэлцэл нь 1 жилийн хугацаатай ба жилийн 2.75 хувь дээр нэмэх нь 3 сарын хугацаатай ЛИБОР хүү байсан бөгөөд 2022 онд бүрэн төлөгдсөн (2021: 200.12 сая ам.доллар буюу 570,417 сая төгрөг).

Зээлжих тусгай эрхийн хуваарилалт ОУВС-ийн гишүүн орнуудад ОУВС-д оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн ЗТЭ-ийг хуваарилсан. Энэ хуваарилалт нь ОУВС-д төлөх өр төлбөрийг илэрхийлэх ба Тодруулга 8-д энэ талаар тодруулсан. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хуваарилалтын цэвэр хуримтлал нь 541,183 сая төгрөг буюу 118,053 сая ЗТЭ (2021: 470,698 сая төгрөг буюу 118,053 сая ЗТЭ)-тэй тэнцүү байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

25. ГАДААД ӨР ТӨЛБӨР (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эм Ю Эф Жи банкнаас авсан зээл. Алт олборлогч аж ахуй нэгжүүдэд санхүүжилт олгох замаар алт цэвэршүүлэгч Самсунг компанид цэвэршүүлэх Монголбанкны алтны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдөр 10,800 сая иенийн санхүүжилтын гэрээг Эм Ю Эф Жи Банк болон Сумитомо Мицуй Банк Корпорацитай байгуулсан. Гэрээнд ногдох ачилтын хэмжээ нь зээлийн эргэн төлөлтийн хэмжээнээс их байх бөгөөд үлдснийг нь Банкны дансанд шилжүүлнэ. Ачуулахаар тохиролцсон хэмжээнээс дутууг ачуулвал дутсан унц бүрт хүү төлөхөөр гэрээлэгдсэн. Тус зээлийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Лондонгийн үнэт металын зах зээлийн унци тутамд тогтоосон ханшийг ашиглан Самсунг компанид 7 удаагийн алтны ачилтаар бүрэн төлсөн.

Алт олборлогч аж ахуй нэгжүүдэд санхүүжилт олгох замаар алт цэвэршүүлэгч Самсунг компанид цэвэршүүлэх Монголбанкны алтны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр 100 сая ам долларын санхүүжилтын гэрээг Эм Ю Эф Жи банктай байгуулсан. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Эм Ю ЭФ Жи банкнаас авсан зээлийн үлдэгдэл нь 42.8 сая ам.доллар буюу 147,665 сая төгрөг, жилийн 3.2 хувийн хүүтэй, 1.6 жилийн хугацаатай (2021: 100.01 сая ам.доллар буюу 284,905 сая төгрөг) байна.

Олон Улсын Төлбөр Тооцооны банк (ОУТТБанк). ГВУН-ыг нэмэгдүүлэх зорилгоор ОУТТБанктай 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр гэрээ байгуулж, 43 сая ам.долларын санхүүжилт авсан бөгөөд энэ нь барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийн 86 хувиас хэтрэхгүй байхаар тусгасан (Тодруулга 11). 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ОУТТБанкны 43 сая ам.долларын санхүүжилт нь 148,186 сая төгрөгтэй тэнцэж байсан бөгөөд энэ нь 7 хоногийн хугацаатай, жилийн 5.45 хувийн хүүгийн нөхцөлтэй байхаар тусгасан байна (2021: 43.01 сая ам.доллар буюу 122,512 сая төгрөг, жилийн 1.05 хувийн хүүтэй, 1 жилийн хугацаатай).

Дэлхийн банк ба Олон улсын хөгжлийн агентлагт оруулсан хувь хөрөнгө Энэ үлдэгдэл нь Дэлхийн банк болон Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)-г оруулсан хувь хөрөнгө юм. 2022 оны 12 дугаар сарын 31 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тусгай нөхцөлийн (ковенант) зөрчил байхгүй болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

26. БУЦААН ХУДАЛДАН АВАХ ХЭЛЦЭЛ

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Олон Улсын Төлбөр Тооцооны банк (ОУТТБанк)	95,857	-
Нийт буцаан худалдан авах хэлцэл	95,857	-

Банк 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр Олон Улсын Төлбөр Тооцооны банк (ОУТТБанк)-тай 27.8 сая ам.долларын АНУ-ын засгийн газрын бондыг барьцаалсан буцаан худалдан авах хэлцэл байгуулсан (Тодруулга 10). Тус хэлцлийг ам.доллароор байгуулсан бөгөөд жилийн 2.12 хувийн хүүтэй, 1 жилийн хугацаатай.

27. БУСАД ӨР ТӨЛБӨР

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Бусад санхүүгийн өр төлбөр		
Банкнаас бусад санхүүгийн байгууллагаас байршуулсан хөрөнгө	296,100	505,468
Бусад өглөг	96,836	159,703
Бусад санхүүгийн бус өр төлбөр		
Нийгмийн хөгжлийн сан	3,265	2,060
Нийт бусад өр төлбөр	396,201	667,231

Банкнаас бусад санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж. Банкнаас бусад санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж нь засгийн газрын байгууллагууд болох Үнэт цаасны төлбөр тооцооны төв, Хадгаламжийн даатгалын корпорацийн хадгаламжуудаас бүрдэнэ.

Нийгмийн хөгжлийн сан. Дотоод журмын дагуу Банк тодорхой хэмжээний санхүүжилтийг ажилтнуудын ажлын болон амьжиргааны нөхцөлийг сайжруулах зорилгоор Нийгмийн хөгжлийн санд хуваарилдаг. Энэхүү санхүүжилт нь ажилтнуудад тэтгэмж, тусламж олгох, ажилтны нийгмийн байдлыг хангах үүднээс орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай үед нь санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд зориулагдсан байна. Удирдлага санхүүгийн тайлант жилийн эцсээр Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан хөрөнгийг хүлээгдэж буй үүргээ биелүүлэхэд хангалттай гэж үзсэн.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

28. ДҮРМИЙН САН БОЛОН БУСАД НӨӨЦ САН

Сая төгрөгөөр	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Дүрмийн сан	60,000	60,000

Бусад нөөцийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

Сая төгрөгөөр	БДОБҮЦ-ээрх хөрөнгө оруулалтын үнэт цаасны дахин үнэлгээний сан	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний сан	Мөнгөжсөн алт болон гадаад валютын дахин үнэлгээний сан	Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний сан	Нийт дүн
2021 оны 1 дүгээр сарын 1	162,747	30,331	703,420	1,061,764	1,958,082
БДОБҮЦ-ээр илэрхийлэгдэх өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтийн гарз	(25,570)	-		-	(25,570)
ХБЭА-ын өөрчлөлт-БҮЦ-ийн өөрчлөлт	5,534				5,534
Борлуулах үед ашиг алдагдалд шилжүүлсэн	1,335	-	-	-	1,335
Бусад нөөцөөс хуримтлагдсан алдагдалд шилжүүлсэн		-	(12,432)	-	(12,432)
2021 оны 12 дугаар сарын 31	144,046	30,331	690,988	1,061,764	1,927,129
БДОБҮЦ-ээр илэрхийлэгдэх өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтийн гарз	(120,195)	-	-	-	(120,195)
ХБЭА-ын өөрчлөлт-БҮЦ-ийн өөрчлөлт	9,540	-	-	-	9,540
Борлуулах үед ашиг алдагдалд шилжүүлсэн	(64,153)	-	-	-	(64,153)
Бусад нөөцөөс хуримтлагдсан алдагдалд шилжүүлсэн	-	-	145,321	-	145,321
2022 оны 12 дугаар сарын 31	(30,762)	30,331	836,309	1,061,764	1,897,642

БДОБҮЦ-ээр илэрхийлэгдэх өрийн үнэт цаасны дахин үнэлгээний нөөц сан. Энэхүү санд бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх бодит үнэ цэнээр бүртгэгдэх хөрөнгө оруулалтын үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бүртгэнэ. ХБЭА-ын өөрчлөлт, хөдөлгөөнд БДОБҮЦ-ээр бүртгэгдэх засгийн газрын үнэт цаас болон өрийн үнэт цаасны ХБЭА-ыг бүртгэдэг.

Барилгын дахин үнэлгээний нөөц сан. Банкны барилгын дахин үнэлгээнээс үүссэн нэмэгдлийг өөрийн хөрөнгийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний санд бүртгэсэн. Дэлгэрэнгүйг Тодруулга 20-оос харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

28. ДҮРМИЙН САН БОЛОН БУСАД НӨӨЦ САН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Мөнгөжссөн алт болон гадаад валютын дахин үнэлгээний нөөц сан. Энэхүү санд гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн ханшийн тэгшитгэл болон мөнгөжссөн алтны бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн хэрэгжээгүй олз, гарзыг бүртгэдэг.

Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний нөөц сан. Энэ санд Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний нэмэгдлийг бүртгэсэн. Дэлгэрэнгүйг Тодруулга 4-өөс харна уу.

29. ХҮҮГИЙН ОРЛОГО БА ЗАРДАЛ

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого		
ХӨ-өөр бүртгэгдэх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	142,681	159,487
ХӨ-өөр бүртгэгдэх буцаан худалдан авах хэлцэл	105,696	52,854
ХӨ-өөр бүртгэгдэх дотоодын банкуудад олгосон зээл	71,515	15,005
БДОБҮЦ-ээр бүртгэгдэх өрийн хэрэгсэл	38,383	25,263
ХӨ-өөр бүртгэгдэх гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	37,274	18,690
БДОБҮЦ-ээр бүртгэгдэх Засгийн газрын үнэт цаас	5,028	14,928
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон нийт хүүгийн орлого	400,577	286,227
Бусад адилтгах орлого		
ААБҮЦ-ээр бүртгэгдэх бусад хөрөнгө	10,243	22,165
ААБҮЦ-ээр бүртгэгдэх банкуудад олгосон зээл	292	-
Нийт бусад адилтгах орлого	10,535	22,165
Нийт хүүгийн орлого	411,112	308,393
Хүүгийн зардал		
Төв банкны үнэт цаас	(461,441)	(532,079)
Гадаад өр төлбөр	(288,602)	(262,992)
Дотоодын банкуудын заавал байлгах нөөцийн биелэлтэд олгосон урамшуулал	(57,109)	(23,954)
Засгийн газарт төлөх өр төлбөр	(54,468)	(36,384)
Бусад хүүгийн зардал	(34,546)	(21,486)
Дотоодын банкуудын хөрөнгө	(34,003)	(9,367)
Буцаан худалдан авах хэлцэл	(185)	-
Нийт хүүгийн зардал	(930,354)	(886,262)
Цэвэр хүүгийн зардал	(519,242)	(577,869)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

30. АЛТ, ҮНЭТ МЕТАЛЫН АРИЛЖААНЫ ОЛЗ/ГАРЗ

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Мөнгөжсөн алт, үнэт метал борлуулсаны хэрэгжсэн олз/(гарз)	153,849	(6,018)
Мөнгөжсөн алт, үнэт метал цэвэршүүлэлтийн зөрүүнээс үүссэн гарз	(83,043)	(60,961)
Мөнгөжсөн алт, үнэт металын арилжааны гарз	(8,739)	(1,559)
Алт, үнэт металын арилжааны олз/(гарз)	62,067	(68,538)

31. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Шимтгэлийн орлого	31,956	22,536
Үйл ажиллагааны бусад орлого	3,786	1,935
Дотоодын банкуудын торгуулийн орлого	2,168	4,231
Үндсэн хөрөнгийн түрээсийн орлого	1,195	666
Нийт үйл ажиллагааны бусад орлого	39,105	29,368

Банкны салбарыг зохицуулах үүрэгтэй Банк нь өөрийн тавьсан шаардлагын дагуу арилжааны банкуудаас заавал байлгах нөөцийг авч байршуулдаг. Заавал байлгах нөөцийн хэмжээг 14 хоногоор тооцдог (Тодруулга 24-ийг харна уу). 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар заавал байлгах нөөц хангаагүй банкуудаас авсан торгуулийн орлогын дүн 2,168 сая төгрөг (2021: 4,231 сая төгрөг) байсан.

Шимтгэлийн орлогод их болон бага дүнтэй банк хоорондын гүйлгээ, картын болон гадаад валютын гүйлгээний шимтгэлийн орлого багтана. Үйл ажиллагааны бусад орлого гэдэгт мөнгөн тэмдэгт болон зоос борлуулсаны орлого орно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

32. ЗАХИРГААНЫ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ЗАРДАЛ

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Цалингийн зардал	29,650	25,472
Мөнгөн тэмдэгт хэвлүүлэх зардал	13,657	9,928
Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн элэгдэл/хорогдуулалт	8,442	7,568
Алт тээвэрлэх хүргүүлэх зардал	3,476	5,434
Харилцаа холбоо, ашиглалтын зардал	2,517	2,366
Байгууламж, зохион байгуулалтын төлбөр	2,294	3,275
Харуул хамгаалалтын зардал	1,767	1,766
Лиценз ба техник хангамжийн зардал	1,566	884
Тээврийн болон албан томилолтын зардал	1,194	565
Гишүүнчлэл болон мэргэжлийн үйлчилгээний зардал	996	783
Зар сурталчилгааны зардал	815	690
Үндсэн хөрөнгийн засварын зардал	442	756
Сургалтын зардал	274	112
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	-	1,217
Бусад зардал	5,975	5,201
Нийт захиргааны ба үйл ажиллагааны бусад зардал	73,065	66,017

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

33. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Шийдэгдээгүй хэрэг. 2022 оны 12 дугаар сарын 31-ний болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ямар нэгэн материаллаг гарз учруулах, нэхэмжлэгчээр дуудагдсан шүүн таслах хуулийн хэргийн талаар удирдлагад мэдээлэл байхгүй байна. Иймд удирдлага ямар нэг эрсдэлийн санг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзсэн.

Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг. Монгол Улсын Засгийн газар, түүний харьяа байгууллагуудын хүсэлтээр Банк нь Монгол Улсын хувьд чухал ач холбогдол бүхий салбарт (бараа үйлчилгээ экспортлох гэх мэт) зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг хүлээдэг. Эдгээр хэрэгслүүдийн гол зорилго нь Засгийн газар болон холбогдох талуудыг шаардлагатай эх үүсвэрээр хангахад оршино.

Гаргасан аккредитивүүд нь зээл болон аккредитивийн хэмжээнээс ашиглагдаагүй үлдсэн хэсгийг илэрхийлнэ. Доорх мэдээллийг харна уу. Монголбанк ийм зээлтэй холбоотой төлбөрийн үүргийн хувьд уг зээлээс ашиглагдаагүй үлдсэн хэмжээгээр алдагдал хүлээх эрсдэлтэй юм.

Гэвч ихэнх зээл нь эрсдэл багатай харилцагчдад олгогддог тул энэхүү болзошгүй алдагдлын хэмжээ нь нийт ашиглагдаагүй байгаа төлбөрийн үүргийн хэмжээнээс бага байна. Зээлтэй холбоотой төлбөрийн хариуцлагын хэмжээг дор харуулав:

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Болзошгүй өр төлбөр		
Импортын аккредитивүүд	19,143	22,475
Төлбөрийн үүрэг хариуцлага		
Хятадын ардын банкинд өгөх ашиглаагүй зээлийн шугамын эх үүсвэр	6,000,000	6,000,000
Нийт зээлтэй холбоотой үүрэг хариуцлага	6,019,143	6,022,475

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлтэй холбоотой үүрэг хариуцлагын зээлийн эрсдэлийн үнэлгээ нь дараах байдалтай байна:

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31 Шатлал 1 (12 сарын ХБЭА)	2021 оны 12 дугаар сарын 31 Шатлал 1 (12 сарын ХБЭА)
Импортын аккредитив		
- Хангалттай	19,143	22,475
Хүлээн зөвшөөрөөгүй нийт дүн	19,143	22,475
Төлбөрийн үүрэг хариуцлага		
- Онц сайн	6,000,000	6,000,000
Хүлээн зөвшөөрөөгүй нийт дүн	6,019,143	6,022,475

ХБЭА-ыг тооцоолох зорилгоор болзошгүй өр төлбөр болон үүргийн үлдэгдэл дүнг Шатлал 1-д ангилсан бөгөөд тооцоолсон дүн нь бага дүнтэй байсан учир Банк 2022 он болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ЭАС-г байгуулаагүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

33. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Импортын аккредитивүүд. Импортын аккредитив нь Монгол Улсын Засгийн газарт импортын гэрээ хэлцэлтэй холбоотойгоор олгогдоно. Импортын аккредитивээр Монголбанк Монгол Улсын Засгийн газрын эсвэл төрийн байгууллагуудын өмнөөс тэдгээрт болон Засгийн газрын хүсэлтээр бусад байгууллагуудад үйлчилгээ үзүүлсэн ба бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн гадаадын хуулийн этгээдүүдэд төлбөр шилжүүлэх үүрэг хүлээнэ.

Хятадын Ардын банктай байгуулсан своп хэлэлцээр. Банк нь Хятадын Ардын банктай “Хятадын юань/Монгол төгрөг солилцох своп хэлэлцээр”-ийн гэрээг 2011 оны 5 дугаар сард байгуулсан ба гэрээг 2014 оны 8 дугаар сард, 2017 оны 7 дугаар сард болон 2020 оны 7 дугаар сард шинэчлэн баталсан.

Төв банкууд энэ мөнгийг хоёр улсын хоорондох худалдааг санхүүжүүлэх, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор богино хугацаанд хөрвөх чадварыг хангах болон гэрээгээр тохирсон бусад зорилгоор ашиглах боломжтой. Гэрээний дагуу Хятадын Ардын банк болон Банк нь хятадын юаниар төгрөг, монгол төгрөгөөр юань худалдан авах, худалдах хэлцлийг цаашид тодорхой хугацаанд хийх боломжтой. Гэрээнд зааснаар энэхүү хөрөнгийн ашиглах хугацаа 12 сар хүртэл байна. Хөрөнгө ашиглах зөвшөөрлийг нэг тал нь нөгөө талаас авах ёстой ба тухайн ашиглах хөрөнгийн дээд хэмжээ нь Банкны хувьд гэрээний дүн болох 15,000 сая юань (2021: 15,000 сая юань), Хятадын Ардын банкны хувьд 6,000,000 Сая төгрөгөөр (2021: 6,000,000 сая төгрөг) хязгаарлагдана.

Хөрөнгийг ашиглах банк хөрөнгийн хэмжээндээ гэрээнд заагдсан хүүг тооцон төлөх үүрэгтэй. Монголбанк юань ашигласан тохиолдолд, хүүгийн түвшин нь Шанхай-Интер банкны санал болгосон түвшин (“ШИБОР”) дээр 200 үндсэн оноо нэмсэнтэй тэнцэх ба ашиглах хугацааны турш тооцно. Харин Хятадын Ардын банк төгрөг ашигласан тохиолдолд, харгалзах ашиглалтын хугацаанд хүүгийн түвшин нь банк хоорондын төгрөгийн жигнэсэн дундаж хүүгийн түвшинтэй тэнцүү байна.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар зээлтэй холбоотой үүрэг нь ашиглагдсан дүн болох 12,000 сая юань буюу 5,944,800 сая төгрөг (2021: 12,000 сая юань буюу 5,365,800 сая төгрөг) ба ашиглагдаагүй дүн болох 3,000 сая юань буюу 1,486,200 сая төгрөг (2021: 3,000 сая юань буюу 1,341,450 сая төгрөг) байна.

Банкны удирдлага аккредитивийн гэрээ болон зээлийн шугамтай холбоотой өр төлбөрийн бодит үнэ цэнийг материаллаг бус гэж үзсэн. Эдгээр ашиглагдаагүй зээлийн шугам болон аккредитив нь санхүүжилт хийгдэлгүйгээр хугацаа дуусах боломжтой. ХБЭА-ыг зээлийн хөрвүүлгийн факторын аргаар үнэлсэн бөгөөд эдгээр үлдэгдлийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь материаллаг бус дүнтэй байна. Иймд Банк ямар нэг эрсдэлийн алдагдлын санг зээлийн эдгээр үүрэг хариуцлагын хувьд хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзсэн.

Хөрөнгийн үүрэг. Банк 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4,740 сая төгрөг (2021: 2,029 сая төгрөг)-ийн үүрэг хүлээсэн ба энэ нь *Эрдэнэсийн санд зориулж барих Чингис Хааны алтан бүрмэл хөшөөний гүйцэтгэлийн ажилтай холбоотой.* (2021: шинэ датабазын худалдан авалттай холбоотой үүрэг).

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Холбоотой талууд гэдэг ерөнхий ойлголтод, хэрэв талууд нь нэг төвлөрсөн удирдлагатай, эсвэл талуудын аль нэг нь нөгөө байгууллагуудынхаа хувьд нөлөө бүхий санхүү болон үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргах түвшинд хянаж байхыг хамруулан ойлгоно. Холбоотой талуудын боломжит бүх хамаарлыг авч үзэхдээ зөвхөн хуулийн хэлбэрийг биш хамаарлын мөн чанарыг чухалчлан анхаарна. 2022 оны 12 дугаар сарын 31 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх холбоотой талуудыг тодруулсан:

- Монгол Улсын Засгийн газард Монгол Улсын Сангийн Яам болон Засгийн газрын агентлагууд багтах ба удирдлагыг Монгол Улсын Засгийн газраас томилон ажиллуулдаг.
- Төрийн Банк – УИХ-аас удирдлагыг томилох бөгөөд Монгол Улсын Сангийн Яам бүрэн эзэмшдэг.
- Хөгжлийн Банк – Монгол Улсын Засгийн газраас удирдлагыг томилох бөгөөд төрийн өмчит байгууллага.
- Хадгаламжийн Даатгалын Корпораци (ХДК), Засгийн газар бүрэн эзэмшдэг бөгөөд ХДК-ийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгчөөр ахлуулсан Үндэсний хорооны долоон гишүүн тус бүрийн саналаар батлах ёстой. Удирдлагын ХДК-д тавьж байгаа хяналтын талаарх дүгнэлтийг Тодруулга 4-өөс харна уу.
- Эрдэнэс Монгол ХХК нь 100 хувь төрийн өмчит байгууллага.
- Эрдэнэс Таван Толгой ХК –ийн 81.5 хувийг Эрдэнэс Монгол ХХК эзэмшидэг, болон
- Нийслэлийн Орон Сууцны Корпораци нь 100 хувь төрийн өмчит байгууллага.

НББОУС 24-ийн чөлөөлөгдөх хэсгийг Банк засгийн газрын харьяа холбоотой талуудын тайландаа ашигласан. Иймээс, талуудын материаллаг бус ажил гүйлгээг энэхүү санхүүгийн тайландаа толилууллаагүй болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Холбоотой талуудын орлого, зардлын үзүүлэлтүүд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах байдалтай байсан:

Сая төгрөгөөр	асгийн Газар	Төрийн Банк	Монгол Улсын Хөгжлийн Банк	ХДК	Эрдэнэс Монгол ХХК	Эрдэнэс Таван Толгой ХК	НОСК	Нийт дүн
Хүүгийн орлого	5,028	2,287	3,893	315	46,791	31,100	6,233	95,647
Хүүгийн зардал	(54,468)	(74,470)	(76,945)	(14,534)	-	-	-	(220,417)
Хураамж шимтгэлийн орлого	1,434	3,214	-	-	-	-	-	4,648
БДОБҮЦ-ээрх засгийн газрын үнэт цаасыг данснаас хассаны олз	64,153	-	-	-	-	-	-	64,153
Засгийн газраас авах авлагад тооцсон гарз-анхны хүлээн зөвшөөрөлтөөр	(133,482)	-	-	-	-	-	-	(133,482)
Засгийн газраас авах авлагад тооцсон үнэ цэнийн бууралтын гарз	(9,333)	-	-	-	-	-	-	(9,333)
Нийт	126,668	(68,969)	(73,052)	(14,219)	46,791	31,100	6,233	(198,785)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2022 оны 12 дугаар сарын 31-нд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын дараах холбоотой талуудын дансны үлдэгдэл доорх байдалтай байсан:

Сая төгрөгөөр	Тодруулга	Засгийн газар	Төрийн Банк	Монгол Улсын Хөгжлийн Банк	Хадгаламжийн Даатгалын Корпораци	Эрдэнэс Монгол ХХК	Эрдэнэс Таван Толгой ХК	Нийслэлийн Орон Сууцны Корпораци	Нийт дүн
Засгийн газрын үнэт цаас	17	38,646	-	-	-	-	-	-	38,646
Засгийн газраас авах авлага	18	514,942	-	-	-	-	-	-	514,942
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	13	-	253,049	-	-	-	-	-	253,049
Дотоодын банкуудад олгосон зээл	9	-	81,207	381,945	-	-	-	-	463,152
Санхүүгийн бус байгууллагуудад олгосон зээл	19	-	-	-	57,000	-	-	-	57,000
Эрдэнэс Бонд	11	-	-	-	-	646,299	-	-	646,299
Эрдэнэс Таван Толгой Бонд	11	-	-	-	-	-	301,247	-	301,247
Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бонд	11	-	-	-	-	-	-	151,056	151,056
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	16	-	(13,452)	698	-	-	-	-	(12,754)
Төв банкны үнэт цаас	22	-	(767,904)	-	-	-	-	-	(767,904)
Дотоодын банкуудын хөрөнгө	24	-	(675,857)	(57,400)	-	-	-	-	(733,257)
Банк бус санхүүгийн байгууллагуудын хөрөнгө	27	-	-	-	(231,016)	-	-	-	(231,016)
Засгийн газарт төлөх өр төлбөр	23	(3,160,938)	-	-	-	-	-	-	(3,160,938)
Бусад өглөг	27	(21,217)	-	-	-	-	-	-	(21,217)
Нийт дүн		(2,647,710)	(1,122,957)	325,243	(174,016)	646,299	301,247	151,056	(2,520,838)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Холбоотой талуудын орлого, зардлын үзүүлэлтүүд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах байдалтай байсан:

<i>Сая төгрөгөөр</i>	Засгийн газар	Төрийн Банк	Монгол Улсын Хөгжлийн Банк	Хадгаламжийн Даатгалын Корпораци	Эрдэнэс Монгол ХХК	Эрдэнэс Таван Толгой ХК	Нийслэлийн Орон Сууцны Корпораци	Нийт дүн
Хүүгийн орлого	14,928	1,070	6,744	320	44,036	15,716	5,054	87,868
Хүүгийн зарлага	(36,384)	(64,149)	(5,541)	(11,695)	-	-	-	(117,769)
Шимтгэлийн орлого	1,253	182	-	-	-	-	-	1,435
Нийт	(20,203)	(62,897)	1,203	(11,375)	44,036	15,716	5,054	(28,466)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын дараах холбоотой талуудын дансны үлдэгдэл доорх байдалтай байсан:

Сая төгрөгөөр	Тол-руулга	Засгийн газар	Төрийн Банк	МУ-ын Хөгжлийн Банк	Хадгаламжийн Даатгалын Корпораци	Эрдэнэс Монгол ХХК	Эрдэнэс Таван Толгой ХК	Нийслэлийн Орон Сууцны Корпораци	Нийт дүн
ЗГҮЦ	17	231,778	-	-	-	-	-	-	231,778
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	13	-	87,863	-	-	-	-	-	87,863
Дотоодын банкинд олгосон зээл	9	-	83,330	-	-	-	-	-	83,330
Санхүүгийн бус байгууллагад олгосон зээл	19	-	-	-	57,576	-	-	-	57,576
Эрдэнэс Бонд	11	-	-	-	-	715,209	-	-	715,209
Эрдэнэс Таван Толгой Бонд	11	-	-	-	-	-	297,659	-	297,659
Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бонд	11	-	-	-	-	-	-	100,487	100,487
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	16	-	(2,857)	(131,191)	-	-	-	-	(134,048)
Төв Банкны үнэт цаас	22	-	(855,367)	-	-	-	-	-	(855,367)
Дотоодын банкуудын хөрөнгө	24	-	(200,562)	(263,639)	-	-	-	-	(464,201)
Санхүүгийн бус байгууллагын хадгаламж	27	-	-	-	(495,649)	-	-	-	(495,649)
Засгийн газрын хөрөнгө	23	(1,734,116)	-	-	-	-	-	-	(1,734,116)
Бусад өглөг	27	(10,725)	-	-	-	-	-	-	(10,725)
Нийт		(1,513,063)	(887,593)	(394,830)	(438,073)	715,209	297,659	100,487	(2,120,204)

Банкны ердийн үйл ажиллагааны үр дүнд дээр дурдсан үлдэгдэл дүнгүүд үүссэн болно. Удирдлага холбоотой талуудын ажил гүйлгээнд анх хүлээн зөвшөөрөлтийн олз/гарз бүртгэх шаардлагатай эсэхийг авч үзсэн. Энэ үнэлэлтийг хийхдээ удирдлага нь дээрх ажил гүйлгээ нь анхдагч зах зээлд хийгдсэн гэдгийг анхаарч үзсэн. Дэлгэрэнгүйг Тодруулга 4-өөс харна уу.

Холбоотой талд олгосон урвуу буцаан худалдан авах хэлцэл, Эрдэнэс бонд, Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондоос бусад тайлант жилийн эцсээрх үлдэгдэл дүнгүүд барьцаагаар хангагдаагүй болно. Холбоотой талуудын өглөг эсвэл авлагад зориулж ямар нэгэн хүлээн авсан эсвэл гаргасан баталгаа байхгүй.

Импортын аккредитивүүд. Холбоотой талуудад 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 19,143 сая төгрөг (2021: 22,475 сая төгрөг)-ийн импортын аккредитив гарган өгч үүрэг хүлээсэн. Тодруулга 33-аас дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банкны Удирдлагын Зөвлөлийн үндсэн удирдлагын цалин хөлс болон бусад тэтгэмжийн талаарх мэдээллийг дор толиллуулаа:

<i>Сая төгрөгөөр</i>	2022 оны 12 дугаар сарын 31	2021 оны 12 дугаар сарын 31
Цалин хөлс	995	764
<i>Нийгмийн болон тэтгэврийн санд төлсөн шимтгэл</i>	140	113
Тэтгэмжүүд	125	110
Бусад олговор	30	5
Нийт дүн	1,290	992

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Монголбанкны үйл ажиллагаа нь эрсдэлтэй байдаг ба эдгээрийг зөв тодорхойлж, хэмжиж, хянаж байснаар эрсдэлийг хязгаарлаж, бусад хяналтын бодлогоор удирддаг. Эрсдэлийг зохистой удирдах нь банкуудын үйл ажиллагааг хэвийн явуулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, тухайлбал инфляцыг зохистой түвшинд барих мөнгөний зөв бодлого явуулахад чухал ач холбогдолтой. Эрсдэлүүд нь гол зорилгодоо хүрэх чадварыг хязгаарлах үр дагавартай байж болно. Ийм өндөр үр дагавартай эрсдэл илрэх бөгөөд гадаад валютын хөрвүүлгээс хүлээх санхүүгийн гэнэтийн алдагдал нь үүний нэг жишээ болно. Санхүүгийн алдагдал нь бүхий л төрлийн санхүүгийн эрсдэлээс хамааралтай үүсдэг.

Санхүүгийн талаас нь авч үзвэл зээлийн, хөрвөх чадварын болон зах зээлийн эрсдэлд өртөж болно. Үүнээс гадна үйл ажиллагааны, нэр хүндийн болон хууль, эрх зүйн зэрэг эрсдэлд өртөж болно. Одоогийн эрсдэлийн удирдлага нь төвлөрсөн бус ба газар, хэлтэс тус бүр тэдгээрийн үйл ажиллагаанд учирсан аливаа эрсдэлээс сэргийлэх бодлогыг баримталдаг. Монгол Улсын Төв банк учраас түүний эрсдэлүүд онцгой байдаг ба тэдгээр эрсдэлүүдийг стратеги төлөвлөлтийн үйл явцаар дамжуулан хянаж, илрүүлж байдаг. Үүнээс гадна эрсдэлийн хяналтын стратегийг боловсруулах ба зарчим, хүрээ, бодлого хязгааруудыг хэрэгжүүлэх ажлыг ерөнхийлөн хариуцах “Эрсдэлийн хороо”-г байгуулах боломжийг идэвхтэй судалж байна. Хороо нь эрсдэлийн стратеги боловсруулах болон журам, цар хүрээ, бодлого, хязгаарлалтыг хэрэгжүүлэх, эрсдэлийг хянах, удирдахтай холбоотой холбогдох шийдвэрүүдийг гаргах ерөнхий үүрэг хариуцлагатай байх ёстой.

Одоогоор Хөрөнгө оруулалтын хороо нь эрсдэлийн стратегийг боловсруулж, шаардлагатай хязгаарыг тогтоох үүрэгтэй бол Эрсдэлийн удирдлагын алба болон Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар нь үүнтэй холбоотой зарчмууд, үйлчлэх хүрээ, бодлого, хязгаарыг хэрэгжүүлдэг.

Эрсдэлийн удирдлагын бүтэц. Захирлуудын зөвлөл нь эрсдэлийг хянах ба энэ асуудлаар эцсийн хариуцлагыг хүлээнэ. Гэхдээ эрсдэлийг тодорхойлох, удирдах, хянах үүрэг бүхий бие даасан нэгжүүд байдаг.

Захирлуудын Зөвлөл. Захирлуудын Зөвлөл ерөнхий эрсдэлийн удирдлага болон эрсдэлийн стратеги, бодлогыг батлахаас гадна эрсдэлтэй холбоотой асуудлаар Ерөнхийлөгч, Тэргүүн Дэд Ерөнхийлөгчид зөвлөмж өгдөг.

Хяналтын Зөвлөл. Хяналтын зөвлөл нь дотоод бүтэц, зохион байгуулалтад харьяалагддаггүй бөгөөд бие даасан хяналт тавьж, дотоод ерөнхий эрсдэлийн үйл явцыг нь хянах үүрэгтэй.

Хөрөнгө оруулалтын хороо. Хөрөнгө оруулалтын хороо нь санхүүгийн эрсдэлийг удирдах үүрэгтэй хамгийн үндсэн нэгж бөгөөд Захирлуудын Зөвлөл болон Ерөнхийлөгчид санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлогын талаар зөвлөмж өгдөг. Хөрөнгө оруулалтын хорооны бүрэлдэхүүнд Тэргүүн Дэд Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Эрсдэлийн удирдлагын албаны захирал, Мөнгөний бодлогын газрын захирал, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал нар багтдаг.

Хөрөнгө оруулалтын хороо нь тайлант оны “Жилийн хөрөнгө оруулалтын бодлого”-ыг хэлэлцэж, зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинг тодорхойлдог. Энэхүү зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинд үндэслэн улсын гадаад валютын нөөцийн бүтцийг гарган Ерөнхийлөгчид танилцуулж, батлуулдаг байна. Үүнд гадаад валютын нөөцийн бүтэц, түүний зохистой хэлбэлзэл, хөрөнгийн хуваарилалт, хөрөнгө оруулалтын хугацаа, боломжит хэрэгсэл, харилцагч байгууллагад тавьсан хязгаарлалт зэргийг тусгасан байдаг.

35. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Мөн Ерөнхийлөгч гадаад валютын нөөцтэй холбоотой харилцагч банк санхүүгийн байгууллагуудын жагсаалт, тэдгээрт тавих лимитийг улирал тутамд батлах ба энэ нь гадаад валют, зээл, хөрвөх чадвар, хүүгийн түвшний эрсдэлийг удирдах гол арга хэрэгсэл болдог.

Санхүүгийн эрсдэлүүдээс нийт хөрөнгийн гадаад валютын нөөцийн харьцаанаас үүдэн гадаад валютын нөөцийн эрсдэл нь хамгийн чухал байдаг. Тиймээс Хөрөнгө оруулалтын хороо болон холбогдох газруудын үйл ажиллагаа нь гадаад валютын улсын нөөцтэй холбоотой эрсдэлийг удирдахад түлхүү чиглэгдсэн байна. Хөрөнгө оруулалтын хорооны өөр нэгэн үүрэг бол Эрсдэлийн удирдлагын алба, бусад холбогдох газруудад хяналт тавих, санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн эрсдэлийн бодлогын хэрэгжилт нийцтэй байгаа эсэхийг хянах үүрэгтэй байдаг. Санхүүгийн эрсдэлийг удирдах зорилгоор ашигласан аргуудыг доор толилуулав.

Эрсдэлийн удирдлагын алба. Эрсдэлийн удирдлагын алба (“ЭУА”) нь гадаад валютын улсын нөөцтэй холбоотой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, бусад эрсдэлтэй холбоотой үйл ажиллагаанд хараат бус хяналт тавих үүрэгтэй. Мөн гадаад валютын нөөцийн удирдлага, эрсдэлийн бодлого боловсруулах, бенчмаркийн биелэлтийг хангуулах, лимитийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг эрхэлдэг. Мөн түүнчлэн ЭУА гадаад валютын улсын нөөцийн эрсдэл, бүртгэлийн системтэй холбоотой эрсдэлийн арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлэх үүрэгтэй.

Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын журамд зааснаар, нөөцийн удирдлагын үндсэн зорилго нь төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, төгрөгийн ханшийг тогтвортой байлгахад оршино. Гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж буй гол зорилго нь:

- Мөнгөний бодлогыг дэмжих;
- Валютын зах зээлийн ханшийн хэт хэлбэлзлийг зохицуулах;
- Засгийн газрын гадаад валютын өр төлбөрт баталгаа гаргах;
- Улс орны хэмжээнд тохиолдсон гамшиг болон онцгой байдлын үед мөнгөний эх үүсвэр болгон хэрэглэх зэрэг болно.

Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийг бодлоготойгоор удирдаж, хянах нь гадаад валютын нөөцийн эрсдэлийн удирдлагын дээрх зорилгод дэмжлэг болно. Гадаад эрсдэлийг хянах зорилгоор гадаад активыг сонгох, хуваарилах стратегийг тодорхойлдог. Үүнд нөөцийг байршуулах чөлөөтэй хөрвөх валютыг сонгох, валютуудын бэлэн байлгах хэмжээ, ямар бүтэцтэй байлгах, хөрвөх чадварын болон аюулгүй байлгах шаардлагуудад нийцүүлж хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийг ямар түвшинд барих, хүүгийн эрсдэлийг хянахын тулд хэрэгслүүдийн хугацаа ямар байх ёстой гэх мэт параметруудийг тогтоох зэрэг багтдаг.

Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар. Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар нь хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхой нэгжүүдээр дамжуулан хэрэгжүүлэх үүрэгтэй. Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал нь хөрөнгийн багцын бүтэц буюу хөрөнгийн бүрдэл хэсэг, хэрэгслүүд, харилцагч талууд, дуусгавар хугацаа, гадаад валютын нөөцийн хязгаарлалт зэргийг удирдах, хянах үүрэгтэй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дотоод аудитын газар. Зорилгод хүрэх, бодлого, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд үйл ажиллагаан дахь эрсдэлийн удирдлагын тогтолцоо зохистой, үр ашигтай эсэхийг шалгах, үнэлэх нь Дотоод аудитын газар (ДАГ)-ын эрхэм зорилго юм. ДАГ нь Монголбанкны мөрдөж буй бодлого, холбогдох горимуудын төлөвлөлт болон зохион байгуулалт, зохицуулалт, хэрэгжилттэй холбоотой үйл ажиллагааны, эрсдэлийн удирдлагад хяналт тавих санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийн иж бүрэн байдал, аюулгүй байдлыг хангах зэрэг үйл ажиллагаанууд нь холбогдох хууль, журамд нийцэж буй эсэхийг шалгах үүрэг бүхий нэгж болно. ДАГ нь эрсдэлийн ерөнхий болон тусгайлсан үнэлгээг хийдэг. Эрсдэлийн зэрэгт нь тааруулан дотоод боловсон хүчний нөөцийг зохистой хуваарилах үүднээс урт хугацааны болон жилийн төлөвлөгөөг боловсруулж эрсдэлийн ерөнхий үнэлгээг тодорхойлж гүйцэтгэдэг бол эрсдэлийн тусгайлсан үнэлгээг тодорхой нэг асуудал үүссэн цаг тухай бүр хийдэг. ДАГ нь Монголбанкны 2022 оны хяналт, шалгалтын ажлын хөтөлбөр, жилийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааны хэсэг нэг бүрийн болзошгүй болон бодит эрсдэлийн зэргийг тусган харуулж чадах шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж хяналт шалгалтын ажлын дэс дарааллыг тогтоосон байна. Энэ зорилгын үүднээс тодорхой зарим нэг шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулдаг ба шалгах гэж буй үйл ажиллагаанаас хамааран шалгуур үзүүлэлтийн төрөл нэг бүр дээр зохих жигнэсэн оноог гаргана. Үйл ажиллагааны хэсэг нэг бүр дээр жигнэсэн онооны нийт дансны үлдэгдлийг гаргаж, тэдгээрийг эрсдэлийн зэргээр нь өндөр, дунд, бага гэж ангилна.

Дотоод хяналтын системийг үнэлэх ажил нь дотоод аудитын ажлын маш чухал хэсэг юм. Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь зохистой горимууд, чадварлаг гүйцэтгэл байгаа эсэхийг баталгаажуулах түүнчлэн санхүүгийн тайлагналын системийн найдвартай байдал, бүх үйл ажиллагааны хууль журмын нийцлийг баталгаажуулах явдал юм. ДАГ нь хяналтын дүгнэлт болон өөрсдийн зөвлөмжүүдийг Ерөнхийлөгч болон Хяналтын зөвлөлд тайлагнадаг. Шалгалт бүрийн эцэст ДАГ удирдлагуудтай шалгалтын үр дүнг хэлэлцэж, удирдлагын авч хэрэгжүүлсэн арга хэмжээг эргэн хянадаг.

Зээлийн эрсдэл. Зээлийн эрсдэл нь гэрээ байгуулсан хэрэглэгч, үйлчлүүлэгч, харилцагч талууд үүргээ биелүүлж чадахгүйд хүрснээс үүдэн алдагдал хүлээж болох нэг төрлийн эрсдэл юм. Харилцагч талуудтай хийсэн ажил гүйлгээ болон зээл олголтоос үүдэн зээлийн эрсдэл бий болдог бөгөөд энэ нь санхүүгийн хөрөнгөө нэмэгдүүлэх болон тэнцлийн гадуурх зээлтэй холбоотой үүрэг хариуцлагыг үүсгэдэг.

Зээлийн эрсдэлд өртөх хамгийн их магадлал нь санхүүгийн байдлын тайланд санхүүгийн хөрөнгийн дансны дүнгээр тусгагддаг. Санхүүгийн баталгаа, ашиглаагүй зээлийн шугам болон импортын аккредитивын хувьд хамгийн их өртөх магадлалтай эрсдэл нь үүрэг хариуцлагын дүнгийн хэмжээ байна.

Зээлийн эрсдэлийн удирдлага. Зээлийн эрсдэлийг хөрөнгө оруулалтын хөрөнгийг зөв сонгох, хөрөнгө оруулалтын хөрөнгийн зээлийн чанарыг хянах, хөрөнгө оруулалтын хөрөнгө бүрийн оруулах хөрөнгө оруулалтын хэмжээнд хязгаарлалт тавьж өгөх зэргээр удирдаж, хянана. Хөрөнгө оруулалтын төрлөөр нь зээлийн эрсдэлийн хэмжээнд тавих хязгаарлалтын хэмжээ болон оролцогч талыг сонгоход удирдлагаас байнга зөвшөөрөл авна. Эдгээр эрсдлүүдийг тойрох байдлаар хянадаг бөгөөд жил бүр эсвэл бүр ойр давтамжтайгаар хяналт тавина.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зээлийн эрсдэлийг бууруулахын тулд гадаад валютын нөөцийг Ааа-с Аа3 болон Ааа зэрэглэлтэй Засгийн газар (эсвэл Төв банк)–ын болон олон улсын байгууллагуудын үнэт цаасанд хөрөнгө оруулдаг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хадгаламж болон мөнгөний зах зээлийн хэрэгслүүдэд учрах зээлийн эрсдэл нь олон улсын үнэлгээний байгууллагуудаас АЗ болон түүнээс дээш зэрэглэл авсан харилцагчидтай ажил гүйлгээ явуулах замаар хязгаарлагдаж байна. Хэрэв харилцагч нь нэгээс дээш үнэлгээний байгууллагаас үнэлгээ (рейтинг) авсан бол хамгийн бага үнэлгээнд нь үндэслэдэг.

Дотоодын мөнгөний бодлогын үйл ажиллагааны хувьд зээлийн эрсдэлээ бууруулахын тулд барьцаа хөрөнгийг түлхүү хэрэглэдэг. Төв банкнаас санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгийн жагсаалтад заасан үндсэн төрлийн барьцаа хөрөнгүүдийг дор дурдав:

1. Төв банкны үнэт цаас (ТБҮЦ);
2. Засгийн газрын үнэт цаас;
3. Хөгжлийн банкны үнэт цаас;
4. Санхүүгийн байгууллагуудын гаргасан зээл.

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүх зээлдэгч банкууд хангах үүрэгтэй ба хэрэв дотоодын зээлдэгч банкууд энэхүү харьцаануудаас нэгийг биелүүлээгүй тохиолдолд тухайн банкинд олгох буюу олгосон зээлийн үйл ажиллагааг цуцалдаг.

Хязгаарлалт. Цаашилбал гадаад валютын улсын нөөцийн хувьд бүх харилцагчдад зээлийн хязгаар тогтоосон бөгөөд энэ нь зээлдэгчийн зэрэглэл, хөрөнгө, бусад хүчин зүйлд үндэслэнэ. Монголбанкны Ерөнхийлөгч нь зээлийн хязгаарыг улирал бүр тогтоох бөгөөд зээл нь тухайн хязгаартаа байгаа эсэхийг Эрсдэлийн удирдлагын алба өдөр тутам хянана. Өөрийн зээлийн эрсдэлийг хянахын тулд санхүүгийн хөрөнгийн, ялангуяа банкуудад олгосон зээл болон бусад санхүүгийн хөрөнгийн насжилтын шинжилгээг хийж зээлээ эргэн төлөх чадвар нь муудаж буй харилцагчдын талаарх мэдээллийг Захирлуудын Зөвлөлд танилцуулах бөгөөд тус хурал дээр хэлэлцэн үзэж, холбогдох шийдвэрийг гаргана.

Тодруулга 33-д толиллуулснаар Банк тодорхой хэмжээний зээлтэй холбоотой үүрэг хариуцлага хүлээсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газар эсвэл түүний харьяа байгууллагуудын хүсэлтээр Монгол Улсын хувьд чухал ач холбогдол бүхий (бараа, үйлчилгээ экспортлох гэх мэт) зээлийн үүрэг хүлээдэг. Энэхүү хэрэгслийн гол зорилго нь Засгийн газарт болон бусад төрийн байгууллагуудад санхүүжилтийн хөрөнгийг хангалттай байлгахад оршино. Нээсэн аккредитивүүд нь өмнөөс нь төлбөрийг нь барагдуулах зайлшгүй үүрэг хүлээснийг илэрхийлдэг ба эдгээр хэрэгслийн эрсдэл нь зээлийн эрсдэлтэй ижил юм. Энэ төрлийн эрсдэлийг зээлтэй ижил аргаар бууруулж болно.

Зээлтэй холбоотой үүрэг нь Хятадын Ардын банктэй хийсэн гэрээтэй холбоотой ба ашиглаагүй хэмжээг тодорхойлно (Тодруулга 33). Хийсэн шинжилгээндээ үндэслэн удирдлага нь энэ төрлийн харилцагчаас үүдэлтэй зээлийн эрсдэлд орох магадлал нь бага хэмээн дүгнэжээ.

Зээлийн эрсдэлд өртөх хамгийн их магадлал нь санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн бүртгэлээрх дүнд нөлөөлдөг. Зээлийн эрсдэл нь Тодруулга 12-д үзүүлсний дагуу барьцаа хөрөнгөөр багасч болно. Аккредитивууд болон своп хэлэлцээрийн ашиглах хэмжээг нэмэх хүсэлтээс үүдэх үүргийн хувьд зээлийн эрсдэлийн дээд хэмжээ нь энэхүү үүрэг, хариуцлагын дүнгээр илэрхийлэгдэнэ. (Тодруулга 33).

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Үнэ цэнийн бууралтын үнэлгээ

Хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал (ХБЭА)-ын аргачлал. ХБЭА нь ирээдүйд хүлээж болзошгүй алдагдлын өнөөгийн үнэ цэнэ (өөрөөр хэлбэл: зээлийн үргэлжлэх хугацаанд зээл дефолт болоход жигнэсэн дундаж алдагдал юм). ХБЭА нь нэг хүчин зүйлээс шууд хамааралтай бус хэд хэдэн боломжит хувилбаруудаас хамаарч тооцоологддог. Банкны ХБЭА-ын тооцоолол дөрвөн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд: Дефолт болох магадлал («ДМ»), Дефолт болох үеийн үлдэгдэл («ХЗА»), Алдагдал хүлээх магадлал («АХМ») болон хорогдуулалтын хувь («ХХ»).

ХЗА гэдэг нь төлбөр төлөгдөхгүй болох үеийн үлдэгдэл бөгөөд тайлант хугацаанаас хойших төлбөрийн үлдэгдлийг таамаглахдаа зээлийн эргэн төлөлт буюу үндсэн зээлийн болон хүүгийн төлөлт, нэмж олгож болзошгүй зээлийн дүнг харгалзан авч үздэг. Зээлтэй холбоотой амлалтуудын ХЗА-ийг Зээл хөрвүүлэлтийн хүчин зүйл («ЗХХЗ»)-ийг ашиглан тооцдог. ЗХХЗ нь тогтоосон хугацаанд хүлээх үүргийн дүнг тайлан тэнцэлд тусгах магадлалыг харуулдаг коэффициент юм. ДМ нь өгөгдсөн хугацааны туршид дефолт болох магадлалын тооцоолол юм. АХМ нь зээл дефолт болсон тохиолдолд түүнээс хүлээж болзошгүй алдагдлын тооцоолол юм. АХМ нь гэрээний дагуух төлөх ёстой мөнгөн дүн болон зээлдүүлэгч тухайн зээлээс төлүүлж чадах мөнгөн дүн хоёрын зөрүү юм. Харилцагчаас төлүүлж чадах мөнгөн дүнд барьцаа хөрөнгө орно. АХМ нь ихэвчлэн ХЗА –д эзлэх хувиар илэрхийлэгддэг. Хүлээгдэж буй алдагдлыг тайлант хугацааны эцэст өнөөгийн үнэ цэнээр хорогдуулна. Хорогдуулалтын хувь нь санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн түвшин («ҮАХ») бөгөөд эсвэл түүнтэй ойролцоо байдаг.

Банк санхүүгийн хэрэглүүрийн дуусах хугацааны турш дахь ХБЭА-ын загвар боловсруулсан ба энэ нь зээлийн дуусах хугацааны турш болзошгүй бүх дефолт тохиолдлоос үүсэх алдагдал юм. 12 сарын ХБЭА нь зээлийн дуусах хүртэлх хугацааны ХБЭА-ын нэг хэсэг нь бөгөөд тайлант хугацаанаас хойших 12 сарын хугацаанд үүсэж болзошгүй алдагдал юм. Хэрэв зээлийн дуусах хугацаа нь 12 сараас бага байвал хүлээж болзошгүй зээлийн алдагдлыг дуусах хугацаа хүртэл тооцоолно.

Санхүүгийн тайланд толилуулсан ХБЭА-ын тооцоолол нь дотоодын зохицуулагч байгууллагад зориулсан урт хугацааны өгөгдлийг ашиглах бус сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан. Тооцоолол нь ирээдүйн таамаглалыг агуулсан буюу зээлийн эрсдэлд нөлөөлдөг гол макро хувьсагчуудын ирээдүйд болох таамаглал тусгагдсан.

Худалдан авсан болон үнэ цэнийн бууралт («ХАҮЦБ»)-тай санхүүгийн хөрөнгийн хувьд ХБЭА-ын загвар дараахаас бусад тохиолдолд ялгаатай биш: (а) нийт дансны үнэ болон хөнгөлөлтийн хувь нь хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед нөхөгдөх боломжтой байсан мөнгөн гүйлгээнд суурилдаг, гэрээгээрх мөнгөн гүйлгээнд үндэслэгддэггүй, болон (б) ХБЭА нь хугацааны туршид дахь ХБЭА байна. Худалдан авсан болон үнэ цэнийн бууралт («ХАҮЦБ»)-тай санхүүгийн хөрөнгө нь өнгөрсөн бизнесийн нэгдэлд авсан үнэ цэнийн бууралттай зээл зэрэг анхны хүлээн зөвшөөрөлтөөр үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгө юм.

Зээлийн эрсдэлийн үнэлгээний систем. Эрсдэлийг үнийн дүнгээр нь санхүүгийн хэрэгслийг үнэлэх болон эрсдэлийг хэмжихийн тулд хөндлөнгийн олон улсын үнэлгээний байгууллага (Мүүдийс, Стандарт энд Пүүрс, Фитч)-ын гаргасан эрсдэлийн үнэлгээг ашигладаг. Дараах хүснэгтэд хөндлөнгийн үнэлгээг дефолтын магадлалын хүрээг үндсэн хэмжүүртэй нь тохируулж харуулсан:

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зээлийн эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр	Хөндлөнгийн үнэлгээний агентлагийн өгсөн тохирох үнэлгээ	
	С&П	Мүүдийс
Онц сайн	AAA to A-	AAA to A3
Сайн	BBB+ to B-	Baa1 to B3
Хангалттай	CCC+ to CCC-	Caа1 to Caа3
Тусгайлан хянах	CC to C	Ca to C
Дефолт	Дефолт	Дефолт

Эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр бүрээр зээлжих чадварын зэргийг тодорхойлсон:

- *Онц сайн* – зээлийн чанар маш сайн, зээлийн эрсдэл бага;
- *Сайн* – зээлийн чанар сайн, зээлийн эрсдэл дунд зэрэг;
- *Хангалттай* – зээлийн чанар дунд зэрэг, зээлийн эрсдэл хангалттай;
- *Тусгайлан хянах*– ойроос хянах шаардлагатай, сайжруулах удирдлагыг баримтлах хэрэгслүүд;
- *Дефолт* – дефолт болсон хэрэгсэл.

Монгол Улсын томоохон банкууд нь олон улсын үнэлгээний байгууллагуудаар зэрэглэлээ тогтоолгодог учир дотоодын банкуудад байршуулсан санхүүгийн хөрөнгийг энэхүү үнэлгээн дээр тулгуурлан хянана. Үнэлэгдээгүй банкуудын хувьд, тэдгээр банкуудын сүүлийн үеийн санхүүгийн мэдээлэл, Хяналт шалгалтын газраас гаргаж буй санхүүгийн харьцааны шинжилгээ болон хамааралтай хөрөнгийн эрсдэлийг үнэлэхэд хэрэглэдэг мэдээлэл болон бусад мэдээлэлд тулгуурлан дүгнэлт гаргадаг.

Дефолт болох, шатлал тогтоох тодорхойлолт. Дефолт болох магадлалыг тооцоолохдоо доор дурдсан нөхцлүүдийн аль нэгийг эсвэл хэд хэдэн нөхцөлийг зэрэг хангасан зээлийг дефолт болсон гэж үздэг. Үүнд:

- Зээлдэгч нь гэрээний эргэн төлөлтийг 90 хоногоос дээш хугацаагаар хэтрүүлсэн.
- Дотоодын банкуудын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд тогтоосон шаардлагыг хангаагүй.
- Санхүүгийн хөрөнгийн зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа 100%-с их.
- Дотоодын банкууд болон байгууллагуудын (хөгжиж буй орнууд) Алтманы Z оноо 1.1 болон 1.8-аас доош гарсан.
- Зээл төлөгдөхгүй байх: доорх нөхцөлүүд илэрсэн тохиолдолд зээлийн төлөгдөхгүй байх магадлал ихэсдэг:
 - гэрээний үүрэгт хүү эсвэл үндсэн төлөлтийг төлөөгүй эсвэл хугацаа хэтэрсэн.
 - дампуурлаа зарласан эсвэл хуулийн эрх хүлээн авсанаас үүдэн гэрээгээр хүлээсэн өр төлбөрийн эргэн төлөлтийг төлөхгүй байх эсвэл хугацаа хэтрэх магадлалтай болсон.
 - валютын ханшийн хямрал.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

- зээлийн гэрээний эргэн төлөлтийн нөхцөлд өөрчлөлт орсон эсвэл эрх бүхий байгууллагаас гэрээ байгуулсанаас үүдэн санхүүгийн үүрэг хариуцлагыг нь бууруулсан, үүнд гэрээний валютыг хүчээр өөрчилсөн (зээлдэгч эсвэл зээлдэгчийн эрх бүхий байгууллагаас) эсвэл анхны амлалтын зарим зүйлсийг хүчээр өөрчилсөн, жишээ нь индекс, дуусах хугацаа гэх мэт

Банкны удирдлага санхүүгийн хөрөнгүүдийн шатлалыг тодорхойлохдоо доорх шалгууруудыг тавьдаг:

№.	Шалгуур	Шатлал 1	Шатлал 2	Шатлал 3
1	Гэрээний эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн хоног	30-аас доош хоног	30-90 хоног	90-ээс дээш хоног
2	Дотоодын банкуудын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Банкнаас тогтоосон хамгийн доод шалгууруудыг хангасан	Банкнаас тогтоосон хамгийн доод шалгууруудыг хангаагүй	Дефолт болсон/ дампуурсан
3	Дотоодын банкууд болон байгууллагуудын Алтманы Z оноо	Банкууд: Z-оноо > 2.6 Байгууллагууд: Z-оноо > 3	Банкууд: 1.1 <Z- оноо >2.6 Байгууллагууд: 1.8 <Z- оноо >3	Банкууд: Z- оноо < 1.1 Байгууллагууд: Z- оноо < 1.8
4	Зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа (LTV)	70%-аас бага	70%-100%	100%-аас их

Банк дээр дурдсан шалгуур үзүүлэлтүүдээс гадна олон улсын үнэлгээний байгууллагуудын банкууд болон байгууллагад өгсөн үнэлгээг хянадаг. Олон улсын байгууллагуудаас гаргасан зээлжих зэрэглэлийн өсөх, буурах нь санхүүгийн хөрөнгийн шатлал тодорхойлоход тусгагддаг.

Банк дээрх шалгуур үзүүлэлтүүд нь биелэхгүй дор хаяж 6 сар үргэлжилсэн үед санхүүгийн хөрөнгийн чанар “сайжирсан” гэж үзэн Шатлал 3-аас дахин ангилдаг. Шатлал 1 эсвэл Шатлал 2 руу ангилах эсэх нь дахин ангилах үеийн хөрөнгийн шинэ зээлийн үнэлгээнээс хамаарах бөгөөд мөн анхны хүлээн зөвшөөрөлтийн үетэй харьцуулахад зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт байсан эсэх хамаарна.

Энэхүү санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч буй ХБЭА нь зээлдэгчийн зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхээс хамаардаг. Энэ нь ХБЭА-ын тооцоолох гурван шатлалт загвар юм. Анхны хүлээн зөвшөөрөлтийн үед үнэ цэнийн бууралтгүй байсан хөрөнгөнд, зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (ЗЭМӨ) байхгүй үед, 12 сарын ХБЭА-ыг (Шатлал 1) тооцож эрсдэлийн алдагдлын санг байгуулна. Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш ЗЭМӨ мэдэгдсэн бол, санхүүгийн хөрөнгийг Шатлал 2 руу дахин ангилдаг бөгөөд хараахан үнэ цэнэ буурсан хөрөнгө гэж хүлээн зөвшөөрдөггүй боловч хөрөнгийн нийт хугацаанд ХБЭА-ыг тооцдог. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ бурсан гэж үзсэн үед Шатлал 3 руу дахин ангилах бөгөөд мөн хөрөнгийн нийт хугацаанд ХБЭА-ыг тооцдог. Шатлал 3-т байгаа хөрөнгийн хувьд санхүүгийн хөрөнгөөс орж ирж буй хүүгийн орлогыг нийт дансны үнээс бус хөрөнгийн үр ашигт хүүгээр ХБЭА-ыг оруулсан цэвэр дансны үнээс тооцдог.

Хөрөнгө нь ЗЭМӨ-ийн шалгуурыг хангахаа больсон баримт, мэдээлэл байгаа үед хөрөнгийг буцаан Шатлал 1-д ангилна. Хөрөнгийн чанарын үзүүлэлт ашиглан үнэлж Шатлал 2-руу ангилсан бол Банк нь тухайн үзүүлэлт нь оршин байгаа үгүйг үргэлжлүүлэн хянана.

Худалдан авсан, шинээр гаргасан хөрөнгийн зээлжих чадамжаас үүдэлтэй үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгийн хувьд ХБЭА-ыг үргэлж нийт хугацааны туршид тооцоолно. Иймд Банк нь нийт хугацааны туршид тооцсон ХБЭА-д орсон хуримтлагдсан өөрчлөлтийг л хүлээн зөвшөөрдөг.

35. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

ХБЭА нь дараах зээлийн эрсдэлийн үзүүлэлтүүдийн үржвэр юм. Үүнд: ДҮД, ДАХ, ДМ-ыг дээр дурдсан байдлаар хөрөнгийг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан өнөөгийн үнэ цэнийг тооцно. Дээрх гурван үзүүлэлтийг хооронд нь үржүүлж магадлалыг мөн тооцдог (өмнөх сард эргэн төлөгдсөн эсхүл дефолт болсон). Энэхүү арга нь ирээдүйн тайлант үеүдийн ХБЭА-ыг амжилттай тооцон гаргадаг бөгөөд тооцсон дүнг хорогдуулан тайлангийн үеийн өнөөгийн үнэ цэнийг тооцдог. ХБЭА-ын тооцоололд ашиглаж байгаа хорогдуулалтын хувь нь анхны үр ашигт хүү эсхүл тооцоолсон хүү байна.

Дефолт болох үеийн үлдэгдэл. Дефолт болох үеийн үлдэгдэл (ДҮД) гэдэг нь үндсэн үлдэгдэл ба хүүний эргэн төлөлт, зээлийн төлбөрийн хоцролт дээр хуримтлагдсан хүү, г.м., тайлагналын өдрийн дараа бүртгэлийн дүнд нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан үзэж ирээдүйд чанаргүй болох өдрийн хүлээгдэж буй зээлийн бүртгэлийн дүнг хэлнэ.

1-р шатлалд буй зээлийн ДҮД-ийг тооцоолохын тулд 12 сарын хугацаанд үүсэж болох чанаргүйдэх үйл явдлыг 12 сарын хүлээгдэж буй эрсдэлийн алдагдалыг тооцоход авч үзнэ. 2-р шатлал болон 3-р шатлалд ДҮД-ийг тодорхойлохдоо нийт хугацааны түүхэн чанаргүйдэх үйл явдлыг авч үзнэ.

Дефолтын магадлал. ХБЭА-ыг тооцоход хоёр төрлийн ДМ-ыг ашигладаг. Үүнд: 12 сарын болон нийт хугацааны ДМ. 12 сарын ДМ-ыг хамгийн сүүлийн байдлаар мэдэгдэж байгаа түүхэн өгөгдөл ашиглан тооцож шаардлагатай үед ирээдүйд чиглэсэн мэдээллээр тохируулдаг. Нийт хугацааны ДМ-ыг тооцохын тулд санхүүгийн хөрөнгийн үлдсэн хугацаанд дефолт болох магадлалыг тооцдог бөгөөд жил бүрийн 12 сарын ДМ-ын нийлбэр юм.

Дефолтын алдагдлын хэмжээ. Дефолтын алдагдлын хэмжээ (ДАХ)-г Эрсдэлийн удирдлагын алба жил бүр үнэлдэг. ДАХ нь санхүүгийн хөрөнгийн чанаргүй болсон үнийн дүнд хүлээх алдагдлын түвшинг илтгэнэ. ДАХ нь харилцан тохиролцсон хэлбэр, нэхэмжлэлийн төрөл болон зэрэглэл, барьцаа хөрөнгө эсвэл бусад зээлийн дэмжлэг зэргээс шалтгаалан харилцан адилгүй байдаг. ДАХ нь ДҮД-ийн хувиар илэрхийлэгддэг. ДАХ-ийг 12 сар эсвэл зээлийн хугацааны туршид тооцдог бөгөөд 12 сарын ДАХ-г дараагийн 12 сард чанаргүйдэл болох тохиолдолд гарах алдагдлын хувиар тооцдог. Зээлийн хугацааны турш дахь ДАХ-ийг үлдэгдэл зээлийн хугацаанд гарах алдагдлын хувиар тооцдог.

Санхүүгийн хэрэгсэлд барьцаа хөрөнгө байхгүй, чанаргүйдлийн түүхэн өгөгдөл хангалтгүй байгаа тохиолдолд шинжээчдийн дүгнэлтийг ашигладаг.

ДАХ-г тооцоолоход алдагдлын талаарх тоон мэдээллийн боломжит байдлаас хамаарч дараах аргачлалуудаас тохирохыг нь сонгоно:

- Алдагдлын талаар хангалттай мэдээлэл байгаа үед: макро эдийн засгийн, салбарын болон алдагдлын тухай хангалттай мэдээлэлтэй үед симуляцийн аргыг ашиглан ирээдүйн алдагдлыг тооцоолох дотооддоо ашиглах загвар бүтээх.
- Алдагдлын талаар тодорхой хэмжээний мэдээлэлтэй үед: Багцын арга буюу зээлийн барьцаагаар хангагдсан хэсэг болон барьцаагаар хангагдаагүй хэсэгт нэгэн ижил алдагдлын хувь тооцох, симуляцийн арга ашиглан ирээдүйд учрах алдагдлыг тооцох.
- Алдагдлын талаар мэдээлэл хомс буюу байхгүй үед: Ижил төстэй санхүүгийн хөрөнгийн алдагдлын хувь хэмжээний мэдээлэл, эсвэл гадаадын зохицуулалтын байгууллагаас гаргасан өгөгдлийг ашиглах.

Түүхэн өгөгдөл хязгаарлагдмал тул ДАХ-г тооцоолохдоо Томсон Ройтерсийн өгөгдлийн терминалаас авсан, байгууллагын үнэлгээ болон гэрээний хугацаа бүрт харгалзах эргэн төлөлтийн хувийг ашигласан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дараах хүснэгт нь 2022 болон 2021 оны байдлаарх ДАХ-г санхүүгийн хөрөнгийн ангилал бүрээр харуулж байна.

	Гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	Урвуу буцаан худалдан авах хэлцэл	Засгийн газрын үнэт цаас	Дотоодын банкуудад олгосон зээл	Бусад санхүүгийн хөрөнгө
	Тодруулга (8)	Тодруулга (11)	Тодруулга (13)	Тодруулга (17)	Тодруулга (9)	Тодруулга (19)
2022	60%	2.21% - 69.68%	0%-4.04%	47%	0% - 77.5%	47% - 100%
2021	60%	18% - 77%	0%	64%	0% - 77.2%	64% - 100%

Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (ЗЭМӨ). ХБЭА-д хамаарах бүх хөрөнгийг тасралтгүй хянадаг. Санхүүгийн хэрэгсэл эсвэл санхүүгийн хэрэглүүрээс бүрдсэн багцын үнэ цэнийн бууралтыг 12 сарын ХБЭА эсвэл зээлийн дуусах хүртэлх хугацааны ХБЭА-ын аргачлалаар тооцох нь зохистой эсэхийг тодорхойлохын тулд Банк нь анхлан хүлээн зөвшөөрснөөс хойш тухайн хөрөнгийн зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (“ЗЭМӨ”) ажиглагдсан эсэхийг үнэлдэг.

Гэрээний нөхцөлд өөрчлөлт орсон хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц ихэссэн тохиолдолд чанарын шинжилгээ хийдэг. Зарим тохиолдолд зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийн шалтгааныг чанаргүйдэл бус “Дефолтын тодорхойлолт”-д дурдагдсан үйл явдлуудтай холбож тайлбарладаг.

ХБЭА-ын загварын ирээдүйн мэдээллийн тохируулга. ХБЭА-ын бүрэлдэхүүн хэсэг болох ДМ-ыг ирээдүйн мэдээлэлд үндэслэн тохируулснаар ХБЭА-ын загварт ирээдүйн макро эдийн засгийн хөгжил хэрхэн нөлөөлж болохыг тусгадаг. ХБЭА-ын хасагдуулгын хувьд ДМ-ыг санхүүгийн хөрөнгийн онцлогоос хамаарч тусгай үнэлгээгээр тооцоолдог. Арга зүйн хувьд, оновчтой макро эдийн засгийн хүчин зүйлүүдийг урьдчилан сонгохын тулд хамаарлын шинжилгээг хийсэн. Улмаар энгийн регрессийн шинжилгээг ашиглан коэффициентуудыг тодорхойлсон. Тодорхойлсон коэффициентууд болон таамаглалуудыг ашиглан чанаргүйдлийн хувийн урьдчилсан таамаглал болон түүхэн дундаж чанаргүйдлийн хувийн харьцааг тооцож, ДМ-ын ирээдүйн мэдээллийн тохируулгыг тооцоолсон. Дараах ирээдүйн мэдээлэлд үндэслэн ДМ-ыг тохируулж тооцооллыг гүйцэтгэсэн. Олон улсын үнэлгээний байгууллагын (Мүүдийс болон Стандарт энд Пүүрс) дефолтын түүхэн хувь хэмжээ болон макро эдийн засгийн үзүүлэлтэд үндэслэн ирээдүйн мэдээлэлд суурилсан жинлэсэн ДМ-ыг тооцсон:

- Дотоодын банкуудад олгосон зээл

Олон улсын үнэлгээний байгууллагын (Стандарт энд Пүүрс) чанаргүйдлийн түүхэн үнэлэмж болон макро эдийн засгийн үзүүлэлт дээр үндэслэн ирээдүйн мэдээлэлд суурилсан жинлэсэн ДМ-ыг тооцсон:

- Жилийн дотоодын нийт бүтээгдэхүүн
- Инфляцын түвшин (1 жилээр хоцорсон)
- Зээлийн хүүгийн хувь (1 жилээр хоцорсон)
- Ажилгүйдлийн түвшин (1 жилээр хоцорсон)

Сүүлийн 22 жилийн макро эдийн засгийн хувьсагчид болон ДМ-ын түүхэн өгөгдөлд шугаман регрессийн шинжилгээ хийсэн ба уг шинжилгээгээр эдгээр хувьсагчид нь статистик ач холбогдолтой макро эдийн засгийн үзүүлэлт болох нь нотлогдсон.

- Дотоодын банкинд олгосон барьцаат зээл

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Олон улсын үнэлгээний байгууллагын (Стандарт энд Пүүрс) чанаргүйдлийн түүхэн үнэлэмж болон макро эдийн засгийн үзүүлэлт дээр үндэслэн ирээдүйн мэдээлэлд суурилсан жинлэсэн ДМ-ыг тооцсон:

- Жилийн дотоодын нийт бүтээгдэхүүн
- Инфляцын түвшин (1 жилээр хоцорсон)

Сүүлийн 22 жилийн макро эдийн засгийн хувьсагчид болон ДМ-ын түүхэн өгөгдөлд шугаман регрессийн шинжилгээ хийсэн ба уг шинжилгээгээр эдгээр хувьсагчид нь статистик ач холбогдолтой макро эдийн засгийн үзүүлэлт болох нь нотлогдсон.

- ИЗББ болон Түрээсийн Орлогоор Баталгаажсан Бонд

Өөрийн сайтаар олон нийтэд нийтэлдэг нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь болон макро эдийн засгийн үзүүлэлтэд үндэслэн ирээдүйн мэдээлэлд суурилсан жинлэсэн ДМ-ыг тооцсон:

- Улирлын дотоодын нийт бүтээгдэхүүн (2 улирлаар хоцорсон)
- Нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь (1 улирлаар хоцорсон)
- Ажилгүйдлийн түвшин (1 улирлаар хоцорсон)

Банк нь сүүлийн 12 жилийн макро эдийн засгийн хувьсагчид болон нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээлийн түүхэн хувьд шугаман регрессийн шинжилгээ хийсэн ба уг шинжилгээгээр эдгээр хувьсагчид нь статистик ач холбогдолтой макро эдийн засгийн үзүүлэлт болох нь нотлогдсон.

- Эрдэнэс Монгол бонд

Өөрийн сайтаар олон нийтэд нийтэлдэг нийт уул уурхайн зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь болон макро эдийн засгийн үзүүлэлт дээр үндэслэн ирээдүйн мэдээлэлд суурилсан жинлэсэн ДМ-ыг тооцсон:

- Улирлын дотоодын нийт бүтээгдэхүүн (2 улирлаар хоцорсон)
- Нийт уул уурхайн зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь (1 улирлаар хоцорсон)

Банк нь сүүлийн 12 жилийн макро эдийн засгийн хувьсагч болон нийт уул уурхайн зээлд эзлэх чанаргүй зээлийн түүхэн хувь дээр шугаман регрессийн шинжилгээ хийсэн ба уг шинжилгээгээр эдгээр хувьсагчид нь статистик ач холбогдолтой макро эдийн засгийн үзүүлэлт болох нь нотлогдсон.

Эдгээр тохируулгын хүчин зүйлс болон тохируулагдсан ДМ-ын хувиуд нь ирээдүйн эдийн засгийн өсөлтийн талаар сайн төсөөлөл өгч чадах тул ХБЭА-ын загварын суурь төсөөлөл гэж үзсэн. Хамгийн сайн болон хамгийн муу төсөөллүүдийг тухайн загвараар таамагласан чанаргүйдлийн хувь дахь түүхэн тохируулагч хүчин зүйлүүдийг үндэслэн тооцсон ба тохируулагч хүчин зүйлийн тархалтыг тодорхой тоонуудаар хэмжсэн.

ДМ-ын хувилбар тус бүрээр тооцдог хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцдог бөгөөд, бодит хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал нь 3 өөр хувилбарыг жингээр тодорхойлогдож байна. Үүнд: Хамгийн сайн болон муу хувилбар нь тус бүр 5 хувь, суурь хувилбарт 90 хувийн жин тооцсон.

Доорх хүснэгт нь ХБЭА-ын тооцоололд ашигласан ирээдүйд чиглэсэн макро эдийн засгийн таамаглалуудыг хувилбар бүрээр харуулж байна. Бусад хувилбарууд нь хангалттай хувьсагч байгаагүй тул бодит статистик тоо ашигласан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Түлхүүр драйверууд	ХБЭА-ын хувилбар	2022 оны 12 дугаар сарын 31		2022 оны 12 дугаар сарын 31	
		Жин	Таамаглал	Жин	Таамаглал
ДНБ-ий өсөлтийн %	Хамгийн сайн	5%	12.8%	5%	14.40%
	Суурь	90%	3.2%	90%	5.50%
	Хамгийн муу	5%	(5.5%)	5%	(2.60%)
Инфляци %	Хамгийн сайн	5%	1.2%	5%	(0.50%)
	Суурь	90%	9.1%	90%	6.70%
	Хамгийн муу	5%	17.6%	5%	14.40%
Ажилгүйдлийн түвшин	Бүх хувилбар	100%	8.35%	100%	8.30%

Дараах хүснэгт нь харилцагчийн үнэлгээний байгууллагаас авсан үнэлгээг авч үзээгүй үед ашигласан ДМ-ын суурийг санхүүгийн хөрөнгө тус бүрээр харуулав. Үүнд:

Санхүүгийн хөрөнгө	ДМ-ын суурь
Дотоодын банкуудад олгосон зээл	С&П өгөгдмөл суурь
Дотоодын банкуудтай хийсэн урвуу буцаан худалдан авах хэлцэл	С&П өгөгдмөл суурь
<i>Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт</i>	
Давуу эрхтэй ИЗББ	Ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээлийн %
Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бонд	Орон сууцны зээлд эзлэх чанаргүй зээлийн %
Эрдэнэс бонд	Уул уурхайн зээлд эзлэх чанаргүй зээлийн %
Эрдэнэс таван толгой бонд	Уул уурхайн зээлд эзлэх чанаргүй зээлийн %

Доорх хүснэгтэд харуулсан үржүүлэгч нь ХБЭА-ын загварчлалд ашиглах ДМ-д оруулсан ирээдүй рүү харсан тохируулгууд болон харгалзсан макро эдийн засгийн хувьсагчид юм. Жил бүрийн түүхэн ДМ-ын регресс болон дээр дурдсан хувьсагчид дээр үндэслэн үржүүлэгчийг тооцоолсон. Дараах хүснэгтэд ХБЭА-ын загварчлалд ашигласан үржүүлэгч болон тус тусын ДМ-ыг харуулав. Үүнд:

Хувилбар	Эзлэх хувь	Дотоодын банкуудад олгосон зээл		Давуу эрхтэй ИЗББ		Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бонд		Эрдэнэс бонд Эрдэнэс таван толгой бонд	
		Үржүүлэгч	ДМ	Үржүүлэгч	ДМ	Үржүүлэгч	ДМ	Үржүүлэгч	ДМ
Хамгийн сайн	5%	0.23	0.70% - 1.37%	0.52	0.24%	0.52	2.00%	0.73	27.30%
Суурь	90%	1.11	3.33% - 6.56%	0.91	0.42%	0.91	3.47%	0.90	33.53%
Хамгийн муу	5%	1.91	5.72% - 11.26%	1.71	0.79%	1.71	6.55%	1.04	38.85%

Гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө болон гадаадын өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын хувьд удирдлага нь Блүүмберг терминал дээрх Дефолтын магадлал хэмжих үнэлгээ, судалгаа цэс нь ирээдүй рүү харсан мэдээллийг харгалзсан гэж үзсэн. Иймд, ирэх 12 сарын Эрсдэлийн алдагдлын сангийн хувилбар тус бүр дээр дефолтын магадлалыг оруулан, дээр дурдсан санхүүгийн хөрөнгүүдтэй ижил жинтэйгээр тооцсон.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зах зээлийн эрсдэл. Зах зээлийн эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн орж ирэх мөнгөн урсгалын дүн нь зах зээлийн хувьсагчууд болох хүү болон валютын хөрвүүлгээс шалтгаалан хэлбэлзэх эрсдэлийг хэлнэ. Зах зээлийн болон эргэн төлөгдөх чадварын эрсдэлийг тодорхойлохдоо удирдлагын гол анхаардаг зүйлийн нэг нь гадаадын байгууллагуудад төлөх өр төлбөр болон импортын бүтцэд зөрүүг тодорхойлох явдал юм. Энэхүү эрсдэлийг мэдрэмтгий байдлын шинжилгээг ашиглан удирдаж хянадаг. Гадаад валютын төвлөрлийг эс тооцвол зах зээлтэй холбоотой өөр ноцтой зах зээлийн эрсдэл байхгүй байна. Одоогоор үнийн бусад эрсдэлд онцгой байдлаар өртөөгүй болно.

Ханшийн эрсдэл. Ханшийн эрсдэл нь санхүүгийн хэрэгслийн үнэ цэнэ нь валютын ханшийн хэлбэлзлээс үүдэн өөрчлөгдөж байх эрсдэлийг хэлнэ. Ханшийн эрсдэлийг гадаад валютын багцыг төрөлжүүлэх замаар удирдаж болох ба дараах параметруудээр тодорхойлно:

- Гадаад валютын нөөцийн удирдлага
- Гадаад валютын нөөц болон гадаад валютаар илэрхийлэгдэх урт ба богино хугацаат хөрөнгө оруулалтын багцад эзлэх тухайн гадаад валютын хамгийн их байх хэмжээ

Гадаад валютын нөөцийг бүрдүүлэх валютын бүтцийг Хөрөнгө оруулалтын зөвлөлөөс жил бүр баталдаг.

Дараах хүснэгтэд тайлант хугацааны эцэст гадаад валютын болон ЗТЭ-ийн ханшийн төгрөгтэй харьцах харьцангуй боломжит өөрчлөлтөд (бусад бүх хувьсагчид тогтмол байхад) ашиг, алдагдал болон өөрийн хөрөнгөд үзүүлэх мэдрэмтгий байдлыг харуулсан. Хүснэгт дэх сөрөг утгатай дүнгүүд нь ашиг, алдагдал дахь болзошгүй цэвэр бууралтыг илэрхийлэх ба эерэг утгатай дүнгүүд нь боломжит цэвэр өсөлтийг илэрхийлнэ.

<i>Сая төгрөгөөр</i>	2022.12.31-нээрх ашиг/ алдагдал болон өөрийн хөрөнгө дэх нөлөө	2021.12.31-нээрх ашиг/ алдагдал болон өөрийн хөрөнгө дэх нөлөө
Ам.доллар 10%-аар чангарахад (2021:10%)	(544,806)	(16,961)
Ам.доллар 10%-аар сулрахад (2021:10%)	544,806	16,961
Юань 10%-аар чангарахад (2021:10%)	(537,108)	(455,114)
Юань 10%-аар сулрахад (2021:10%)	537,108	455,114
Евро 10%-аар чангарахад (2021:10%)	(16,390)	(19,098)
Евро 10%-аар сулрахад (2021:10%)	16,390	19,098
ЗТЭ 10%-аар чангарахад (2021:10%)	(75,773)	(70,215)
ЗТЭ 10%-аар сулрахад (2021:10%)	75,773	70,215
Алт 10%-аар чангарахад (2021:10%)	131,197	159,468
Алт 10%-аар сулрахад (2021:10%)	(131,197)	(159,468)
Бусад валют 10%-аар чангарахад (2021:10%)	13,326	28,434
Бусад валют 10%-аар сулрахад (2021:10%)	(13,326)	(28,434)

Эрсдэлийг зөвхөн үйл ажиллагааны бүртгэлийн мөнгөн тэмдэгтээс бусад мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдсэн мөнгөн үлдэгдэл болон ЗТЭ-ээр илэрхийлэгдсэн мөнгөний үлдэгдэлд тооцсон.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгтэнд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх алт ба үнэт металыг оролцуулсан мөнгөн хөрөнгө, өр төлбөрийг ханшийн мэдэгдэхүйц эрсдэлд оруулж буй валют, алт болон ЗТЭ-ийг харуулж байна.

Сая төгрөгөөр	Монгол төгрөг	Ам.доллар	Юань	Евро	ЗТЭ	Алт	Бусад	Нийт дүн
Бэлэн мөнгө	39	92,381	27,643	31,873	-	-	14,970	166,906
Гадаадын санхүүгийн байгууллага дахь хөрөнгө	-	1,913,308	599,354	104,039	417,069	-	954,758	3,988,528
Дотоодын банкуудад олгосон зээл	1,926,356	730	-	-	-	-	-	1,927,086
Буцаан худалдан авах хэлцэл	-	94,864	-	-	-	-	-	94,864
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	3,733,801	1,569,660	730,661	-	-	-	-	6,034,122
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	-	-	-	6,533	-	-	-	6,533
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	1,385,517	3,835,328	-	-	-	-	-	5,220,845
Алт ба үнэт метал	-	-	-	-	-	1,311,969	9,918	1,321,887
Засгийн газрын үнэт цаас	38,646	-	-	-	-	-	-	38,646
Бусад санхүүгийн хөрөнгө	113,925	-	-	-	-	-	-	113,925
Нийт санхүүгийн хөрөнгө	7,198,284	7,506,271	1,357,658	142,445	417,069	1,311,969	979,646	18,913,342
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(1,089,243)	-	-	-	-	-	-	(1,089,243)
Төв банкны үнэт цаас	(5,641,303)	-	-	-	-	-	-	(5,641,303)
Засгийн газрын хөрөнгө	(503,480)	(1,095,208)	(10)	(119,774)	(633,612)	-	(808,854)	(3,160,938)
Дотоодын банкуудын хөрөнгө	(3,136,334)	(4,081,949)	(693,272)	(186,566)	-	-	(37,513)	(8,135,634)
Гадаад өр төлбөр	(2,180)	(296,067)	(6,035,307)	-	(541,183)	-	-	(6,874,737)
Буцаан худалдан авах хэлцэл	-	(95,857)	-	-	-	-	-	(95,857)
Бусад санхүүгийн өр төлбөр	(377,018)	(15,749)	(146)	-	-	-	(23)	(392,936)
Нийт санхүүгийн өр төлбөр	(10,749,558)	(5,584,830)	(6,728,735)	(306,340)	(1,174,795)	-	(846,390)	(25,390,648)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	6,543,392	(7,369,504)	-	-	-	-	-	(826,112)
Цэвэр позиц	2,992,118	(5,448,063)	(5,371,077)	(163,895)	(757,726)	1,311,969	133,256	(7,303,418)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгт нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх алт ба үнэт металыг оролцуулсан мөнгөн хөрөнгө, өр төлбөрийг ханшийн мэдэгдэхүйц эрсдэлд оруулж буй валют, алт болон ЗТЭ-ийг харуулж байна.

Сая төгрөгөөр	Монгол төгрөг	Ам.доллар	Юань	Евро	ЗТЭ	Алт	Бусад	Нийт дүн
Бэлэн мөнгө	38	72,542	51,136	35,712	-	-	18,163	177,591
Гадаадын санхүүгийн байгууллага дахь хөрөнгө	-	2,996,207	702,108	65,600	387,299	-	322,575	4,473,789
Дотоодын банкуудад олгосон зээл	1,486,637	671	-	-	-	-	-	1,487,308
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	3,312,896	2,835,320	245,606	-	-	-	-	6,393,822
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	-	-	-	6,533	-	-	-	6,533
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	1,430,987	3,091,233	-	-	-	-	-	4,522,220
Алт ба үнэт метал	-	-	-	-	-	1,594,676	-	1,594,676
Засгийн газрын үнэт цаас	231,778	-	-	-	-	-	-	231,778
Бусад санхүүгийн хөрөнгө	298,108	(81)	-	-	-	-	-	298,027
Нийт санхүүгийн хөрөнгө	6,760,444	8,995,892	998,850	107,845	387,299	1,594,676	340,738	19,185,744
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(1,105,589)	-	-	-	-	-	-	(1,105,589)
Төв банкны үнэт цаас	(8,622,184)	-	-	-	-	-	-	(8,622,184)
Засгийн газрын хөрөнгө	(394,543)	(618,915)	(9)	(78,074)	(618,751)	-	(23,824)	(1,734,116)
Дотоодын банкуудын хөрөнгө	(2,323,564)	(1,812,787)	(86,407)	(220,754)	-	-	(28,365)	(4,471,877)
Гадаад өр төлбөр	(2,416)	(977,317)	(5,463,574)	-	(470,698)	-	-	(6,914,005)
Бусад санхүүгийн өр төлбөр	(650,000)	(13,025)	-	-	-	-	(4,206)	(667,231)
Нийт санхүүгийн өр төлбөр	(13,098,296)	(3,422,044)	(5,549,990)	(298,828)	(1,089,449)	-	(56,395)	(23,515,002)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	5,350,805	(5,743,460)	-	-	-	-	-	(392,655)
Цэвэр позиц	(987,047)	(169,612)	(4,551,140)	(190,983)	(702,150)	1,594,676	284,343	(4,721,913)

Хүүгийн түвшний эрсдэл. Хүүгийн түвшний хэлбэлзлээс ирээдүйд орж ирэх мөнгөн урсгал эсвэл санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ өөрчлөгдөх эрсдэлийг хүүгийн түвшний эрсдэл гэнэ. Хүүгийн түвшний эрсдэлийг удирдах гол зорилго нь хөрөнгө оруулалт тус бүрээс эрсдэлийн хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тогтвортой үр ашиг хүртэх явдал юм.

Хөрөнгө болон өр төлбөрийн ихэнх хувь нь тогтмол хүүгийн түвшинтэй эсвэл хүүгүй байгаа нь хүүгийн түвшний эрсдэлийг ихээхэн хэмжээгээр буруулдаг. Стратегийн харьцуулсан үзүүлэлтийг тодорхойлох явцдаа, хүүгийн түвшингийн эрсдэлийг багасгах зорилгоор гадаад валютын нөөцийн багцдаа хугацааг нь зааж өгдөг. Энэхүү хугацааны хэрэгжилтийг өдөр бүр хянадаг. Хөрөнгө оруулалтын хугацаа нь хөндлөн шинжилгээний аргаар тодорхойлогдоно. Хөрөнгө оруулалтын хугацааг 1 жилээр, хамгийн бага үр өгөөжийн түвшинг сөрөг үр өгөөжөөр (1 жилийн хугацаанд үр өгөөжийн өөрчлөлт сөрөг бол), сөрөг үр өгөөжийн хүлээн зөвшөөрөх боломж 5 хувиас ихгүй байхаар өөрийн эрсдэлийн түвшинг тодорхойлж, ирээдүйн өгөөжийг таамаглах аргаар зохистой хугацааг тооцдог.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дараах хүснэгтэд хүүгийн түвшний эрсдэлийн байдлыг харуулав. Энэ хүснэгтэд алт ба үнэт металыг оролцуулсан санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг дансны үлдэгдэл дүнгээр, мөн гэрээнд заасан хүүгийн түвшин өөрчлөгдсөн буюу зээлийн хугацаа дуусгавар болсон өдрүүдийн аль түрүүнд болсноор ангилан үзүүлсэн байна:

<i>Сая төгрөгөөр</i>	Хугацаагүй ба 1 сараас бага	1-6 сар	6-12 сар	12 сараас дээш	Нийт дүн хүүтэй	Хүүгийн мэдрэмтгий байдалгүй	Нийт дүн
2022.12.31-нээрх							
Нийт санхүүгийн хөрөнгө	5,982,836	1,409,365	796,099	6,454,277	14,642,577	4,385,504	19,028,081
Нийт санхүүгийн өр төлбөр	(17,808,185)	(424,033)	(6,204,828)	(1,251,096)	(25,688,142)	(643,357)	(26,331,499)
2022.12.31-нээрх хүүгийн мэдрэмтгий байдлын цэвэр зөрүү	(11,825,349)	985,332	(5,408,729)	5,203,181	(11,045,565)	3,742,147	(7,303,418)
2021.12.31-нээрх							
Нийт санхүүгийн хөрөнгө	9,583,810	55,820	1,141,763	6,598,300	17,379,693	1,883,155	19,262,848
Нийт санхүүгийн өр төлбөр	(16,354,976)	(124,529)	(6,676,453)	(791,524)	(23,947,482)	(162,501)	(24,109,983)
2021.12.31-нээрх хүүгийн мэдрэмтгий байдлын цэвэр зөрүү	(6,771,166)	(68,709)	(5,534,690)	5,806,776	(6,567,789)	1,720,654	(4,847,135)

Дараах хөрөнгө болон өр төлбөрийн хүүг хөвөгч/хувьсах хүүгийн хувь хэмжээгээр тооцож хуримтлуулдаг: ЗТЭ-ийн эзэмшил (Тодруулга 8), ЗТЭ-ийн хуваарилалт, Хятадын Ардын банкнаас авсан зээлүүд (Тодруулга 25).

Бусад хувьсагчийг тогтмол гэж үзэн, 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх хүүгийн түвшин 100 суурь нэгжээр бага байсан тохиолдолд тайлант жилийн алдагдал 148,816 сая төгрөг (2021: 98,789 сая төгрөг)-өөр буурах байсан нь Хятадын ардын банкны зээлд төлөх хүү багасч байгаатай холбоотойгоос гадна ААБҮЦ-ээрх өрийн үнэт цаасны бодит үнэ цэнийн үнэлгээнд эерэгээр нөлөөлж байгаатай холбоотой. Өөрийн хөрөнгийн бусад хэсэг нь 37,730 сая төгрөг (2021: 33,111 сая төгрөг)-өөр өсөх байсан нь БДОБҮЦ-ээрх тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн үнэлгээ өссөнтэй холбоотой.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Харин эсрэгээрээ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх хүүгийн түвшийн 100 суурь нэгжээр их байх тохиолдолд, бус хувьсагчийг тогтмол гэж үзэн, тайлант жилийн алдагдал 142,921 сая төгрөг (2021: 98,789 сая төгрөг)-өөр өсөх байсан нь хүүгийн төлөх дүн нэмэгдэж, ААБҮЦ-ээрх өрийн үнэт цаасны бодит үнэ цэнэ буурахтай холбоотой. Өөрийн хөрөнгийн бусад хэсэг нь 37,562 сая төгрөг (2021: 33,111 сая төгрөг)-өөр буурах байсан нь БДОБҮЦ-ээрх тогтмол хүүтэй, санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн үнэлгээ буурахтай холбоотой.

Банк санхүүгийн хэрэгслийн хүүгийн түвшинг хянаж байдаг. Доорх хүснэгтэд харгалзах тайлант өдрийн байдлаарх хүүгийн түвшинг эрх бүхий албан тушаалтны хянаж баталгаажуулсан удирдлагын тайланд үндэслэн нэгтгэсэн. Хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цааснуудын хувьд хүүгийн түвшин нь тайлант өдрийн байдлаар дуусгавар болох өдөр хүртэлх хугацааны өгөөжийн зах зээл дээрх түвшинг илэрхийлнэ.

Жилийн хүү	2022				2021			
	Төгрөг	Ам. доллар	Юань	Бусад	Төгрөг	Ам. доллар	Юань	Бусад
Хөрөнгө								
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	-	4.34%	1.31%	2.92%-3.10%	-	0.17%	2.86%	0.08%
Буцаан худалдан авах хэлцлийн авлага	-	0.66%	-	-	-	-	-	-
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	6.63%	0.82%	1.63%	-	7.13%	0.93%	2.79%	-
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	10.25%	0.05%-4.3%	-	-	7.00%	0%-0.05%	-	-
Засгийн газрын үнэт цаас	1.00%	-	-	-	1.00%	-	-	-
Дотоодын банкуудад олгосон зээл	4.03%	0.75%	-	-	3.74%	0.75%	-	-
Өр төлбөр								
Төв банкны үнэт цаас	12.31%	-	-	-	6.00%	-	-	-
Засгийн газрын хөрөнгө	7.50%	2.52%	-	3.72%	-	2.17%	-	1.00%
Дотоодын банкуудын хөрөнгө	11.00%	4.42%	-	-	5.00%	-	-	-
Гадаад өр төлбөр	-	3.99%	4.00%	-	-	2.41%	4.73%	-
Буцаан худалдан авах хэлцэл	-	2.12%	-	-	-	-	-	-

Хүснэгт дэх “-” тэмдэглэгээ нь харгалзах валютаар, харгалзах хөрөнгө, өр төлбөр байхгүйг илтгэнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Газар зүйн эрсдэлийн төвлөрөл. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх мөнгөжсөн алт, үнэт металыг багтаасан санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн газар зүйн төвлөрлийг доорх хүснэгтээр харууллаа:

<i>Сая төгрөгөөр</i>	Монгол Улс	ЭЗХАБ-ын орнууд	ОУВС	ЭЗХАБ-ын бус орнууд	Нийт дүн
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	166,906	-	-	-	166,906
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж	-	2,981,001	417,069	590,458	3,988,528
Дотоодын банкуудад олгосон зээл	1,927,086	-	-	-	1,927,086
Буцаан худалдан авах хэлцлийн авлага	-	94,864	-	-	94,864
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	3,733,801	2,204,505	-	95,816	6,034,122
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	-	6,533	-	-	6,533
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	1,385,517	3,835,328	-	-	5,220,845
Алт ба үнэт металл	-	1,321,887	-	-	1,321,887
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	114,739	-	-	-	114,739
Засгийн газрын үнэт цаас	38,646	-	-	-	38,646
Бусад санхүүгийн хөрөнгө	113,925	-	-	-	113,925
Нийт санхүүгийн хөрөнгө	7,480,620	10,444,118	417,069	686,274	19,028,081
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(1,089,243)	-	-	-	(1,089,243)
Төв банкны үнэт цаас	(5,641,303)	-	-	-	(5,641,303)
Засгийн газрын хөрөнгө	(3,160,938)	-	-	-	(3,160,938)
Банкуудын хөрөнгө	(8,135,634)	-	-	-	(8,135,634)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	(940,851)	-	-	-	(940,851)
Гадаад өр төлбөр	-	(298,247)	(541,183)	(6,035,307)	(6,874,737)
Буцаан худалдан авах хэлцэл	(95,857)	-	-	-	(95,857)
Бусад санхүүгийн өр төлбөр	(392,936)	-	-	-	(392,936)
Нийт санхүүгийн өр төлбөр	(19,456,762)	(298,247)	(541,183)	(6,035,307)	(26,331,499)
2022 оны 12 сарын 31-нээрх цэвэр позиц	(11,976,142)	10,145,871	(124,114)	(5,349,033)	(7,303,418)
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг (Тодруулга 33)	(19,143)	-	-	(6,000,000)	(6,019,143)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх мөнгөжсөн алт, үнэт металлыг багтаасан санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн газар зүйн төвлөрлийг доорх хүснэгтээр харууллаа:

Сая төгрөгөөр	Монгол Улс	ЭЗХАБ-ын орнууд	ОУВС	ЭЗХАБ-ын бус орнууд	Нийт дүн
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	177,591	-	-	-	177,591
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж	-	3,543,394	387,299	543,096	4,473,789
Дотоодын банкуудад олгосон зээл	1,487,308	-	-	-	1,487,308
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	3,313,009	3,058,132	-	22,681	6,393,822
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	-	6,533	-	-	6,533
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	1,430,987	3,091,233	-	-	4,522,220
Алт ба үнэт металл	-	1,594,676	-	-	1,594,676
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	77,103	-	-	-	77,103
Засгийн газрын үнэт цаас	231,778	-	-	-	231,778
Бусад санхүүгийн хөрөнгө	298,027	-	-	-	298,027
Нийт санхүүгийн хөрөнгө	7,015,803	11,293,968	387,299	565,777	19,262,847
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(1,105,589)	-	-	-	(1,105,589)
Төв банкны үнэт цаас	(8,622,184)	-	-	-	(8,622,184)
Засгийн газрын хөрөнгө	(1,734,116)	-	-	-	(1,734,116)
Банкуудын хөрөнгө	(4,471,877)	-	-	-	(4,471,877)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	(469,758)	-	-	-	(469,758)
Гадаад өр төлбөр	-	(979,732)	(470,698)	(5,463,575)	(6,914,005)
Бусад санхүүгийн өр төлбөр	(665,171)	-	-	-	(665,171)
Нийт санхүүгийн өр төлбөр	(17,068,695)	(979,732)	(470,698)	(5,463,575)	(23,982,700)
2021 оны 12 сарын 31-нээрх цэвэр позиц	(10,052,892)	10,314,235	(83,399)	(4,897,797)	(4,719,853)
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг (Тодруулга 31)	(22,475)	-	-	(6,000,000)	(6,022,475)

Бусад эрсдэлийн төвлөрөл. Удирдлага дээр дурдсан харилцагчдын хязгаар бүрт зээлдэгчдийн талаарх тайлан мэдээллийг авах замаар зээлийн эрсдэлийн төвлөрлийг судалж, хяналт тавьдаг. 2022 оны 12 дугаар сарын 31 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ийм төрлийн томоохон эрсдэлийн төвлөрөл байхгүй байна.

